

**ШУДАРГА СОНГУУЛИЙН ТӨЛӨӨ
ИРГЭНИЙ НИЙГМИЙН ХЯНАЛТ СҮЛЖЭЭ**

УЛСЫН ИХ ХУРЛЫН СОНГУУЛЬ – 2012

**“ШУДАРГА СОНГУУЛИЙН ТӨЛӨӨ ИРГЭНИЙ НИЙГМИЙН ХЯНАЛТ”
СҮЛЖЭЭНЭЭС ХИЙСЭН МОНИТОРИНГ**



НИЙГМИЙН ДЭВШИЛ
ЭМЭГТЭЙЧҮҮД ХӨДӨЛГӨӨН



"МИДАС" ТББ



ФИЛАНТРОПИИ ХӨГЖЛИЙН
ТӨЛӨӨ ТӨВ



ГЛОБ ИНТЕРНЭШНЛ
ТӨВ



УЛСЫН ИХ ХУРЛЫН СОНГУУЛЬ – 2012 “ШУДАРГА СОНГУУЛИЙН ТӨЛӨӨ ИРГЭНИЙ НИЙГМИЙН ХЯНАЛТ” СУЛЖЭЭНЭЭС ХИЙСЭН МОНИТОРИНГ

Сүлжээний гишүүн төрийн бус байгууллагууд:

- НЭЭЛТТЭЙ НИЙГЭМ ФОРУМ
- НИЙГМИЙН ДЭВШИЛ ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ХӨДӨЛГӨӨН
- ФИЛАНТРОПИИ ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨ ТӨВ
- MIDAS
- ГЛОБ ИНТЕРНЭШНЛ ТӨВ
- ΘӨРЧЛӨЛТИЙН ТӨЛӨӨХ ЗАЛУУ ЭМЭГТЭЙЧҮҮД

Энэхүү тайланг Нээлттэй Нийгэм Форумын санхүүжилтээр хэвлэн нийтлэв.

Хавтасны зургийг Б.Бямба-Очир.

Энэхүү тайлангийн бүх зургийг хандивлаж, хэвлэх эрх олгосон www.gogo.mn сайтын хамт олонд талархал илэрхийлье.

Хаяг: Жамъян гүний гудамж
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар-48,
Утас: 976-11-313207
Факс: 976-11-324857
Вэб: <http://www.forum.mn>
И-мэйл: osf@forum.mn

DDC
1213131
1212121212
121212121212

Гарчиг



ӨМНӨТГӨЛ	4
ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР	5
ЕРӨНХИЙ ТАНИЛЦУУЛГА	6
НЭГ. САНАЛЫН ХУУДАС ХЭВЛЭХ, ХАДГАЛАХ, ХАМГААЛАХ, ХҮРГҮҮЛЭХ, АРХИВТ ШИЛЖҮҮЛЭХ ҮЙЛ ЯВЦЫН ХЯНАЛТ	
1.1 Төслийн танилцуулга	10
1.2 Хууль эрхзүйн орчин	12
1.3 Мониторингийн дүн	15
1.4 Мониторингийн дүгнэлт, зөвлөмж	32
1.5 Ашигласан материалын жагсаалт	35
ХОЁР. СОНГУУЛИЙН АВТОМАТЖУУЛСАН СИСТЕМИЙН МОНИТОРИНГ	
2.1 Төслийн танилцуулга	38
2.2 Хууль эрхзүйн орчин	40
2.3 Мониторингийн дүн	43
2.4 Мониторингийн дүгнэлт зөвлөмж	49
ГУРАВ. СОНГОГЧДЫН НЭРИЙН ЖАГСААЛТЫН МОНИТОРИНГ	
3.1 Төслийн танилцуулга	54
3.2 Хууль эрхзүйн орчин	57
3.3 Мониторингийн дүн	61
3.4 Мониторингийн дүгнэлт зөвлөмж	64
ДӨРӨВ. 2012 ОНЫ УИХ-ЫН СОНГУУЛИЙН ҮЕЭР ХИЙСЭН ТЕЛЕВИЗИЙН МОНИТОРИНГ	
4.1 Төслийн танилцуулга	70
4.2 Хууль эрхзүйн орчин	71
4.3 Мониторингийн аргачлал	76
4.4 Мониторингийн дүн	79
4.5 Мониторингийн дүгнэлт зөвлөмж	90
ТАВ. СОНГУУЛИЙН САНАЛ АВАХ, САНАЛ ТООЛОХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ АЖИЛЛАЛТ	
5.1 Төслийн танилцуулга	96
5.2 Эрхзүйн орчин	97
5.3 Ажиглалтын үйл ажиллагаа	99
5.4 Ажиглалтын дүн	104
5.5 Дүгнэлт зөвлөмж	106
ХАВСРАЛТ	119

Өмнөтгөл

Нээлттэй Нийгэм Форум 2012 онд “Шударга сонгуулийн төлөө иргэний нийгмийн хяналт” төрийн бус байгууллагуудын сүлжээнээс эрхлэн УИХ-ын сонгуульд хийсэн мониторинг болон ажиглалтын дүнгийн тайланг Та бүхний сонорт хүргэж байгаадаа баяртай байна. 2008 онд байгуулагдсан энэхүү сүлжээ 2012 оны сонгуулийн үеэр сонгогчдын нэрийн жагсаалт, саналын хуудас, санал тоолох үйл явцын автоматжуулалт, хэвлэл мэдээлэлд мониторинг хийж, анх удаа сонгуулийн санал хураах байранд ажиглалт хийсэн юм.

2004 оноос эхлэн Нээлттэй Нийгэм Форум бусад төрийн бус байгууллагатай хамтран сонгуулийн мониторинг хийж эхэлсэн бөгөөд энэ хугацаанд багагүй туршлага туршлага хуримтлуулж сонгуулийн эрх зүйг уlam боловсронгуй болгоход хувь нэмэр оруулж ирлээ. Анх 2004 оны УИХ-ын сонгуулийн үеэр Нийгмийн Дэвшил Эмэтэйчүүд Хөдөлгөөн, Глоб Интернэшил ТББ-уудтайхамтран Сонгуулийн кампанит ажлын санхүүжилтэд мониторинг хийж төрийн эх үүсвэрийг улс төрийн зорилгод ашиглаж буйг баримтжуулсан нь цаашид улс төрийн намууд төрийн өмчийн байр, техник хэрэгсэл, унаа, төрийн албан хаагчдыг сонгуулийн кампанит ажилд дайчилдаг зохисгүй үйлдлийг хуулиар хориглоход хүргэсэн чухал үр нөлөө үзүүлэв.

Нээлттэй Нийгэм Форум 2008 онд сонгуулийн мониторингийн үйл ажиллаагаа тэлж сонгуулийн үйл явцын ил тод байдлыг хангах, сонгуулийг шударга явуулахад иргэний нийгмийн

хяналт, оролцоог нэмэгдүүлэх зорилго бүхий “Шударга сонгуулийн төлөө иргэний нийгмийн хяналт” төрийн бус байгууллагуудын сүлжээ байгуулж, сонгуулийн хороодын үйл ажиллагаа, сонгогчдын нэрийн жагсаалт, саналын хуудас, сонгуулийн кампанит ажил, хэвлэл мэдээлэлд цогц мониторинг хийхэд нь арга зүйн болон санхүүгийн дэмжлэг үзүүлсэн юм. Сонгогчдын нэрийн жагсаалтад хийсэн аудитын үр дүнд үлэмж хэмжээний зөрчил илрүүлж, засаж залруулахад нөлөөлснийг онцлон тэмдэглэхэд таатай байна.

Олон жилийн туршид хязгаарлагдмал нөөц боломжкоо дайчлан сонгуулийн мониторинг хийж, сонгуулийг шударга зохион байгуулахад идэвхитэй оролцож, улс орныхоо ардчилсан хөгжил дэвшилд үнэтэй хувь нэмэр оруулж ирсэнд Нийгмийн Дэвшил Эмэтэйчүүд Хөдөлгөөн, Глоб Интернэшил Төв, Филантропи Хөгжлийн Төлөө Төв, Хүний Эрх Хөгжил Төв, МИДАС, Өөрчлөлтийн Төлөөх Залуу Эмэгтэйчүүд ТББ-уудад гүн талархал илэрхийлье.

Та бүхний сонорт хүргэж буй энэхүү тайланд тусгалаа олсон дүгнэлт, зөвлөмжүүд цаашид сонгуулийн үйл явцыг улам боловсронгуй болгох, улмаар Монгол Улсын иргэд сонгох сонгогдох эрхээ бүрэн дүүрэн эдлэхэд зохих хувь нэмэр оруулна гэдэгт гүнээ найдаж байна.

Нээлттэй Нийгэм Форумын
Гүйцэтгэх захирал
П. Эрдэнэжаргал

Товчилсон үгийн тайлбар

АН	Ардчилсан Нам	МШХХТГ	Мэдээлэл, Шуудан, Харилцаа, Холбоо, Технологийн газар
АНУ	Америкийн Нэгдсэн Улс	НИТХ	Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
БГД	Баянгол дүүрэг	САС	Сонгуулийн автоматжуулсан систем
БД	Бие даагч	СЕХ	Сонгуулийн Ерөнхий Хороо
БЗД	Баянзүрх дүүрэг	СЕХ- МТ	Сонгуулийн Ерөнхий Хорооны Мэдээллийн төв
БНН	Бүгд Найрамдах Нам	СХД	Сонгинохайрхан дүүрэг
ГХЭ	Гурав дахь хүчин эвсэл	ТББ	Төрийн Бус Байгууллага
ДВС	Доминион Вөүтинг Системс	ТЕГ	Тагнуулын Ерөнхий Газар
ЗДТГ	Засаг Даргын Тамгын Газар	УБЕГ	Улсын Бүртгэлийн Ерөнхий Газар
ЗГ	Засгийн Газар	УИХ	Улсын Их Хурал
ИЗНН	Иргэний Зориг Ногоон Нам	ХМХ	Хэвлэл мэдээллийн хэрэгслүүд
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	ХХЗХ	Харилцаа Холбооны Зохицуулах Хороо
ИХН	Иргэний Хөдөлгөөний Нам	ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
МАН	Монгол Ардын Нам	ЧД	Чингэлтэй дүүрэг
МАХН	Монгол Ардын Хувьсгалт Нам	ХХН	Хөгжлийн Хөтөлбөр Нам
МНН	Монголын Ногоон Нам	ШЁЭ	Шударга Ёс Эвсэл
МСДН	Монголын Социал Демократ Нам	ЭОН	Эх Орон Нам
МТТ	Мэдээллийн Технологийн Төв	ЭОНН	Эх Орончдын Нэгдсэн Нам
МТУП	Мэдээллийн Технологийн Үндэсний Парк	ЭЧХН	Эрх Чөлөөг Хэрэгжүүлэгч Нам
МУНН	Монголын Уламжлалтын Нэгдсэн Нам		
МУАН	Монголын Үндэсний Ардчилсан Нам		
МУОНТ	Монголын Үндэсний Олон Нийтийн Телевиз		

2012 оны Монгол Улсын Их Хурлын сонгуульд хийсэн иргэний нийгмийн мониторингийн ерөнхий танилцуулга



УИХ-ын сонгуулийн 19-р тойргийн санал
авах байр, 2012 оны 6 дугаар сарын 24.
Эх сурвалж www.gogo.mn сайт.

“Шударга Сонгуулийн Төлөө Иргэний Нийгмийн Хяналт” сүлжээний гишүүн байгууллагууд 2012 оны 6 дугаар 28-нд болсон Улсын Их Хурлын ээлжит сонгуулийн үйл явцад зөрчил, маргаан гарч болзошгүй, хяналтзайлшгүй шаардлагатай гэж үзсэн зарим асуудлаар мониторинг хийллээ. Тухайлбал, “Сонгогчдын нэрийн жагсаалтын мониторинг”, “Саналын хуудас хэвлэх, хадгалах, хамгаалах, хүргүүлэх, архивт шилжүүлэх үйл явцын хяналт”, “Сонгуулийн автоматжуулалтын мониторинг”, “Хэвлэл мэдээллийн мониторинг”, “Сонгуулийн өдрийн ажиглалт: Санал хураах, тоолох, дүнг гаргах үйл явцын ажиглалт” гэсэн таван үндсэн чиглэлээр хяналт тавьсан юм.

УИХ-аас 2011 оны 12 дугаар сарын 15-нд баталсан УИХ-ын Сонгуулийн тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийн 8 дугаар зүйлд “Сонгуулийг санал авах өдрөөс 60-аас доошгүй хоногийн өмнө Улсын Их Хурал товлон зарлана” гэж заасны дагуу 2012 оны 4 дүгээр сарын 26-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар Улсын Их Хурлын ээлжит сонгуулийг 2012 оны 4 дүгээр сарын 28-ны өдрөөс эхлэхээр товлон зарласан билээ.

Сонгуулийн сурталчилгаа албан ёсоор нам, эвсэл, нэр дэвшигч бүртгүүлж үнэмлэхээ авсан өдрөөс буюу 6 дугаар сарын 6-ны өдрөөс эхэлж, сонгуулийн санал хураалтыг 2012 оны 6 дугаар сарын 28-ны өдөр явууллаа. УИХ-ын сонгуульд нэр дэвшигчээр 11 нам, 2 эвслийн 544 хүн бүртгүүлсэн бөгөөд үүнээс 354 нь 26 тойрогт, 190 нь нам, эвслийн жагсаалтаар нэр дэвшсэн байна. Нийт нэр дэвшигчийн 174 буюу 32 хувь нь эмэгтэй, 26 буюу 4,7 хувь нь бие даан нэр дэвшигч байлаа.

Монгол Улс ардчилсан тогтолцоог сонгосноос хойш зургаа дахь удаагаа УИХ-аа байгуулах болсон энэ сонгууль нь өмнөх сонгуулиудтай харьцуулахад хэд хэдэн онцлогтой боллоо. Юуны өмнө

шинэчлэн баталсан УИХ-ын сонгуулийн тухай хуульд сонгуулийг анх удаа холимог тогтолцоогоор явуулахаар зааснаас гадна сонгууль шударга явагдах нөхцлийг хангахад чиглэсэн хэд хэдэн өөрчлөлт тусгалаа олсон юм. Сонгогчдын саналыг гараар олон цаг тоолохыг зогсоож анх удаа автоматжуулсан систем нэвтрүүлэхээр боллоо. Сонгогчдын нэрийн жагсаалтыг улсын хэмжээнд нэгтгэн үнэн зөв гаргах үүргийг Улсын бүртгэлийн газарт хариуцуулж, жагсаалтыг хэсгийн хороод дур мэдэн хяналтгүйгээр өөрчилдөг явдлыг хориглов. Тойрог, хэсэг, салбар хороодын бүрэлдэхүүнийг улстөрийн намуудын төлөөллөөс бус төрийн албан хаагчдаас бүрдүүлж, хууль зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг хуульд тодорхой тусгасан болно. Сонгууль шударга явагдах нэг чухал нөхцөл болох сонгуулийн үйл явцын ил тод байдлыг хангах үүднээс анх удаа бие даасан иргэний нийгмийн байгууллагууд сонгуульд хөндлөнгийн хяналт тавих, санал хураах өдрийн үйл ажиллагааг ажиглах эрхтэй болсон юм.

УИХ-ЫН СОНГУУЛИЙН ТУХАЙ ХУУЛИАС ...

9.5. Төрийн хэргийг удирдахад иргэдийг оролцуулах дүрмийн үүрэг, зорилт бүхий төрийн бус байгууллага нь Сонгуулийн Ерөнхий Хорооноос тогтоосон журмын дагуу сонгуулийн хороод, сонгуульд оролцогч бусад байгууллага, албан тушаалтан сонгуулийн хууль тогтоомжийг хэрхэн биелүүлж байгаад хяналт шинжилгээ (мониторинг) хийх, сонгогчийн боловсрол, мэдлэгийг дээшлүүлэх, түүнд эрхээ хэрэгжүүлэхэд нь аргачилсан туслалцаа үзүүлэх зэргээр сонгуулийг хуулийн дагуу, шударгаар явуулахад туслалцаа үзүүлэх эрхтэй.

Хуулийн дээрх заалтыг хэрэгжүүлэхэд холбогдох журмыг Сонгуулийн Ерөнхий Хороо (СЕХ) 30 дугаар тогтоолоороо баталсан бөгөөд уг журмыг боловсруулахад Сүлжээний гишүүд идэвхийлэн оролцсон билээ. Уг журамд сонгуулийн үйл явцыг ажиглаж мониторинг хийх ТББ нь тодорхой шалгуурыг заавал хангасан байхаар заасан ба юуны өмнө улстөрийн нам, эвслээс хараат бус, бие даан үйл ажиллагаа явуулж тодорхой туршлага хуримтлуулсан, байгууллага нь дүрмээрээ тухайн чиглэлээр ажиллах үүрэг зорилттой, хяналт шинжилгээ хийх ажлын төлөвлөгөөтэй байх зэрэг шаардлагыг багтаасан байна. Эдгээр шаардлагыг хангасан байгууллагад СЕХ зөвшөөрөл олгон хяналт-шинжилгээ (мониторинг) хийх нөхцөлөөр хangan дэмжлэг үзүүлэхээр журамд тусгасан. Тухайлбал, мониторинг хийж буй иргэний нийгмийн байгууллагуудад үйл ажиллагаагаа саадгүй явуулахад нь шаардлагатай мэдээллээр хangan ажиллахыг СЕХ доод шатны сонгуулийн хорооддоо үүрэг болгохоор зааж зохицуулсан болно. Түүнчлэн ажиглалт хяналт, шинжилгээнд шаардлагатай мэдээлэл нь хуулиар хориглоогүй мэдээлэл байхаар тусгажээ. Тухайлбал, сонгогчдын нэрийн жагсаалтыг, нягтлан шалгах, өөрчлөлт оруулах үйл явц хуулийн дагуу хийгдэж байгаа эсэхтэй танилцах, сонгуулийн хороодын хуралдааны тэмдэглэл, шийдвэртэй танилцах, хуулбарлан авах, санал хураах, тоолох төхөөрөмжийн ажиллагааг туршин шалгах үйл явцыг хянах, сонгуулийн хороодод ирсэн өргөдөл гомдлыг хэрхэн шийдвэрлэж байгаа талаар мэдээлэл авах, саналын хуудас хэвлэх, хадгалалт хамгаалалт, тээвэрлэлт, аюулгүй байдал, битүүмжлэн хадгалах ажиллагаанд хяналт тавих зэрэг асуудал тус багтжээ.

Дээрх журмын хүрээнд 2012 оны УИХ-ын сонгуулийн үеэр хяналт, мониторинг хийх зөвшөөрлийг СЕХ-ноос “Шударга Сонгуулийн Төлөө Иргэний Нийгмийн Хяналт” сүлжээнээс гадна нийт долоон иргэний нийгмийн байгууллагад олгосон байна¹. Ийнхүү 2012 оны УИХ-ын ээлжит сонгууль нь төрийн бус байгууллагууд хамгийн идэвхтэйгээр хөндлөнгийн хяналт тавьж оролцсон сонгууль боллоо. Энэхүү нааштай өөрчлөлт, дэвшил гарахад 2007 онд Нээлттэй Нийгэм Форумын дэмжлэгээр байгуулагдсан “Шударга Сонгуулийн Төлөө Иргэний Нийгмийн Хяналт” сүлжээний гишүүн байгууллагуудын сонгуулийн үйл явцад хийсэн мониторингийн дүгнэлт, зөвлөмж, нөлөөллийн үйл ажиллагаа багагүй хувь нэмэр болсныг дурдах нь зүйтэй юм.

Энэхүү эмхтгэлд Сүлжээний гишүүн байгууллагуудын 2012 оны УИХ-ын сонгуулийн үйл явцад хийсэн мониторингийн тайланг чиглэл тус бүрээр хураангуйлан хургэж байна. Сонгуульд иргэний нийгмийн зүгээс хяналт тавих, мониторинг хийхдээ өмнөх сонгуулиудаар хуримтлуулсан мэдлэг, туршлагад тулгуурлан маргаан гарч болзошгүй гэж үзсэн асуудлуудад гол анхаарал хандуулснаас гадна УИХ-ын сонгуулийн тухай шинэ хуульд туссан сонгуулийн процессыг боловсронгуй, ил тод болгохтой холбоотой зарим чухал заалтын хэрэгжилтийг хянах зорилгыг дэвшүүлсэн болно.

¹ Сонгуулийн Ерөнхий Хорооны 71-р тогтоолыг Хавсралт 1.1-ээс харна уу.



НИЙГМИЙН ДЭВШИЛ
ЭМЭГТҮҮЛҮҮД ХӨДӨӨЛГӨӨН

САНАЛЫН ХУУДАС ХЭВЛЭХ, ХАДГАЛАХ, ХАМГААЛАХ, ХҮРГҮҮЛЭХ, АРХИВТ ШИЛЖҮҮЛЭХ ҮЙЛ ЯВЦЫН ХЯНАЛТ



УИХ-ын сонгуулийн автомат төхөөрөмжийд
унцуулах саналын хуудасны багц,
2012 оны 6 дугаар сарын 20.
Гэрэл зургийг Б.Бямба-Очир

1.1 ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

МОНИТОРИНГИЙН ЗОРИЛГО

Сонгуулийн үндсэн баримт бичиг болох саналын хуудсыг хэвлэх, хадгалах хамгаалах, архивлах үйл явцад хөндлөнгийн ажиглалт хийж, холбогдох мэдээллийг олон нийтэд хүргэх замаар ил тод байдал, хуулийн хэрэгжилтийг хангах, саналын хуудастай холбоотой болзошгүй зөрчлөөс сэргийлэх.

МОНИТОРИНГИЙН ЗОРИЛТУУД

- Саналын хуудсыг хэвлэх, хүргүүлэх, хадгалах хамгаалах, зарцуулах, архивлах үйл явц, үүнтэй холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтэд хөндлөнгийн хяналт тавих;
- Дээрх үйл явцыг баримтжуулах, зөрчилтэй тохиолдлыг тэмдэглэх, бүртгэх;
- Сонгуулийг чөлөөтэй, шударга зохион байгуулахад иргэд, төрийн бус байгууллагын хувь нэмэр, оролцоог нэмэгдүүлэх, чадавхийг дээшлүүлэх зэрэг болно.

Дээрх зорилго, зорилтын хүрээнд мониторингийн үе шатуудад дараах үйл ажиллагааг шат дараатай хэрэгжүүллээ.
Үүнд:

- Сонгуулийн Ерөнхий Хороонд хандан ажиглалт мониторинг хийх зохих зөвшөөрөл авах;
- Сонгуулийн Ерөнхий Хороо болон мониторинг хэрэгжүүлсэн тойрог, хэсгийн хороодод хандан албан хүсэлт гаргах, холбогдох мэдээлэл цуглуулах;

- Саналын хуудсыг хэвлэх үйл явцад ажиглалт хийх сайн дурын ажилтнуудыг сонгон холбогдох хууль тогтоомж, ёс зүйн дүрэм зэргийг танилцуулсан сургалт зохион байгуулах;
- Саналын хуудсыг хүлээн авах, хүлээлгэн өгөх, хадгалах хамгаалах үйл ажиллагаа хэрхэн хийгдэж байгааг ажиглан, мэдээлэл цуглуулах, баримтжуулах;
- Мониторингийн үйл явцын талаарх мэдээллийг олон нийтэд тухай бүр танилцуулах, тайлагнах;
- Саналын хуудасны зарцуулалт, тооцооны талаарх холбогдох баримт бичгүүдэд дүн шинжилгээ хийх, үнэлэх;
- Саналын хуудсыг архивт шилжүүлэн өгөх үйл явц, баримт бичгүүдийг хуулбарлан авах, дүн шинжилгээ хийх;
- Саналын хуудасны мониторингийн эцсийн тайланг боловсруулан хэвлэж, холбогдох байгууллагад хүргүүлэх зэрэг болно.

Саналын хуудасны мониторингийн хүрээнд дараах тодорхой асуудлуудад хяналт тавив. Үүнд:

- Саналын хуудсыг хэвлэх компанийг сонгон шалгаруулсан цыл ажиллагаа
Саналын хуудас хэвлэх компанийг эрх бүхий байгууллага сонгон шалгаруулж, гэрээ байгуулах шийдвэр гаргасан байсан тул зөвхөн уг сонгон шалгаруулалттай холбоотой албан ёсны баримт бичгүүдтэй танилцаж, холбогдох байгууллага, албан тушаалтнуудаас авсан мэдээлэлд дүн шинжилгээ хийлээ.
- Саналын хуудсыг хэвлэх, хүлээлгэн өгөх цыл ажиллагаа
Саналын хуудсыг хэвлэх үйл явц, үйлдвэрийн байранд хүлээлгэн өгөх үйл ажиллагааг хамруулав.

- Саналын хуудсыг хадгалах, хамгаалах үйл ажиллагаа

УИХ-ын сонгуулийн 19 болон 24 дүгээр тойргуудыг сонгон саналын хуудас хүлээн авах, тойрог болон хэсгийн хороонд хүргүүлэх, хүргүүлснээс хойшхи хадгалалт хамгаалалт зэрэг асуудлыг хамруулсан.

- Саналын хуудасны зарцуулалт

Санал авах өдөр буюу 2012 оны 6 дугаар сарын 28-ны өдөр санал авах байр болон зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар санал авахад зарцуулсан, мөн зарцуулаагүй үлдсэн саналын хуудасны тоо, хэсгүүдэд саналын хуудастай холбоотой гарсан зөрчил маргаан, түүнийг шийдвэрлэсэн байдал, саналын хуудасны тоонд гарсан зөрүү зэрэг асуудлуудыг хамрууллаа.

- Саналын хуудсыг архивлах үйл ажиллагаа

19 болон 24 дүгээр тойргийн хороо харьяа хэсгийн хороодоос хүлээн авсан саналын хуудас, бусад холбогдох баримт бичгийг архивт хүлээлгэн өгөх үйл ажиллагаанд ажиглалт хийсэн болно.

МОНИТОРИНГИЙН ХУГАЦАА БА ХАМРАХ ХҮРЭЭ

“Саналын хуудасны мониторинг” нь нийт 4 сарын хугацаанд хэрэгжсэн бөгөөд 5 дугаар сарын 01-нээс 8 дугаар сарын 31 хүртлэх хугацааг хамарсан болно. Энэ хугацаанд мониторингийн асуудал тус бүрийн хүрээнд ажиглалт явуулж, мэдээлэл цуглувуулан дун шинжилгээ хийн тухай бүрт нь олон нийтэд мэдээлж байлаа. Төслийн тайлан нь саналын хуудас хэвлэснээс эхлээд сонгуулийн албан ёсны дун гарч, сонгуулийн баримт бичгүүд архивт шилжүүлэн өгөх үйл явц зэргийг бүхэлд нь багтаасан болно.

МОНИТОРИНГИЙН АРГАЧЛАЛ

Саналын хуудасны мониторингийг хэрэгжүүлэхдээ төслийн багаас мониторингийн асуудал, үе шат бүрт тохирох шалгах хуудас, удирдамж, шалгах асуулт зэргийг боловсруулан түүний дагуу мэдээлэл, баримт цуглувуулан, дун шинжилгээ хийх замаар тайлан боловсруулж олон нийтэд танилцууллаа. Саналын хуудасны мониторингийг УИХ-ын сонгуулийн 19-р болон 24-р тойротг тус тус хийв. Мониторингийн үе шат болон сонгуулийн үйл явц, онцлогоос хамааран дараах арга, аргачлалыг ашигласан.

Ажиглалтын арга	Сонгуулийн саналын хуудас хэвлэх, хүлээлгэн өгөх, хүргүүлэх, саналын хуудас архивлах үйл ажиллагааг ажигласан. Саналын хуудсыг хэвлэх үйл ажиллагааг эхлэхээс дуусах хүртэл өдөр бүр 24 цагийн турш сайн дурынхны тусламжтайгаар ажигласан.
Контент анализ (баримт бичиг судлах арга)	Хууль, эрх зүйн баримт бичгүүд, сонгуулийн хороодын тогтоол, шийдвэр, журам, тайлан гэх мэт.
Ярилцлагын арга	Мониторингийн нэмэлт мэдээлэл, жишээ кейс цуглувулах зорилгоор гол оролцогч болон холбогдох талуудаас мэдээлэл авах.
Баримтжуулах аргууд	Дүрс бичлэг хийх, фото зураг авах, дуу хураагчид бичлэг хийх, ажиглалтын маягт хөтлөх, бичмэл баримтуудыг хуулбарлан авах гэх мэт.

Саналын хуудас хэвлэх үйл явцад зураг авах, дүрс бичлэг хийх, гар утас ашиглахыг СЕХ-ноос хориглосон тул үйлдвэрийн байранд өрнөсөн үйл явцыг зөвхөн шалгах хуудаст бүртгэх, дэлгэрэнгүй тэмдэглэх байдлаар баримтжуулсан болно.

1.2 ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 9.5-д төрийн бус байгууллага нь сонгуулийн үйл ажиллагаанд ажиглалт, хяналт шинжилгээ хийх, байгууллагын үйл ажиллагааны хүрээнд иргэдэд мэдээлэл өгөх, сонгох эрхээ эдлэхэд нь хуулийн дагуу аргачилсан туслалцаа үзүүлэх боломжтой гэж заасан нь өмнөх сонгуулиудаар иргэний нийгмийн зүгээс саналын хуудастай холбоотой үйл явцыг хянахад тулгардаг байсан гол бэрхшээл болох хаалттай байдлыг шийдвэрлэхэд эхний чухал алхам болсон юм. Хуулийн заалтыг хэрэгжүүлэхэд чиглэсэн дагалдах эрх зүйн баримт бичгийг Сонгуулийн Ерөнхий Хороо боловсруулж баталсан ба түүнд сонгуульд мониторинг хийх зөвшөөрөл авсан төрийн бус байгууллага “саналын хуудас хэвлэх, хадгалалт хамгаалалт, тээвэрлэлт, аюулгүй байдал, битүүмжлэн хадгалах ажиллагаанд хяналт тавих” эрхтэй гэж тусгасан байв.

Сонгуулийн саналын хуудас нь сонгогчдын саналыг авах, дүн гаргах үндсэн баримт болохын хувьд тусгай нууцлалтай байх бөгөөд хуульд заасан шаардлагыг хангасан байх, түүнтэй холбогдон гарах зардлыг улсын төсвөөс санхүүжүүлэх тухай ерөнхий зохицуулалтыг УИХ-ын сонгуулийн тухай хуульд тусгасан байна.

УИХ-ЫН СОНГУУЛИЙН ТУХАЙ ХУУЛИАС...

- 42.1. Саналын хуудас нь ... дараах шаардлагыг хангасан байна:
 - 42.1.1. агуулга, бичилт, хэлбэрийн хувьд сонгогчдод саналаа илэрхийлэхэд хялбар, ойлгомжтой байх;
 - 42.1.2. сонгогч саналаа хэрхэн тэмдэглэх тухай товч заавар агуулсан байх.
- 42.2. Саналын хуудас нь тусгай нууцлалтай, нэгдсэн таних нууц тэмдэгтэй байна.
- 42.9. Саналын хуудасны загвар, тоо, түүнийг хэвлүүлэх, хадгалах, хүргүүлэх, хамгаалах журмыг Сонгуулийн Ерөнхий Хороо батална.
- 10.1. Сонгууль зохион байгуулахтай холбогдсон дор дурдсан зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ:
 - 10.1.1 ...саналын хуудас ... хэвлэх ... хамгаалах, хадгалах, ... тээвэрлэх, хүргэх зардал;

Саналын хуудсыг хэвлэх, хадгалах, хамгаалах, зарцуулах, архивлах үйл ажиллагаа нь УИХ-ын сонгуулийн тухай хууль, Сонгуулийн төв байгууллагын тухай хууль болон түүнтэй нийцүүлэн баталсан СЕХ-ны журам, загвар, маягтуудын хүрээнд хамаарна. Сонгуулийн саналын хуудасны загварыг батлах, хэвлүүлэх, хуваарилах ажил нь Сонгуулийн төв байгууллагын бүрэн эрхэд хамаарах асуудал тул СЕХ-ны журмаар нарийвчлан зохицуулдаг. Үүнийг тодорхой үе шатуудаар задлан танилцуулбал:

A. Саналын хуудас хэвлэх компанийг сонгон шалгаруулах цүл ажиллагааны хуулийн зохицуулалт

СЕХ-НЫ 59 ТООТ ТОГТООЛООС

3.4. Саналын хуудас хэвлэх үйлдвэрийг түүний хүчин чадал, техник, технологийг судалсан тухай санал авах, тоолох, дүн гаргах техник, тоног төхөрөмж нийлүүлэгч компанийн дүгнэлтийг үндэслэн сонгож, гэрээ байгуулна. Гэрээнд хэвлүүлэх саналын хуудасны тоо ширхэг, үнэ ... саналын хуудасны тоо, чанар, баглаа боодол, хадгалах, хамгаалах, хяналт тавих, хүлээн авах, талуудын эрх, үүрэг, хариуцлага зэрэг асуудлыг тусгана.

3.5. Саналын хуудасны хэвлэлийн эхийг Сонгуулийн Ерөнхий Хорооноос баталсан загварын дагуу бэлтгэнэ. Түүний Сонгуулийн Ерөнхий Хорооны нарийн бичгийн дарга хянан баталгаажуулж, хэвлэх зөвшөөрөл олгоно.

СЕХ-ны 59 тоот тогтоолын дагуу сонгуулийн автомат төхөрөөмж нийлүүлэгч АНУ-ын Доминион Вөүтинг Системс (Dominion Voting Systems) компанийн санал, дүгнэлтэд тулгуурлан саналын хуудас хэвлэх компанийг сонгон шалгаруулж гэрээ хийжээ. Өөрөөр хэлбэл, тус компани Монголын дотоодын хэвлэлийн компаниудын чадавхийг тодорхой шалгуурын дагуу үнэлж дүгнэлт гаргасан бөгөөд тухайн үнэлгээ, санал нь саналын хуудас хэвлэх компанийг сонгон гэрээ байгуулах үндэслэл болсон байна. Гэрээнд саналын хуудасны тоо ширхэг, чанар, баглаа боодол, хадгалах хамгаалах, хяналт тавих, хүлээн авах талуудын эрх, үүрэг хариуцлага зэрэг асуудлыг тусгахаар дээр дурдсан журамд заасан болно.

B. Саналын хуудсыг хэвлэх, хадгалах, хүргүүлэх цүл ажиллагааны хуулийн зохицуулалт

УИХ-ын сонгуулийн саналын хуудсыг хэвлэх, хадгалах хамгаалах, хуваарилах зэрэг үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар ханган чиглүүлэх нь бүхэлдээ СЕХ-ны Үүрэг бөгөөд СЕХ-ноос тусгай ажлын хэсэг байгуулагдан зохион байгуулахаар хуульд заажээ. Энэ хэсгийг СЕХ-ны Улсын Их Хурлын сонгуулийн саналын хуудсыг хэвлүүлэх, хадгалах, хүргүүлэх, хамгаалах тухай 59 тоот журамд мөн зааж зохицуулсан. Уг журмаар сонгуулийн саналын хуудас хэвлэх, боож баглах, хүлээлгэн өгөх зэрэг үйл явцад СЕХ-ны ажлын хэсгийн гишүүд болон сонгуулийн үйл явцад хяналт, мониторинг хийж буй ТББ, улстөрийн нам, эвсэл, нэр дэвшигчийн ажиглагчид хөндлөнгөөс ажиглах боломжийг бүрдүүлж өгсөн. Мөн илүү хэвлэсэн болон буруу хэвлэсэн, алдаатай гологдол саналын хуудсыг устгах зэрэг үйл ажиллагаанд ТББ ажиглалт хийх боломжтой болсон.

СЕХ-НЫ 59 ТООТ ТОГТООЛООС ...

3.7. Саналын хуудасны эх бэлтгэл, хэвлэх, боож баглах, хүлээлцэх явцад хэвлэх үйлдвэрийн ажилчдаас гадна Ажлын хэсгийн гишүүд, нам, эвсэл, төрийн бус байгууллагын ажиглагч, харуул, хамгаалалтын ажилтнаас өөр хүн байхыг хориглоно.

3.12. Саналын хуудсыг хэвлүүлж дууссаны дараахэвлэлийн явцад гарсан гологдол саналын хуудсыг устгах ажлыг талууд хамтран зохион байгуулж тэмдэглэл үйлдэнэ. Уг ажиллагаанд нам, эвслийн болон төрийн бус байгууллагын ажиглагчид байлцаж болно.

УИХ-ЫН СОНГУУЛИЙН ТУХАЙ ХУУЛИАС ...

46.11.... саналын хуудсыг аймаг, нийслэлийн архивт нууцын журмаар хадгалах бөгөөд битүүмжилсэн саналын хуудасны баглаа боодлыг хууль, журамд зааснаас бусад тохиолдолд задлах, устгахыг хориглоно.

СЕХ-НЫ 59 ТООТ ТОГТООЛООС

- 3.13. Саналын хуудасны хэвлэлийн эх, компьютерийн файлыг Сонгуулийн ерөнхий хороо сонгууль дуустал хадгалж, архивт зохих журмын дагуу хүлээлгэн өгнө.
- 6.1. Зөөврүйн битүүмжилсэн хайрцгаар санал авах үед болон санал хураах өдөр хэрэглэсэн саналын хуудасны зарцуулалтад тойрог, салбар, хэсгийн хороо, ажиглагчид хяналт тавина.
- 7.1. Тойргийн хороо саналын хуудсыг баримтын дагуу аймаг, нийслэлийн архивт тэмдэглэл үйлдэн хүлээлгэн өгч, дараагийн ээлжит сонгууль хүртэлх хугацаагаар хадгалуулна.
- 7.2. Аймаг, нийслэлийн архив нь битүүмжилсэн саналын хуудсыг нууцын журмаар хадгалах бөгөөд битүүмжилсэн саналын хуудасны баглаа, боодлыг задлах, устгахыг хориглоно.

B. Саналын хуудасны зарцуулалт ба архивлах үйл ажиллагааны хуулийн зохицуулалт

Саналын хуудсыг хэсгийн хороод хүлээн авснаар зарцуулалт, архивлах үйл ажиллагааг хэрхэн гүйцэтгэснээ тайлагнах нь сонгуулийн үеэр түр хугацаанд байгуулагдан ажилладаг Тойргийн болон Хэстийн хороодын үүрэг болно. Тойргийн хороо нь санал хураалт дууссаны дараа хэсэг, салбар хорооноос ирүүлсэн саналын хуудасны зарцуулалтын тайланг нэгтгэж тойргийн нэгдсэн тайланг сонгуулийн хэсэг тус бүрээр гарган СЕХ-нд өгдөг. Тухайн тойргийн хэмжээнд сонгуулийн дүн гарсны дараа зарцуулсан болон үлдэгдэл саналын хуудсыг битүүмжлэн, бусад баримт бичгийн хамт Тойргийн хороо нь аймаг, дүүргийн архивын газарт хүлээлгэн өгдөг. Аймаг нийслэлийн архивын газар нь тухайн баримт бичгийг хүлээн авснаас хойш түүний бүрэн эрхэд шилжих бөгөөд ингэхдээ хууль тогтоомжид заасны дагуу дараагийн ээлжит сонгууль хүртэлх хугацаанд хадгална.

1.3 МОНИТОРИНГИЙН ДҮН

УИХ-ЫН СОНГУУЛИЙН САНАЛЫН ХУУДАС ХЭВЛЭХ КОМПАНИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

УИХ-ын сонгуулийн саналын хуудас хэвлэх хэвлэлийн компанийг хэрхэн сонгон шалгаруулсан, үүнд ямар шалгуур үзүүлэлтийг харгалзан үзсэн болохыг уг асуудалд хамаарах хууль, эрх зүйн орчинтой нь холбон дүн шинжилгээ хийлээ. Хэвлэлийн компанийг сонгох ажлыг 2012 оны 2-3 дугаар саруудад зохион байгуулсан байсан бөгөөд мониторингийн багийн хувьд ажлаа 5 дугаар сард эхэлсэнтэй холбоотой сонгон шалгаруулалтын процесст шууд ажиглалт, мониторинг хийх боломжгүй байв. Харин уг үйл ажиллагааг хэрхэн зохион байгуулсан талаар мэдээлэл цуглуулан, албан ёсны баримт бичгүүдийг хуулбарлан авч, зарим оролцогч талуудтай уулзаж ярилцсан мэдээлэлд үндэслэн шинжилгээ хийсэн юм.

Юуны өмнө мониторингийн багаас шаардсан зарим мэдээллийг СЕХ өгөхөөс татгалзсан тул бүрэн дүн шинжилгээ хийхэд бэрхшээлтэй байлаа. Тухайлбал, УИХ-ын сонгуулийн саналын хуудас хэвлэх цаас худалдан авах, саналын хуудсыг хэвлэх аж ахуйн нэгжийг сонгон шалгаруулах, гэрээ байгуулах үйл явц нь Хорооны дотоод ажил хэрэгт хамаатай, төрийн аудитын хяналтад байдаг асуудал хэмээн СЕХ² тайлбарлан шалгарсан

компанитай байгуулсан гэрээ, гэрээний үнийн дүн зэрэг мэдээлэлтэй танилцах боломж олгоогүй болно.

Сонгон шалгаруулах үйл ажиллагааг Монгол Улсад сонгуулийн автомат төхөөрөмж нийлүүлж буй АНУ-ын ДВС компани Монголын хэвлэлийн компаниудын дунд 2012 оны 2-3 сарын хооронд зохион байгуулжээ. Уг сонгон шалгаруулалт 3 үе шаттайгаар хийгдсэн байна. Сонгон шалгаруулалтын нэг дэх шатанд оролцсон хэвлэлийн компаниудаас 3 нь шалгарсан байна. Эдгээрт Адмон ХХК, Мөнхийн Үсэг ХХК болон Үндэсний үнэт цаас ХХК-ууд багтсан аж. ДВС компани нь дээрх гурван хэвлэлийн компанийн дунд хоёр болон гуравдах шатны сонгон шалгаруулалтыг 20 орчим шалгуур үзүүлэлтэд тулгуурлан үргэлжлүүлэн хийсний эцэст Мөнхийн Үсэг ХХК-ийг сонгон, улмаар 2012 оны 2 дугаар сарын 29 болон 3 дугаар сарын 20-ны өдрийн албан бичгүүдээр Сонгуулийн Ерөнхий Хороонд уг компанийт саналын хуудас хэвлүүлэх гэрээ хийх саналаа илэрхийлжээ.

ДВС компанийн зүгээс сонгон шалгаруулалтыг явуулахдаа оролцогч хэвлэлийн үйлдвэрүүдтэй биеэр очиж танилцах, удирдлагуудтай нь уулзах, хэвлэлийн төхөөрөмжүүдийг шалгаж үзэх зэргээр ажилласан байв. Анхан шатны шаардлагыг хангасан дээрх хэвлэлийн үйлдвэр бурт сонгон шалгаруулалтын шаардлагуудыг нарийвчлан танилцуулах зорилго бүхий хагас өдрийн сургалт зохион байгуулж тус бүр 6000 ширхэг, нийт 18000 ширхэг туршилтын саналын хуудас хэвлүүлж тест хийсэн байна. Улмаар хоёр дахь шатны сонгон шалгаруулалтад оролцсон 3 хэвлэлийн компанийд нэгэн адил шалгуураар үнэлгээ хийсэн байх бөгөөд үүнд:

² Сонгуулийн Ерөнхий Хорооны 2012 оны 5 дугаар сарын 26-ны өдрийн 279 тоот албан бичгийг Хавсралт 1.2-oos харна уу.

- Хэвлэлийн компаниудын үйлдвэрлэлийн байгууламжууд:
 - Үйл ажиллагаа;
 - Сонгуулийн саналын хуудас; хэвлэж байсан туршлага;
 - Үйлдвэрийн талбай;
 - Цэвэр байдал;
 - Чанарын удирдлага/хяналтын талбай;
 - Багалтын талбай;
 - Хаягдлыг устгах зайлцуулах;
 - Саналын хуудсыг шалгах талбайны боломж;
 - Нэмэлт цахилгаан эх үүсвэр;
 - Машины зогсоол;
 - Байгууламж доторх агуулах;
 - Агуулахын хамгаалалт;
 - Хоёрдогч нэмэлт хэвлэлийн үйлдвэр.
- Үйлдвэрлэлийн төхөөрөмж:
 - Хэвлэх даралтын өмнө ашиглагдах төхөөрөмжүүд;
 - 4 өнгийн хэвлэлийн машинууд;
 - Зүсэлтийн машинууд;
 - Гялгар уутаар баглах төхөөрөмжүүд;
 - Үндсэн байгууламжаас гадуур байрлах нөөц төхөөрөмжүүд гэсэн шалгуур үзүүлэлтээр үнэлгээ хийжээ.

Дээрх үзүүлэлтээр сүүлийн шатны сонгон шалгаруулалт хийгдэж дуусахад ДВС нь Сонгуулийн Ерөнхий Хороонд саналын хуудас хэвлэх компанийг сонгох талаар өөрсдийн саналаа гаргасан. Түүнд дараах тодорхой үндэслэлүүдийг дурдсан байна:

Бидний гаргасан техникийн үнэлгээн дээр тайлбарласны дагуу, Мөнхийн Үсэг ХХК нь үнэлгээнд хамрагдсан байгууллагуудаас хамгийн сайн нь байсан бөгөөд уг компанийн олон тооны хэвлэх

төхөөрөмжүүд, чанарын удирдлагын болон саналын хуудас шалгах талбай, нэгтгэсэн агуулах зэрэг нь шаардлагатай саналын хуудсуудыг хурдан бөгөөд баталгаатайгаар хэвлэх боломжийг бурдуулж чадна гэж үзэж байна. Мөнхийн Үсэг ХХК нь саналын хуудас хэвлэлтийн эрсдлийг арилгах нөхцлийг үнэлгээнд хамрагдсан байгууллагуудаас хамгийн сайн бурдуулсэн нь байсан бөгөөд уг компани нь төв үйлдвэр дээрээ дизель хөдөлгүүрт нөөц эрчим хүчний үүсгүүр системтэй, мөн бие даасан хоёрдахь хэвлэх үйлдвэртэй юм. Мөнхийн Үсэг компанийн хэвлэсэн баталгаажуулах саналын хуудсууд нь үнэлгээнд хамрагдсан гурван байгууллага дундаас илт сайн нь байсан.

Үүнээс харвал ДВС нь саналын хуудсыг хэвлэх явцад гарах эрсдэл, аюулгүй байдлыг хангах боломж, хэвлэх явц дахь хадгалалт хамгаалалтын найдвартай байдлыг гол шалгуур болгон шийдвэр гаргажээ. Мөн саналын хуудас хэвлэх үйл явцын шат дамжлага болон тэдгээрт ажилчид чөлөөтэй ажиллах боломж нөхцөл, аюулгүй ажиллагаа зэргийг харгалзан үзсэн болох нь харагдаж байна. Түүнчлэн сонгуулийн саналын хуудас хэвлэж байсан туршлага, үйлдвэрийн талбай, цэвэр байдал, багалтын талбай, хаягдлыг устгах зайлцуулах, нэмэлт цахилгаан эх үүсвэр, машины зогсоол, агуулах, үйлдвэрлэлийн төхөөрөмжүүд зэрэг шалгуурыг авч үзсэн байх бөгөөд эдгээрээс дээрх шаардлага нөхцлийг хамгийн сайн хангасан хэмээн үзэж Мөнхийн Үсэг ХХК-ийг сонгон саналын хуудсыг хэвлүүлэх санал, дүгнэлтийг гаргасан болохоо тайлбарласан байdag.

Мөн ДВС-ийн саналд: “Адмон ХХК болон Үндэсний Үнэт Цаас компанийдад үнэлгээнд оролцсон явдалд талархаж байгаа бөгөөд тухайн байгууллагуудын тохиромжтой цаг үед нь бид бүхэн өөрсдийн дэвшүүлсэн саналын

шалтгааныг тайлбарлахад бэлэн байна” гэжээ. Гэвч сонгон шалгаруулалт хэрхэн явагдсан, ямар шалгууруудад үндэслэсэн, гэрээний нөхцөл, шаардлага ямар байсан талаарх мэдээлэл оролцогч талуудад хангалтгүй байсан. Тухайлбал, мониторингийн багийн зүгээс сүүлийн шатны шалгаруулалтад оролцсон хэвлэлийн компанийн удирдлагатай (Адмон ХХК болон Мөнхий Үсэг групп) уулзаж ярилцахад Адмон ХХК-ий зүгээс сонгон шалгаруулалтын дүн, түүнтэй холбоотой СЕХ-ны шийдвэрийн талаар СЕХ-нд хандан тайлбар авахаар албан хүсэлт явуулсан хэдий ч ямар нэгэн хариу ирээгүй гэж байв. ДВС компанийн хувьд хариуцан гүйцэтгэсэн сонгон шалгаруулалтынхаа талаар мэдээлэл өгөх, Монголын хуулийн этгээд, хувь хүнтэй бие даан харилцахаас татгалзаж, СЕХ-гоор дамжуулах, эсвэл шууд СЕХ-той харилцаж мэдээлэл авахыг зөвлөж байсан бөгөөд үүнийхээ шалтгааныг ДВС нь СЕХ-ны хүсэлт шаардлага, захиалгын дагуу ажиллаж байгаатай холбоотой гэж тайлбарласан юм.

Сонгуулийн Ерөнхий Хорооны 59 тоот тогтоолын 3.4 дэх хэсэгт заасны дагуу сонгуулийн автоматжуулсан хэрэгсэл, тоног төхөөрөмж нийлүүлэгч компанийн санал, дүгнэлтийг үндэслэл болгон 2012 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн тогтоолоор Улсын Их Хурлын сонгуулийн саналын хуудсыг Мөнхийн Үсэг ХХК-аар хэвлүүлэхээр СЕХ гэрээ байгуулах шийдвэр гаргажээ. УИХ-ын сонгуулийн тухай хуулийн 19.15-д “Сонгуулийн Ерөнхий Хороо ... хуваарилагдсан төсвийн хөрөнгийн хэмжээнд сонгуулийг зохион байгуулахтай холбогдуулан хувь хүн, хуулийн этгээдтэй сонгон шалгаруулалтгүйгээр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах гэрээ байгуулах ба энэхүү үйл ажиллагаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай

хуулийн зохицуулалтад хамаарахгүй” гэжээ. СЕХ-ны Улсын Их Хурлын сонгуулийн саналын хуудсыг хэвлүүлэх, хадгалах, хамгаалах, хүргүүлэх журмын 3.4 дэх хэсэгт “Саналын хуудас хэвлэх цийлдвэрийг түүний хүчин чадал, техник, технологийг судалсан тухай санал авах, тоолох, дүн гаргах техник, тоног төхөөрөмж нийлүүлэгч компанийн дүгнэлтийг үндэслэн сонгож, гэрээ байгуулна” гэж заасан. Эдгээр зохицуулалтын дагуу сонгуулийн саналын хуудас хэвлэх компанийг сонгон гэрээ байгуулахдаа зөвхөн ДВС компанийн үнэлгээ дүгнэлтэд тулгуурлан СЕХ шууд гэрээ хийх тухай шийдвэрийг гаргах боломжтой байна. Ийнхүү хуулиар ямар нэгэн сонгон шалгаруулалтгүйгээр шууд худалдан авах эрх олгосон нь “Худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломж, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх” зэрэг асуудлыг харгалзан үзэх боломжгүйд хүргэж байна.

Түүнчлэн Мөнхийн Үсэг группийг сонгон шалгаруулж сонгуулийн саналын хуудсыг хэвлүүлэх хариуцлагатай ажлыг гүйцэтгүүлэх шийдвэр гарсны дараа Мөнхийн Үсэг группийн Удирдах Зөвлөлийн дарга нь УИХ-ын сонгуульд МАН-аас намын жагсаалтад бичигдэн нэр дэвшин өрсөлдсөн нь сонгуульд оролцож буй талуудын сонгуулийн үйл явцад итгэх итгэл буурах, хардлага сэрглэг үүсэх нөхцлийг бий болгосон. Цаашид саналын хуудсыг хэвлэх компанийг сонгон шалгаруулах шалгуур үзүүлэлтийг нь зөвхөн техникийн үзүүлэлтээр хязгаарлах бус саналын хуудас үйлдвэрлэх хуулийн этгээд нь улстөрийн хувьд хараат бус байх, сонирхлын зөрчлөөс ангид байх шалгууруудыг мөн давхар харгалзан үзэх нь зүйтэй гэж үзэж байна.

САНАЛЫН ХУУДАС ХЭВЛЭХ, САВЛАХ, ХҮЛЭЭЛГЭН ӨГӨХ ЗЭРЭГ ХЭВЛЭХ ҮЙЛДВЭРТ ХИЙГДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА, ЭНЭ ЯВЦАД ТУЛГАРСАН ЗАРИМ АСУУДАЛ

УИХ-ын сонгуулийн саналын хуудас хэвлэх үйл ажиллагаа нь 2012 оны 6 дугаар сарын 10-ны өдрөөс эхлэн арван өдрийн хугацаанд 24 цагийн турш тасралтгүй явагдсан. Мөнхийн Үсэг хэвлэлийн компани нь Сонгуулийн Ерөнхий Хорооны захиалсан тоо ширхэгийн дагуу саналын хуудас хэвлэж 6 дугаар сарын 19 гэхэд СЕХ болон Тойргийн хороодод хүлээлгэн өгч дууссан. Саналын хуудсыг хэвлэх үйл явц нь ажиглагчдад нээлттэй байж, мэдээлэл авах боломжийг үйлдвэрийн дотоод журмын хүрээнд хангаж ажилласан боловч мониторингийн төлөвлөсөн үр дүнд хүрэхүйц байгаагүй.

2012 оны УИХ-ын болон НИТХ-ын сонгуульд хэрэглэхээр хэвлэсэн саналын хуудасны тоо ширхэг болон тэдгээрийн харьцааг График 1-ээс харна уу.



2012 оны УИХ-ын сонгуулиар улсын хэмжээнд 26 тойргийн 1,935,329 ширхэг саналын хуудас хэвлэсэн. Үүнээс орон

нутагт 55.77, нийслэлд 43.98, гадаадад байгаа сонгогчдын санал авахад 0.23 хувийг тус зарцуулсан байна.

Сонгуулийн тухай хууль тогтоомжоор саналын хуудсыг 5 хувийн нөөцтэй хэвлэдэг бөгөөд энэ удаагийн сонгуулиар орон нутагт 1,028,082 сонгогч, нийслэлд 810,767 сонгогч, гадаад улсад амьдарч буй саналаа өгөхөөр бүртгүүлсэн 4,329 сонгогч, нийт дүнгээр 1,843,178 сонгогч нэрийн жагсаалтад бүртгүүлж, үүнээс 5 хувийн нөөцтэй байх шаардлагад нийцүүлэн хэвлэх тоог тогтоосон байна.

Мөн энэ удаагийн сонгуульд хэрэглэх саналын хуудас нь тойрог бүрээр ялгарах тойргийн дугаар болон саналын хуудасны индекстэй бөгөөд УИХ-ын болон НИТХ-ын сонгуулийг хамтад зохион байгуулж байгаа тул нийслэлд хэрэглэсэн саналын хуудсыг хоёр талдаа өөр өөр индексийн дугаартайгаар хэвлэсэн. Саналын хуудасны эдгээр дугаар индекс нь тухайн нэг тойргийн саналын хуудсыг өөр тойротгот ашиглаж санал өгөхөөс сэргийлэх боломжийг бүрдүүлэх нэг арга зам болно.

Хэвлэх үйлдвэрт дараах шат дамжлагаар саналын хуудас хэвлэх үйл явцыг зохион байгуулсан.

Үйлдвэрийн байранд саналын хуудас хэвлэх цийн шат дамжлага

- Саналын хуудасны эх файлыг компьютерт тулган шалгах, хавтан шарах:** Үйлдвэрийн компьютер дэх саналын хуудасны эх файлыг Сонгуулийн Ерөнхий Хорооны хэвлэсэн саналын хуудасны эхтэй тулган шалгаж, саналын хуудасны эх хавтанг шарж, хэвлэлтэд бэлэн болгоно. Тухайн үйл ажиллагаанд улстөрийн намуудын төлөөлөл болон иргэний нийгмийн байгууллагын ажиглагчид байлцан хяналт тавьсан.
- Хайрцагтай цаасыг задлах, хэвлэлтэд бэлтгэх:** Хайрцагны боодол

- битүүмжлэлийг задалж, саналын хуудас хэвлэхэд бэлтгэн хэмжээг нь хэвлэх машинд тааруулан зүсэлт хийнэ.
3. **Хэвлэхээс өмнө гараар шалгах:** Хэвлэлд тааруулан зүссэн цаасыг үйлдвэрийн ажилтан шалгана. Энэ нь хэвлэх машинд оруулахаас өмнө үйлдвэрийн гологдол байгаа эсэхийг шалгах үйл явц юм. Үүний дараа хэвлэх хэсэг рүү хургуулнэ.
 4. **Саналын хуудас хэвлэх:** Хэвлэх машинаас гарсан эхний даралтыг СЕХ-ны бэлтгэсэн саналын хуудасны эхтэй таарч байгаа эсэхийг няягтлан шалгана. Үүнийг СЕХ-ны ажлын хэсэг няягтлан шалгадаг. Үүний дараа саналын хуудсыг үргэлжлүүлэн хэвлэнэ. Хэвлэлээс гарсан саналын хуудсыг шилжүүлэн зөөнө (үйлдвэрийн ажилтнаас өөр хүн очихыг хориглож тусгаарласан үйлдвэрлэлийн талбайн өөр нэг бүсэд).
 5. **Хөргөлт:** Саналын хуудсыг хэвлэсний дараа үйлдвэрийн өөр хэсэг рүү зөөж, 1 цагийн турш хэвлэлийн будгийг хөргөнө.
 6. **Зүсэлтээс өмнө хэвлэсэн цаасыг гараар тоолох:** Хэвлэсний дараа гараар тоолох хэсэгт тоолж, гологдол гарсан эсэхийг шалгаж, гологдол байгаа бол ялгана. Гараар тоолсон даралтуудыг 200 ширхэгээр багцална.
 7. **Жин хэмжигчээр дахин тоолж баталгаажуулах:** Гараар тоолж 200 ширхэгээр багцалсны дараа дахин жин хэмжигчээр тоолдог. Гараар тоолсон 200 ширхэг цаас бүхий багцыг баталгаажуулах байдлаар тухайн тооллогыг хийнэ.
 8. **Саналын хуудас болгож зүсэлт хийх:** Зүсэлтийн хэсэгт тухайн тойргоосоо хамааран нэг даралтаас 8 эсвэл 9 ширхэг саналын хуудас зүсэгдэж гарна. Цаасыг босоогоор хэвлэсэн бол 9 ширхэг (тус бүр 3 ширхэгтэй 3 эгнээ), хэвтээгээр нь хэвлэсэн бол 8 ширхэг (тус бүр 4 ширхэгтэй 2 эгнээ) саналын хуудас хэвлэнэ. Зүсэлтээс гарсан саналын хуудас багцлах, тоолох хэсэгт шилжинэ.
 9. **Гараар тоолж 200 ширхэгээр багцлах:** Зүсэлтээс гарсан саналын хуудсыг гараар тоолж 200 ширхэгээр багцална. Гэхдээ гараар тоолохын өмнө гологдол байгаа эсэхийг дахин шалгана.
 10. **Тунгалаг гялгар цаасаар вакуумдах:** Тооллогоос 200 ширхэгээр багцлагдсан саналын хуудсыг гялгар уутаар бүрж битүүмжлэн вакуумдана. Энэ нь саналын хуудсыг хайрцагт савлахад бэлэн болж байна гэсэн уг юм.
 11. **Хайрцаглах, хаяг наах:** Тунгалаг гялгар уутаар вакуумдсан багцуудын битүүмжлэлийг шалгана. Хайрцаг бүрт 200 ширхэг бүхий багц б ширхэг байх бөгөөд нийтдээ 1200 ширхэг саналын хуудас савлана. Хайрцагны гаднах гурван тал бүрт тойрог болон саналын хуудасны нийт тоо, жин, хайрцагны дугаар зэрэг мэдээлэл бүхий хаягийг нааж хайрцагны амсрыг улаан өнгийн туузан скочоор наана (үүнийгээ нэг удаагийн туузан лац гэж нэрлэж байсан, учир нь скочийг хуулсан тохиолдолд улаан өнгө гадаргуу дээр нь үлдэж задалсан нь мэдэгдэнэ). Эцэст нь хайрцагны гадуур 2 удаа цагаан өнгийн нарийн туузаар ороноо. Үүний дараа тухайн саналын хуудсыг тойрогт хүргэхэд бэлэн болно.

Саналын хуудас хэвлэх үйл явцад зохион байтуулалттай холбоотой дараах асуудлууд үүссэн нь хэвлэлтийн үйл явцыг удаашруулах зэргээр сөрөг нөлөө үзүүлсэн. Үүнд:

1) Нийслэлийн сонгогчдын тоо 5526-аар нэмэгдсэн³.

2012 оны 6 дугаар сарын 13-ны өдөр буюу саналын хуудас хэвлэж байх явцад Нийслэлийн сонгогчдын тоо 5526-аар нэмэгдсэн ба үүнтэй холбоотой нийт хэвлэх саналын хуудасны тоо ширхэгт өөрчлөлт орж нэмэгдсэн. Ийнхүү сонгогчдын тоо өөрчлөгдөх болсон шалтгааныг Иргэний бүртгэлийн байгууллага тайлбарлахдаа саналын хуудасны тоо ширхэгийг баталсны дараа урьдчилан хорих газарт саатуулагдсан сонгогчид болон цэргийн анги, нэгжүүд дэх сонгогчдын тоонд гарсан өөрчлөлттэй холбоотой гэжээ. Сонгогчдын нэрийн жагсаалт хэсгийн хороодод ирснээс хойш 2 төрлийн тулган шалгалт хийгддэг. Цаг хугацааны хувьд хэсгийн хороодод хийгдэх дээрх хоёр төрлийн тулгалт нь саналын хуудас хэвлэж эхэлснээс хойш хийгдсэн тул ийнхүү саналын хуудасны тоог нэмж хэвлэх асуудал тулгарсан байна. Энэ нь саналын хуудас хэвлэх үйл явцыг төлөвлөгөөний дагуу цаг хугацаанд нь багтаан явуулахад бэрхшээл учруулсан.

2) Саналын хуудсыг олон тоогоор дахин хэвлэсэн.

Зарим тойргийн саналын хуудаст хүний үсний ширхэг наалдан хэвлэгдсэн. Эдгээр саналын хуудсыг ашиглах боломжгүй гэж ДВС үзсэн тул дахин хэвлэсэн билээ. Тодруулбал,

- Орхон аймагт 12,067 ширхэг саналын хуудсыг ашиглах боломжгүй болсон нь тухайн тойргийн саналын хуудасны 17.5 хувийг эзэлж байна. Эдгээр саналын хуудсыг дахин хэвлэсэн хэмээн мэдээлсэн хэдий ч дахин хэвлэхэд зарцуулсан цаасны тоо зэрэг мэдээллийг ажиглагчдад өгөөгүй.

- Сэлэнгэ аймаг 10,227 ширхэг саналын хуудсыг ашиглах боломжгүй болсон нь тойргийн нийт саналын хуудасны 14 хувь юм. Эдгээр саналын хуудсыг дахин хэвлэсэн хэмээн мэдээлсэн хэдий ч дахин хэвлэхэд зарцуулсан цаасны тоо зэрэг мэдээллийг ажиглагчдад мөн өгөөгүй.
- Дорнод аймаг 6,052 ширхэг саналын хуудас хүчингүй болсон нь тойргийн саналын хуудасны 11.6 хувь болж байна. Тухайн саналын хуудсыг дахин хэвлэхэд 772 ширхэг цаас ашигласан бөгөөд үүний 100 ширхэг нь үйлдвэрийн хадаас болно.

Дээрх 3 аймгийн нийт 28,346 ширхэг саналын хуудсыг ашиглах боломжгүй гэж үзсэн тул дахин хэвлэхэд хүрсэн. Энэ алдаа нь хэвлэх үйлдвэрийн ажилтнуудын хариуцлагатай шууд холбоотой бөгөөд саналын хуудсыг ямар үнэ өртгөөр дахин хэвлэсэн, үүний улмаас хэдий хэмжээний хохирол гарсан, хэнд ямар хариуцлага тооцсон талаар мэдээлэл бидэнд өгөөгүй болно.

3) Нийслэлийн Иргэдийн

**Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн
24 тойргийн 736,016 саналын хуудас
буруу кодтой хэвлэгдсэн.**

Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийг УИХ-ын сонгуультай зэрэг зохион байгуулсантай холбоотой саналын хуудасны 2 талд ижил код хэвлэх байсан ч өөр өөр кодтой хэвлэсэн алдаа гарч үүний улмаас нийслэлийн хэмжээнд ашигласан саналын хуудасны 86.5 хувь буюу дийлэнхийг нь дахин хэвлэх шаардлагатай болсон. Тодруулбал, НИТХ-ын 30 тойргоос 6 тойргийн саналын хуудас кодын алдаагүй, үлдсэн 24 тойргийн 92,002 даралт⁴ буюу 736,016 ширхэг саналын

³ Нийслэлд нэмэгдсэн 5526 сонгогчтой холбогдох өөрчлөлтийг Хүснэгт 1-д оруулан тооцсон болно.

⁴ Нэг даралтад нийслэлийн хувьд 8 ширхэг саналын хуудас хэвлэгдэнэ. $92,002 \times 8 = 736,016$ саналын хуудас болж байна.

хуудас нь буруу кодтой хэвлэгдсэн. Автомат төхөөрөмжийн програмчлалтай холбоотойгоор тойрог бурийн саналын хуудас өөр кодтой хэвлэгдсэнээр тухайн нэг тойрогт хэрэглэх саналын хуудсыг өөр тойрогт ашиглах боломжгүй юм. Энэ утгаараа ДВС компани нь сонгуулийн тойрог бүрээр өөр кодтой байхаар хийсэн эхний дардсыг хэвлэх үед нягталж шалгахдаа хайхрамжгүй хандсаны улмаас энэ алдаа гарсан.

Саналын хуудас дахин хэвлэхтэй холбоотой зардлыг хэрхэх талаар холбогдох талууд ажиглагчдад ямар нэгэн тайлбар өгөөгүй. Буруу кодтой болон үсний ширхэг наалдсан зэрэг шалтгаанаар нийт 764,362 ширхэг саналын хуудсыг устгалд оруулж дахин хэвлэсэн. Энэ нь 2012 оны УИХ-ын болон НИТХ-ын сонгуульд зарцуулсан нийт саналын хуудасны 39,4 хувийг эзэлж байна. Өөрөөр хэлбэл, дээр дурдсан алдаанаас үүдэн улсын төсвийн хөрөнгө тэр хэрээр үр ашиггүй зарцуулагдсан гэж үзэх үндэслэлтэй. Хөрөнгө санхүүгийн асуудлаас гадна хэвлэх үйл явц дээрх алдаанаас үүдэн саналын хуудас хэвлэх үйл явц 2-3 хоногоор хойшилсон нь ажиглагчдын болоод бусад оролцогч талын хувьд цаг хугацаа болон санхүүгийн хүндрэл бэрхшээл бас учруулсан.

Саналын хуудас хэвлэсэн цаас ба түүнтэй холбогдох мэдээлэл

Усан хээ бүхий нууцлалтай цаасыг ашиглан хууль бусаар саналын хуудас хэвлэх асуудал үүсэхээс сэргийлж саналын хуудас хэвлэх цаасыг хэрхэн зарцуулж буйд хяналт тавих нь маш чухал байдаг. Сонгуулийн Ерөнхий Хороо УИХ-ын сонгуулийн саналын хуудас

хэвлэхээр 72 ширхэг хайрцагтай цаасыг Канадын компаниас худалдан авсан. Цаас нь 3 давхар баглаа битүүмжлэлтэй, гадна талаасаа харагдах байдал нь нарийн төмрөөр 2 удаа ороосон, цагаан өнгийн модон хайрцагтай, хайрцагны дотуур тунгалаг гялгар уутаар ороосон байсан.

Хайрцаг бурийн гадна талд тухайн цаасны үзүүлэлт холбогдох мэдээллийг бичсэн. Тодруулбал, нэг ширхэг цаас бурийн жин: 161,8g/m², хэмжээ: 94x74cm, цагаан өнгөтэй. Цаас нь нууцлалын хувьд дэлхийн бөмбөрцгийн дурс бүхий усан хээтэй (ул ялиг товгор) байсан. Хайрцаг бүр 1-72 хүртэл дугаартай 72 ширхэг бөгөөд хайрцаг тус бүрт 4,750 ширхэг цаас савлагдсан. Худалдан авсан нийт цаасны нөөцийг тооцож үзвэл $72 \times 4,750 = 342,000$ ширхэг болж байна.

Нэг ширхэг цаасанд тухайн тойргоос хамааран 8-9 ширхэг саналын хуудас хэвлэгдсэн. Тухайлбал, Дархан-Уул аймгийн 19-р тойрог, Орхон аймгийн 20-р тойрог болон Нийслэлийн тойргууд болох 21, 22, 23, 24, 25, 26-р тойргуудад хэрэглэх саналын хуудас нь нэг цаасанд 8 ширхэгээр бусад тойргийн саналын хуудас нь нэг цаасанд 9 ширхэгээр тус бүр хэвлэгдсэн.

Саналын хуудас хэвлэж дууссаны дараах үлдэгдэл цаасны тооцоог хийж үзвэл, УИХ-ын сонгуулийн 26 тойрог болон гадаад дахь сонгогчдын саналыг авахад нийт 1,935,329 ширхэг саналын хуудас хэвлэсэн.

Дээрх бүх саналын хуудсыг хэвлэхэд зарцуулсан цаасны тооцоог сонгуулийн тойрог бүрээр тооцон гаргасантай Хүснэгт 1-ээс дэлгэрэнгүй танилцана уу.

Хүснэгт 1. УИХ-ын болон НИТХ-ын сонгуулийн саналын хуудас хэвлэхэд зарцуулсан цаасны тооцоо

№	Аймгийн нэр (тойргийн хороо/	Нэрийн жагсаалтад бичигдсэн сонгогчдын тоо	Тойротг ногдох саналын хуудасны тоо	Хадаас цаасны тоо	Хэвлэлтэд ашигласан даралт цаасны тоо
1	Ховд	48,678	51,111	272	5,951
2	Увс	47,185	49,544	400	5,905
3	Баян-Өлгий	53,313	55,978	400	6,620
4	Говь-Алтай	34,288	36,002	350	4,350
5	Завхан	44,398	46,617	400	5,580
6	Хөвсгөл	79,633	83,614	450	9,740
7	Дорнод	49,300	51,765	300	6,052
8	Өмнөговь	36,420	38,241	350	4,599
9	Сүхбаатар	36,772	38,610	350	4,640
10	Баянхонгор	51,710	54,295	400	6,433
11	Архангай	57,367	60,235	400	7,093
12	Дорноговь, Говьсүмбэр	48,754	51,191	400	6,088
13	Сэлэнгэ	69,253	72,715	400	8,330
14	Өвөрхангай	71,269	74,832	400	8,715
15	Дундговь	28,943	30,390	350	3,727
16	Хэнтий	45,422	47,693	400	5,550
17	Булган	38,136	40,042	350	4,799
18	Төв	59,146	62,103	400	7,300
19	Дархан-Уул	62,571	65,699	400	8,612
20	Орхон	65,524	68,800	450	9,050
21	Хан-Уул, Багахангай, Багануур дүүрэг	103,289	108,453	1,357	14,916
22	Баянзүрх, Налайх дүүрэг	207,189	217,548	1,908	29,104
23	Сүхбаатар дүүрэг	89,453	93,926	1,143	12,876
24	Чингэлтэй дүүрэг	104,751	109,989	1,200	14,950
25	Баянгол дүүрэг	125,057	131,310	1,080	17,500
26	Сонгинохайрхан дүүрэг	181,028	190,079	1,568	25,286
27	Гадаад дахь сонгогчийн санал авахад	4,329	4,547	124	605
Нийт дүн		1,843,178	1,935,329	16,002	244,371

Хүснэгт 1-ээс харвал анх худалдан авсан 342,000 ширхэг цаасны 71.4 хувь буюу 244,371 ширхэг цаасыг ашиглаж 97,629 шаас үлдсэн бөгөөд үүнийг алдаатай хэвлэсэн тойргийн саналын хуудсыг дахин хэвлэхэд ашигласан болно.

Дээр дурдсанчлан нийслэлийн зарим тойргийн саналын хуудас нь буруу кодтой хэвлэгдсэн тул дахин хэвлэхээр болсон. НИТХ-ын 30 тойргоос 6 тойрог буюу 1, 7, 13, 17, 21, 25-р тойргуудын саналын хуудас зөв кодтой байсан тул дахин хэвлээгүй.

Буруу код бүхий НИТХ-ын сонгуулийн 24 тойргуудын хувьд өмнө хэвлэгдсэн

92,002 даралтын 736,016 ширхэг саналын хуудаснаас Сонгинохайрхан дүүргийн нэг тал хэвлэлттэй даралтаас үйлдвэрийн хадаас хувьд 14,400 ширхэгийг ашиглаж үлдсэн 722,056 ширхэг нэг тал дардас цаасыг саналын хуудас хэвлэж дууссаны дараа устгасан. Учир нь саналын хуудас нь буруу кодтой байгааг тогтоох үед нийслэлийн бүх тойргийн саналын хуудасны УИХ-ын сонгуулийн тал⁵ буруу кодтойгоор хэвлэгдээд байсан.

⁵ УИХ-ын болон НИТХ-ын сонгуулийг хамтад нь зохион байгуулсан тул нийслэлд хэрэглэх саналын хуудас нь 2 талдаа хэвлэгдсэн бөгөөд нүүрэн талд УИХ-ын сонгуульд, ар талд НИТХ-ын сонгуульд санал өгөхөөр зохион байгуулсан.

НИТХ-ын 24 тойргийн саналын хуудсыг дахин хэвлэхтэй холбоотой дэлгэрэнгүй мэдээллийг Хүснэгт 2-оос дэлгэрүүлэн танилцана уу.

Хүснэгт 2. Буруу кодтой тойргийн саналын хуудасны дахин хэвлэлтийн мэдээлэл

Жич: Саарал өнгөөр ялгасан мөрүүд
дэх тойргийн саналын хуудасны код зөв байсан тул дахин хэвлээгүй.

Дүүрэг	НИТХ сонгуулийн Т/Д	Саналын хуудасны тоо	Саналын хуудас хэвлэхэд шаардлагатай даарлт цаас	Цэвэр хадаасны тоо	Нэг тал хадаасны тоо	Дахин Хэвлэлтэд ашигласан нийт даарлт цаас
	1					
Хан-Уул	2	20,054	2,507	40	600	3,147
Багахангай	3	22,542	2,818	40	600	3,458
Багануур	4	16,147	2,019	40	600	2,659
	5	21,940	2,743	40	600	3,383
	6	22,571	2,822	40	600	3,462
	7					
Баянзүрх	8	30,814	3,852	40	600	4,492
Налайх	9	33,357	4,170	40	600	4,810
	10	35,334	4,417	40	600	5,057
	11	30,548	3,819	40	600	4,459
	12	32,807	4,101	40	600	4,741
	13					
Сүхбаатар	14	22,472	2,809	40	600	3,449
	15	23,146	2,894	40	600	3,534
	16	26,313	3,290	40	600	3,930
	17					
Чингэлтэй	18	29,048	3,631	40	600	4,271
	19	30,938	3,868	40	600	4,508
	20	29,248	3,656	40	600	4,296
	21					
Баянгол	22	32,874	4,110	40	600	4,750
	23	32,982	4,123	40	600	4,763
	24	33,780	4,223	40	600	4,863
	25					
Сонгинохайрхан	26	32,002	4,001	40	600	4,641
	27	31,374	3,922	40	600	4,562
	28	27,204	3,401	40	600	4,041
	29	35,258	4,408	40	600	5,048
	30	30,861	3,858	40	600	4,498
Нийт дүн		683,614	85,462	960	14,400	100,822

Хүснэгт 2-оос харвал код буруу хэвлэгдсэн саналын хуудсыг дахин хэвлэхэд $85,462+960=86,422$ ширхэг цэвэр цаас дахин ашиглажээ.

Үйлдвэрийн хадаас цаас

Саналын хуудас хэвлэх үйл явцад “хадаас” цаас гэсэн нэр томъёогоор саналын хуудас хэвлэх явцад үйлдвэрийн болон шаардлага хангахгүй гологдол хэвлэгдэх мөн хэвлэх машин болон зүсэлтийн машинуудад туршилтаар хэрэглэх цаасыг нэрийдэж байв. Тэрчлэн бидэнд мэдээлснээр тухайн нэг тойргийн саналын хуудасны тодорхой хэсэгт хэвлэх, шалгах, зүсэх зэрэг үйл явцад механик гэмтэл гарсан тохиолдолд хадаас цааснаас нөхөн ашиглана гэж байсан ч орон нутгийн гурван тойргийн саналын хуудасны зарим хэсэгт хүний үсний ширхэг наалдан хэвлэгдсэн зэрэг алдаа гарахад хадаас цааснаас ашиглаагүй. Дээр дурдсанчлан энэ удаагийн сонгуулиар 1,935,329 ширхэг саналын хуудас хэвлэхэд 244,371 ширхэг цаас ашигласан. Тухайн цаасанд хэвлэгдсэн саналын хуудсыг тооцож үзвэл 2,067,045 ширхэг болж байна. Ийнхүү нийт хэвлэгдсэн саналын хуудасны тооноос сонгуульд ашигласан тоог хасвал хадаас цаасанд 131,716 ширхэг⁶ саналын хуудас хэвлэгдсэн гэсэн тооцоо гарч байна. Энэ нь сонгуульд ашигласан саналын хуудасны 6,8 хувь байна.

Бэлэн болсон саналын хуудасны баглаа боодол, битүүмжлэлийн найдвартай байдал

СЕХ болон тойргийн хороодод хүлээлгэн өгсөн саналын хуудас нь нийт 4 давхар баглаа битүүмжлэлтэй. Хэвлэлтээс гарсан саналын хуудсыг гараар тоолсны дараа дахин нягтлан шалгах үүднээс автомат жин хэмжигчээр хэмжин тоог давхар хянах арга хэмжээ мөн авч байв. Ийнхүү тоолж дуусаад саналын хуудасны хэмжээнд тааруулан зүсэлт хийх бөгөөд үүний дараа гараар дахин тоолж 200 ширхэгээр багцлан тавьсан. 200 ширхэгээр багцалсан

саналын хуудсыг нэгдүгээрт тунгалаг гялгар уутаар бүрж вакуумдаад цаасан хайрцагт хийж улмаар хайрцагны амсрыг улаан туузан скочоор наан цагаан өнгийн туузаар ороож нийт дөрвөн төрлийн баглаа битүүмжлэл ашигласан билээ.

Саналын хуудас нугарах, норох зэрэг гадны нөлөөллийн улмаас гэмтсэн тохиолдолд автомат төхөөрөмж уншихгүй учир ашиглах боломжгүй. Энэ удаагийн сонгуулиар баглаа, савлагaa хангалтгүйгээс саналын хуудас норж гэмтсэн тохиолдол гаралаагүй ч баглаа битүүмжлэл нь ийм эрсдлээс найдвартай хамгаалахуйц түвшинд байгаагүй хэмээн ажиглагчдын зүгээс дүгнэсэн болно.

Саналын хуудсыг хэвлэх, зүсэлтийн өмнөх тооллого, савлагaa зэрэг үйл явцыг ажиглагчид чөлөөтэй харах боломжтой ч зүсэлтийн дараах гар тооллого, гэмтэл шалгах болон ДВС компани тестлэх үйл явцыг бүрэн гүйцэд ажиглах боломжгүй байлаа.

Хэвлэгдсэн саналын хуудас нь хайрцаг бүрт 1,200 ширхэгээр савлагдсан (200 ш бүхий 6 багц). Өөрөөр хэлбэл, саналын хуудсыг 200 ширхэг бүрээр нь гялгар уутанд вакуумдан багцалсан бөгөөд ийм 6 ширхэг багцыг нэг хайрцагт савласан. Хайрцагны гадна саналын хуудасны тоо ширхэг, жин, хайрцгийн дугаар, орон нутаг болон тойргийн дугаар зэрэг мэдээлэл бүхий стикерийг хайрцагны гаднах 3 талын гадаргууд нааж байрлуулсан нь тодорхой, харагдахуйц байж чадсан.

⁶ Хадаас цаасанд хэвлэгдсэн саналын хуудас нь Архангай болон Орхон аймагт хэрэглэсэн саналын хуудасны тооноос их гэсэн үг юм.

Үлдэгдэл болон хадаас саналын хуудас, хавтан устгах цйл ажиллагаа

Хүснэгт 3. УИХ-ын болон НИТХ-ын сонгуулийн саналын хуудас хэвлэхэд зарцуулсан болон устгалд оруулсан саналын хуудасны тооцоо

№	Аймгийн нэр /тойргийн хороо/	Хэвлэгдсэн нийт саналын хуудасны тоо	Тойротг ногдох саналын хуудасны тоо	ДВС тест хийх	ТЕГ баталгаажуулах	СЕХ-ны архивт	Устгах
1	Ховд	53,559	51,111	105	20	9	2,314
2	Увс	53,145	49,544	99	20	9	3,473
3	Баян-Өлгий	59,580	55,978	112	20	9	3,461
4	Говь-Алтай	39,150	36,002	72	20	9	3,047
5	Завхан	50,220	46,617	56	20	9	3,518
6	Хөвсгөл	87,660	83,614	167	20	9	3,850
7	Дорнод	54,468	51,765	104	20	9	2,570
8	Өмнөговь	41,391	38,241	76	20	9	3,045
9	Сүхбаатар	41,760	38,610	77	20	9	3,044
10	Баянхонгор	57,897	54,295	109	20	9	3,464
11	Архангай	63,837	60,235	120	20	9	3,453
12	Дорноговь, Говьсүмбэр	54,792	51,191	102	20	9	3,470
13	Сэлэнгэ	74,970	72,715	145	20	9	2,081
14	Өвөрхангай	78,435	74,832	150	20	9	3,424
15	Дундговь	33,543	30,390	61	20	9	3,063
16	Хэнтий	49,950	47,693	95	20	9	2,133
17	Булган	43,191	40,042	80	20	9	3,040
18	Төв	65,700	62,103	124	20	9	3,444
19	Дархан-Уул	68,896	65,699	131	20	8	3,038
20	Орхон	72,400	68,800	138	20	8	3,434
21	Хан-Уул, Багахангай, Багануур дүүрэг	119,328	108,453	159	100	40	10,576
22	Баянзүрх, Налайх дүүрэг	232,832	217,548	189	140	64	14,891
23	Сүхбаатар дүүрэг	103,008	93,926	119	80	32	8,851
24	Чингэлтэй дүүрэг	119,600	109,989	116	80	32	9,383
25	Баянгол дүүрэг	140,000	131,310	142	80	32	8,436
26	Сонгинохайрхан дүүрэг	202,288	190,079	192	120	48	11,849
27	Гадаад дахь сонгогчийн санал авахад	5,445	4,547	14	-	4	873
Нийт дүн		2,067,045	1,935,329	3,054	1,000	430	127,225

Саналын хуудсыг хэвлэх, хэвлэж дууссаны дараа Сонгуулийн Ерөнхий Хороо болон Тойргийн хороодод хүлээлгэн өгөх үйл ажиллагаа нь Мөнхийн Үсэг ХХК-ийн үйлдвэрийн байранд болсон. Энэ үйл явцад хэвлэх ажиллагаанд ажиглалт, хяналт тавьж ажилласан бүх тал оролцсон.

Тухайлбал, гадаадад ажиллаж амьдарч байгаа сонгогчдын саналын хуудсыг Гадаад Харилцааны Яамны Консулын Газрын ажлын хэсэг хүлээн авч нийт 39 хотын Дипломат төлөөлөгчийн газарт онгоцоор хүргэсэн.

Мөн алслагдсан хөдөө орон нутгийн тойргийн саналын хуудсыг онгоцоор, бусад орон нутгийн тойргуудад болон нийслэлд хэрэглэх саналын хуудсыг цагдаагийн хамгаалалт бүхий машинаар хүргүүлсэн болно. Ийнхүү хүргүүлэхэд тухайн тойргийн хорооны дарга, нарийн бичгийн дарга, эсвэл тойргийн хорооны гишүүд болон цагдаагийн ажилтны бүрэлдэхүүн тус тус хүлээн авсан.

Мониторингийн багийн ажиглагчид нь үйлдвэрийн байрнаас саналын хуудас хүлээлгэн өгөх үйл ажиллагаанд ажиглалт хийсэн бөгөөд хүлээн авснаас хойш тойргуудад хүргэх үйл явцад (Чингэлтэй дүүргийн 24-р тойргийн хорооноос бусад) ажиглалт хийгээгүй болно. Саналын хуудсыг хэвлэх, үйлдвэрийн байранд хүлээлгэн өгөх үйл явцад хууль зөрчсөн болон ноцтой алдаа дутагдал ажиглагдаагүй болно.

САНАЛЫН ХУУДАС ХҮРГҮҮЛЭХ, ХАДГАЛАХ ХАМГААЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Хэвлэлийн компаниас 2012 оны 6 дугаар сарын 19-нд саналын хуудсыг хэвлэж дуусаад хүлээлгэн өгөхөд бэлэн болсон ба энэхүү мониторингийн хүрээнд УИХ-ын сонгуулийн 24-р тойрог, Дархан-Уул аймгийн 19-р тойргийг сонгон саналын хуудас хүлээн авах, хүргүүлэх, хадгалах хамгаалах ажил хэрхэн хийгдэж байгаад ажиглалт хийллээ.

УИХ-ын сонгуулийн Чингэлтэй дүүргийн 24-р тойргийн хороо

УИХ-ын 24-р тойргийн хороо б дугаар сарын 19-ний өдрийн 14:35 цагт Мөнхийн Үсэг хэвлэлийн компанийн байрнаас саналын хуудсаа хүлээн авахаар ирсэн. Саналын хуудсыг хүлээлгэн өгөхөд Сонгуулийн Ерөнхий Хороо, Нийслэлийн Сонгуулийн Хороо, Тагнуулын Ерөнхий Газар, Төрийн Тусгай Хамгаалалтын Албаны төлөөлөл байлцсан. УИХ-ын 24-р тойргийн хороо болон НИТХ-ын Чингэлтэй дүүргийн

тойргийн хорооны ажилтнууд, дүүргийн цагдаагийн газрын хамгаалалттай ирж саналын хуудсаа хүлээж авсан. Саналын хуудсыг тоолон хүлээж авсны дараа 3110 УНХ дугаартай жижиг оврын ачааны машиндачиж, дүүргийн цагдаагийн газрын 4065 УБЗ дугаартай машин аюулгүй байдлыг хангах зорилгоор дагалдан явсан. Чингэлтэй дүүрэг нь НИТХ-ын 17, 18, 19, 20-р тойргуудад хуваагддаг. Хайрцаг бүрт 1200 ш саналын хуудас савлагдсан байсан ба 24-р тойргийн нийт дүнгээр бүтэн савлагаатай 90 хайрцаг, хагас савлагаатай 4 хайрцаг, нийт 109,989 ширхэг саналын хуудас хүлээн авсан. Үүнд:

- НИТХ-ын сонгуулийн 17-р тойргийн саналын хуудас бүтэн савлагаатай 17 хайрцаг, хагас савлагаатай 1 хайрцаг (355 ш) бүгд 18 хайрцаг бүхий 20,755 саналын хуудас,
- НИТХ-ын сонгуулийн 18-р тойргийн саналын хуудас бүтэн савлагаатай 24 хайрцаг, хагас савлагаатай 1 хайрцаг (248 ш) бүгд 25 хайрцаг бүхий 29,048 саналын хуудас,
- НИТХ-ын сонгуулийн 19-р тойргийн саналын хуудас бүтэн савлагаатай 25 хайрцаг, хагас савлагаатай 1 хайрцаг (938 ш) бүгд 26 хайрцаг бүхий 30,938 саналын хуудас,
- НИТХ-ын сонгуулийн 20-р тойргийн саналын хуудас бүтэн савлагаатай 24 хайрцаг, хагас савлагаатай 1 хайрцаг (448 ш) бүгд 25 хайрцаг бүхий 29,248 саналын хуудас тус тус хүлээн авсан.

Саналын хуудсыг хэсгийн хороодод хүргүүлэх хүртэлх хугацаанд Чингэлтэй дүүргийн Засаг Даргын Тамгын Газрын байранд түр хугацаанд хадгалахаар зөөж байрлуулж, өрөөний хаалгыг лацах хүртэл манай ажиглагчид хамт байж ажиглалт хийсэн. Үүний дараа харьяа хэсгийн хороодод хүргүүлэх хүртэлх хугацаанд саналын хуудас дүүргийн цагдаагийн хамгаалалтад байсан.

Хэсгийн хороодод саналын хуудас хүргэгдсэний дараа зарим хэсгийн хороод дээр ажиглалт хийж хадгалалт хамгаалалт хэрхэн хийгдэж байгаатай биечлэн танилцсан. Ийнхүү ажиглалт хийхэд аюулгүй байдлыг хангасан байдал нь ерөнхийдөө ижил байсан бөгөөд лацтай төмөр шүүгээнд хадгалж, цагдаагийн хамгаалалтад авсан байв.



Саналын хуудас хадгалах төмөр сейф

УИХ-ын сонгуулийн Дархан-Уул аймгийн 19-р тойргийн хороо

Саналын хуудсыг Улаанбаатар хотын Мөнхийн үсэг ХХК-ийн байранд 2012 оны 6 дугаар сарын 17-ны өдөр хэвлэх үйлдвэрээс 19-р тойргийн хорооны 5 гишүүний бүрэлдэхүүнтэй хүлээн авсан. Хэвлэх үйлдвэрээс нийт 55 ширхэг хайрцааг саналын хуудас хүлээн авсан бөгөөд үүний 54 нь бүтэн савлагаатай буюу 1,200 ширхэгээр савлагдсан бол 1 хайрцагт 899 ширхэг саналын хуудас савлагдсан байсан. Хүлээн авсан нийт саналын хуудас 65,699 ширхэг бөгөөд хүлээн авсан болон хүлээлгэн өгсөн тухай баримт үйлдсэн.

Саналын хуудсыг Дархан-Уул аймгийн 19 дүгээр тойргийн хороо байрлаж буй аймгийн ЗДТГ-ын байранд 2012 оны 6 дугаар сарын 17-ны орой авчирч буулгасан ба 18-ны өдөр тойргийн хорооны доторж шилэн кабин бүхий тусгаарлагч өрөөнд хэсгийн хороодод хүргүүлэх хүртэл буюу 6 дугаар сарын 21-нийг хүртэл хадгалсан. Тойргийн хорооны байранд хадгалахдаа цагдаагийн ажилтнуудын харуул

хамгаалалтад тусгайлан байлгаагүй ба ЗДТГ-ын харуулын хамгаалалтад байсан.

Саналын хуудсыг 2012 оны 6 сарын 20, 21-ний өдрүүдэд тойргийн хорооноос Хонгор, Шарын гол, Орхон, Дархан сумуудын салбар хорооны гишүүдийн хамт тус бүр хүлээлгэн өгсөн. Тойргийн хорооноос сумдын салбар хороо, хэсгийн хороодод хүлээлгэн өгөхдөө ямар нэгэн баримт бичиг, тэмдэглэл тусгайлан үйлддэггүй, зөвхөн саналын хуудас хуваарилах хүснэгтэд гарын үсэг зуруулан хүлээлцсэн байна.

Ийнхүү хэсгийн хороод саналын хуудсаа хүлээн авсны дараа цагдаагийн ажилтны хамгаалалттайгаар хэсэг тус бүр цоож лац бүхий сейфэнд хадгалсан. Сонгогчдын Боловсрол Төвөөс саналын хуудсыг хэсгийн хороодод хуваарилах, хүргүүлэх үйл явцад ажиглалт хийх хүсэлтээ илэрхийлсэн боловч 24-р тойргийн хорооны хувьд харьяа хэсгүүдэд саналын хуудсыг хуваарилах, хүргүүлэх үйл явцад ажиглалт хийх боломжийг бидэнд олгоогүй болно.

САНАЛЫН ХУУДАСНЫ ЗАРЦУУЛАЛТ


Сонгогчдын Боловсрол Төвөөс саналын хуудасны зарцуулалтын тайлан болон түүнтэй холбоотой тэмдэглэл, бусад баримт бичгийн хуулбарыг хэсэг тус бүрээр авах тухай хүсэлтээ СЕХ-ны 4 дүгээр сарын 20-ны өдрийн 30 тоот журмын 3.2.1-д заасны дагуу албан бичгээр дээрх 2 тойргийн хороодод хүргүүлсэн.

Энэ дагуу 19-р тойргийн хорооны хувьд саналын хуудасны зарцуулалтын тайланг хэсэгтусбүрээрхолбогдох мэдээллийнхамт, 24-р тойргийн хорооны хувьд хэсгүүдийн зарцуулалтын тайланг тойргийн хороонд нэгтгэн гаргасан тайлантай танилцах боломж олгосон болно.

УИХ-ын сонгуулийн Чингэлтэй дүцргийн 24-р тойргийн хороо

УИХ-ын сонгуулийн 24-р тойргийн хороо нь сонгуулийн 44 хэсгийн хороотой. Тойргийн хэмжээнд нэрийн жагсаалтад бичигдсэн сонгогчдын тоо 104,751 бөгөөд сонгогчдын саналыг авах 109,989 ширхэг саналын хуудас хүлээн авсан. Харьяа 44 хэсгийн хороодод хүлээлгэн өгсөн саналын хуудасны тоо болон зарцуулсан саналын хуудасны тоонд ямар нэгэн зөрүү гаралтай болох нь тойргийн хорооны тайлангаас харагдаж байна.

Зарцуулалтын тайланд⁷ дурдсанаар 6 дугаар сарын 27-нд зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар санал авахад 611 ширхэг саналын хуудас зарцуулсан бол 6 дугаар сарын 28-ны өдөр сонгогч саналаа буруу тэмдэглэнээс 699 ширхэг саналын хуудас хүчингүй болсон, санал авах төхөөрөмжөөр санал авахад 66,493 саналын хуудас зарцуулжээ.



⁷ 24-р тойргийн саналын хуудасны зарцуулалтыг Хавсралт 1.3-аас харна уу.

Тойргийн дүнгээр анх хүлээн авсан саналын хуудаснаас зарцуулаагүй үлдсэн 42,367 ширхэг саналын хуудас байна. Энэ нь тойргийн нийт саналын хуудасны 38.5 хувийг эзэлж байна. Үлдсэн 67,622 ширхэг буюу нийт саналын хуудасны 61.5 хувийг сонгуульд зарцуулжээ.


Тойргийн хорооны нэгтгэсэн зарцуулалтын тайланг хэсгийн хороо бүрийн тайлантай тулган шалгах боломж гаралтай болно. Мониторингийн баг 24-р тойргийн хороонд хандан зарцуулалтын тайланг 44 хэсэг тус бүрээр гаргаж өгөхийг 6 дугаар сарын 29-өөс 7 дугаар сарын 3 хүртэлх өдрүүдэд удаа дараа албан бичгээр болон биечлэн уулзаж хүсэлт гаргасан боловч эцэст нь 24-р тойргийн хэсгүүдийн саналын хуудасны зарцуулалтын тайлантай ТББ танилцах боломжгүй гэсэн хариуг авсан. Боломжгүй шалтгааныг тодорхой хэлээгүй бөгөөд энэ тухай албан бичгээр хариулах шаардлагагүй гэж тайлбарласан.

УИХ-ын сонгуулийн Дархан-Уул аймгийн 19-р тойргийн хороо

19 дүгээр тойргийн хороо Дархан сумын салбар хороонд 53,050, Шарын гол салбар хороонд 5,600, Хонгор сумын салбар хороонд 3,950, Орхон сумын салбар хороонд тус бүр 2,300 ширхэг, нийт 64,900 ширхэгийг хуваарилж, 799 ширхэгийг нөөцдөд үлдээсэн байна (Хавсралт 1.6-г харна уу.) Холбогдох хуулиар тойргийн хороо, хэсгийн хороодод саналын хуудсыг хуваарилах ёстой бөгөөд тойргийн хороо өөрөө санал авах ажлыг зохион байгуулдаггүй тул тэнд саналын хуудсыг нөөцлөн үлдээх боломжгүй юм. Гэтэл тус тойротг тойргийн хороо өөртөө саналын хуудсыг нөөцлөн авч үлдэх нь зохимжгүй юм.

Дархан-Уул аймгийн тойргийн хороо нь нийт 36 хэсгийн хороотой бөгөөд тухайн хэсэг тус бүрийн зарцуулалтын тайлан болон тойргийн хорооны нэгдсэн тайлангийн мэдээллийг дараах хэсэгт дэлгэрэнгүй орууллаа.

График 3. 19-р тойргийн хорооны саналын хуудасны зарцуулалт



19 дүгээр тойргийн хороонд 65,699 саналын хуудас хуваарилагдсан бөгөөд үүний 63 хувь буюу 41,453 саналын хуудсыг санал тоолох төхөөрөмжээр, 307 ширхэгийг зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар, 158 ширхэг буюу 0.2 хувийг сонгогч саналаа буруу тэмдэглэнсээс хүчингүй болгожээ. Мөн нийт саналын хуудасны 36,1 хувь буюу 23,781 ширхэг саналын хуудас зарцуулагдаагүй үлдсэн байна.

Дархан-Уул аймгийн УИХ-ын сонгуулийн 19 дүгээр Тойргийн хороо нь УИХ-ын сонгуулийн саналын хуудсыг хэвлүүлэх, хадгалах, хүргүүлэх, хамгаалах журмын 2 дугаар хавсралтад заасны дагуу Дархан сумын 28 хэсгийн хороо, Хонгор сумын 3 хэсгийн хороо, Шарын гол сумын 3 хэсгийн хороо, Орхон сумын 2 хэсгийн хороо нийт 36 хэсгийн хороо тус бүрээр саналын хуудас хуваарилагдсан тоо, хүлээн авсан тоо, санал хураалтад зарцуулсан саналын хуудасны тоо зэргийг тайлagnаж, зарцуулагдаагүй үлдсэн саналын хуудсыг 19-р тойргийн хороонд хүлээлгэн өгсөн байна.

Хэсэг тус бүрээр гаргасан саналын хуудасны зарцуулалтын тайланг тойргийн хорооны нэгтгэсэн тайлантай харьцуулан үзэхэд зөрүү гараагүй. Саналын хуудсыг хэсгийн хороод тайлан гаргаж, тэмдэглэл үйлдэн боож битүүмжлэн Тойргийн хороонд санал авах ажиллагаа дуусмагц цагдаагийн ажилтнуудын хамгаалалт дор хүргэж ирсэн болно.

САНАЛЫН ХУУДСЫГ АРХИВЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 46.11-д заасны дагуу тойргийн сонгуулийн дүн гарсны дараа саналын хуудас болон бусад баримт бичгийг битүүмжлэн аймаг, дүүргийн архивын газарт хүлээлгэн өгсөн. Тухайн аймаг, дүүргийн архивын газар нь саналын хуудас болон сонгуулийн баримт бичгийг хүлээн авснаас хойш архивын тухай хууль тогтоомжид заасны дагуу хадгалж, энэ хугацаандаа задлах, устгах, үрэгдүүлэхгүйгээр дараагийн сонгууль хүртэл аюулгүй байдлыг хангах ёстой.

УИХ-ын сонгуулийн Чингэлтэй дүцргийн 24-р тойргийн хороо

УИХ-ын болон НИТХ-ын сонгуулийн дүн гарсны дараа 2012 оны 7 дугаар сарын 5-ны өдөр 24-р тойргийн хороо саналын хуудас болон сонгуулийн бусад баримт бичгийг Чингэлтэй дүүргийн архивын газарт хүлээлгэн өгсөн. Саналын хуудас архивлах үйл ажиллагаанд тойргийн хорооны 2 гишүүн, нарийн бичгийн дарга хүлээлгэн өгч, Чингэлтэй дүүргийн архивын газрын эрхлэгч хүлээн авсан.

Дүүргийн архивын газарт хүлээлгэн өгөхдөө 24-р тойргийн харьяа 44 хэсгийн хороодоос саналын хуудас хүлээн авсан баримт №1 дэх мэдээллийн дагуу саналын хуудсыг архивт хүлээлгэн өгсөн. Уг баримт дахь мэдээллээс харвал зарим хэсгийн хороодын хувьд нийт саналын хуудасны тоо нь анх хэсгийн хороодод хүлээлгэн

өгсөн саналын хуудасны тооноос зөрүүтэй байна. Тодруулбал, 24-р тойргийн хороо нь сонгуулийн дүн гарсны дараа саналын хуудсыг дүүргийн архивт хүлээлгэн өгсөн тухай баримтад 7, 12, 14, 20, 21, 24, 25,

26, 33, 34, 36-р хэсгийн хороодын нийт 3,890 ширхэг саналын хуудсыг баримтад дурдалгүй орхигдуулсан байна (Хүснэгт 3-аас харна уу).

Хүснэгт 3⁸. 24-р тойргийн хорооны архивт саналын хуудас хүлээлгэн өгсөн тухай мэдээлэл

Жич: Архивт саналын хуудас хүлээлгэн өгөхөд саналын хуудасны тоо зөрүүтэй байсан хэсгийн хороодын мэдээллийг оруулав.

Хэсгийн хороо №	Хуваарилагдсан саналын хуудасны тоо	Хүлээн авсан саналын хуудасны тоо	Архивт хүлээлгэн өгсөн саналын хуудасны тоо	Зөрүү + (илүү) - (дутуу)/
7-р хэсэг	1,847	1,847	1,864	+17
12-р хэсэг	3,093	3,093	0	-3,093
14-р хэсэг ⁹	1,561	1,561	1,560	-1
20-р хэсэг	2,354	2,354	2,353	-1
21-р хэсэг	2,279	2,279	2,275	-4
24-р хэсэг	2,933	2,933	2,930	-3
25-р хэсэг	2,310	2,310	1,510	-800
26-р хэсэг	3,041	3,041	2,941	-100
33-р хэсэг	3,097	3,097	3,197	+100
34-р хэсэг	2,722	2,722	2,726	+4
36-р хэсэг	2,069	2,069	2,060	-9
Нийт дүн				-3,890

АЖИГЛАГЧИЙН ТЭМДЭГЛЭЛЭС...

2012.07.05.

24-р тойргийн хорооны гишүүний шаардлагын дагуу саналын хуудас архивт хүлээлгэн өгөх үйл явцыг ойроос ажиглах боломжгүй байсан. Тиймээс саналын хуудсыг битүүмжилсэн утны дээр бичигдсэн мэдээллийг харах боломжгүй, зөвхөн холоос харж байсан болно.

24-р тойргийн хороо нь анх 109,989 ширхэг саналын хуудас хэвлэх үйлдвэрээс хүлээн авсан. Зургадугаар сарын 22-нд

харьяа хэсгийн хорооддоо саналын хуудас хуваарилахдаа хүлээн авсан бүх саналын хуудсыг 44 хэсгийн хороодод хуваарилсан¹⁰. Сонгуулийн дараа Чингэлтэй дүүргийн архивт 106,099 ширхэг саналын хуудас хүлээлгэн өгсөн байгаа нь 3,890 ширхэг саналын хуудсаар зөрүүтэй байна. Мөн хэсгийн хороод нь тойргийн хорооноос хүлээн авсан саналын хуудасны тоотой тэнцүү тооны саналын хуудсыг сонгуулийн дараа тойргийн хороонд хүлээлгэн өгөх учиртай. Гэвч тойргийн хорооны саналын хуудасны зарцуулалтын тайлан, архивт саналын хуудас хүлээлгэн өгсөн тухай баримтаас харвал 24-р тойргийн хэмжээнд нийт 3,890 саналын хуудас архивт шилжээгүй үлджээ.

⁸ 24-р тойргийн хэсгийн хороодоос саналын хуудас хүлээн авч архивт өгсөн баримтыг Хавсралт 1.4-өөс харна уу.

⁹ Хавсралт 1.4-өөс харна уу. Тус хэсгийн хорооны зүгээс архивт хүлээлгэн өгсөн саналын хуудасны тоо бичигдээгүй байсан болно.

¹⁰ Хавсралт 1.3-ын “24-р тойргийн саналын хуудасны зарцуулалтын тайлан”-гийн “Хуваарилагдсан саналын хуудас” гэсэн баганыг харна уу.

УИХ-ын сонгуулийн Дархан-Уул аймгийн 19-р тойргийн хороо

Сонгуулийн дүн гарсны дараа 19-р тойргийн хороо салбар, хэсгийн хороодоос саналын хуудас хүлээн авах үйл явц 6 дугаар сарын 28-ны шөнөөс эхлэн 29-ний өдөр хүртэл үргэлжилсэн. Тойргийн хороонд саналын хуудас хүлээн авсны дараа цагдаагийн хамгаалалттай байсан. Ийнхүү хүлээн авсны дараа 19-р тойргийн хороо 6 дугаар сарын 30-ны өдрийн 11 цагийн үед Дархан-Уул аймгийн архивт шилжүүлэн өгсөн. Тойргийн хорооны гишүүд, аймгийн Архивын тасгийн дарга болон архивын ажилтнууд хамтран саналын хуудас хүлээн авсан болно.

19-р тойргийн хорооны хувьд 65,699 ширхэг саналын хуудас хүлээн авсан бөгөөд саналын хуудасны зарцуулалт болон сонгуулийн дараа саналын хуудсыг архивт хүлээлгэн өгөх үед тооны хувьд ямар нэгэн зөрүү гараагүй болохыг тус тойргийн хорооны дарга мэдээлсэн (Хавсралт 1.5-аас харна уу.) Мөн саналын хуудсыг архивт хүлээлгэн өгсөн тухай ямар нэгэн баримт үйлдээгүй бөгөөд хүлээлгэн өгсөн саналын хуудсыг хүснэгтэд нэгтгэсэн байдлаар аймгийн архивт өгсөн тухай мэдэгдсэн. Харин 19-р тойргийн хорооны хувьд саналын хуудас архивт хүлээлгэн өгсөн тухай тоон мэдээллийг бидэнд ирүүлээгүй болно.

1.4 МОНИТОРИНГИЙН ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

МОНИТОРИНГИЙН ДҮГНЭЛТ

Анх удаа сонгуулийн үйл явцад төрийн бус байгууллагын ажиглалт, мониторинг хийх боломжийг хууль тогтоомжоор бататган хүлээн зөвшөөрч, сонгуулийн үйл явцыг ил тод, хяналттай, сонгогчдыг төлөөлөн ажиглалт хийх боломж олгосны үндсэн дээр сонгуулийн хамгийн чухал буюу сонгогч саналаа илэрхийлэх, сонгуулийн дүн гаргах албан ёсны баримт бичиг болох саналын хуудастай холбоотой бүхий л үйл явцад хяналт мониторинг хийллэ. Саналын хуудсыг хэвлэх, хуваарилах, хүргүүлэх, хадгалах хамгаалах, архивлах үйл явцыг тоймлон дүгнэхэд хууль зөрчсөн ноцтой алдаа бөгөөд анхаарал татсан томоохон зөрчил ажиглагдаагүй хэдий ч цаашид анхаарч үзвэл зохих зүйлүүд байна. Энэхүү мониторингийн дунд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна.

Нэг. Саналын хуудастай холбоотой дүгнэлт

1. Саналын хуудас хэвлэх цаасыг худалдан авах, саналын хуудсыг хэвлэх аж ахуйн нэгжийг сонгон шалгаруулах, гэрээ байгуулах зэрэг үйл явц нь “СЕХ-ны дотоод хэрэгт хамаарах” гэсэн шалтгаанаар хаалттай, ил тод бус байна. Энэ нь сонгон шалгаруулалтад оролцсон болон түүнийг зохион байгуулсан талуудын хооронд үл итгэлцэл, маргаан үүсэхэд хүргэж, олон нийт ч үүнийг хардахад хүргэж байна.

2. Саналын хуудас хэвлэх компанийг сонгон шалгаруулахдаа дан ганц техникийн шалгуур үзүүлэлтийг харгалзан үзээд харин хэвлэлийн компани өөрөө сонирхлын зөрчилгүй байх, улстөрийн хувьд хараат бус байх, олон нийтэд итгэл төрүүлэхүйц байх зэрэг шалгуур үзүүлэлтийг орхигдуулсан. Тухайлбал, саналын хуудас хэвлэх эрх авсан компанийн Удирдах Зөвлөлийн дарга нь сонгуульд нэр дэвшин өрсөлдсөн нь тухайн сонгогдсон компани саналын хуудсыг хуульд заасны дагуу, батлагдсан тоо ширхэгээр, үнэн зөв хэвлэх эсэх талаар сонгогчид болон улстөрийн намуудын дунд хардлага төрүүлж, үл итгэх байдал, эргэлзээ бий болгосон.
3. Саналын хуудас нугарах, норох зэрэг гадны нөлөөллийн улмаас гэмтсэн тохиолдолд төхөөрөмж уншихгүй учир ашиглах боломжгүй болож юм. Энэ удаагийн сонгуулиар баглаа, савлагаанаас хамаарсан дээрх эрсдэл гараагүй хэдий ч баглаа битүүмжлэл нь тухайн эрсдлийг бүрэн хамгаалах хэмжээнд биш байсан болно.
4. Саналын хуудас хэвлэх үйл явцыг бүхэлд нь баримтжуулах боломж олдоогүйн улмаас саналын хуудасны хавтангийн тоо болон түүгээр хэвлэсэн саналын хуудас, устгал хийгдсэн саналын хуудас зэргийн тооцоог нэгбүрчлэн тулгаж тооцоо хийх боломжгүй байв. Дараагийн удаа саналын хуудас хэвлэх явцыг бүхэлд нь фото камер болон дүрс бичлэгийн хэрэгсэл ашиглан тасралтгүй буулган авах боломжийг олгох хэрэгтэй гэж үзэж байна.

Хоёр. Санхүүгийн үр ашигтай холбоотой дүгнэлт

1. Саналын хуудасны цаас худалдан авах, саналын хуудсыг хэвлэх зэрэг нь төрийн өмчийн хөрөнгөөр хийгдэх бараа, ажил, үйлчилгээ атал УИХ-ын сонгуулийн тухай хуулиар СЕХ хуваарилагдсан төсвийн хөрөнгийн хэмжээнд шууд худалдан авалт хийх эрх олгож, үүнийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээхудалданавахтухайхуулийн зохицуулалтад үл хамааруулсан нь “Худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломж, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх” зарчим зөрчигдөхөд хүргэж байна. Техникийн шаардлагаас гадна, хуулийн зохицуулалтад үл хамааруулах энэхүү зохицуулалт нь хэт өндөр үнэтэй цаас, хэвлэлийн үйлчилгээг худалдан авахад хүргэсэн гэсэн шүүмжлэлд өртөж байна.
2. Сонгуулийг зохион байгуулж байгаа байгууллага болон хэвлэх үйлдвэрийн буруугаас нийт саналын хуудасны бараг 40 хувийг дахин хэвлэсэн бөгөөд үүнтэй холбоотой цаг хугацаа, зардлыг хэн хариуцах, хэн үүнд хариуцлага хүлээх талаар ямар ч зохицуулалт байхгүй, энэ хэрээр төсвийн хөрөнгө үр ашиггүй зарцуулагдахад хүргэж байна.
3. Саналын хуудасны “хадаас” тоог хэт өндөрөөр тогтоосны улмаас үр ашиггүй зардлын хэмжээ мөн өсөхөд хүргэж байна. Өөрөөр хэлбэл, хадаас саналын хуудасны тоо нийт саналын хуудасны бараг 7 хувийг эзэлж байгаа бөгөөд хадаас цаасыг ийнхүү их хэмжээгээр хэвлэж, устгалд оруулж байгаа нь эргээд төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарахад хүргэж байна. Үйлдвэрлэлийн явцад гарах гологдол, техникийн алдаа, болзошгүй эрсдэлүүдийг тооцож байгаа сайн талтай ч хэт олноор ийнхүү хадаас цаасны тоог тогтоож байгааг эргэж нягтлах нь зүйтэй юм.
4. Саналын хуудсыг хууль тогтоомжид 5 хувийн нөөцтэй байхаар тогтоосон бөгөөд ийнхүү нөөцтэй хэвлэх нь мөн ургүй зардал гараад хүргэж байна. Мониторингийн дүнгээс харахад сонгогдсон хоёр тойргийн хувьд нийт хүлээн авсан саналын хуудасны 61 орчим хувийг лсаналавахад зарцуулсан бөгөөд үлдэх 39 хувь нь зарцуулаагүй үлдсэн байна. Ээлжит сонгууль тус бүрт сонгогчдын идэвхи оролцоо аажмаар буурсаар байгаа бөгөөд 2008 онд 74 хувь, энэ удаагийн сонгуулиар сонгогчдын оролцоо 66 орчим хувьтай байсан. Тиймээс цаашид саналын хуудсыг нөөцгүй буюу сонгогчдын нэрийн жагсаалтад бичигдсэн тоонд үндэслэн хэвлэх тоог тогтоодог байх нь зүйтэй.

Гурав. Сонгуулийг зохион байгуулах байгууллагын үйл ажиллагаатай холбоотой дүгнэлт

1. Саналын хуудсыг хэвлэхтэй холбоотой бүх үйл явцыг баримтжуулж авах боломжийг ТББ-ын болон улстөрийн намын ажиглагчдад хэвлэлийн компани болон СЕХ олгоогүй. Хэвлэх үйлдвэрийн тогтоосон дотоод журмаар ажиглагчдад дүрс бичлэгийн хэрэгсэл ашиглахыг хориглосон бөгөөд үйлдвэрийн байран дахь ажиглагчдын тогтоосон тооноос хамааран хэвлэх үйл явцтай холбоотой дамжлага бүрийт нэгэн зэрэг ажиглаж, хяналт тавих боломжгүй байсан.
2. ТББ-ын хяналт мониторинг хийхтэй холбоотой хууль тогтоомжийн зохицуулалт боломжийн байсан ч түүнийг хэрэгжүүлж, сахин мөрдөж ажиллах сонгуулийн анхан шатны байгууллагын ажилтнуудын өөрсдийн хууль эрх зүйн мэдлэг сул,

хүнд сурталтай, ТББ-ын ажиглалт мониторингийг үл ойшоо хандлага нь хангалттай мэдээлэл авах, харилцан ойлголцож хамтарч ажиллахад нэлээд бэрхшээл үүсгэсэн.

3. Саналын хуудасны тоог тогтоох, хэвлэх, хүргүүлэх, хадгалах хамгаалах, зарцуулалтад хяналт тавих Ажлын хэсгийг СЕХ байгуулж ажилладаг бөгөөд энэ ажлын хэсэгт орох албан ёсны хүсэлт тавьсан боловч хүлээн аваагүй болно.

ЗӨВЛӨМЖ

Мониторингийн дүн болон дүгнэлтэд үндэслэн дараах зөвлөмжийг гаргаж байна.

Нэг. Сонгуулийн хууль тогтоомжийг боловсронгуй болгохтой холбоотой зөвлөмж

- Саналын хуудас хэвлэх цаас худалдан авах, хэвлэх зэрэг сонгуулийн байгууллагуудын худалдан авдаг бараа, ажил, үйлчилгээг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах журмын дагуу зохион байгуулахаар холбогдох хуульд тусгах;
- Саналын хуудас хэвлэх үйл явцыг ил тод, нээлттэй мэдээлдэг, хэвлэх үйлдвэртэй байгуулагдсан гэрээг олон нийтэд нээлттэй байхаар журамлах;
- Саналын хуудасны баглаа, боодол, битүүмжлэлд тавигдах шаардлагыг хуулиар тогтоох;
- Саналын хуудсыг нөөцгүй хэвлэдэг бусад улс орны туршлагыг хуульчлах;
- Сонгуулийн саналын хуудас хэвлэх компани болон энэ хүрээнд хамтран ажиллах байгууллага, аж ахуй нэгжийг сонгохдоо зөвхөн техникийн шалгуур

үзүүлэлт, чадавхийг харгалzan үзэхээс гадна сонирхлын зөрчилтэй холбоотой асуудлыг харгалzan үзэх шалгуурыг хуулиар тогтоох;

- Саналын хуудсыг архивт хүлээлгэн өгөх үйл ажиллагаанд төрийн бус байгууллагыг оролцуулан ажиглалт хийх тухай заалтыг холбогдох хууль журамд тусгах.

Хоёр. Сонгуулийг зохион байгуулах байгууллагын үйл ажиллагаатай холбоотой зөвлөмж

- Саналын хуудас хэвлэх, хадгалах хамгаалах, хуваарилах ажлыг зохион байгуулдаг СЕХ-ны ажлын хэсэгт тухайн асуудалд мониторинг хийж буй төрийн бус байгууллагын төлөөллийг оруулдаг болох;
- Сонгуулийг нээлттэй, шударга зохион байгуулахад хөндлөнгийн байгууллагын оролцоог бий болгох ажиглалт, мониторинг хийх, түүний үнэлгээ дүгнэлт чухал ач холбогдолтой болохыг бүх шатны сонгуулийн хороодын ажилтнуудад ойлгуулан таниулах зорилго бүхий сургалт, гарын авлагыг боловсруулах;
- Сонгуулийг зохион байгуулах байгууллагын ажилтнуудын хууль, эрхийн мэдлэгийг дээшлүүлэх.

Гурав. Бусад зөвлөмж

- Үйлдвэрийн хадаас цаасыг тухайн тойргийн саналын хуудасны 1 хувиас илүүгүй хэвлэж байх;
- Үйлдвэрийн хэвлэх болон зүсэлтийн машинуудад туршилтаар хэвлэх цаасыг саналын хуудасны зориулалтын бус цаас ашиглах замаар хэмнэлт бий болгох.


1.5 АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, 2011 оны 12 дугаар сарын 15. Төрийн Ордон, УБ хот.
2. Сонгуулийн төв байгууллагын тухай хууль. 2006 оны 1 дүгээр сарын 12. Төрийн ордон. УБ хот.
3. Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль. 2011 оны 6 дугаар сарын 16. Төрийн ордон. УБ хот.
4. Байгууллагын нууцын тухай хууль. 1995 оны 5 дугаар сарын 16. Төрийн ордон. УБ хот.
5. Монгол Улсын Их Хурлын сонгуулийг ажиглах, сурвалжлах тухай журам. Дугаар 25. 2012 оны 4 дүгээр сарын 6. СЕХ.
6. Төрийн бус байгууллага сонгуулийн үйл ажиллагаанд хяналт, шинжилгээ (мониторинг) хийх, сонгогчдод аргачилсан туслалцаа үзүүлэх тухай журам, дугаар 30. 2012 оны дүгээр 4 сарын 20. СЕХ.
7. Улсын Их Хурлын сонгуулийн саналын хуудсыг хэвлүүлэх, хадгалах, хамгаалах журам, дугаар 59. 2012 оны 5 дугаар сарын 15. СЕХ.
8. Сонгуулийн үйл ажиллагаанд хяналт шинжилгээ хийх төрийн бус байгууллагуудыг буртгэж, зөвшөөрөл олгох тухай, дугаар 71. 2012 оны 5 дугаар сарын 22. СЕХ.
9. Сонгуулийн үйл явцыг ажиглах төрийн бус байгууллагуудыг буртгэж зөвшөөрөл олгох тухай, дугаар 93. 2012 оны 6 дугаар сарын 2. СЕХ.
10. Саналын хуудасны тоо тогтоох тухай Сонгуулийн Ерөнхий Хорооны 2012 оны 6 дугаар сарын 8-ны өдрийн тогтоол. СЕХ.
11. Гэрээ байгуулах тухай, дугаар 22. 2012 оны 3 дугаар сарын 22. СЕХ
12. Саналын хуудасны тоо тогтоох тухай, дугаар 77. 2012 оным 6 дугаар сарын 2. СЕХ.
13. Ажлын хэсэг байгуулах тухай, дугаар 15. 2012 оны 5 дугаар сарын 31. СЕХ.
14. Ирэх сонгуулийг явуулах тухай бидний зөвлөмж. 2012 оны 2 дугаар сарын 29. Доминион Вөутинг Системс.
15. Ирэх сонгуулийг явуулах тухай бидний зөвлөмж. 2012 оны 3 дугаар сарын 20. Доминион Вөутинг Системс.
16. 2008 оны УИХ-ын сонгуулийн саналын хуудас хэвлэх, хүргүүлэх, хадгалах явцын мониторингийн тайлан. 2008 он. Хүний Эрх Хөгжил Төв.



"МИДАС" ТББ

СОНГУУЛИЙН АВТОМАТЖУУЛСАН СИСТЕМИЙН МОНИТОРИНГИЙН ТАЙЛАН



2.1 ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

МОНИТОРИНГИЙН ЗОРИЛГО

Сонгуулийг автомат тоологч машин, шинэ цахим иргэний үнэмлэх ашиглан анх удаа явууллахтай уялдуулан автоматжуулсан системд гарч болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх, сонгуулийн үйл ажиллагааг шударга явуулах замаар иргэний сонгох эрхийг дэмжиж, хамгаалахад хувь нэмэр оруулах.

МОНИТОРИНГИЙН АРГАЧЛАЛ

Энэхүү төслийн хүрээнд сонгуулийн автоматжуулсан системийн найдвартай байдлыг шалгах хэд хэдэн төрлийн тестийг бие даасан мэргэжлийн хүмүүсийн оролцоотойгоор хийхээр төлөвлөсөн болно.
Үүнд:

A. Сонгуулийн өмнөх тестийн це шатанд хийгдэх ажлууд

1. Автомат тоологч машины техникийн тест
 - Тог тасрах үед мотор, UPS-ийн найдвартай байдал
 - Орчны тест буюу халуун, хүйтэн, чийг машины үйл ажиллагаанд нөлөөлөх байдал
 - Шалгалтын дараа лацах үйл явц, лацны найдвартай байдал
 - Засвар үйлчилгээний зохион байгуулалт
 - Нөөц машины хангамжийн асуудлыг хэрхэн шийдвэрлэсэн байдал

2. Програмын тест
 - Програмын эх кодын шалгалт
 - Компиляци хийгдсэн эх код мөн эсэхийг шалгах (binary-аар шалгах - ижил компилятор ашигласан эсэх)
 - Үйл ажиллагааны тест
3. Цаас скайнердэх үйл ажиллагааны тест
 - Цаасыг хэдэн удаа уншсаныг тоолох тэмдэглэгээ хийгдэж буй эсэх, эсвэл тодорхой хуудсыг нэг л удаа унших боломжтой байгаа эсэхийг шалгах
 - Хуудсыг унших цэг бүрээр тестлэх
 - Үйл ажиллагааны бүрэн тест
 - Цөөн цаас
 - Θөр цаас
 - Олон цаас
 - Алдаатай цаас
 - Олныг бөглөсөн
 - Огт бөглөөгүй
 - Засвартай цаас
 - Урагдсан цаас уншуулж тус тус шалгах.
4. Мэдээлэл дамжуулах
 - Сүлжээний холболт
 - Сүлжээний хамгаалалт
 - Мэдээлэл дамжуулах эрх бүхий этгээдийг таних аргачлал
5. Аудит логийн шалгалт
 - Эхлэлийн байдлын тест
 - Үйлдлүүдийг бүрэн бүртгэж байгаа эсэх
 - Саналын хуудасны тооцоо
6. Ажиллах боловсон хүчиний гэрчилгээжүүлэлт, шалгалт
 - Ажиллах боловсон хүчин бэлтгэх хөтөлбөр
 - Чадамжийн үнэлгээ (түүврээр)

7. Зохион байгуулалт, хяналт
 - Холбогдох эрх зүйн орчны судалгаа, дүгнэлт
 - Ажиллах хүмүүсийн ажил үүргийн хуваарь
 - Цахилгаан тасрах, сүлжээ гэмтэлтэй зэрэг ад лог нөхцөлийн бэлтгэлүүд
8. Иргэний цахим үнэмлэхийг унших, сонгогчийг бүртгэх
 - Цахим үнэмлэх уншигч төхөөрөмжийн түүвэрчилсэн тест
 - Хурууны хээ таних төхөөрөмж ба програмын тест

Б. Сонгуулийн цеэр хийх ажиглалт, хяналт

1. Сонгогчийг бүртгэхэд цахим иргэний үнэмлэх ашиглаж байгаа байдал хуульд нийцэж буй эсэх
2. Хурууны хээ зөрсөн болон бусад тохиолдол
3. Техникийн тест
 - Автомат тоологч машины бэлэн байдлыг шалгах (тог тасрахад мотор, UPS найдвартай ажилласан эсэх)
 - Лацны бүрэн байдал
 - Эхлэлийн лог зөв эсэх
4. Программын тест
 - Аудит лог болон программын ажиллагаа хэвийн явагдаж байгаа эсэх
5. Цаас скайнердэх үйл ажиллагааны тест
 - Цаасыг зөв уншуулж байгаа эсэх
 - Уншигдахгүй байгаа цааснуудтай хэрхэн ажиллаж байгаа
6. Мэдээлэл дамжуулах
 - Сүлжээний холболт
 - Сүлжээний хамгаалалт
 - Мэдээлэл дамжуулахад бэлтгэх үйл ажиллагаа горимын дагуу явагдаж байгаа эсэхийг хянах

7. Аудит логийн шалгалт
 - Эхлэлийн байдлын тест зөв эсэх
 - Үйлдлүүдийг тухай бүр бүрэн бүртгэж байгаа эсэх
 - Саналын хуудасны тооцоо
8. Ажиллах боловсон хүчин
 - Ажиллах боловсон хүчний зүгээс техник болон бусад төхөөрөмжтэй горимын дагуу ажиллаж байгаа эсэх
 - Шаардлагатай завсар, үйлчилгээ, тохиргоог журмын дагуу явуулж байгаа эсэх

СЕХ-ноос мониторингийн багт дээрх аргачлалын дагуу нарийвчилсан хяналт тавих бололцоо олгохоос татгалзсан бөгөөд зөвхөн автоматжуулсан системийг санал хураалтад бэлдэх процессыг хөндлөнгөөс ажиглахыг зөвшөөрсөн. Төслийн баг СЕХ-ны зүгээс автомат тоологч машины эх кодыг танилцуулахад байлцсан ба машиныг гэрчилгээжүүлэх үйл ажиллагааг хөндлөнгөөс ажигласан. Үүнд, автоматжуулсан системийг гэрчилгээжүүлэх ажиллагааг СЕХ-ны МТ-ийн төв, Тагнуулын Ерөнхий Газар, МШХХТГ-ын төлөөлөл оролцсон ажлын хэсэг ДВС болон Интерактив компанийн хамтран төрийн хамгаалалт бүхий тусгай агуулахад оюутнуудын тусламжтайгаар гүйцэтгэсэн ба техник, програм, үйл ажиллагаа, наалтын шалгалт хийхэд төслийн багийн гишүүд хоёр удаа хагас өдрөөр ажиглалт хийх боломж олгосон.

Эдгээр ажиглалтын мэдээллээс гадна Улаанбаатар хотын 121 хэстийн хороонд ажиглалт хийсэн. “Шударга сонгуулийн төлөө иргэний нийгмийн хяналт” сүлжээний 180 ажиглагчаас авсан мэдээлэл, СЕХ болон УБЕГ-ын холбогдох хүмүүстэй уулзаж ярилцах замаар цуглуулсан мэдээ, баримтад үндэслэн энэхүү тайланг бэлтгэлээ.

2.2 ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧИН

УИХ-ын сонгуулиар санал тоолох явцад дүнг өөрчилж будлиан гаргахаас сэргийлэх, сонгуулийн дүнг нэгтгэн зарлах үйл явцыг хурдастгах, хүний оролцоог аль болох багасгах зорилгоор 2012 онд анх удаа сонгогчдын саналыг гараар бус автомат төхөөрөмжөөр тоолох шийдвэрийг УИХ-аас гаргасан. Үүнтэй холбоотой 2011 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр УИХ-аас Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хуулийг баталсан билээ. Энэхүү хуулийн зорилгыг бүх шатны сонгууль болон ард нийтийн санал асуулгын дүнг гаргах ажиллагаанд автомат тоолох хэрэгсэл ашиглах зарчим, журмыг тодорхойлж, түүнийг ашиглахтай холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино гэж тодорхойлжээ.

Хуулиар юуны өмнө Сонгуулийн автоматжуулсан систем (САС)-ийг ашиглах үндсэн зарчмыг дараах байдлаар тодорхойлж өгсөн. Үүнд:

5.1.1. САС-ийг ашиглах шийдвэрийг гаргахад улс төрийн намуудын зөвшилцлийг хангах;

5.1.2. Хуульд өөрөөр заагаагүй бол САС-ийг ашиглаж байгаа сонгуулийн хороодын үйл ажиллагаа ил тод байх;

5.1.3. Сонгуулийн үйл явц, санал хураалтын дүнгийн талаарх мэдээ, мэдээллийг нийтэд шуурхай хүргэх;

5.1.4. САС-ийг ашиглан явуулж байгаа мэдээллийн ажиллагаанд хуулиар эрх олгогдоогүй хэн нэгэн хөндлөнгөөс оролцохыг хориглох;

5.1.5. Ашиглаж байгаа САС, мэдээллийн технологитой давхардуулан тухайн сонгуульд өөр автоматжуулсан систем, мэдээллийн технологийг ашиглахгүй байх;

5.1.6. САС-ийн мэдээллийн санд байгаа мэдээллийн аюулгүй байдлыг хангах;

5.1.7. САС-ийн программ хангамж, санал авах техник хэрэгслийг ашиглах заавар сонгогчид ойлгомжтой, хэрэглэхэд хялбар, мэдээллийн сангаас хуулийн дагуу авах мэдээлэл нээлттэй, хүртээмжтэй байх гэж зааж тодорхойлсон.

САС-ТЭЙ ХОЛБООТОЙ ТӨРИЙН ЭРХ БҮХИЙ БАЙГУУЛЛАГУУДЫН ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА

Уг хуульд зааснаар САС-ийг сонгуульд хэрэглэх талаарх шийдвэрийг УИХ гаргах ба (6.1.1) Засгийн газар САС-ийн хэвийн ажиллагааг хангахад шаардлагатай дэмжлэг, туслалцаа үзүүлэх (7.1.1), шаардагдах мэдээлэл, харилцаа холбооны сүлжээ, эрчим хүчний найдвартай эх үүсвэрээр хангах (7.1.4) үүрэг хүлээнэ. Харин СЕХ нь САС-д тавигдах шаардлагыг тодорхойлохын зэрэгцээ САС ашиглахтай холбогдсон дүрэм, журам, зааврыг баталж мөрдүүлэн биелэлтийг хянах, уг системийг ашиглан явуулж байгаа мэдээллийн ажиллагааны явцад хяналт тавих үүрэг хүлээнэ гэж тусгажээ.

САС-ийг ашиглах талаарх сонгуулийн тойргийн болон салбар, хэсгийн хорооны бүрэн эрхийг хуульд мөн тодорхой зааж зохицуулсан. Үүнд:

10.1.1. САС-ийг ашиглах үйл ажиллагааг харьялах тойргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд хариуцан зохион байгуулж, СЕХ-оос баталсан дүрэм, журам, зааврыг хэрэгжүүлэх арга хэмжээ авах;

10.1.2. мэдээллийн аюулгүй байдалд хяналт тавих;

10.1.3. техник хэрэгслийн бүрэн бүтэн байдал, хэвийн ажиллагааг хангах арга хэмжээ авах;

10.1.5. САС ашиглах талаар доод шатны сонгуулийн хорооны үйл ажиллагаанд хяналт тавьж, өөрийн бүрэн эрхийн хүрээнд даалгавар, чиглэл өгөх;

10.1.7. САС-г ашиглах явцад гарсан зөрчил, маргааныг бүрэн эрхийнхээ хүрээнд шалган шийдвэрлэх;

Сонгуулийн хэсгийн хороод нь:

10.3.1. автоматжуулах хэрэгслийн иж бүрдлийг ашиглаж, мэдээллийн ажиллагааг зохион байгуулах;

10.3.2. автоматжуулах хэрэгслийн иж бүрдэл дэх мэдээллийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээ авах;

10.3.3. САС-ийг ашиглах үйл явцын ил тод байдлыг хуулийн хүрээнд хангах;

10.3.4. САС-ийг ашиглан явуулсан сонгуулийн явц, санал хураалтын дүнгийн талаар дээд шатны сонгуулийн хороонд болон сонгогчдод үнэн, бодит мэдээллийг шуурхай хүргэх;

10.3.5. САС-ийг ашиглах явцад гарсан зөрчил, маргааныг бүрэн эрхийнхээ хүрээнд шалган шийдвэрлэх үүрэг хүлээнэ гэж заасан.

Дээрхээс гадна мөн хуулийн 10.4-т “Сонгуулийн тойрог (нутаг дэвсгэр)-ийн болон салбар, хэсгийн хороод, тэдгээрийн дарга, нарийн бичгийн дарга, гишүүн, ажилтан нь өөрийн бүрэн эрхэд хамааруулаагүйасуудлаар автоматжуулах хэрэгслийн иж бүрдлийг ажиллуулж байгаа мэргэжилтэн, мэдээллийн технологийн даамлын үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцохыг хориглоно.” гэж заасан.

Түүнчлэн САС-ийг сонгуульд ашиглах бэлтгэлийг хангах гол үүрэг бүхий Мэдээллийн Технологийн Төв (МТТ)-ийг СЕХ-ны дэргэд байгуулахаар хуульд тусгасан. Хуулийн 12.1 д заасанчлан, уг төв нь:

- системийн хэвийн ажиллагааг хангаж, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх;
- технологийн нэгдсэн удирдлагыг хэрэгжүүлэх;

- систем дэх мэдээллийн аюулгүй байдлыг хариуцан хангах;

- САС-ийг ашиглах мэргэжлийн хүнийг сонгон сургалт явуулж ашиглах эрхийн гэрчилгээ олгох үүрэг тус тус хүлээнэ.

МТТ-өөс гадна хуулийн 13-т заасны дагуу Сонгуулийн тойргийн хорооны дэргэд мэдээллийн технологийн багийг 5 хүртэл хүний бүрэлдэхүүнтэйгээр томилж ажиллуулах ба 14 дүгээр зүйлд хэсгийн хороод дээр мэдээллийн технологийн даамал ажиллаж, сонгуулийн зохих шатны хороонд мэдээллийн ажиллагааг явуулах, техник, хэрэгслийн хэвийн ажиллагааг хариуцан хангах үргийг гүйцэтгэхээр заасан. Эдгээр ажилтан нь МТТ-ийн сургалтад заавал хамрагдсан, эрхийн гэрчилгээ авсан байх шаардлагыг мөн тусгасан байна.

СОНГУУЛИЙН АВТОМАТЖУУЛСАН СИСТЕМИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ

САС-д ашиглах програм хангамж, техник хэрэгслийн ажиллагааг шалган туршиж баталгаажуулах ажлыг Мэдээллийн Технологийн Төв, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, Тагнуулын Ерөнхий Газрын төлөөлөл оролцсон ажлын хэсэг хариуцан гүйцэтгэж, гэрчилгээг олгоно.

21.2.2. Нийтийн хэрэглээний болон тусгай зориулалтаар ашиглах зөвшөөрөл, гэрчилгээ бүхий програм, техник хэрэгсэл, харилцаа холбооны суваг ашиглах;

21.2.3. Сонгуулийн автоматжуулсан системд хууль бусаар нэвтрэх боломжийг бүрэн хаах;

21.2.4. Мэдээллийн санд байгаа мэдээллийн бүрэн бүтэн байдал, үнэн зөв болохыг баталгаажуулах;

21.2.5. Мэдээллийг мэдээлэл, харилцаа холбооны сүлжээгээр дамжуулах үед хамгаалах;

21.2.6. Сонгууль зохион байгуулахад сонгуулийн автоматжуулсан системийн бэлэн байдлыг тусгайлан шалгах;

21.2.7. Холбогдох журмаар баталсан ашиглалтын баримт бичгийг хэрэглэх;

21.2.8. Автоматжуулах хэрэгслийн иж бурдлийн хэвийн ажиллагаа, түүний бүрэн бүтэн байдлыг хангах арга хэмжээ авах;

21.2.9. Автоматжуулах хэрэгслийн иж бурдлийг ашиглах эрхийн гэрчилгээ бүхий ажилтныг бэлтгэх.

САС-ийн ашиглалтад тавих хяналт

Хуулийн 23.1-д зааснаар сонгуулийн бүх шатны хороод САС-ийг ашиглахтай холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, зааврын биелэлтэд хяналт тавих үүрэг бүхий хяналтын хэсэг байгуулж ажиллуулна. Хяналтын хэсгийг СЕХ-д 3, сонгуулийн тойрог, салбар хороонд 5, сонгуулийн хэстийн хороонд тус бүр 3 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр тухайн сонгуулийн хорооны гишүүдээс томилж, мэргэжлийн болон бусад төлөөллийг оролцуулан байгуулна.

САС-д гарсан гэмтэл, saatlyg ariilgax

Хуулийн 26.1-д заасанчлан САС-ийн иж бурдлийн аль нэг техник хэрэгсэл, тоног төхөөрөмжид гэмтэл, saat ал гарсан тухай бүр зохих шатны сонгуулийн хорооны даргад нэн даруй мэдэгдэх бөгөөд тухайн хорооны хяналтын хэсэг гэмтэл, saatlyn шалтгааныг шалган тодруулж, уг гэмтлийг хэрхэн засварласан, saatlyg ariilgasan талаар тэмдэглэл хөтөлне. Түүнчлэн 26.4-д Сонгуулийн хороод нь сонгуулийн автоматжуулсан системд гарсан гэмтэл, saat ал, мэдээллийн гажуудлын шалтгааныг шалган тогтоож, тэдгээрийг ariilgax, системийн хэвийн ажиллагааг хангах арга хэмжээг шуурхай шийдвэрлэж, shaardlagatai хөрөнгө хүч, мэргэжилтнийг дайчлах, техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийг яаралтай хүргүүлэх зэргээр системийн хэвийн ажиллагааг хангах арга хэмжээг шуурхай шийдвэрлэх,

shaardlagatai асуудлыг дээд шатны сонгуулийн хороо, бусад байгууллагад тавьж шийдвэрлүүлэх үүрэгтэй гэжээ.

Техник хэрэгсэл, тоног төхөөрөмж ажиллахгүй болсон, түүнийг өөр техник хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр солих, засварлах боломжгүй болсон тохиолдолд санал авах, санал тоолох, мэдээлэл дамжуулах зэрэг мэдээллийн ажиллагааг саадгүй үргэлжлүүлэн явуулах нөөц төлөвлөгөөг СЕХ баталж, санал хураах өдрөөс 15-аас доошгүй хоногийн өмнө нийтэд мэдээлж, сонгуулийн хэсгийн байранд ил тавихаар мөн хуульд заасан байна. Хуулийн 27.1-д зааснаар сонгуулийн автоматжуулсан системийн автоматжуулах хэрэгслийн иж бурдэлд гэмтэл, saat ал гарсны улмаас гар ажиллагаанд шилжих үндэслэл, журмыг Сонгуулийн ерөнхий хороо баталж мөрдүүлнэ гэжээ.

Автоматжуулах хэрэгслийн иж бурдлийг турших

САС-ийн найдвартай ажиллагааг хангахтай холбоотой дараах зохицуулалтыг хуульд тусгасан байна. Үүнд:

29.1. Сонгуулийн автоматжуулсан системийн автоматжуулах хэрэгслийн иж бурдэл, програм хангамжийг урьдчилан туршигүйгээр сонгуулийн үйл ажиллагаанд ашиглахыг хориглоно.

29.2. Сонгуулийн автоматжуулсан систем, түүний автоматжуулах хэрэгслийн иж бурдлийг турших журмыг Сонгуулийн Ерөнхий Хороо батална.

29.3. Автоматжуулах хэрэгслийн иж бурдэлд орсон техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийг шалган туршиж, түүний бэлэн байдлыг баталгаажуулсан тухай гэрчилгээг энэ хуулийн 21.4-т заасан ажлын хэсэг техник хэрэгсэл тус бурд олгоно.

2.3 МОНИТОРИНГИЙН ДҮН

ТЕХНИК ХАНГАМЖИЙН БҮРЭН БҮТЭН НАЙДВАРТАЙ БАЙДАЛ, ГЭРЧИЛГЭЭЖҮҮЛЭЛТ

СЕХ-ны зүгээс автомат төхөөрөмжийг гэрчилгээжүүлэх үйл ажиллагааг бүхэлд нь хянах боломж олгоогүй нь энэ үйл явцад бүрэн хангалттай хяналт тавьж дүгнэлт гаргахад бэрхшээл учруулсан билээ. Улмаар иргэний нийгмийн зүгээс мониторингтой холбоотой мэдээлэл хүсэх, ажиглалт хийх зөвшөөрөл авахад СЕХ, ДВС хоёр бие бие рүүгээ түлхэх, удаа дараа албан бичиг нэхэх зэргээр саад учруулж байлаа. Үүнээс үүдэлтэй сонгуулийн автоматжуулсан системийн техник хангамжийн найдвартай ажиллагааны талаар дүгнэлт гаргахдаа санал тоолох төхөөрөмжийг гэрчилгээжүүлэх үйл ажиллагааг хөндлөнгөөс хянасан хоёр удаагийн богино ажиглалт, сонгуулийн өдөр иргэний нийгмийн ажиглагчдын хийсэн тэмдэглэл, СЕХ-ны МТ-ийн мэргэжилтнүүдтэй хийсэн ярилцлагад голлон тулгуурлалаа. Сонгуулийг зохион байгуулах явцад техникийн холбогдолтой дараах асуудлууд гарсан. Үүнд:

1. Сонгуулийн өдрөөс өмнө төхөөрөмжийг гэрчилгээжүүлэх явцад хэсгүүдэд очих компьютерт зөвхөн тухайн сонгуулийн хэсгийн сонгогчдын нэrsийн жагсаалт бүхий мэдээллийн баазыг суулгаж сонгуулийн тойрог хэсгийн дугаар бүхий наалтыг гадна талд нь нааж байсан нь цөөн тохиолдолд доторж баазтайгаа зөрсөн.

2. Орон нутагт төхөөрөмжийн нөөц зайд залгахдаа туйлыг сольж салгаж шатаах тохиолдол гарсан.
3. Сонгуулийн өдөр болоход санал тоолох төхөөрөмж гацсан тохиолдол цөөн байв. Улс даяар нийт 2446 санал тоолох машин ажилласнаас 10-аад машин гацаж гар ажиллагаанд шилжсэн. Нийслэлийн 24-р тойргийн 25-р хэсгийн хороо, 22-р тойргийн 71-р хэсгийн хороонд тус бүр төхөөрөмж түлхүүр, кодоо танихгүй байсан тул санал хураалт оройтож эхлэх тохиолдол гарчээ.
4. Хэд хэдэн хэсгийн хорооны санал тоолох машин саналын хуудсыг эргүүлж тойруулан өөр өөр аргаар уншуулах оролдлого хийсний дараа уншиж байсан байна. Тухайлбал, 24-р тойргийн 42-р хэсгийн хороонд ийм байдал олон удаа давтагдсан. Улмаар хэсгийн хорооноос өгсөн засварын дуудлагын дагуу холбогдох мэргэжилтнүүд ирж төхөөрөмжид засвар үйлчилгээ хийсэн.
5. Зарим нэг хэсгийн хороон дээр санал тоолох машин саналын хуудсыг уншиж чадахгүй байсан тул гаднаас хүн ирж санал тоолох төхөөрөмжийн уншигчийн толгойг цэвэрлэх үйлчилгээ хийсэн. Өмнөнь толгойцэвэрлэх тухай мэдээлэл, заавар байхгүй байсан ба машинаар 500 хуудас уншуулаад толгойг нь цэвэрлэх шаардлагатай тухай сонгуулийн өдөр СЕХ-ны ажилтан хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлсэн нь цаг хугацааны хувьд хэтэрхий тулгасан байв.
6. Санал тоолох машины гацалт нь ихэнх тохиолдолд сонгогчид зааврын дагуу саналын хуудсаа уншуулаагүйгээс болж гарсан байна. Тухайлбал, хажуугийн жижиг дэлгэц дээрх мэдээллийг уншихгүй дараагийн саналын хуудас уншихад төхөөрөмж бэлэн болоогүй байхад саналын хуудас хийх, хуудсаа нугалж хийх, хаашаа

хийхээ мэдэхгүй байх тохиолдлууд гарсан. Санал тооллогын машин санал хураалт эхлэх болон дуусах үед гацсан тохиолдол нэлээд байна. Ялангуяа модем залгах үед олон машин гацсан тухай технологийн даамлууд дурдаж байсан.

7. Орчны тест хангалттай хийгдээгүй, ийм тест хийх бидний саналыг СЕХ зөвшөөрөөгүйгээс үүдэн санал хураалт явуулж байгаа байрны орчны хуурайшилт, шал, даамлын хувцасны синтетик орц зэргээс шалтгаалж статик цэнэгжилт үүсч улмаар машин гацах, унтрах тохиолдлууд гарсан байна.
8. Санал тоолох машин дээр зарим нэг хэсгийн хороод өөрсдөө анхааруулах хуудас бичиж хадах, саналын хуудсаа уншуулах хэсэгт сум наах зэргээр сонгогчдод саналын хуудсаа уншуулахад нь туслах арга хэмжээ авсан байлаа. Ийм зааварчилгаа байхгүйгээс мэдээллийн технологийн даамал санал тоолох машинд зарим саналын хуудсыг өөрөө уншуулах, хэт ойр ирж зааварчлах явдал гарч байсан нь саналын нууцлал алдагдах нөхцлийг бүрдүүлж байв.
9. Сонгогч саналын хуудсан дээр бэхтэй үзгээр тэмдэглэгээ хийсэнтэй холбоотой санал тоолох машинд гүйцэд хатаагүй байхад нь уншуулснаас толгойг бохирдуулах, саналын хуудсаа бохирдуулах явдал гарч байлаа.

Харин тойргийн хэсгийн хороодод тараасан машины гэрчилгээ болон сериал дугаар зөрөх, CF карт, модемийн оролт болон бусад лацадсан хэсгийн лацны бүрэн бутэн байдал алдагдсан зэрэг зөрчил, энэ асуудалтай холбоотой маргаан гараагүй нь сайшаалтай. Түүнчлэн СЕХ-ны зүгээс төхөөрөмжийн засвар үйлчилгээ болон нөөцийн хуваарилалтыг зохих түвшинд сайн зохион байгуулсныг энд дурдах нь зүйтэй.

Ерөнхийд нь дүгнэхэд:

- 1 Сонгуулийн өдөр нийт төхөөрөмжийн 0.4 хувь нь доголдож санал хураах, тоолох үйл явц гар ажиллагаанд шилжсэн. Анх удаа автомат төхөөрөмж ашигласан манай орны хувьд энэ нь чамлахааргүй үзүүлэлт болно.
- 2 Төхөөрөмжийг гэрчилгээжүүлэх, шалгах, ажиллагааг СЕХ сайн зохион байгуулсан. Сонгуулийн өдөр техникийн saat, эвдрэл бага гарсан нь ч үүнтэй холбоотой. Төхөөрөмжийг гэрчилгээжүүлэх явцад наалт зөрсөн нь өрөөний гэрэлтүүлэг муу, анхаарал суларснаас үүдсэн ба ийм алдааг дахин давтахгүй байх, илрүүлж засах арга хэмжээг нэн даруй авч хэрэгжүүлсэн нь сайшаалтай.
- 3 Хурууны хээний бүртгэл болон бүртгэлийн систем нь санал тоолох машинаас тусдаа байсныг цаашид нэгтгэж уялдааг хангах шаардлагатай.

ПРОГРАМЫН АЮУЛГҮЙ, НАЙДВАРТАЙ БАЙДАЛ

Програмын эх кодыг шалгах ажлыг улстөрийн нам, эвслийн болон ТББ-ын төлөөллийг оролцуулан СЕХ, МШХХТГ, ТЕГ-ын ажлын хэсэг 2012 оны 6 дугаар сарын 6-ны өдөр МТҮП дээр зохион байгуулсан. Ингэхэд програмыг зохиосон ДВС компанийн төлөөлөгчид урьд нь эх кодыг танилцуулж байсан туршлага илт дутагдаж хаанаас эхлэхээ мэдэхгүй байсан.

Програмын эх код маш олон модультай (40) байсан ба эдгээрээс дээр дурдсан уулзалтад оролцогчдод нийт 7 модуль танилцуулахаар болсон боловч гурвыг танилцуулсан. Үүнд саналын хуудсыг скайнердах хэсэг, скайнердсан саналын хуудсыг шалгаж тухайн саналыг хүчинтэй, эсвэл хүчингүйд тооцох хэсэг, нууцлал буюу түлхүүр үгийг шалгах хэсэг, баазтай харилцах хэсгүүдийг мөр

мөрөөр нь танилцуулсан. Танилцуулсан хэсгүүдийн эх кодод ямар нэг хорт код илрээгүй. Гэвч дээрх цөөн хэдэн модулийг шалгаад програмд хорт код огт байхгүй гэж бүрэн батлах боломжгүй болохыг энд дурдах нь зүйтэй.

Ерөнхийдөө эх код нь хэдэн сая мөртэй тул уулзалтын хэдхэн цагт багтааж хянах боломжгүй. СЕХ, ДВС эх кодтой бүрэн танилцах боломж олгоогүй ба компанийн өмч гэсэн байдлаар хандаж байсан. Түүнчлэн эхэд олон хэрэгцээгүй модулиуд байгаа нь ажиглагдсан ба энэ нь хорт кодыг нуух боломжийг бүрдүүлэх эрсдэлтэй тул хэрэгцээгүй модулиудыг салгаж зөвхөн хэрэглэгдэх модулиудыг үлдээн эх кодтой танилцах үйл ажиллагааг цаашид хялбарчлах, Австрали, Филиппин улсуудын туршлагаар эх кодыг нээлттэй болгон олон нийт чөлөөтэй танилцах боломжоор хангах шаардлагатай гэж үзэж байна.

ТӨХӨӨРӨМЖӨӨР САНАЛЫН ХУУДАС УНШУУЛАХ АЖИЛЛАГААНЫ ТЕСТ

Төслийн багийн зүгээс төхөөрөмжөөр саналын хуудас уншуулж турших хэд хэдэн хувилбар бүхий тестийн тавил боловсруулсан боловч СЕХ-ны зүгээс бидэнд түүнийгээ турших боломж олгоогүй. Харин дээр дурдсанчлан СЕХ-ны МТ-ийн төв, МШХХТГ, ТЕГ-ын хамтарсан ажлын хэсэг төхөөрөмжийг гэрчилгээжүүлэх ажил гүйцэтгэх явцад 2 өдөр байлцан ажиглалт хийсэн. Энэхүү ажиллагаа нь зохион байгуулалт сайтай байсан ба ажлын хэсэг санамсаргүй тохиолдлоор бөглөсөн 20 хуудсыг нэг машинд 50 удаа уншуулж тест хийсний зэрэгцээ ДВС 17 саналын хуудас уншуулж мөн тест хийсэн. Ялгаатай байдлаар бөглөсөн 37 саналын хуудас нь бүрэн тест хийхэд хангалтгүй байв. Ийм цөөн тооны саналын хуудсаар тест хийсэн асуудлыг саналын хуудасны хэвлэлт, түүний хяналттай холбон тайлбарлаж байлаа. Тестийн сайтар

бодож боловсруулсан тавил байхгүй байсан ба туршилтад ашигласан саналын хуудсуудыг санамсаргүй тохиолдлоор бөглөсөн байв. Түүнчлэн тест хийсний дараа уншигчийн толгойг цэвэрлээгүй нь сонгуулийн өдөр толгой бохирдох, санал хураалтад саад учруулах нэг шалтгаан болсон байх талтай.

Гэрчилгээжүүлэлтийн явцад хийсэн дээрх туршилтаас гадна 6 дугаар сарын 23-нд орон даяар бүх машинд урьдчилан бэлтгэсэн 5 хуудас уншуулж ерөнхий тест хийсний сацуу зарим нэг олон нийтийн газар, сургуулиудад иргэд санал тоолох машинд хуудас уншуулж турших боломж олгосон. Орон даяар ийнхүү урьдчилсан туршилт хийснээр сонгуулийн өдрийн ажиллагааны дарааллыг шалгах, боловсон хүчинээ дадлагажуулах боломж бүрдүүлсэн нь сайн.

МЭДЭЭЛЭЛ ДАМЖУУЛАЛТ

Мэдээлэл дамжуулах сүлжээг санал тоолсны дараа санал тоолох машинд modem холбох замаар шийдсэн нь сүлжээгээр дамжуулан хийдэг олон тооны луйвраас сэргийлэхүйц сайн шийдэл болсон гэж үзэж байна. Харин зарим хэсгийн хороодын дарга нарын хайнга байдалтай холбоотой сүлжээгээр мэдээлэл дамжуулахгүй удсан тохиолдол гарсан.

Сүлжээний modem залгах үед машин гацах тохиолдол нэлээд гарсан. Сүлжээгээр санал хураалтын дүнг дамжуулах нь уг дүнг тойргийн хороодын нэгтгэсэн дүнтэй тулгаж нягтлах, түүнчлэн нэгдсэн үр дүнг шуурхай гаргах сайн талтай байв. Харин үүрэн холбооны операторуудтай хаана үйлчилгээ үзүүлж байгаагаас нь хамаарч гэрээ байгуулалгүй цөөн тооны оператортай гэрээ байгуулсан учир үүрэн холбооны сүлжээ байгаа ч зарим сумдаас мэдээлэл дамжуулах боломжгүй байсан.

АУДИТ ЛОГИЙН ШАЛГАЛТ

Сонгуулийн өдөр төхөөрөмжид урьдчилж санал тоолж бүртгээгүйг батлах эхлэлийн лог хуудсыг цөөн тоогоор хэвлэсэн нь ажиглагчдад хүртээмжгүй байх нь олонтаа тохиолдлоо. Харин санал хураалтын дүнг үзүүлсэн лог хуудсыг хүссэн хүн бүрт хэвлэж өгч байв.

Лог хуудсыг ашиглаад хүчинтэй, хүчингүй саналыг тоолж баланс бариулахад хүндэрэл учирч байлаа. Жишээ нь, Сүхбаатар дүүргийн 23-р тойргийн 1-р хэсгийн хороонд нийт уншигдсан саналын хуудасны тоо 1251, санал огт тэмдэглэгдээгүй саналын хуудасны тоо 1 буюу нийт саналтай хуудас нь 1250 буюу 2 мандаттай тойрог тул дээд тал нь 2500 санал байх боломжтой. Үүнээс 2394 санал хүчинтэй тооцогдож 68 санал хүчингүйд тооцогдсон буюу нийт 2462 санал тоологдсон байна. Өөрөөр хэлбэл, 38 саналын зөрүү гарч ирж байна. Энэ нь нэг санал өгсөн саналын хуудасны тоо байгаа боловч үүнийг харуулсан мэдээлэл огт алга байгаа учир хүмүүст эргэлзээ төрүүлсэн байна. Харин нийслэлийн иргэдийн төлөөлөгчийн саналын хэсгийн хувьд нэг мандаттай, илүү, дутуу саналын хуудасны мэдээллийг гаргасан тул балансыг нь шалгахад хялбар, ойлгомжтой байв.

Саналын хуудас нь 4 хэсгээс бүрдсэн боловч хүчинтэй саналын хуудас гэж зөвхөн эхний хэсгийн санал нь хүчинтэй хуудсыг тоолж байсан. Ялангуяа УИХ-ын нэр дэвшигчдийн хэсэгт зөвхөн “Санал огт тэмдэглэгдээгүй саналын хуудасны тоо” хуудасны мэдээлэл гарсан.

Иргэдийн төлөөлөгчдийн хурлын нам эвсэлд өгсөн саналд дутуу саналын тоо нэлээд өндөр гарсан байна. Жишээ нь, 23-р тойргийн 1-р хэсгийн 1251 саналаас 155, 10-р хэсгийн 2-р машин 805 саналаас 99 санал дутуу буюу бөглөгдөөгүй байна. Ялангуяа өндөр настай сонгогчид энэ хэсгийг бөглөөгүй орхисон, дахиж бөглөж болох уу гэсэн асуудал гаргаж байсан. Нийслэлийн

иргэдийн хурлын төлөөлөгчийн саналд хүчинтэй саналын хуудасны тооноос илүү санал гарах тохиолдол байсан. Жишээ нь, Сүхбаатар дүүргийн 23-р тойргийн 3-р хэсгийн хороонд нийт уншигдсан санал гэдэгт 906 саналын хуудас байгаа боловч ИТХ-ын хэсэгт 908 нь хүчинтэй гэсэн байв.

Үр дүнгийн тайландаа төхөөрөмжийн серийн дугаар, тойрог, хэсгийн хорооны дугаар зэрэг нийтэд нээлттэй мэдээлэл хэвлэгдэж байсан. Зарим хуудсанд тойрог, хэсгийн дугаар хэд хэд давтагдсан байсан ба сонгуулийн тойргийн дугаар гэсэн мөрөнд хэсгийн хорооны дугаар бичигдсэн зэрэг алдаа байсныг цаашид анхаарч засах шаардлагатай. Түүнчлэн үр дүнгийн хуудсыг өөр газар хэвлээд солих бололцоотой бүх мэдээлэл нь статик буюу нууцлал байхгүй байсан. Эцэст нь нэмж дурдахад саналын хуудасны хэсгүүд, ялангуяа нийслэлийн ИТХ-ын 2 хэсгийн хороонд зайд, ялгалт багатай байсан тул нам, эвслийн хэсгийг бөглөхгүй орхих тохиолдол нэлээд тохиолдсон байж болзошгүй байна.

АЖИЛЛАХ БОЛОВСОН ХҮЧНИЙ ГЭРЧИЛГЭЭЖҮҮЛЭЛТ, ШАЛГАЛТ

Мониторингийн хүрээнд ажиллах боловсон хүчин бэлтгэх хөтөлбөртэй танилцах, санал оруулах, чадамжийн үнэлгээг түүвэрчлэн хийхээр тусгагдсан боловч СЕХ-ны зүгээс мэдээлэл, боломжоор хангаагүй тул энэ асуудлаар дүгнэлт гаргах аргагүй байна. Харин ажиглалтын явцаас харахад хэсгийн хороод дээр ажилласан мэдээллийн технологийн ажилтнуудын мэдлэг дутмаг тухайлбал, төхөөрөмжийг зайнд холбохдоо туйлыг сольж холбосон, алдаа гарсан үед хэрхэн ажиллах, хаашаа хандахаа мэдэхгүй тохиолдлууд гарч байлаа.

ЗОХИОН БАЙГУУЛАЛТ ХЯНАЛТ

2012 оны сонгуулиар сонгогчийн бүртгэлийг УБЕГ, харин сонгогчийн бүртгэлийн автоматжуулсан системийг СЕХ хариуцаж ажилласан. Энэхүү хоёр байгууллагын хоорондын үйл ажиллагааны уялдаа муугаас СЕХ нь УБЕГ-ын сонгогчдын мэдээллийн бааз дахь хурууны хээний стандартаас өөр стандарттай хурууны хээ унших төхөөрөмж авсан. Үүнээс үүдэлтэй бэрхшээл нэлээд учирсан ч хурууны хээний баазад хувиргалт хийсний үр дүнд асуудлыг эцэст нь шийдэж чадсан байна.

СЕХ-ны хувьд сонгуулийн шинэ хуулийг хэрэгжүүлж байгаатай уялдан холбогдох журмуудад ойр ойр өөрчлөлт хийж байсан нь оролцогч талуудыг төөрөгдүүлэх сөрөг талтай байв. Тухайлбал, автоматаар тоолсон саналын дүнг хяналтын тооллого гараар хийх замаар баталгаажуулах асуудлыг сонгуулийн өмнөхөн шийдсэн ба хэрхэн хийх талаар заавар, журам гаргаагүй тул ойлгомжгүй байдал үүсэхэд хүргэсэн. Харин боловсруулж баталсан журам, тогтоолыг өөрийн цахим хуудсаар дамжуулан нийтэд танилцуулах ажиллагааг сайн зохион байгуулж чадсан ба цаашид энэ мэдээллийг цаг тухайд нь хожимдуулалгүй гаргахад анхаарах нь чухал юм. Тойрог бүрээс санамсаргүй тохиолдлоор сонгож хийсэн 2 хэсгийн хороо буюу нийт 52 хэсгийн хорооны хяналтын тооллогын дүн 2 хэсгийн хорооноос бусадад яг тохирч, нэг хэсгийн хороонд 1, нөгөөд нь 3 саналаар зөрсөн нь санал тоолох машинд итгэж болохыг илтгэсэн дүн гарчээ гэж үзэж байна.

Санал тоолох машины уншсан саналын хуудаснуудын зурган файлыг 2 хувь хэвлэж өгсөн. Энэ үйл явц хэсгийн хороо тус бүр дээр харилцан адилгүй явагдсан ба энэ тал дээр мэдээллийн технологийн даамлуудад зааварчилгаа дутмаг өгөгдсөн нь ажиглагдсан. Саналын хуудасны зурган файлыг ийнхүү хувилж тараах саналын

нууцлалыг алдагдуулах эрсдэлтэй гэх болгоомжлол олон нийт болон зарим хэсгийн хороодын гишүүд, улс төрийн намын төлөөллүүд дунд байсан нь СЕХ-ны зүгээс энэ талаар зөв ойлголт өгөх, мэдээлэл түгээх асуудалд хангалттай анхаараагүйтэй холбоотой гэж үзэж байна.

Төхөөрөмжөөс үр дүнг хэвлэн гаргасан хуудсан дээр санал тоолох машинд хамгийн эхэнд уншуулсан болон хамгийн сүүлд уншуулсан саналын хуудасны цаг хугацааг гаргах боломжгүй ба зөвхөн үр дүнг хэзээ хэвлэсэн цагийг л үзүүлсэн байв. Үүний зэрэгцээ явуулын хайрцгаар авсан саналыг хэдийд машинд уншуулах талаар нарийвчлан заагаагүй зэрэгтэй холбоотой 20 цагаас хойш санал хураалт үргэлжилсан гэсэн хардлага үүссэн.

СОНГОГЧИЙН БҮРТГЭЛ БА ХУРУУНЫ ХЭЭ ТАНИХ ТӨХӨӨРӨМЖИЙН АЖИЛЛАГАА

Энэ удаагийн ээлжит сонгуулиар эрх бүхий сонгогч мөн болохыг батлах иргэний цахим үнэмлэх ашиглахаар төлөвлөөд байсан ч бүрэн хэвлэх боломжгүй болсон тул цахим үнэмлэх унших биш хурууны хээ унших төхөөрөмж ашигласан билээ. Мониторингийн багт сонгуулийн бэлтгэл явцад хурууны хээ таних төхөөрөмж, зөөврийн компьютерийг бэлтгэх явцыг алсаас ажиглах боломж олгосон. Сонгогчийн нэрсийн жагсаалт гаргахдаа холбогдох байгууллагууд дараах байдлаар ажилласан. Үүнд:

1. УБЕГ-аас сонгогчдын жагсаалтыг Excel file хэлбэрээр offline горим дээр ажиллахаар аймаг, сум, дүүрэг, хороо руу илгээсэн. Ингэхдээ жагсаалтад сонгогчийн нэр давхардсан эсэхийг шалгаж тулгалт хийсэн. Энэ ажил нь 6 дугаар сарын 19-нд дууссан. Энэ мэдээллийн дагуу нэрийн жагсаалтыг эцэслэн СЕХ-нд гардуулсан байна.

- Тойргийн хороодоос ирсэн нэмэлт, хасалттай холбоотой мэдээллийг баазад оруулж шалгах тусгай програм зохиож шалгажээ.
 - Сонгогчдын нэрийн жагсаалттай ажиллах талаар З өдрийн сургалт холбогдох хүмүүст зориулан зохион байгуулсан.
 - 6 дугаар сарын 23-ны байдлаар мэдээллийн баазыг цоожижлж сонгогчдын нэрийн жагсаалтад өөрчлөлт оруулах боломжгүй болгосон.
- Сонгуулийн өдөр иргэний нийгмийн ажиглагчдын хийсэн ажиглалтын дүнгээс үзэхэд:
- Бүртгэлийн хэсэгт сонгогчийн хурууны хээг танихгүй байх, хэвлэх машин гацах, компьютер гацах, мэдээллийн баазад бүртгэлгүй хүмүүс олон байх зэрэг тохиолдлууд нийслэлийн 10 гаруй хэсгийн хороонд гарсан байна.
 - Компьютер гацсан нөхцөлд ихэнх тохиолдолд унтрааж дахин асаах хэлбэрээр өөрсдөө засах оролдлого хийж байсан.
 - Хурууны хээний машин бохирдсоноос уншихгүй байх тохиолдол 22-р тойргийн 12-р хэсгийн хороонд гарсан.
 - Бүртгэлийн системийг автоматжуулсны ачаар 25-р тойргийн 24 хэсгийн хороон дээр дахин санал өгөх оролдлого 2 удаа гарсныг болон 9-р хэсгийн хороон дээр хүүхдийнхээ иргэний үнэмлэхээр санал өгөх гэж байсан тохиолдлыг тус тус илрүүлжээ.
 - Хэдийгээр шинэчилсэн бүртгэлд бүртгэгдсэн ч иргэд шилжилтийн бүртгэлээ бүрэн хийгээгүйн улмаас мэдээллийн баазад өөрчлөлт хийгдээгүй тохиолдол нэлээд гарсан. 24-р тойргийн 46-р хэсгийн хороонд шинээр ашиглалтад орсон байрны оршин суугчид бүртгэгдээгүй байсан тул мэдээллийн баазад байгаагүй.
 - Бүртгэлийн систем нь зөвхөн кабель утсаар хоорондоо сүлжээ үүсгэсэн гадагшаа сүлжээнд холбогдоогүй тул толгой компьютер дээр тухайн хэсгийн хорооны сонгогчдын мэдээллийн баазыг суурилуулсан байсан.
 - Мэдээллийн баазад байхгүй сонгогчид олноор гарч байсан нь зарим тохиолдолд бүтэн байшин 2 хэсгийн хорооны дунд орхигдох, шилжилт хөдөлгөөнөө хийлгээгүй байх, бүртгэлийн ажилтны алдаа зэргээс болж байлаа.
 - Хурууны хээ танихгүй тохиолдолд шууд регистрийн дугаараар оруулах тохиолдолд хэд хэд гарсан.

Эндээс дүгнэхэд энэ удаагийн сонгуулиар шинэчилсэн бүртгэл, хүний хөгжлийн мөнгөтэй холбоотой иргэдийн мэдээллийн бааз нэлээд зүгширсэн нь сонгогчдын нэрийн жагсаалтыг гаргах, шалгахад ихээхэн дөхөм болсон. Гэвч хурууны хээ танигч болон сүлжээнд ажиллаж байгаа компьютер, принтерүүдийн тест бүрэн хийгдээгүй, ажиллаж байгаа хүмүүсийн бэлтгэл сайн хангагдаагүй байсантай холбоотой зарим бэрхшээл үүссэн байна. Түүнчлэн хурууны хээ нь танигдаагүй сонгогчийгэрхбүхий сонгогч болохыг хэрхэн тогтоож санал өгүүлэх талаарх журам тодорхойгүй байсантай холбоотойгоор хэсгийн хорооны гишүүд шийдвэр гарган шууд регистрийн дугаарыг нь шалган санал өгүүлсэн тохиолдлууд бүртгэгдсэн байна. Мониторингийн багийн зүгээс сонгогчдын нэрийн жагсаалт, мэдээллийн баазын давхардлыг санамсаргүй түүврээр шалгах хүсэлт УБЕГ-т тавьсан боловч хугацаа давчuu байсан гэсэн шалтгаанаар хүлээж аваагүй болно.

2.4 МОНИТОРИНГИЙН ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Сонгуулийн шинэ хуулийг хэрэгжүүлэх, санал тоолох машиныг анх удаа хэрэглэх, сонгуулийн шинэ системийг хэрэгжүүлэх зэрэг олон шинэ үйл ажиллагааг зохион байгуулах амаргүй сорилт СЕХ-нд энэ удаагийн ээлжит сонгуулиар тулгарсан бөгөөд системийн дизайн, зохион байгуулалтыг ерөнхийдөө амжилттай гүйцэтгэж хэрэгжүүлсэн гэж үзэж байна. Цаашид автоматжуулсан системийг ашиглахын тулд програмын эх кодыг нээлттэй болгох, үйл ажиллагааны бүрэн тест хийх, хяналтын тооллого хийх журмыг батлах зэрэг асуудлуудад анхаарч ажиллах шаардлагатай байна. Түүнчлэн СЕХ, УБЕГ болон бусад байгууллагын хоорондын хамтын ажиллагаа, уялдаа холбоог сайжруулахад анхаарах шаардлагатай байна.

ЗӨВЛӨМЖ

1. Техникийн бүрэн бүтэн найдвартай байдлыг хангах, цүнд оролцогч талуудын хяналт, оролцоог нэмэгдүүлэх

- САС-ийн бүрэн бүтэн, найдвартай байдалд хөндлөнгийн хяналт хийх, холбогдох бүх үйл явцыг тасралтгүй ажиглах нөхцлийг магадлан итгэмжлэгдсэн, зөвшөөрөл бүхий иргэний нийгмийн байгуулагуудад бүрдүүлж өгөх;
- Санал хураах автомат төхөөрөмжийг шалгаж гэрчилгээжүүлэхдээ техникийн орчны тест хийх;

- Санал тоолох машины толгойг хэрхэн цэвэрлэх тухайлбал, ямар хуудсаар цэвэрлэдэг болох, тэр нь санал тооллогын дүнд ямар ч нөлөөгүй байх талаар баталгаа гарган гэрчилгээжүүлэлтийн үед шалгах;
- Төхөөрөмжөөр саналын хуудсыг хэрхэн уншуулах зааврыг сонгогчдод ойлгомжтой болгож уншигчийн дээр сум, анхааруулга наах гэх мэт арга хэмжээ нэгдсэн байдлаар авах;
- Санал тоолох машин сонгогчийн санал уншсаны дараа хүчинтэй, хүчингүй, санал хэрхэн уншигдсан эсэхийг хэвлэн мэдээлдэг байх технологийг цаашид нэвтрүүлэх.

2. Програм хангамжийн найдвартай баталгаатай байдлыг хангах

- Австрали, Филиппин улсуудын туршлагаар эх кодыг цаашид нээлттэй болгон олон нийт чөлөөтэй танилцах боломжоор хангах;
- Сонирхогч талуудад эх кодыг үзэх боломжоор бүрэн хангах үүднээс “Сонгуулийн автоматжуулсан системийн мэдээллийн сангийн мэдээлэл, түүнтэй холбогдох бусад мэдээллийг нууцлах, нууцалсан мэдээлэлтэй харьцах” журмын 1.3 буюу” СЕХ нь сонгуулийн тухай хууль тогтоомжид нийцүүлэн САС-ийн аюулгүй байдлыг хангах зорилгоор дараах мэдээллүүдийг хаалттай байлгана” гэсэн заалтын 1.3.4-д санал тоолох төхөөрөмжийн программын эх код, 1.3.5-д санал хураалтын үр дүng нэгтгэх программын эх код гэсэн заалтуудыг өөрчлөх;
- Програм хангамж нийлүүлэх компанийтай гэрээ хийхдээ эх кодыг нээлттэй байх заалтыг оруулах.

3. Төхөөрөмжийн тест, цр дцнг нээлттэй, хүртээмжтэй болгох

- Төхөөрөмжийн ажиллагааг иргэдэд танилцуулах үйл ажиллагааг илүү өргөн хүрээтэй зохион байгуулах, үүнд олон нийтийн мэдээллийн хэрэгслүүдийг татан оролцуулах;
- Тестийн тавил зохиож түүнийгээ сонирхогч талуудад нээлттэй танилцуулах, нам эвсэл болон хөндлөнгийн хяналтын байгууллагууд, олон нийтийн мэдээллийн хэрэгслүүдийг тестийн үйл ажиллагаанд өргөн оролцуулах;
- Тест хийсний дараа машинуудын толгойг цэвэрлэх;
- Тестийн дүнг олон нийтэд нээлттэй танилцуулах.

4. Мэдээлэл дамжуулалтыг хурдасгах

- Интернэтийн холболтгүй газруудад интернэтэд холбох асуудлыг шийдвэрлэх;
- Сумдад үйлчилгээ үзүүлж үүрэн холбооны операторуудыг нь олж тогтоон гэрээ хийж тэдгээрийн сүлжээг ашиглан мэдээлэл дамжуулах.

5. Аудит логийн шалгалтыг сайжруулах

- Үр дүнгийн саналын хуудас хэвлэхэд хэсгийн хорооны даргын болон мэдээллийн технологийн даамлын нууц түлхүүрийг ашиглан тухайн хэсгийн хорооны нууцлал бүхий дугаарыг хэвлэж баталгаажуулах;
- Үр дүнгийн тайланг ойлгоход хялбар болгох үүднээс цэгцлэх саналын хуудасны тооноос гадна хэсэг тус бүрийн хувьд хүчинтэй саналын тоог гаргах, мөн огт санал өгөөгүй, 1, 2, 3 санал өгсөн саналын тоог тус тусд нь гаргаж балансыг нь харах бололцоо олгох;

- Лог хуудасны давхардсан мэдээллийг цэгцэлж эмх замбраатай болгох,
- Саналын хуудсанд өөр өөр хэсгүүдийг нэг нэгнээс ялгагдахаар сонгогчдод шууд харагдахаар тусгаарлагчтай хэвлэх.

6. Ажиллах боловсон хүчиний чадавхийг нэмэгдүүлэх

- Мэдээллийн технологийн суурь мэдлэгтэй хүмүүсийг бүртгэлийн болон мэдээллийн технологийн даамлаар ажиллуулах, өмнөх үр дүнд суурилсан ахисан шатны сургалт зохион байгуулах, ажиллах хүчиний гэрчилгээжүүлэлт, шалгалтыг хөндлөнгийн байгууллагаар хийлгэх.

7. Зохион байгуулалт, хяналтыг боловсронгуй болгох

- Хэсгийн хороод дээр ажилласан мэдээллийн технологийн даамал нь зөвхөн САС-ийн санал тоолох машиныг бус сонгогчийн бүртгэлийн асуудлыг давхар хариуцаж байхаар цаашид зохион байгуулах;
- СЕХ, УБЕГ-ын явуулын засвар үйлчилгээг нэгтгэн зохион байгуулж, шуурхай ажиллагааг хангаж зардлыг хэмнэх;
- Хяналтын тооллого хийх тусгай журам боловсруулах;
- Хяналтын тооллогын үр дүнг олон нийтэд нээлттэй мэдээлэх, онлайнаар харуулах;
- Явуулын хайрцаар авсан саналыг хураалтын дараа бус өмнө нь уншуулахаар журамд тусгах.

8. Сонгогчийн бүртгэл ба хурууны хээ таних төхөөрөмжийг шалгах цүл явцыг боловсронгуй болгох

- Тойрог тус бүрээс санамсаргүй тохиолдлоор 2-3 хэсгийн хорооны сонгогчдын нэрийн жагсаалтыг мэдээллийн баазтай нь тулгалт хийх;

- Мэдээллийн баазад байгаа сонгуулийн насны иргэдийн тоо сонгогчдын нэрийн жагсаалтын тоог тулгах;
- Иргэдийн шилжилт хөдөлгөөнийг цаг тухайд нь хийдэг болгох тал дээр анхаарах, энэ талаар олон нийтэд хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан сурталчилж таниулах;
- Хурууны хээний машиныг ажиллуулах боловсон хүчний сургалтыг сайжруулах;
- Хурууны хээний машинтай ажиллах зааварчилгааг сайтар боловсруулж бэлтгэх;
- Ямар нөхцөлд регистрийн дугаараар бүртгэлийн хуудас хэвлэх журмыг тодорхой болгох.

Түүнчлэн сонгуульд хяналт тавьж буй иргэний нийгмийн байгууллагуудын хувьд СЕХ-той хамтран ажиллахад харьцангуй түвэг багатай байсан ч УБЕГ-тай харьцахад олон хүндрэл бэрхшээл тулгарч байсныг дурдах нь зүйтэй. Цаашид энэ байгууллагын зүгээс сонгуулийн үйл явц ил тод байх хуульд заасан зарчмын хүрээнд сонгогчдын нэрийн жагсаалтад давхардлыг шалгах, нэрийн жагсаалт гаргаж байгаа програмд тест хийх зэрэг асуудлаар иргэний нийгмийн байгууллагуудтай хамтарч ажиллах нь сонгогчдын нэрийн жагсаалтын үнэн зөв байдалд итгэх оролцогч талуудын итгэлийг нэмэгдүүлэх ач тустай юм.



ФИЛАНТРОПИ ХӨГЖЛИЙН
ТӨЛӨӨ ТӨВ

СОНГОГЧДЫН НЭРИЙН ЖАГСААЛТЫН МОНИТОРИНГ



Дорнод аймгийн Иргэний
бүртгэлийн улсын бүртгэгчид
сонгогчийн нэрийн жагсаалтыг
нягтлан шалгаж дууслаа.
2012 оны 4 сар.

3.1 ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

ЗОРИЛГО

2012 оны Монгол Улсын Их Хурлын ээлжит сонгуулийн ил тод, шударга явагдах нөхцлийг бүрдүүлэхэд иргэний нийгмийн оролцоог хангах, сонгогчдын нэрийн жагсаалт, түүнтэй холбогдох хууль тогтоомж, сонгогчдын эрхийн хэрэгжилтэд хяналт тавьж, зөрчлөөс сэргийлэх.

ЗОРИЛТУУД

1. Сонгогчдын нэрийн жагсаалт хуулийн хүрээнд үнэн зөв хийгдсэн эсэхэд үнэлгээ хийх:

- Зохих стандарт шаардлагыг хангасан байдал
 - Сонгогчдын овог, нэр, хаяг, иргэний үнэмлэх, регистрийн бүртгэл бүрэн хийгдсэн эсэх.
- Хуулийн хүрээнд холбогдох журмын дагуу хийгдсэн байдал
 - Байнгын оршин суугчдыг бүрэн хамруулсан эсэх;
 - Шинээр сонгуулийн насанд хурсэн сонгогчдыг бүрэн хамруулсан эсэх
 - Гадаадад байгаа сонгогчдыг жагсаалтаас хассан эсэх.

2. Сонгуулийн хэсгийн хороодын нэрийн жагсаалттай холбоотой үйл ажиллагаанд хяналт тавих:

- Нэрийн жагсаалтыг ил тод нээлттэй танилцуулах байдал
 - Сонгогчдын нэрийн жагсаалтыг хуулийн хугацаанд нь гаргасан эсэх;

- Иргэдэд ил тод нээлттэй хүргэсэн эсэх.

3. Цагдан хорих 461-р анги болон Албадан саатуулах баривчлах төвд байгаа сонгогчдын нэрийн жагсаалтад тулгалт хийх:

- Сонгуулийн хэсэгт бүртгэгдсэн иргэдийн байнга оршин суух хаягт тулгалт хийх.
- 4. Сонгогчдын нэрийн жагсаалттай холбоотой гаргасан гомдол, зөрчлийг шийдвэрлэсэн байдалд үнэлгээ хийх.

Мониторингийн зорилго, зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг шат дараатай хэрэгжүүллээ. Үүнд:

Сонгуулийн өмнө:

- УБЕГ-ын иргэдийн шилжилт хөдөлгөөний мэдээллийг 2012 оны эхний хагас болон 2011 оны мөн үетэй харьцуулав.
- Сонгуулийн хэсгийн хороодын сонгогчдын нэрийн жагсаалттай холбоотой үйл ажиллагаанд хяналт хийсэн (СХД-ийн 20 хэсгийн хороонд).
- Цагдан хорих 461-р ангиас гаргаж өгсөн сонгогчдын нэрийн жагсаалтад хяналт тавьсан.
- Дэнжийн мянгийн албадан саатуулах байр буюу “111”-ээс гаргаж өгсөн сонгогчдын нэрийн жагсаалтыг хянасан.
- Шилжилт хөдөлгөөн хамгийн их байгаа СХД-ийн сонгуулийн 20 хэсгийн хороог сонгон авч сонгогчдын нэрийн жагсаалтад лавлагааг үндэслэн оруулж байгаа өөрчлөлтөд ажиглалт хийх аргаар хяналт тавьлаа.

Сонгуулийн дараа:

- Зөөврийн хайрцагаар санал өгсөн сонгогчдын нэрийн жагсаалтад тулгалт хийсэн.

Саналын хуудасны мониторингийн хүрээнд дараах тодорхой асуудлууд анхаарал татаж байв. Үүнд:

Сонгогчдын нэрийн жагсаалтын давхардал: Гадаадад байгаа сонгогчдын нэрийн жагсаалтыг хэзээ, хэрхэн үйлдэж, хаана хүргүүлэх талаарх зохицуулалт дутагдалтай, түүнчлэн УБЕГ-т Монгол Улсын иргэний гадаадад зорчсон болон аль улсад оршин суугаа бүртгэл байдаггүйтэй холбоотой гадаад улсад амьдарч буй сонгогчдын нээрс дотоодод санал өгөх сонгогчдын нэрийн жагсаалтад давхардах магадлалтай. Үүнээс гадна захиргааны зөрчил болон байцаан шийтгэх албадлагын арга хэмжээний улмаас баривчлагдсан, албадан саатуулагдсан, цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авагдсан сонгуулийн насны иргэдийн нэр сонгогчдын нэрийн жагсаалтад давхардал үүсгэж болзошгүй.

Шилжилт хөдөлгөөний талаар: Нэр дэвшигчид өөрт нь санал өгөх сонгогчдыг олноор нь нэр дэвшсэн тойрогоо нүүлгэн шилжүүлэх ажиллагааг зохион байгуулдаг нь өмнөх сонгуулиудаар ажиглагдсан тул иргэдийн засаг захиргааны нэг нэгжээс нөгөө нэгжид шилжих хөдөлгөөнийг хяналж, улмаар өмнөх жилийн мөн үетэй, өмнөх сартай гэх мэтээр харьцуулж хяналт тавих нь зүйтэй гэж үзсэн. Шилжилт хөдөлгөөн хамгийн өндөр Улаанбаатар хотын СХД-ийн 20 хороог сонгож, нэрийн жагсаалтад хяналт хийв.

Сонгогчдын нэрийн жагсаалттай холбоотой гомдолыг хянан шийдвэрлэх үйл явц: УИХ-ын сонгуулийн тухай шинэ хуульд заасанчлан 2012 оны сонгуулийн үеэр сонгогчдын нэрийн жагсаалтад өөрчлөлт оруулахдаа УБЕГ-ын лавлагааг үндэслэх болсон. Гэвч энэ нь сонгочийг хэд хэдэн хэсгийн хороонд бүртгэн давхар санал өгүүлэхгүй байх хангалттай баталгаа болж чадахгүй байна гэж дүгнэв.

Сонгогчдын нэрийн жагсаалттай холбоотой хэсгийн хорооны цургийн талаар: Сонгуулийн хэсгийн хороод сонгогчдын нэрийн жагсаалтыг өөрийн байранд ил тавьж нийтэд танилцуулах үүргийг хуулиар хүлээсэн ч энэ үүргээ биелүүлэх талаар туйлын хайхрамжгүй ханддаг, нэрийн жагсаалтыг хуульд заасан хугацаанд ил тавьдаггүй, сонгогчдын эрх ашгийг хамгаалан ажилладаг иргэний нийгмийн байгууллагууд хяналт тавих боломж хомс байгаа нь сонгогчдын нэрийн жагсаалтыг анхлан нэгтгэх явцад гарсан алдаа тэр чигээрээ засагдахгүй үлдэх, улмаар будлиан зөрчил гарах нөхцлийг бурдуулдэг. Үүнээс үүдэлтэй хуульд заасанчлан хэсгийн хороод сонгогчдын нэрийн жагсаалтыг өөрийн байранд ил тавьж “Сонгогчдод чөлөөтэй танилцах бололцоо олгоно” гэсэн заалтын биелэлтэд хяналт тавих нь зүйтэй гэж үзсэн билээ.

МОНИТОРИНГИЙН АРГАЧЛАЛ

Сонгогчдын нэрийн жагсаалтад мониторинг хийх уг төслийг хэрэгжүүлэхэд олон улсад сонгогчдын нэрийн жагсаалтад мониторинг хийхэд ашигладаг дараах үндсэн аргуудыг дотоодын нөхцөлд тохиуулан боловсруулж ашигласан болно. Үүнд:

1. Нэрийн жагсаалтын мониторинг

А. Сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдсэн иргэний мэдээллийг хаягаар нь очиж тулгах (list-to-people)

- Сонгогчдын нэрийн жагсаалтад нэг хаяг дээр 6 ба түүнээс дээш сонгогч бүртгэлтэй хаягийн бүртгэлийг хийж нэрийн жагсаалт дахь хаягийн дагуу очиж шалгах, мэдээлэл үнэн зөв эсэхийг нягтлах;
- Нэр бүхий иргэн тухайн хаяг дээрээ байнга болон түр оршин суугаа бол, тухайн хаяг дээр байдаг ч сонгуулийн санал хураах өдрийг өнгөртөл эзгүй байх бол, байнга

оршин суудаггүй ч сонгуулийн саналыг тухайн хаягаар өгөх бол мэдээлэл өгөгч иргэний өөрийнх нь зөвшөөрлөөр холбоо барих утас, регистрийн дугаарыг нь авч нэрийн жагсаалттай тулгах.

Б. Иргэдээс нэрийн жагсаалтад байвал зохих мэдээллийг авч жагсаалттай тулгах (people-to-list)

- УИХ-ын сонгуулийн 26-р тойргийн хороонд хамаарах тодорхой хаяг дээр оршин суугаа хүнээс мэдээлэл авч сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдсэн эсэх, хэрэв бүртгэгдсэн бол мэдээлэл нь үнэн зөв эсэхийг нягтлах. Ингэхдээ СЕХ-ноос хүлээн авсан сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэсэн хаягаар очиход нэр бүхий иргэн тухайн хаяг дээр огт оршин суудаггүй юмуу нас барсан тохиолдолд түүний оронд тухайн хаяг дээр байнга болон түр оршин сууж буй хүнээс өөрийнх нь зөвшөөрлөөр холбоо барих утас, регистрийн дугаарыг нь авч нэрийн жагсаалттай тулгах.

Дээрх аргачлалын хүрээнд мэдээлэл цуглуулах явцад:

- Нэр бүхий иргэнтэй холбоо барьж, мэдээлэл авч чадаагүй бол, холбоо барьж, уулзсан ч тухайн хүн мэдээлэл өгөхөөс татгалзсан бол, хаяг дээр байнга буюу удаан хугацаагаар оршин сууж байгаа хүнтэй холбоо барьж мэдээлэл авч чадаагүй бол тухайн иргэний хаягаар тодорхой хугацааны дараа дахин очих, зурvas захидал үлдээх, холбоо барих нэмэлт хаяг олж авах,
- Хэрэв дээрх арга хэмжээ авсны дараа холбогдож чадаагүй тохиолдолд мониторингийн багийн ахлагчаар

баталгаажуулсны үндсэн дээр зохицуулах хэсгийн зөвшөөрлөөр тусгай тэмдэглэл хөтлөн мэдээлэл авах уйл ажиллагааг зогсоно.

2. Сонгогчдын нэрийн жагсаалттай холбоотой хэсгийн хороодын үйл ажиллагааны мониторинг

- Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль болон СЕХ-оос гаргасан сонгуулийн тухай хуулийг хэрэгжүүлэх цаг хугацааны хугаарийн дагуу хэсгийн хороод сонгогчдын нэрийн жагсаалтыг цаг хугацаанд нь өөрийн байранд ил тавьж, нийтэд чөлөөтэй танилцах бололцоо олгосон эсэхэд ажиглалт хийх;
- Мониторингийн явцад илэрсэн зөрчлийг СЕХ-нд мэдээлсний дагуу нэрийн жагсаалтад зохих өөрчлөлтийг оруулж, зөрчлийг арилгасан эсэхийг хянах. Үүнд:
 - Нас барсан хүмүүсийн нэрийг зохих ёсоор хассан эсэх;
 - Гадаадад байгаа хүмүүсийг зохих тодотголоор бүртгэсэн эсэх;
 - Насанд хүрээгүй хүүхдийн нэрийг хассан эсэх;
 - Шилжсэн хүмүүсийн нэр давхардан орсон эсэх.

Төслийн явцад мониторингийн үр дүнг “Шударга Сонгуулийн Төлөө Иргэний Нийгмийн Хяналт” сүлжээний мэдээллийн албаар дамжуулан долоо хоног тутам олон нийтийн хүртээл болгож байв. Түүнчлэн илэрсэн зөрчлийн талаарх мэдээллийг илгээн зохих арга хэмжээ авах талаар санал зөвлөмжийн хамт СЕХ-нд цаг тухайд нь хүргүүлж ажиллалаа.

ХАМАРСАН ХҮРЭЭ, ТҮҮВЭР

2012 оны УИХ-ын сонгуулийн 25-р тойргийн 50-р хэсгийн хороо буюу БГД-ийн Цагдан хорих 461-р анги байрлах хэсгийн хороо, 24-р тойргийн 25-р хэсгийн хороо буюу ЧД-ийн 12-р хорооны Албадан саатуулах баривчлах төв 111, 2012 оны 1 дүгээр сараас 4 дүгээр сарын 25-ны хооронд хамгийн их шилжилт хөдөлгөөн хийгдсэн СХД-ийн 20 хэсгийн хороодын сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдсэн нийт сонгогчид.

ТӨСЛИЙН БАГ

Сонгогчдын нэрийн жагсаалтад хийсэн мониторингийн төслийг “Шударга Сонгуулийн Төлөө Иргэний Нийгмийн Хяналт” сүлжээний гишүүн байгууллага “Филантропи Хөгжлийн төлөө төв”-ийн тэргүүн Ч. Мөнхцэцэг удирдаж, төслийн үндсэн зохицуулагчаар тус төвийн гүйцэтгэх захирал Д. Сүнжид ажиллалаа. Төсөлд өмнөх мониторингийн төслүүдэд амжилттай ажиллаж байсан туршлагатай 4 үндсэн судлаач, 20 сайн дурын ажилтан нийт 24 хүн ажилласан.

3.2 ХУУЛЬ, ЭРХЗҮЙН ОРЧИН

2011 онд батлагдсан УИХ-ын Сонгуулийн тухай хуульд сонгогчдын нэрийн жагсаалтыг үйлдэх, хянах, танилцуулах, үйл явцыг өмнөхөөс боловсронгуй болгож УБЕГ-ын үүрэг оролцоог нэмэгдүүлэн, улмаар төрийн бус байгууллагууд мониторинг хийх нөхцлийг хангасан дэвшилттэй өөрчлөлт туссан билээ. Түүнчлэн уг хуульд хэсгийн хороог сонгогчдынх нь тоог харгалзан байгуулахдаа нэгж хэсгийн хороонд харьялагдах сонгогчдын тоог цөөлж, хэсгийн хороодын тоог нэмэгдүүлэх, иргэний шинэ цахим үнэмлэх нэвтрүүлж сонгогчийн үнэмлэх олгохыг зогсоох зэрэг өөрчлөлтүүд багтсан нь сонгогчдын нэрийн жагсаалтыг ашиглан будлиан гарахаас сэргийлэх чухал алхам болжээ.

Сонгогчдын нэрийн жагсаалттай холбогдох үйл явцыг хууль болон холбогдох журмаар хэрхэн зохицуулсныг товч танилцуулъя.

СОНГОГЧДЫН НЭРИЙН ЖАГСААЛТЫГ ҮЙЛДЭХ ТУХАЙ

УИХ-ын Сонгуулийн тухай шинэ хуульд зааснаар сонгогчдын нэрийн жагсаалтыг иргэний шинэчилсэн бүртгэлд үндэслэн улсын хэмжээнд нэгтгэн гаргах, шаардлагатай өөрчлөлтийг цаг тухайд нь оруулах үүргийг УБЕГ бүхэлд нь хариуцаж, сонгуулийн хэсгийн хороод өмнөхийн адил дураараа өөрчлөлт оруулахыг хориглосон.

Түүнчлэн Улсын дээд шүүх эрх зүйн чадамжгүй нь шүүхийн шийдвэрээр тогтоогдсон сонгуулийн насны иргэдийн мэдээллийг, шүүхийн шийдвэр гүйцэтгэх төв байгууллага хорих газарт ял эдэлж байгаа сонгуулийн насны иргэдийн мэдээллийг тус тус гаргаж улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хуульд заасан хугацаанд хүргүүлэн сонгогчийн нэрийн жагсаалтад өөрчлөлт оруулахаар тусгасан нь өмнөх сонгуулиудаар нэрийн жагсаалтад гарч байсан давхардлыг арилгах зорилго агуулж байна (20.6).

ҮИХ-ын сонгуулийн тухай хуулиас

20.1. Сонгогчдын нэрийн жагсаалтыг иргэний бүртгэл, мэдээллийн улсын санд үндэслэн үйлдэх бөгөөд түүнийг нягтлан шалгах, давхардлыг арилгах, сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдээгүй сонгуулийн эрх бүхий иргэнийг бүртгэх зэрэг ажлыг улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага улсын хэмжээнд зохион байгуулж, нэгдсэн удирдлагаар хангана.

СОНГОЧДЫН НЭРИЙН ЖАГСААЛТЫГ НИЙТЭД ТАНИЛЦУУЛЖ ХЯНАХ БОЛОМЖООР ХАНГАХ ТУХАЙ

УБЕГ-аас сонгогчдын нэрийн жагсаалтыг үйлдэн иргэд, сонгогчдод регистрийн дугаараар нэвтрэн өөрт холбогдох мэдээллээ нягтлан шалгах боломжийг бүрдүүлжээ.

ҮИХ-ын сонгуулийн тухай шинэчлэгдсэн хуулиас

20.5. Улсын бүртгэлийн насуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага сонгуулийн эрх бүхий иргэнийг энэ хуулийн 20.4-т заасан цахим хуудаст байрлуулсан сонгогчдын нэрийн жагсаалт дахь зөвхөн өөрт нь холбогдох мэдээллэтийг танилцах боломжоор хангана.

Түүнчлэн хэсгийн хороо сонгогчдын нэрийн жагсаалтыг сонгуулийн насны иргэдийн мэдээлэлтэй тулган хэсгийн хорооны дарга, нарийн бичгийн дарга гарын үсэг зурж, санал авах өдрөөс 20-иос доошгүй хоногийн өмнө өөрийн байранд ил тавьж, сонгогчдод чөлөөтэй танилцах бололцоо олгосон байна (20.11).

СОНГОЧДЫН НЭРИЙН ЖАГСААЛТЫГ НЯГТЛАН ШАЛГАХ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

ҮИХ-ын сонгуулийн тухай хуулиас

20.12. Сонгогчдын нэрийн жагсаалтыг нягтлан шалгах, түүнд өөрчлөлт оруулах журмыг улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, Сонгуулийн ерөнхий хороо хамтран батална.

Нийтэд цахим хэлбэрээр танилцуулсан сонгогчдын нэрийн жагсаалтад иргэдийн гомдлыг үндэслэн дараах өөрчлөлтуүдийг тусгасны үндсэн дээр нэрийн жагсаалтыг эцэслэн хуульд заасан хугацаанд СЕХ-нд хүргүүлэхээр заажээ. Үүнд:

- Сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдээгүй буюу буруу бүртгэгдсэн талаарх (20.7.1) өөрчлөлт;
- Сонгогчийн эцэг (эх/ийн нэр, өөрийн нэр, иргэний үнэмлэхний болон регистрийн дугаар, оршин суугаа газрын хаягийн өөрчлөлт зэрэг иргэний бүртгэлтэй холбогдох өөрчлөлт (20.7.2);
- Нас барсан иргэний бүртгэлтэй холбогдох өөрчлөлт (20.7.3);
- Эрх зүйн чадамжгүй нь шүүхийн шийдвэрээр тогтоогдсон болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх төв байгууллага хорих газарт ял эдэлж байгаа сонгуулийн насны иргэдийн мэдээлэлтэй холбогдох өөрчлөлт.

Хуульд заасны дагуу СЕХ, УБЕГ-ын даргын 2012 оны 5 дугаар сарын 16-ны өдөр гаргасан хамтарсан тушаалаар “Сонгогчдын нэрийн жагсаалтыг нягтлан шалгах, түүнд өөрчлөлт оруулах журам батлах тухай” журмыг баталжээ. Уг журамд сонгогчдын нэрийн жагсаалтыг хэрхэн нягтлах, түүнд ямар өөрчлөлтийг тусгах талаар холбогдох талуудын үүрэг хариуцлагыг нарийвчлан зааж зохицуулсан байх ба өмнөхөөс дэвшилттэй нь сонгогчдын нэрийн жагсаалтад туссан өөрчлөлтийн талаар тайлан гаргаж СЕХ -нд хүргүүлэх үргийг мөн холбогдох талуудад хүлээлгэжээ.

Сонгогчдын нэрийн жагсаалтыг нягтлан шалгах, түүнд өөрчлөлт оруулах журам батлах тухай журмаас

- 7.1. Иргэний бүртгэлийн байгууллагын итгэмжлэгдсэн ажилтан энэ журмын 4, 5 дугаар зүйлд заасны дагуу сонгогчдын нэрийн жагсаалтыг нягтлан шалгаж, түүнд зохих өөрчлөлтийг оруулсан талаарх тайлан, мэдээг гаргаж гарын үсэг зурж баталгаажуулан тухайн сонгуулийн хэсгийн хороо, сум, хорооны улсын бүртгэгчид санал авах өдрөөс өмнө тус тус хүлээлгэн өгөх бөгөөд түүнд дараах мэдээллийг тусгасан байна:
 - 7.1.1. сонгогчдын нэрийн жагсаалтад нийт хэдэн сонгогчийн мэдээлэлд ямар өөрчлөлт оруулсаныг жагсаалтаар гаргах;
 - 7.1.2. сонгогчдын нэрийн жагсаалтад өөрчлөлт оруулсан үндэслэл тус бүрээр гаргах;
 - 7.1.3. сонгогчдын нэрийн жагсаалтад өөрчлөлт оруулсан огноог сонгогч тус бүрийн мэдээлэлд үндэслэн гаргах;
- 7.2. Хэсгийн хороо энэ журмын 7.1 дэх хэсэгт заасан итгэмжлэгдсэн ажилтны тайлан, мэдээг санал хураалт дууссаны дараа тойргийн хороонд тэмдэглэл үйлдэж, хүлээлгэн өгнө.
- 7.3. Тойргийн хороо уг тайлан, мэдээг үндэслэн нэгдсэн тайлан, мэдээг гаргаж хэсгийн хороодоос ирүүлсэн иргэний бүртгэлийн байгууллагын итгэмжлэгдсэн ажилтнуудын тайлан, мэдээний хамт Сонгуулийн Ерөнхий Хороонд хүргүүлнэ.

СОНГОГЧДЫН НЭРИЙН ЖАГСААЛТАД ХОЛБОГДОХ ГОМДОЛ ГАРГАХ ТУХАЙ

УИХ-ын сонгуулийн тухай хуулиас

- 21.1. Сонгогч өөрийн болон өөрийн гэр бүлийн аль нэг гишүүний нэр сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдээгүй буюу буруу бүртгэгдсэн байвал энэ тухай сонгогч өөрийн болон өөрийн гэр бүлийн гишүүний нэрийн өмнөхөөс гомдолоо улсын бүртгэлийн холбогдох байгууллагад санал авах өдрөөс 10-аас доошгүй хоногийн өмнө бичгээр гаргана.

Улсын бүртгэлийн холбогдох байгууллага нь энэ гомдол гаргасан иргэний мэдээллийг иргэний бүртгэл, мэдээллийн улсын сангаас хайлт хийн тодорхойлж, лавлагаа гаргах ба тухайн лавлагааг үндэслэн сонгогчийн мэдээллийг хэсгийн хорооны дэргэд ажиллах иргэний бүртгэлийн байгууллагын итгэмжлэгдсэн ажилтан 3 хоногийн дотор сонгогчдын нэрийн жагсаалтад өөрчлөлт оруулахаар заажээ (21.2).

ГАДААД УЛСАД БАЙГАА СОНГОГЧДЫН БҮРТГЭЛ, НЭРИЙН ЖАГСААЛТЫН ТУХАЙ

УИХ-ын сонгуулийн тухай хуулийн 6.7-д “Монгол Улсын дипломат төлөөлөгчийн газар байрладаг гадаад улсад байгаа, улсын бүртгэлд бүртгэгдсэн сонгуулийн эрх бүхий иргэн сонгуульд оролцоно”, 6.7.1-д “гадаад улсад байгаа сонгуулийн эрх бүхий иргэн сонгуульд оролцохоо мэдэгдэж бүртгүүлэн өөрийн биеэр ирж оролцох” гэж заасан. Эндээс үзэхэд сонгогчдын нэрийн жагсаалт нь бүртгүүлэхээр ирсэн иргэний болон дипломат төлөөлөгчийн газраар дамжуулан хийгдсэн иргэний шинэчилсэн бүртгэлд бүртгэгдсэн иргэний бүртгэлээс бүрдэхээр харагдаж байна. Түүнчлэн хуулийн 22.1-д “Сонгогч өөрийн байнга

оршин суугаа газрынхаа харьяа хэсэгт санал өгнө” заалтын дагуу сонгогчдын нэрийн жагсаалт санал авах өдрөөс 55-аас доошгүй хоногийн өмнө үйлдэгдэж, СЕХ-нд хүргэгдэнэ. Гэтэл гадаадад байгаа сонгогчдын нэрийн жагсаалтыг хэзээ, хэрхэн үйлдэж, хаана хүргүүлэх талаарх зохицуулалт хуульд тодорхойгүй төдийгүй УБЕГ-т Монгол Улсын иргэний гадаадад зорчсон болон аль улсад оршин суугаа бүртгэл байдаггүй нь гадаадад байгаа сонгогчдын нэрийн жагсаалт давхардах нөхцлийг үүсгэсэн байна.

Ийм давхардал гарахаас сэргийлэх зорилгоор СЕХ, УБЕГ-ын хамтран гаргасан “Сонгогчдын нэрийн жагсаалтыг нягтлан шалгах, түүнд өөрчлөлт оруулах” тухай журамд “Сонгуулийн Ерөнхий Хороо нь гадаад улсад саналаа өгөхөөр бүртгүүлсэн сонгогчдын нэрийн жагсаалтыг санал авах өдрөөс 20-иос доошгүй хоногийн өмнө хилийн чанад дахь Монгол Улсын дипломат төлөөлөгчийн газраас хүлээн авч Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлэх бөгөөд тус байгууллага нь уг жагсаалтыг нягтлан шалгаад тэдгээр иргэдийг Монгол Улс дахь байнга оршин суух хаягаараа бүртгэгдсэн сонгуулийн хэсгийн сонгогчдын нэрийн жагсаалтаас хасч, энэ тухай лавлагааг холбогдох сум, хорооны улсын бүртгэгчид жагсаалтын хамт хүргүүлнэ”(4.5) гэж заажээ.

ЦЭРГИЙН АЛБА ХААГЧ, БАРИВЧЛАГДСАН БОЛОН ЦАГДАН ХОРИГДСОН СОНГОГЧДЫН БҮРТГЭЛ, НЭРИЙН ЖАГСААЛТЫН ТУХАЙ

Хуулийн 20.10-т “Тухайн хэсгийн харьяа нутаг дэвсгэрт байрлаж байгаа цэргийн анги, салбарын захирагч нь тухайн байгууллагад алба хааж байгаа сонгуулийн насны иргэдийн мэдээллийг, цагдаагийн болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын дарга сонгуулийн насны эдгээр иргэдийн мэдээллийг гаргаж харьяа хэсгийн хороонд хүргүүлэхээр зохицуулсан нь захиргааны болон байцаан шийтгэх албадлагын арга хэмжээний улмаас баривчлагдсан, саатуулагдсан, гэмт хэргийн нөхцөл байдлаас цагдан хорих хугацаа нь сунгагдах боломжтой иргэдийн сонгогчдын нэрийн жагсаалтад давхардал бий болгох нөхцлийг бүрдүүлсэн байна.

болон байцаан шийтгэх албадлагын арга хэмжээний улмаас баривчлагдсан, албадан саатуулагдсан, цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авагдсан сонгуулийн насны иргэдийн мэдээллийг Сонгуулийн Ерөнхий Хорооноос баталсан маягтын дагуу тус тус гаргаж, санал авах өдрөөс 30-аас доошгүй хоногийн өмнө харьяа хэсгийн хороонд хүргүүлнэ”, 20.11-д “Хэсгийн хороо энэ хуулийн 20.9-д заасан сонгогчдын нэрийн жагсаалтыг энэ хуулийн 20.10-т заасан сонгуулийн насны иргэдийн мэдээлэлтэй тулган хэсгийн хорооны дарга, нарийн бичгийн дарга гарын үсэг зурж, санал авах өдрөөс 20-иос доошгүй хоногийн өмнө өөрийн байранд ил тавьж, сонгогчдод чөлөөтэй танилцах бололцоо олгоно” гэж заажээ.

Захиргааны журмаар баривчлах хугацаа 7-30 хоног¹¹, байцаан шийтгэх албадлагын арга хэмжээний улмаас баривчлах, албадан саатуулах арга хэмжээ авах хугацаа 72 цаг¹², харин цагдан хорих хугацаа сэжигтэн бол 14 хоногоос¹³ яллагдагч бол 2 сар¹⁴ хүртэл, хэргийн нөхцөл байдлаас болж энэ хугацаа 24 сар хүртэл байдаг. Санал авахаас 30-аас доошгүй хоногийн өмнө цагдаагийн болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын дарга сонгуулийн насны эдгээр иргэдийн мэдээллийг гаргаж харьяа хэсгийн хороонд хүргүүлэхээр зохицуулсан нь захиргааны болон байцаан шийтгэх албадлагын арга хэмжээний улмаас баривчлагдсан, саатуулагдсан, гэмт хэргийн нөхцөл байдлаас цагдан хорих хугацаа нь сунгагдах боломжтой иргэдийн сонгогчдын нэрийн жагсаалтад давхардал бий болгох нөхцлийг бүрдүүлсэн байна.

¹¹ Захиргааны хариуцлагын тухай хуулийн 4.3 дахь заалт

¹² ЭБШХ-ийн 60.2 дахь заалт

¹³ ЭБШХ-ийн 69.1 дэх заалт

¹⁴ ЭБШХ-ийн 69.2 дахь заалт

СОНГОГЧИЙН НЭРИЙН ЖАГСААЛТАД ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ХИЙХ ТВЬ-ЫН ЭРХ

2011 оны 12 дугаар сарын 15-нд шинэчлэн баталсан Улсын Их Хурлын сонгуулийн тухайхуулийн 9.5-д төрийнбүс байгууллага нь сонгуулийн үйл ажиллагаанд ажиглалт, хяналт шинжилгээ хийх боломжтой гэж заасан. Энэхүү заалтыг хэрэгжүүлэхтэй холбоотой журмыг СЕХ-ноос батлан гаргасан бөгөөд үүнд ТББ-ын зүгээс сонгогчдын нэрийн жагсаалтад хяналт тавихтай холбоотой дараах заалтууд багтсан байна.

Төрийн бүс байгууллага сонгуулийн үйл ажиллагаанд хяналт шинжилгээ (мониторинг) хийх, сонгогчдод аргачилсан туслалцаа үзүүлэх тухай журмаас

- 2.5.1 үндсэн ба зөөврийн битүүмжилсан саналын хайрцгаар санал авах сонгогчдын нэрийн жагсаалттай танилцах, эдгээрээс түүвэрлэн хяналт, тулгалт хийх;
- 2.5.2 сонгогчдын нэрийн жагсаалтыг нягтлан шалгах, түүнд өөрчлөлт оруулах ажиллагаа холбогдох хууль, журмын дагуу хийгдэж байгаа эсэхтэй танилцах;
- 3.2.1 сонгуулийн хороодоос авах шаардлагатай мэдээ, мэдээллийг бичгээр гаргуулж авах;
- 3.2.2 хууль тогтоомжийн хүрээнд санал хүсэлт тавьж шийдвэрлүүлэх;
- 3.2.3 өөрийнүйлажиллагаандшаардлагатай, хуулиар хориглогдоогүй дэмжлэг туслалцаа авах;
- 3.2.4 төлөвлөгөөний хүрээнд СЕХ-нд танилцуулсан мониторингийн үр дүнг нийтэд мэдээлэх, танилцуулах, хэвлэн нийтлэх.

3.3 МОНИТОРИНГИЙН ҮР ДҮН

Мониторинг нь сонгогчдын нэрийн жагсаалттай холбоотой хуулийн зүйл заалтыг хэсгийн хороо хэрхэн хэрэгжүүлж буй байдалд хяналт тавих, сонгогчдын бүртгэлийг нягтлах шалгах, Цагдан хорих 461-р анги, Албадан saatuuлах, баривчлах төв буюу дэнжийн 1000-ын 111-д saatuuлагдсан зөөврийн хайрцгаар санал өгөх сонгогчдын жагсаалтыг хянах гэсэн хэсгүүдээс бурдаж байлаа.

СОНГОГЧДЫН НЭРИЙН ЖАГСААЛТЫГ НЯГТЛАН ШАЛГАСАН БАЙДАЛ

Сонгогчдын нэрийн жагсаалтын мониторингийг хүн амын тоо ихтэй, шилжин суурьшигч олонтой гэсэн шалгуур үзүүлэлтийг үндэслэн 179518 сонгогч бүхий Сонгинохайрхан дүүрэг буюу УИХ-ын сонгуулийн 26 дугаар тойргийн 20 хэсгийн хороонд хэрэгжүүллээ. Хэсгийн хороодыг сонгоходо хамгийн олон сонгогчтой, хамгийн цөөхөн сонгогчтой, дундаж тооны сонгогчтой гэсэн бүлгүүдээс тэнцвэртэй түүвэрлэсэн болно. Сонгогдсон хэсгийн хороод нийт 45330 сонгогчтой байв.

Сонгогчдын нэrsийн жагсаалтад мониторинг хийх үйл явцад ашиглагддаг олон улсын стандарт аргачлалуудыг ашиглан тухайн хэсгийн хороодын сонгогчдын нэрийн жагсаалтыг тухайн хорооны оршин суугчдын мэдээлэлтэй харьцуулан нягтлах байдлаар мониторингийн энэ хэсгийг хэрэгжүүлсэн.

“Хүнээ жагсаалттай тулгах” (People to list) аргачлалын дагуу мониторингийн баг тухайн хэсгийн хороодын оршин суугчдын холбогдох мэдээллийг цуглуулан “нягтлан шалгах сонгогчдын нэрийн жагсаалт”-ыг үйлдэн хэсгийн хороонд ил тавигдсан сонгогчдын нэрийн жагсаалттай тулган үзсэн юм. Сонгогчдын нэрийн жагсаалтыг тулган нягтлах явцад дараах зөрчил илэрсэн байна. Үүнд:

1. Сонгогчийн регистрийн дугаар алдаатай бичигдсэн	7
2. Сонгогчийн овог нэр буруу бичигдсэн	3
3. Нас барсан иргэнийг бүртгэсэн	12
4. Хорих ял эдэлж буй	1
5. Нэрийн жагсаалтад бүртгэгдээгүй	56
6. Тухайн хаяг дээр илүү хүн бүртгэгдсэн	38

“Жагсаалтыг хүнтэй тулгах” (List to People) аргачлалын дагуу хэсгийн хороодын ил тавьсан сонгогчдын нэрийн жагсаалтаас сонгогчдын мэдээллийг авч хаягийн дагуу тухайн бүртгэлтэй иргэдийн мэдээллийг нягтлан шалгах үйл явцад мөн цөөнгүй зөрчил дутагдал илэрсэн юм. Мониторингийн баг хэсгийн хороодын сонгогчдын нэрийн жагсаалтаас нийт 876 сонгогчийн мэдээллийг түүвэрлэн авч хаягийн дагуу нягталсан бөгөөд дараах зөрчил илэрсэн байна. Үүнд:

1. Бүртгэгдээгүй сонгогч	25
2. Нас барсан иргэний бүртгэл	1
3. Хорих ял эдэлж буй	1
4. Хаягт байдаггүй илүү хүн	88

Мониторингийн хэрэгжилтийн явцад 53 сонгогчийн бүртгэлийг шалгуулахаар Нийслэлийн Бүртгэлийн Газрын Хяналтын хэлтэс, СЕХ-нд албан хүсэлт гаргасан. Сонгуулийн дараа ирүүлсэн дээрх байгууллагуудын шалгалтын дүнд тухайн сонгогчид шилжилт хөдөлгөөний бүртгэлээ цаг тухайд нь хийлгээгүй бөгөөд

сонгогчдын нэрийн жагсаалтад давхар бүртгэгдээгүй байна гэсэн байна.

Мониторингийн явцад нэг хаягт олон оршин суугч бүртгэгдсэн явдал олон гарсан нь нэг талаар нэг дор амьдардаг олон өрхийн бүртгэл цугтаа байдаг, нөгөө талаар хаягийн давхардал, ойлгомжгүй байдал цөөнгүй байгаатай холбоотой байв.

Баримт жишиг 1

УИХ-ын сонгуулийн 26 дугаар тойргийн 31-р хэсгийн хороо буюу СХД-ийн 11-р хороо, АОС 3-132 тоотод нэг хаяг дээр 24 сонгогч бүртгэлтэй байв. Хаягийн тулгалтын үр дүнд энэ хаяг дээр оршин суудаг 19 сонгогч, огт байдаггүй 5 сонгогч байсан бөгөөд 1 сонгогчийн овог зөрж байлаа.

Баримт жишиг 2

УИХ-ын сонгуулийн 26 дугаар тойргийн 21-р хэсгийн хороо буюу СХД-ийн 7-р хороо 21-р гудамжны 9 тоотод 25 хүн бүртгэгдсэн байсныг шалгахад тухайн хаягт оршин суудаг 7 өрхийн нийт 24 сонгогчийн бүртгэл нь тохирч байсан ч, огт байдаггүй 1 хүн илүү бүртгэгдсэн байв.

Баримт жишиг 3

УИХ-ын сонгуулийн 26 дугаар тойргийн 25-р хэсгийн хорооны сонгогчдын нэрийн жагсаалтаас нэг хаяг дээр 40 сонгогч бүртгэлтэй байсныг шалган нягтлахад нэг байр нь 4 талаасаа ордог 5 нийтийн байранд нийт 14 өрхийн 30 сонгогч оршин суудаг нь тодорхой болсон бөгөөд сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдсэн 10 сонгогч тухайн хаягт огт байхгүй байлаа. Түүнчлэн жагсаалтад бүртгэлгүй 6 сонгогч байв.

Баримт жишиг 4

УИХ-ын сонгуулийн 26 дугаар тойргийн 18-р хэсгийн хороо буюу СХД-ийн 6-р хороо, 1-5 тоотод 4 сонгогчийн бүртгэл байсныг нягтлан шалгахад эдгээр 4 сонгогч огт байдаггүй бөгөөд 1 өндөр настан оршин суудаг нь тодорхой болсон юм.

Мониторингийн багт БЗД-ийн 20-р хорооны иргэнээс нэг хаяг дээр 169 сонгогч бүртгэгдсэн талаар мэдээлэл ирүүлснийг мөн нягтлан шалгалаа. Бүртгэлийн байгууллагын зүгээс тухайлсан хаягтуй өрхүүдийг нэг хаягт нэгтгэн бүртгэсэн гэж мэдээлсэн ч бодит байдал дээрээ айлууд нь тус тусдаа хаягтай байлаа. Мөн эхнэр нөхөр 2 өөр хэсгийн хороодод бүртгэгдсэн тохиолдол нэг бус удаа гарсан байна.

СОНГУУЛИЙН ХЭСГИЙН ХОРООДЫН СОНГОГЧДЫН НЭРИЙН ЖАГСААЛТТАЙ ХОЛБООТОЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА

УИХ-ын сонгуулийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.11 дэх заалт “Хэсгийн хороо энэ хуулийн 20.9-д заасан сонгогчдын нэрийн жагсаалтыг энэ хуулийн 20.10-т заасан сонгуулийн насын иргэдийн мэдээлэлтэй тулган хэсгийн хорооны дарга, нарийн бичгийн дарга гарын үсэг зурж, санал авах өдрөөс 20-оос доошгүй хоногийн өмнө өөрийн байранд ил тавьж, сонгогчдод чөлөөтэй танилцах бололцоо олгоно” гэж заасан байдаг.

Мониторингоор УИХ-ын сонгуулийн 26 дугаар тойргийн 20 хэсгийн хороонд сонгогчдын нэрийн жагсаалтыг иргэдэд нээлтэй тавьсан байдлыг 2012 оны 6 дугаар сарын 8-ны өдрийн байдлаар нягтлан үзэхэд ердөө 8 хэсгийн хороо л зохих шаардлагыг биелүүлсэн байлаа.

ЗӨӨВРИЙН ХАЙРЦГААР САНАЛ ӨГӨХ СОНГОГЧДЫН ЖАГСААЛТЫГ ХЯНАХ

Мониторингийн хүрээнд Цагдан хорих болон албадан саатуулах баривчлах байранд саатуулагдсан хүмүүс тухайн нутаг дэвсгэрийн хэсгийн хороонд зөөврийн битүүмжилсэн хайрцгаар санал өгөх бөгөөд сонгогчийн давхардал үүсч болзошгүй гэдэг утгаар нь хянах, тулгах зорилготой байлаа.

Сонгуулийн хэсгийн хороодод иргэний бүртгэлийн байгууллагаас сонгогчдын нэрийн жагсаалтыг эцэслэн 6 дугаар сарын 26-ны үүрээр хүлээлгэн өгч, хэсгийн хороо сейфэндээ цоожлон сонгуулийн өдөр гаргаж тавьсан. Энэ нь мониторингийн багийн зөөврийн хайрцгаар санал өгөх сонгогчдын жагсаалтыг нягтлах боломжийг хязгаарласан явдал байв.

Баянгол дүүргийн 20-р хорооны нутаг дэвсгэрт байрлах Цагдан хорих 461-р анги санал авахаас 5 хоногийн өмнө харъяалах 25 дугаар тойргийн 50 дугаар хэсгийн хороонд сонгуульд оролцож, санал өгөх 228 сонгогчтой гэсэн дүнг өгсөн байна. Харин УБЕГ-аас тухайн жагсаалтыг шалган нягталж, 108 хүнийг бичиг баримтгүй гэсэн шалтгаанаар хассан бөгөөд жагсаалтад 120 сонгогчийн бүртгэлийг үлдээжээ.

Цагдан хорих 461 дүгээр ангийн сонгогчдын нэрийн жагсаалтад сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч болон анхан шатны шүүхээр таслагдаад ял сонссон, давж заалдах шатны шүүхэд гомдол гаргаад хүлээж байгаа хүмүүсийн бүртгэл орсон байсан бөгөөд хэсгийн хорооноос жагсаалтад нэр нь орсон, сонгуулийн өдөр тухайн ангид байгаа тул сонгуульд оролцож болно хэмээн үзсэн. Цагдан хорих төвөөс шүүхээс ял авсан ч давж заалдаж, өмнөх шүүхийн шийтгэх тогтоол түдгэлзсэн гэж үзэх учиртай тул сонгуульд оролцоход харшлах зүйлгүй гэсэн байна.

Сонгуулийн товлосон өдөр Цагдан хорих төвийн сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдсэн 120 сонгогчоос 11 нь гарсан буюу шилжсэн байсан тул 2 зөөврийн битүүмжилсэн хайрцгаар Цагдан хорих төвөөс 109, энгийн 14 нийт 123 сонгогч санал өгч, энэхүү үйл ажиллагаанд улстөрийн намуудын 3, гадаадын 6, дотоодын байгууллагын 1 ажиглагч хяналт тавьж оролцсон болно. Ажиглагчдын дүгнэснээр зөөврийн хайрцгаар санал авах сонгуулийн үйл ажиллагаа хэвийн явагдаж, ямар нэгэн зөрчил илрээгүй байна.

Чингэлтэй дүүргийн 12-р хорооны нутаг дэвсгэрт байрлах Албадан саатуулах, баривчлах төв нь санал авах өдрөөс 5 хоногийн өмнө тухайн төвөөс нийт сонгуульд оролцож, санал өгөх 85 сонгогч бүхий нэрийн жагсаалт харьялах 24-р тойргийн 25 дугаар хэсгийн хороондоо хүргүүлжээ. УБЕГ-аас нягталснаар 71 хүн сонгуульд санал өгөх боломжтой хэмээн үзсэн байна. Албадан саатуулах баривчлах төвөөс 71 сонгогч санал өгөх боломжтой гэж нэрийн жагсаалтад бүртгэгдсэнээс 2 нь суллагдаж, үлдсэн 69 сонгогчоос нэг зөөврийн битүүмжилсэн хайрцагаар санал авчээ.

СОНГОГЧДЫН НЭРИЙН ЖАГСААЛТТАЙ ХОЛБООТОЙ ГОМДОЛ ШИЙДВЭРЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захирагааны байгууллага буюу УБЕГ УИХ-ын сонгуулийн тухай хуулийн 21.1-т зааснаар “Сонгогч өөрийн болон өөрийн гэр булийн аль нэг гишүүний нэр сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдээгүй буюу буруу бүртгэгдсэн байвал энэ тухай сонгогч өөрийн болон өөрийн гэр булийн гишүүний нэрийн өмнөөс гомдлоо улсын бүртгэлийн холбогдох байгууллагад санал авах өдрөөс арваас доошгүй хоногийн өмнө бичгээр гаргана”. 21.2-т Улсын бүртгэлийн холбогдох байгууллага нь энэ хуулийн 21.1-д заасны дагуу гомдол хүлээн авсан бол тухайн гомдол гаргасан иргэний мэдээллийг иргэний бүртгэл, мэдээллийн улсын сангаас хайлт хийн тодорхойлж, лавлагаа гаргах ба тухайн лавлагааг үндэслэн сонгогчийн мэдээллийг хэсгийн хорооны дэргэд ажиллах иргэний бүртгэлийн байгууллагын итгэмжлэгдсэн ажилтан гурав хоногийн дотор сонгогчдын нэрийн жагсаалтад өөрчлөлт оруулна. 21.3-т Энэ хуулийн 21.2-т зааснаас бусад үндэслэлээр сонгогчдын нэрийн жагсаалтад өөрчлөлт оруулахыг хориглоно гэсэн заалтыг зөрчсөн гэж харагдаж байна.

3.4 МОНИТОРИНГИЙН ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

ДҮГНЭЛТ

1. Сонгуулийн эрхзүйн орчинд зохих өөрчлөлт орж, сонгогчдын нэрийн жагсаалттай холбоотой харилцааны зохицуулалт харьцангуй сайн болжээ.
2. Сонгуулийн үйл явцад хөндлөнгийн хяналт хэрэгжүүлэх төрийн бус байгууллагын оролцоог хуульчлан баталгаажуулж өгснөөр сонгуулийг ил тод, шударга явуулах боломжийг нэмэгдүүлж өгсөн байна.
3. Сонгогчдын нэрийн жагсаалттай холбоотой харилцаа буюу нэрийн жагсаалтыг үйлдэх, хянах, танилцуулах, нягтлан шалгах, үйл явцыг боловсронгуй болгох хууль эрхзүйн зохицуулалт өмнөх сонгуулийн үеийнхээс илүү дэвшилттэй болж чадсан байна. Тухайлбал:
 - УИХ-ын Сонгуулийн тухай шинэ хуульд зааснаар Сонгогчдын нэрийн жагсаалтыг иргэний шинэчилсэн бүртгэлд үндэслэн улсын хэмжээнд нэгтгэн гаргах, шаардлагатай өөрчлөлтийг цаг тухайд нь оруулах үүргийг УБЕГ бүхэлд нь хариуцаж, сонгуулийн хэсгийн хороод дураараа өөрчлөлт оруулахыг хоригложээ.
 - СЕХ, УБЕГ-ын даргын хамтарсан тогтоол /тушаал №63/421-ээр “Сонгогчдын нэрийн жагсаалтыг нягтлан шалгах, түүнд өөрчлөлт оруулах журам”-ыг баталсан байна.

- Сонгогчдын нэрийн жагсаалт үнэн зөв үйлдэгдэж, хуулийн дагуу олон нийтэд танилцуулагдаж чадахгүй байгааг мониторингийн үр дүн нотолж байна. Тухайлбал:
 - УИХ-ын сонгуулийн 26 дугаар тойргийн түүвэрлэн авсан 20 хэсгийн хороонд “Хүнээ жагсаалттай тулгах” (People to list) аргачлалын дагуу оршин суугчдын холбогдох мэдээллийг цуглувлан “нягтлан шалгах сонгогчдын нэрийн жагсаалт”-ыг үйлдэн хэсгийн хороонд ил тавигдсан сонгогчдын нэрийн жагсаалттай тулган нягтлахад 117 зөрчил илэрсэн байна.
 - УИХ-ын сонгуулийн 26 дугаар тойргийн түүвэрлэн авсан 20 хэсгийн хороонд “Жагсаалтыг хүнтэй тулгах” (List to People) аргачлалын дагуу хэсгийн хороодын ил тавьсан сонгогчдын нэрийн жагсаалтаас 876 сонгогчдын мэдээллийг авч хаягийн дагуу тухайн бүртгэлтэй иргэдийн мэдээллийг нягтлан шалгахад нийт 115 зөрчил илэрсэн байна.
 - 2012 оны 6 дугаар сарын 8-ны өдрийн байдлаар УИХ-ын сонгуулийн 26 дугаар тойргийн 20 хэсгийн хороонд сонгогчдын нэрийн жагсаалтыг иргэдэд нээлтэй болгосныг нягтлахад ердөө 8 хэсгийн хороо зохих шаардлагыг биелүүлсэн байлаа.
- Зөөврийн хайрцгаар санал өгөх сонгогчдын нэрийн жагсаалттай холбоотой иргэдийн сонгох эрхийг зөрчсөн явдал байсаар байна.
 - УИХ-ын сонгуулийн тухай хуулиар зөөврийн хайрцгаар санал өгөх сонгогчдын нэрийн жагсаалтад хяналт тавих боломж бий болсон ч уг харилцааг зохицуулах холбогдох журам нь хугацаа хоцорч

батлагдсаны улмаас мониторингийн баг зөөврийн хайрцгаар санал өгөх сонгогчдын жагсаалтыг нягтлах боломжгүй болсон. Бүртгэлийн байгууллагаас сонгогчдын нэрийн жагсаалтыг эцэслэн 6 дугаар сарын 26-ны үүрээр хүлээлгэн өгч, хэсгийн хороо сейфэндээ цоожлон сонгуулийн өдөр гаргаж тавьсан байх жишээтэй.

- Цагдан хорих, Албадан саатуулах, баривчлах төвд хоригдож буй 299 сонгогчоос бичиг баримтын зөрчилтэй хэмээх үндэслэлээр 134 хүн нэрийн жагсаалтаас хасагдаж сонгох эрх нь зөрчигдсөн байна.
- Цагдан хорих, Албадан саатуулах, баривчлах төвөөс зөөврийн хайрцгаар санал өгөх сонгогчдын нэрийн жагсаалтад багтсан хэдий ч сонгуулийн өдрөөс өмнө суллагдсан 13 иргэн сонгуульд оролцон санал өгөх боломжгүй болсон байна.

Иргэний бүртгэл мэдээлэл буюу иргэдийн овог нэр, оршин суугаа хаяг, регистрийн дугаар зэрэгт үг үсгийн техник алдаа олонтаа илэрдэг. Иргэд сонгогчид нэрийн жагсаалттай танилцаж өөрийн мэдээллийг шалгах үүрэгтэй ч үүнийг ухамсартай биелүүлэх, хуулинд заасан хугацаанд гомдол гаргаж, шийдвэрлүүлэх байдал хангалтгүй байdag.

Хуулинд зааснаар сонгуулийн хэсгийн хороодод сонгуулийн санал авах өдрөөс 40-өөс доошгүй хоногийн өмнө сонгогчдын нэрийн жагсаалт хүргэгдэж очсон байх ёстой бөгөөд үүнээс хойш 20 орчим хоногийн дараа л ил тавигдаж сонгогчдод танилцуулагдаж байна. Санал авах өдрөөс 10-аас доошгүй өдрийн өмнө сонгогч гомдол гаргах эрхтэй болохоор мэдээлэлтэй танилцах 10 өдрийн боломж сонгогчдод олдож байна.

Цагдан хорих, Албадан саатуулах, баривчлах газарт хоригдож буй сэжигтэн,

саатуулагдагсдаас сонгуульд оролцох иргэдийн нэрийн жагсаалтыг сонгуулийн санал өгөх өдрөөс 5-аас доошгүй өдрийн өмнө нэгтгэж хянадаг. Хэрэв иргэн сонгуулийн санал өгөх өдрөөс 10 хүртэлх хоногийн өмнө баривчлагдан saatuuulagdajch үндсэн хаягийн дагуу сонгуульд оролцох боломжгүй болсон тохиолдолд 2 газар сонгогчдын нэрийн жагсаалтад давхар бүртгэгдэх боломжтой болж байна.

ЗӨВЛӨМЖ

Сонгогчдын нэрийн жагсаалтад хамгийн ихээр гардаг зөрчил нь иргэдийн бүртгэл мэдээлэлтэй холбоотой байдаг. Хүн амын тооллого, иргэний үнэмлэх солих, эх орны хувь хишиг тараахтай холбоотойгоор иргэдийн бүртгэл, бичиг баримын зөрчилтэй байдлыг багасгаж чадсан ч иргэнд хамаарах бүртгэл мэдээллийг үнэн зөв оруулах, нягтлан шалгах, хаягжилтийн зөрчлийг арилгах асуудалд цаашид илүү анхаарч ажиллах хэрэгтэй юм. Үүний тулд дараах ажлуудыг зохион байгуулж болох юм. Үүнд:

- Сонгуулийн бус үеэр иргэд өөрсдийн бүртгэл мэдээлэлтэй танилцаж, зөрчлийг арилгах боломжийг бүрдүүлэх зорилгоор тодорхой зорилтот бүлэг, байгууллага хамт олон, нутаг дэвсгэрийн нэгжийн хүрээнд олон нийтийг хамарсан үйл ажиллагаа зохион байгуулах, тухайлбал:
- Иргэний үнэмлэх шинээр гардан авах өсвөр үеийхний дунд иргэний бүртгэл мэдээллийн ач холбогдлыг сурталчлах, иргэний үүрэг хариуцлагыг ухамсарлуулах үүднээс сурталчилгаа мэдээлэл, бүтээлч аяанг зохион байгуулах;
- Байгууллагыннийгмийнхариуцлагын шинэ шалгуур үзүүлэлт болгон “иргэний бүртгэл, бичиг баримтын зөрчилгүй хамт олон“ хөтөлбөрийг хэрэгжүүлэн, төрийн болон

төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжүүдийг татан оролцуулах;

- Орон нутгийн засаг захиргааны нэгж, хороо, сум, баг, хэсгүүдийн дунд бүртгэл, мэдээлэл, бичиг баримтын зөрчилгүй нэгж болох аян, болзолт уралдаан, мэдээлэл, сурталчилгааны томоохон арга хэмжээг зохион байгуулах;
- Томоохон байгууллага тэр дундаа төрийн байгууллагад ажилд орох, төрийн албаны шалгалт өгөх, их дээд сургуульд элсэн орох, компани аж ахуйн нэгж байгуулах, банкны зээл авах зэрэгт “бичиг баримтын зөрчилгүй” болох тухай тодорхойлолт лавлагаа гаргуулдаг болох.
- Хаягийн болон давхар бүртгэлийн зөрчлийг арилгах тухайд:
 - Хаяггүй “задгай”-д оршин суугчдыг хаягжуулах, бүртгэлжүүлэх;
 - Хөлсний өрөө, байр, хашаа, байшин, нийтийн байранд түр оршин суугчдын бүртгэл, давхар бүртгэл, шилжилт хөдөлгөөний асуудлыг оновчтой хэлбэрээр шийдвэрлэх;
 - Байр орон сууц, хашаа байшин зэргээ хөлслүүлэгч хөлслөгчтэй байгуулсан гэрээний талаар харьяа орон нутгийн засаг, захиргааны нэгжид хандан түр оршин суугчийн тухай мэдэгдэж, засаг захиргааны анхдагч нэгжийн бүртгэл хариуцсан ажилтан гэрээний хугацааг үндэслэн түр оршин суугчийн тусгай бүртгэлд хамруулах;
 - УБЕГ-аас сонгогчийн нэрийн жагсаалтыг үйлдэхдээ “түр оршин суугчийн тусгай” бүртгэлд бүртгэгдсэн иргэдтэй холбоотой лавлагаа гаргаж, давхар бүртгэгдэх боломжийг хязгаарлах.
- Цагдан хорих, Албадан saatuuulagdajch саатуулах, баривчлах төвөөс сонгуульд оролцож

зөөврийн хайрцагаар санал өгөх сонгогчдын нэрийн жагсаалтыг үйлдэх, хянан нягтлах, баталгаажуулахад анхаарах. Тухайлбал, сонгуулийн санал авах өдрөөс өмнө суллагдах, яллагдах нь тодорхой иргэдийг сонгогчдын нэрийн жагсаалтад оруулахгүй байх, ингэснээр нэг талаар суллагдсан иргэн өөрийн үндсэн хаягийн бүртгэлийн дагуу сонгуульд оролцож санал өгөх боломжтой болно, нөгөө талаар сонгогчдын нэрийн жагсаалтын дагуу сонгуульд оролцох иргэдийн ирц багасахгүй.

Хэдийгээр хуулиар сонгуулийн үйл ажиллагаанд төрийн бус байгууллагууд хөндлөнгийн хяналт тавих боломжийг хүлээн зөвшөөрсөн ч энэхүү хяналтыг өргөн цар хүрээтэйгээр зохион байгуулах, төрийн бус байгууллагуудын оролцоог нэмэгдүүлэхэд цаашид анхаарах хэрэгтэй байна.

- Санхүүжилтын дэмжлэгт орчин бүрдүүлэх:
 - Улсын хэмжээнд нэгдсэн хөтөлбөр байдлаар зохион байгуулж, санхүүжилт төвлөрүүлэх;
 - Санхүүжилт хийх боломжтой байгууллагууд, олон улсын төсөл, хөтөлбөрүүд тодорхой чиглэлүүдийг хариуцан санхүүжүүлэх;
 - Улстөрийн нам, хүчинүүд хамтран хөндлөнгийн мониторингийг дэмжих дундын сан байгуулах боломжийг судлан санал болгох;

- Аргазүйн дэмжлэг үзүүлэх:

- Шударга Сонгуулийн Төлөө Иргэний Нийгмийн Хяналт Сүлжээнээс сонгуулийн мониторингийн чиглэлээр ажиллах сонирхолтой гишүүн бус төрийн бус байгууллагуудад мониторингийн аргазүйн сургалт зохион байгуулах;
- “Шударга Сонгуулийн Төлөө Иргэний Нийгмийн Хяналт” сүлжээний гишүүн байгууллагууд шинэ залуу төрийн бус байгууллагуудад өөрсдийн хариуцан хэрэгжүүлсэн сонгуулийн мониторингийн сэдвийн хүрээнд мониторинг хийх аргазүйн чадвар олгох сургалт, дадлага хэрэгжүүлэх.



ГЛОБ ИНТЕРНЭШНЛ
ТВБ

2012 ОНЫ УИХ-ЫН СОНГУУЛИЙН ҮЕЭР ХИЙСЭН ТЕЛЕВИЗИЙН МОНИТОРИНГ



График зургийг “Данида” сонины хэвлэх
үйлдвэрийн эх бэлтгэлийн тасагт бэлтгэв.

4.1 ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

ЗОРИЛГО

УИХ-ын сонгуулийн үеэр телевиз, радио нь сонгуулийн сурталчилгааг нэвтрүүлэхдээ УИХ-ын Сонгуулийн тухай хуулийн 35.14 зүйлд заасны дагуу нам, эвсэл, нэр дэвшигч бүрт ногдох сонгуулийн сурталчилгааны адил тэнцүү цаг хуваарилах, редакцийн хараат бус байдлыг хангах, олон нийтэд үнэн зөв, бодит мэдээлэл түгээх, сэтгүүл зүйн мэргэжлийн зарчим, ёс зүйн хэм хэмжээг баримтлан ажиллах үүргээ хэрхэн гүйцэтгэснийг тандан судлах.

ЗОРИЛТ

1. МУОНТ сонгуулийн сурталчилгааг СЕХ-ны баталсан хуваарийн дагуу төлбөргүй нэвтрүүлж байгаа эсэхэд хяналт тавих;
2. Нэр дэвшигчдэд тэнцвэртэй сурталчилгааг нэвтрүүлж буй эсэхэд хяналт тавих:
 - Цаг хуваарилалт
 - Мэдээллийн өнгө аяс
3. Сонгуулийн үеэрх сэтгүүл зүйн хараат бус нэвтрүүлгийн цаг, чанарыг тодорхойлох:
 - Мэдээний хөтөлбөр
 - Сонгогчдын боловсролд зориулсан тусгай хөтөлбөр
 - Мэтгэлцээн

4. Арилжааны телевизүүдээр нэвтрүүлж буй сурталчилгааны төлбөртэй нэвтрүүлгийн нийт хугацаа хуульд заасан хоёр цагт явагдсан эсэхэд хяналт тавих;
5. СЕХ, ХХЗХ-оос гаргасан журмын 3.1 заалтыг зөрчиж аливаа хэлбэрийн далд сурталчилгаа явуулж байгаа эсэхийг илрүүлэх.

ТӨСЛИЙН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Мониторингийн баг дүн шинжилгээ хийх хоёр, мэдээлэл цуглуулах тав, мэдээлэл боловсруулах хоёр, зөвлөх зэрэг 10 хүний бүрэлдэхүүнтэй ажиллалаа. Мониторингийн багийн гишүүдийн дөрөв нь 2008 оны УИХ-ын, 2009 оны Ерөнхийлөгчийн сонгуулийн хэвлэл мэдээллийн мониторингийн багт ажилласан туршлагатай хүмүүс юм. Гурван өдрийн сургалтад хамрагдан “Ажиглагчийн ёс зүйн зарчим”-ыг хүлээн зөвшөөрч, гэрээ байгуулан ажиллав.

ТӨСЛИЙН ХАМАРСАН ХҮРЭЭ

Монголын Хэвлэлийн Хүрээлэнгийн судалгаагаар 2012 эхний байдлаар Монголд 469 хэвлэл мэдээллийн байгууллага (126 сонин, 92 сэтгүүл, 72 радио, 149 телевиз, 30 веб сайт) идэвхтэй үйл ажиллагаа явуулж байна. Үндэсний хэмжээнд нэвтрүүлгээ цацдаг телевизийн тоо 16-д хүрчээ.

2012 оны УИХ-ын сонгуулийн үеэр:

- Олон нийтийн буюу төсвийн санхүүжилт ашигладаг;
- Хамгийн хүртээмжтэй, орон даяар цацагддаг;
- Үзэгчдийн тоо, рейтинг өндөр;
- Зах зээлд удаан хугацаагаар оршин тогтнож, үйл ажиллагаа явуулж буй;

- Зөвхөн агаарын долгион ашигладаг зэрэг шалгуурыг үндэслэн дараах таван телевизийг сонгон мониторинг хийлээ. Үүнд:
 1. Монголийн Үндэсний Олон Нийтийн Телевиз
 2. UBS телевиз (I суваг)
 3. ТВ5 телевиз (I суваг)
 4. ТВ9 телевиз (I суваг)
 5. 25-р суваг телевиз (I суваг)

МОНИТОРИНГИЙН ХУГАЦАА

Мониторингийг СЕХ-ноос баталсан “УИХ-ын Сонгуулийн тухай хуулийг хэрэгжүүлэх цаг хугацааны хуваарь”-ийн дагуу сонгуулийн сурталчилгаа эхэлсэн 2012 оны 6 дугаар сарын 6-наас сонгуулийн сурталчилгаа албан ёсоор зогсож 27-ныг дуустал 21 өдөр хийж гүйцэтгэв. Мониторингийг 3 үе шаттай хийж тухай бүрт хэвлэлийн бага хурал зохион байгуулж, дүнг олон нийтэд танилцуулж байлаа.

- 1-р үе шат 6 дугаар сарын 6-11 өдрийг дуустал, нийт 6 өдөр
- 2-р үе шат 6 дугаар сарын 12-19 өдрийг дуустал, нийт 8 өдөр
- 3-р үе шат 6 дугаар сарын 20-26 өдрийг дуустал, нийт 7 өдөр

Мөн сонгуулийн сурталчилгаа явуулахыг бүрэн хориглосон сонгуулийн өмнөх өдөр буюу 27-ны өдрийг мониторингид хамрууллаа.

4.2 ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Монгол Улсын Үндсэн Хуульд иргэдийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, мэдээлэл хайх, хүлээн авах, хэвлэн нийтлэх, уг хэлэх, тайван замаар жагсах, цуглах эрхийг баталгаажуулахын зэрэгцээ ардчилсан сонгуулийн суурь зарчмуудыг тусгасан. Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг тунхагласан Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Иргэний болон улс төрийн эрхийн олон улсын пактын 19-р зүйл, Монгол Улсын Үндсэн Хуулийн дагуу дотоодын хууль адил үйлчлэх ёстой.

Монгол Улсад хэвлэл мэдээллийн хэрэгсэл, сэтгүүлчийн үйл ажиллагааг зохицуулсан тусгайлсан хууль байхгүй. Харин 2002 оны 5 дугаар сарын 30-ны өдөр батлагдсан Зар сурталчилгааны тухай хуулийн 3 дугаар бүлэгт “мэдээлэх хэрэгсэл” гэсэн тодорхойлолт байдгийг Улсын Дээд Шүүх тайлбар гаргахдаа үндэс болгодог. “Мэдээлэх хэрэгсэл” гэж телевиз, радио, холбооны шугам сүлжээ, компьютерийн сүлжээ, тусгай програм, хэвлэл болон бусад арга хэрэгсэл” гэсэн утгаар ойлгоно.

ХЭВЛЭЛИЙН ЭРХ ЧӨЛӨӨГ БАТАЛГААЖУУЛСАН ХУУЛЬ ТОГТООМЖ

Монгол Улсад Үндсэн хуулиас гадна дор дурдсан хуулиар хэвлэл, мэдээллийн эрх чөлөөг баталгаажуулсан байdag.

- Хэвлэл, мэдээллийн эрх чөлөөний тухай хууль

1998 оны 8 дугаар сарын 28-ны өдөр батлагдсан энэ хуулиар цензур, мөн төрөөс олон нийтийн мэдээллийн хэрэгсэл өмчлөхийг хориглож, хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь өөрийн нийтэлж, нэвтрүүлж байгаа зүйлийнхээ төлөө хариуцлага хүлээх үүрэг ногдуулсан. Мөн УИХ-аас хэвлэлийн эрх чөлөөг хязгаарласан хууль батлахгүй байхаар заажээ.

- Олон нийтийн радио телевизийн тухай хууль

2005 оны 7 дугаар сарын 1-нээс хэрэгжиж эхэлсэн энэ хуулиар Монголын ард түмэнд үйлчлэх олон нийтийн радио, телевизийн үйл ажиллагааны зарчим, эрх зүйн үндсийг тогтоож, хөтөлбөрийн бодлогыг тодорхойлсон. Хуулиар редакцийн хараат бус байдал, мэдээлэл олж авах эрх зэрэг чухал эрх, эрх чөлөөг мөн баталгаажуулсан.

Олон нийтийн радио, телевизийн үзэл баримтлал, үндсэн зарчмыг тус хуулийн 4.1-д “...үйл ажиллагаанд хараат бус байх, бодит мэдээлэл олж авах, иргэний эрхийг хүндэтгэх, олон ургалч үзэл, ил тод байдлыг эрхэмлэх, аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан, хувь хүн, улстөрийн намын эрх ашгийг бус нийт үндэсний эрх ашгийг дээдлэх үндсэн зарчмыг баримтална” хэмээн заажээ.

- Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль

УИХ-аас 2011 оны 6 дугаар сарын 16-ны өдөр баталж 2011 оны 12 дугаар сарын 1-ний өдрөөс дагаж мөрдөж эхэлсэн “Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай” хуулиар төрийн

байгууллагуудад мэдээллээ нээлттэй болгох үүрэг ногдуулж, иргэн, хуулийн этгээд төрийн байгууллагаас мэдээлэл авах эрхийг баталгаажуулсан юм.

ӨРГӨН НЭВТРҮҮЛГИЙН ХЭРЭГСЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОХИЦУУЛСАН ХУУЛЬ ТОГТООМЖ

Монгол Улсад сонин хэвлэл, өргөн нэвтрүүлгийн үйл ажиллагааг зохицуулсан тусгай хууль байхгүй. Харин өргөн нэвтрүүлгийн хэрэгсэл буюу радио, телевизийн үйл ажиллагаатай холбоотой зарим зүйлийг дор дурдсан хуулиар зохицуулжээ.

- Радио долгионы тухай хууль

1999 онд батлагдсан Радио долгионы тухай хуулийн 4.1-д зааснаар “Монгол Улсын нутаг дэвсгэр дэх үүсгэгчээс үүссэн болон үндэсний радио давтамжийн хуваарилалтын хүснэгтэд багтаж байгаа радио долгион нь Монгол Улсын төрийн өмч мөн.

Төр нь радио долгион өмчлөгчийн хувьд энэ хуульд заасан нөхцөл, болзолтойгоор радио давтамж, радио давтамжийн зуравасыг ашиглах эрхийг бусад этгээдэд олгоно.

- Харилцаа холбооны тухай хууль

Зохицуулах хороо нь радио давтамж, радио давтамжийн зуравас ашиглах тусгай зөвшөөрөл олгох, түүний нөхцөл шаардлагын биелэлтэд хяналт тавих, гэрээ байгуулах бүрэн эрхтэй. Тусгай зөвшөөрлийг 20 хүртэл жилийн хугацаатайгаар олгоно.

ЗАР СУРТАЛЧИЛГАА ЗОХИЦУУЛСАН ХУУЛЬ ТОГТООМЖ

- Зар сурталчилгааны тухай хууль

2002 оны 5 дугаар сарын 30-ны өдөр батлагдсан Зар сурталчилгааны тухай хуулийн 3-р бүлэгт “Мэдээлэх хэрэгсэл” гэж телевиз, радио, холбооны шугам сүлжээ, компьютерийн сүлжээ, тусгай

программ, хэвлэл болон бусад арга хэрэгсэл” гэсэн утгаар ойлгоно” гэж заажээ.

Хуулийн 6.1-д “Зар сурталчилгаа үнэн, хэрэглэгчдэд хүртээмжтэй байж, агуулга, хэлбэр, түүнийг түгээж байгаа арга хэрэгслээс үл хамааран зар сурталчилгаа гэж ойлгогдоо байна.”

7.5-д “Энэ хуулийн 6.1-д заасныг зөрчсөн, хэрэглэгчийн ухамсарт шууд бусаар нөлөөлөх зар сурталчилгааг далд сурталчилгаа гэж тооцно.”

11.3-т “Улс орны болон дэлхий дахины амьдралын цаг үеийн шинжтэй үйл явдлын талаарх тогтмол мэдээллийн дундуур зар сурталчилгаа нэвтрүүлэхийг хориглоно.”

18.1-т “Мэдээлэх хэрэгсэл ашиглан сурвалжлага, мэдээ, тоймчийн нийтлэл болон зар сурталчилгааны бус хэлбэрээр зар сурталчилгаа байрлуулсан, түгээсний төлбөр авахыг хориглоно” гэж тус тус заасан байна.

· Олон нийтийн радио, телевизийн тухай хууль (2005.1.27)

13.1. Олон нийтийн радио, телевизээр арилжааны болон далд зар сурталчилгаа нэвтрүүлэхийг хориглоно.

СОНГУУЛИЙН ҮЕЭР ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ХЭРЭГСЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОХИЦУУЛСАН ХУУЛЬ ТОГТООМЖ

2012 оны УИХ-ын сонгуулийн сурталчилгаа хууль эрх зүйн шинэ орчинд явагдсанаараа онцлог болсон юм. 2011 оны 12 дугаар сарын 15-нд баталсан УИХ-ын Сонгуулийн тухай хуульд “Олон нийтийн радио телевизээс бусад радио, телевизээр сурталчилгааны төлбөртэй нэвтрүүлгийн нийт хугацаа нь хоногт хоёр цагаас илүүгүй байна” (35.11) гэсэн зохицуулалт шинээр орсон юм.

УИХ-ын Сонгуулийн тухай хуулийн 9.4 зүйлээр сонгуулийн үйл ажиллагааны талаар үнэн зөв, бодитой мэдээлэл түгээхийг хэвлэл мэдээллийн байгууллага, түүний албан тушаалтанд үүрэг болгосон байна.

Хуулийн 35 дугаар зүйлээр сонгуулийн сурталчилгааг зохицуулсан ба үүнд сонгуулийн сурталчилгааг эхлэх болон дуусгах цаг хугацааг (35.1, 35.3) зааснаас гадна нам, эвсэл, нэр дэвшигч хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилгаа явулахад дагаж мөрдөх дараах зарчим, хязгаарыг хуульчилж заажээ.

УИХ-ын сонгуулийн тухай хуулиас

- 35.4. Сонгуульд оролцож байгаа нам, эвсэл нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө танилцуулсан хорин хэвлэлийн хуудас бүхий сонин, хэвлэл, арван хэвлэлийн хуудас бүхий нэг ухуулах болон зурагт хуудас, нэр дэвшигчийн намтар, бусад сурталчилгааны материалыг арван хэвлэлийн хуудаст тус тус багтаана.
- 35.5. Бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө танилцуулсан тус бүр хоёр хэвлэлийн хуудас бүхий хоёр сонин, хэвлэл, нэг хэвлэлийн хуудас бүхий нэг ухуулах болон зурагт хуудас, нэр дэвшигчийн намтар, бусад сурталчилгааны материалыг нэг хэвлэлийн хуудаст тус тус багтаана.
- 35.8. Олон нийтийн радио, телевиз нь сонгуулийн сурталчилгаатай холбогдсон нэвтрүүлэг (цаашид “сурталчилгааны нэвтрүүлэг” гэх)-ийг Сонгуулийн Ерөнхий Хорооноос тогтоосон хуваарь, цагийн дагуу зөвхөн төлбөргүй нэвтрүүлэх ба төлбөртэй нэвтрүүлэхийг хориглоно.
- 35.9. Сонгуулийн Ерөнхий Хороо нь олон нийтийн радио, телевизээр төлбөргүй нэвтрүүлэх сурталчилгааны нэвтрүүлгийн хуваарь, цагийг батлахдаа нам, эвсэл бүрт, түүнчлэн нэг тойрот өрсөлдж байгаа бие даан нэр дэвшигч бүрт тэнцүү хугацаа ногдоо бор тооцож, холбогдох шийдвэр гаргаж мөрдүүлнэ.
- 35.11. Олон нийтийн радио, телевизээс бусад радио, телевизээр сурталчилгааны нэвтрүүлгийг төлбөртэй нэвтрүүлж болох бөгөөд сурталчилгааны төлбөртэй нэвтрүүлгийн нийт хугацаа нь хоногт хоёр цагаас илүүгүй байна.
- 35.12. Олон нийтийн радио, телевизээс бусад радио, телевиз нь нэгээс илүү сувагтай бол сурталчилгааны нэвтрүүлгийг зөвхөн агаарын долгион ашигладаг үндсэн сувгаар нэвтрүүлнэ.

Сонгуулийн сурталчилгааны үнэн зөв, бодитой байдлыг хангахтай холбоотой дараах заалтууд хуульд багтсан байна.

УИХ-ын сонгуулийн тухай хуулиас

- 35.24. Нам, эвсэл, нэр дэвшигч нь хэвлэл мэдээллийн хэрэгслээр сонгуулийн сурталчилгаа явуулах тохиолдолд өөрийн бэлтгэсэн болон захиалсан нийтлэл, нэвтрүүлгийн үнэн зөв, бодитой байдлыг хариуцна.
- 35.25. Хэвлэл мэдээллийн байгууллага нь энэ хуулийн 35.24-т зааснаас бусад өөрийн бэлтгэсэн болон бусдын захиалгаар бэлтгэн нийтэлж, нэвтрүүлсэн сонгуулийн сурталчилгаатай холбогдсон нийтлэл, нэвтрүүлгийн үнэн зөв, бодитой байдлыг хариуцна.
- 35.26. Хэвлэл мэдээллийн байгууллага нь энэ хуулийн 35.24-т заасан нийтлэл, нэвтрүүлгийг захиалагчтай байгуулсан гэрээний үндсэндээр нийтэлж, нэвтрүүлэх бөгөөд нийтлэл, нэвтрүүлгийн материал дээр захиалагчийн нэрийг тодорхой харагдахуйц байдлаар бичсэн байх ба энэ нь тухайн нэвтрүүлгийн нийт хугацаанд хамаарна.

Хуульд заасан дээрх заалтуудыг хэрэгжилтэд хяналт тавих, хууль зөрчсөн тохиолдолд ямар хариуцлага хүлээлгэх талаарх эрхзүйн орчныг авч үзвэл юуны өмнө 2006 оны 1 дүгээр сарын 12-нд батлагдсан Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 14 дүгээр зүйлд СЕХ нь сонгуулийн үеэр дэргэдээ хараат бус хэвлэл мэдээллийн орон тооны бус зөвлөл байгуулах, зөвлөл нь хэвлэл мэдээллийн мэргэжлийн байгууллага, төрийн бус байгууллагын төлөөлөл болон сонгуульд оролцож буй нам, эвслийн тэгш төлөөллөөс бурдсэн байх тухай заажээ. Уг зөвлөл нь нам, эвсэл, нэр дэвшигчийн сонгуулийн сурталчилгааны тэнцвэрт байдалд олон нийтийн оролцоотойгоор хяналт тавих, энэ асуудлаар нам, эвсэл, нэр дэвшигч, байгууллага, иргэнээс ирүүлсэн өргөдөл,

гомдлыг шуурхай хянан шийдвэрлэхэд туслах үүрэгтэй байна.

Хууль зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаар УИХ-ын сонгуулийн тухай хуульд дараах заалт байна:

УИХ-ын сонгуулийн тухай хуулиас

- 35.33. Энэ хуулийн 35.24, 35.25-д зааснаас бусад 35 дугаар зүйлийн холбогдо заалтыг зөрчсөн нэрдэвшигчийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг гурваас тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, нам, эвсэл, хэвлэл мэдээллийн байгууллага болон бусад хуулийн этгээдийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг арван таваас хорь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, бусад этгээдийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг гурваас тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр тус тус торгоно.

УИХ-ын сонгуулийн тухай хуульд заасан зарим зүйл заалтыг хэрэгжүүлэхтэй холбоотой СЕХ дангаараа болон ХХЗХ-той хамтран дараах журмууд баталж мөрдүүлсэн. Үүнд:

- Олон нийтийн радио телевизээс бусад радио телевизээр сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх журам (№56/38, 2012.05.15)

СЕХ, ХХЗХ-ны хамтарсан энэ журам УИХ-ын Сонгуулийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.11 дэх хэсэгт заасан радио телевизэд ХХЗХ-оос олгосон телевиз, радиогийн өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй телевиз, радио хамаарна.

- Хэвлэл мэдээллийн зөвлөлийн ажиллах журам (№64, 2012.05.16)

Хэвлэл мэдээллийн зөвлөл нь УИХ-ын Сонгуулийн тухай хуулийн 35.27-д

заасны дагуу Сонгуулийн Ерөнхий Хороо болон тойргийн хорооноос нам, эвсэл, нэр дэвшигчийн сонгуулийн сурталчилгааны тэнцвэрт байдалд олон нийтийн оролцоотойгоор хяналт тавих, энэ асуудлаар нам, эвсэл, нэр дэвшигч, байгууллага, иргэнээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг шуурхай хянан шийдвэрлэхэд туслах үүрэгтэй.

- УИХ-ын сонгуулийг ажиглах, сурвалжлах тухай журам (№25, 2012.04.06)

Хэвлэл мэдээллийн байгууллагын сурвалжлагч сонгуулийн явцыг сурвалжлахад баримтлах зарчим, эрх, үүрэг, үйл ажиллагаанд хоригло зүйлийг журамд оруулсан байна.

УИХ-ЫН СОНГУУЛИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ЗАРИМ ЗҮЙЛ ЗААЛТЫГ ХЭРЭГЛЭХЭД ГАРСАН ХҮНДРЭЛ

Мониторингийн явцад УИХ-ын Сонгуулийн хуультай холбоотой гарсан хүндрэл, түүнийг хэрхэн шийдвэрлэсэн талаар дурдая.

Сонгуулийн сурталчилгааны үргэлжлэх хугацаа СЕХ-ноос 2012 оны 4 дүгээр сарын 26-ны өдөр баталсан УИХ-ын Сонгуулийн хуулийг хэрэгжүүлэх цаг хугацааны хуваарьт зааснаар бол сонгуулийн сурталчилгааг эхлүүлэх тов нь 2012 оны 6 дугаар сарын 6-ны өдрөөс УИХ-ын сонгуулийн тухай хуулийн 35-р зүйлийн 35.3-т заасны дагуу 2012 оны 6 дугаар сарын 27-ны өдрийн 00.00 цаг хүртэлх хугацаанд тогтсон мэт харагдаж байна. Гэвч УИХ-ын Сонгуулийн тухай хуулийн 35.1-д заасны дагуу нэр дэвшигч бүртгүүлж, үнэмлэх авсан өдрөөс эхлэн сонгуулийн сурталчилгаагаа эхлүүлэх боломжтой тул сонгуулийн сурталчилгаа нь нэр дэвшигч бүрт харилцан адилгүй хугацаанд эхэлж байна. Тиймээс сонгуулийн сурталчилгааг эхлүүлэх хуулийн энэ зохицуулалт нэр дэвшигчдийн сонгуульд тэгш оролцо боломжийг хязгаарласан хэвээр байна.

УИХ-ын сонгуулийн сурталчилгааны явцад сонгож авсан 5 телевизид мониторинг хийх явцад гарсан гол хүндрэл бол далд сурталчилгааг Зар сурталчилгааны тухай хууль болон СЕХ, ХХЗХ-ны хамтран баталсан журмаар зохицуулсан боловч тодорхойлолт нь хэт ерөнхий байсан явдал юм. Иймээс мониторингийн баг хүндрэлээс гарах үүднээс олон улсын жишигт нийцүүлэн далд сурталчилгааг А, Б, В гэсэн турван бүлэгт хуваан авч үзсэн. Тэгэхээр цаашид далд сурталчилгаа гэж юуг хэлэх талаар хууль, журамд тодорхой томъёолох асуудал тулгарч байна.

УИХ-ын Сонгуулийн тухай хуулийн 35.11-д зааснаар Өргөн нэвтрүүлгийн хэрэгсэл нь төлбөртэй сурталчилгааг лхоёр цагаас хэтрүүлэхгүй явуулах, төлбөргүй сонгуулийн нэвтрүүлгийг явуулах цагийн хязгаарлалт байхгүй мэтээр ойлгогдохоор байгаа нь ХМХ болон бусад субъектын хувьд үл ойлголцол үүсгэхээр байна. Мониторингийн багийн тухайд төлбөртэй нэвтрүүлэг болон далд сурталчилгааг хамтад нь 35.11-д хамруулж, өдрийн эфирт үргэлжлэх хугацаа 2 цаг байх ёстой гэж үзэн мониторинг хийсэн.

Сонгуулийн товыг зарлахаас өмнө ухуулга сурталчилгааг ил, далд хэлбэрээр явуулсан бүх тохиолдолд хариуцлага тооцох эрх зүйн механизм байхгүй байсан нь сонгуульд өрсөлдөгч, нэр дэвшигчдийн эрх тэгш байх нөхцлийг ноцтой зөрчихөд хүргэсэн болно.

Мөн олон нийтийн телевиз болон ХМХ-ийн сонгогчдын боловсролыг дээшлүүлэх чиглэлээр хүлээх ямарваа нэг үүрэг хууль, журмаар зохицуулагдаагүй байгаагаас энэ чиглэлийн сонгуулийн мэдээлэл туйлын бага байх нэг нөхцөл болж байна. Сонгуулийн сурталчилгааны явцад мониторинг хийхдээ мэдээллийн өнгө аясыг эерэг, төвийг сахисан, сөрөг хэмээн ангилж үзсэн боловч сонгуулийн мэдээллийн дийлэнх нь хэт эерэг буюу

аль нэг нам, эвсэл, нэр дэвшигчийг магтан сайшаасан, дөвийлгөсөн өнгө аястай байв. Төвийг сахисан мэдээллийн эзлэх хувь бага байна. Энэ нь сонгогчдыг төөрөгдүүлэн, сэтгэл санаанд нь нөлөөлж зөв сонголт хийхэд нь хүндрэл учруулж байна. Ялангуяа энэ салбарт манлайлах Үүрэгтэй МУОНТ нийт сонгуулийн мэдээллийн төвийг сахисан мэдээлэл дөнгөж 9 хувийг эзэлж байна. Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн дагуу байгуулагдсан Хэвлэл мэдээллийн зөвлөл УИХ-ын сонгуулийн сурталчилгааны явцад ямар чиг үүрэг хүлээх талаар холбогдох хууль, журамд тодорхой тусаагүй байгаа нь учир дутагдалтай юм.

4.3 МОНИТОРИНГИЙН АРГАЧЛАЛ

2008 оны УИХ-ын, 2005, 2009 оны Ерөнхийлөгчийн сонгуулийн үеэр хийсэн хэвлэл мэдээллийн мониторингийн аргачлал дээр үндэслэн 2011 онд батлагдсан УИХ-ын Сонгуулийн тухай хуулийн шинэчилсэн найруулга, СЕХ, ХХЗХ-ны хамтран баталсан “Олон нийтийн радио, телевизээс бусад радио, телевизээр сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх журам”-д нийцүүлэн мониторингийн арга зүйг боловсрууллаа.

МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАХ, БАРИМТЖУУЛАХ, МЭДЭЭЛЭЛ БОЛОВСРУУЛАХ

Мэдээлэл цуглуулах, баримтжуулах

Хэвлэл мэдээллийн мониторингийн мэдээллийг тусгай маягт бөглөх замаар цуглуулж байлаа. Мониторингт хамрагдсан

5 телевизийн өглөөний 07 цагаас шөнийн 02 цаг хүртэлх хугацааны эфирийг бичиж, архивлан бүх нэвтрүүлэгт ажиглалт хийсэн. Энэ удаагийн мониторингийн давуу тал нь форс-мажор буюу эфирийн явцад цахилгаан, кабель тасрах зэргээс шалтгаалж бичлэг тасалдах явдал харьцангуй бага гарав. Учир нь бичлэг хийхээр гэрээ байгуулсан “Эн Эс Эм Эй” ХХК хоёр газар зэрэг бичлэг хийж байсан тул бичлэгийг нөхөж өгөх боломжтой байв. Түүнчлэн “UNIVISION” кабелийн суваттай гэрээлэн ажилладаг тул алдагдсан бичлэгийг гурван өдрийн дотор авах боломжтой байсан юм. Гэвч цөөн тохиолдолд зарим бичлэгийн дүрс дуугүй гарч байсан тул тэдгээрийг эфирийн цагаас хасч тооцсон юм. Хүснэгтийн загварыг хавсралтаас үзнэ үү.

Мэдээлэл боловсруулах, дүн шинжилгээ хийх

Мэдээлэл боловсруулагчид ажиглагчдаас авсан мэдээллийг SPSS17 програмд оруулан нэгтгэн боловсруулав. Түүнийг нь хүлээж авсан дүн шинжилгээ хийгч нэг бүрчлэн тулган нягталж анализ хийж байлаа.

1. Сурталчилгааны тэнцвэртэй байдлын мониторингийн аргачлал

2008 оны УИХ-ын сонгууль, 2009 оны Ерөнхийлөгчийн сонгуулийн хэвлэл мэдээллийн мониторингийн үеэр ашиглаж байсан тухайн телевизийн нам, нэр дэвшигчдэд зориулсан цагийг тоон болон чанарын үзүүлэлтээр хэмжих аргаар сурталчилгааны тэнцвэртэй байдалд дүн шинжилгээ хийлээ.

Тоон шинжилгээ

Тоон шинжилгээгээр нам, эвсэл, нэр дэвшигчдийн сурталчилгаанд зориулсан эфирийн цагийг хэмжив. Цаг хэмжихдээ дуу, дурсний аль алиныг нь минут, секундээр тооцсон. Нэр дэвшигчийн тухай сэтгүүлч, эсвэл өөр нэгэн этгээд,

эсвэл өрсөлдөгч нь нэг өгүүлбэрт багтаан дурдаад өнгөрөх, эсхүл гурван секундээс илүүгүй бол автоматаар нэг секунд гэж тооцож байв. Дэлгэц дээр нэг нэр дэвшигч ярьж байхад цаана нь өөр нэр дэвшигч санаандгүй байдлаар гарсан дүрсийг ч хэмжиж байлаа.

Чанарын шинжилгээ

Чанарын шинжилгээгээр сонгуульд өрсөлдсөн улстөрийн нам, эсвэл, нэр дэвшигчдийн талаарх мэдээллийн агуулга эерэг, сөрөг, төвийг сахисан аль нь байсныг үнэлсэн юм. Энэ нь тухайн хэвлэл, мэдээллийн хэрэгсэл сонгуульд өрсөлдсөн нам, эсвэл, нэр дэвшигчдэд аль хэр шударга хандсаны үнэлгээ юм. Үнэлгээ нь таван шатлалт хэмжээстэй. Үүнд:

Нэг гэсэн үнэлгээг тухайн этгээдийг маш эерэг буюу магтсан, биширсэн, тахин шүтсэн байдлаар хэт эерэг сэтгэгдэл төрүүлэхүйц сэтгэлийн хөдөлгөөнтэй мэдээлсэн,

Хоёр гэсэн үнэлгээг хэт магтан биширсэн биш ч сонгогчдод тухайн этгээдийн талаар эерэг сэтгэгдэл төрүүлэхүйц өнгө аястай мэдээлэлд,

Гурав гэсэн үнэлгээг баримттай, сэтгэл хөдлөлгүйгээр мэдээлсэн бол,

Дөрөв гэсэн үнэлгээг муулах хандлагатай, үзэгчдэд сөрөг сэтгэгдэл төрүүлэхүйц бол,

Тав гэсэн үнэлгээг илт муулсан, сөрөг сэтгэлийн хөдөлгөөн гаргаж буруутган, илт нэг талыг барьсан мэдээлэлд өглөө.

Дээрх таван шатлалыг ашиглаж эерэг, сөрөг, төвийг сахисан гэсэн үндсэн гурван түвшингээр дүгнэсэн. Учир нь ажиглагчид тухайн этгээдийн талаарх мэдээллийн өнгө аясыг үнэлэхдээ хэт туйлшрах, эргэлзэх зэрэг байдалд хүргэхгүй тулд ийнхүү таван шатлалд хуваасан юм.

- Сэтгүүл зүйн хараат бус нэвтрүүлгийн цаг, чанарыг хянах мониторингийн аргачлал

Сэтгүүл зүйн хараат бус нэвтрүүлэг гэж дараах гурван нэвтрүүлгийг онцлон авч үзэв.

Цаг үеийн мэдээний хөтөлбөр

СЕХ, ХХЗХ-оос хамтран баталсан “Олон нийтийн радио телевизээс бусад телевиз радиогоор сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх журам”-ын 3.2-т ”Сонгуулийн сурталчилгааг улс орны болон дэлхий дахины амьдралын цаг үеийн шинжтэй үйл явдлын тухай тогтмол мэдээ, мэдээллийн нэвтрүүлэг, боловсролын болон хүүхдэд зориулсан нэвтрүүлгийн дундуур нэвтрүүлэхийг хориглоно” гэсэн заалтад үндэслэн мэдээний хөтөлбөрт тоон болон чанарын шинжилгээ хийв.

Мэтгэлцээн

Мэтгэлцээний үндсэн чухал шаардлага нь оролцогчдын тэгш байдлыг хангах, тэдэнд ижил тэгш боломж олгох явдал юм. Үүнээс гадна дараах шаардлагуудыг зайлшгүй баримтлах ёстой. Ийм тохиолдолд бид мэтгэлцээн гэж дүгнэнэ. Үүнд:

- Хөтлөгчтэй байх
- Мэтгэлцээний дурмийг танилцуулах
- Оролцогчдыг танилцуулах
- Асуултад хариулахаа шодох
- Оролцогчдод адил асуулт тавих
- Хариултад хугацаа тогтоох
- Өрсөлдөгч талуудаас адил тооны хүн оролцох
- Оролцогчдод мөрийн хөтөлбөрөөс халивал сануулах
- Оролцогчид асуултад хариулахгүй бол таслан зогсоох
- Мэтгэлцээнийг рекламаар таслахгүй байх

Сонгогчдын боловсролд зориулсан нэвтрүүлэг

Дараах тохиолдолд “Сонгогчдын боловсролд зориулсан нэвтрүүлэг” гэж үзэв.

- Сонгогчдын боловсролд гэсэн нэр, эсвэл бичвэртэй;
 - Сонгуулийн Ерөнхий хорооны захиалгаар гэсэн тодотголтой;
 - Сонгуулийн тухай хуулийг тайлбарласан;
 - Сонгуульд оролцох эрх, үүргийн тухай тайлбарласан;
 - Саналаа хэрхэн өгөхийг тайлбарласан;
 - Санал өгөхийг уриалсан сурталчилгаа;
 - Мөрийн хөтөлбөрийн талаар хараат бус шинжээч оролцуулсан нэвтрүүлэг.
 - Амлалтын хэрэгжилтийг хараат бус шинжээчид тайлбарласан, дун шинжилгээ хийсэн.
3. Төлбөртэй сурталчилгааг хянах аргачлал

2012 оны УИХ-ын сонгуулийн сурталчилгааг МҮОНТ зөвхөн төлбөргүй нэвтрүүлэх бол арилжааны телевизүүд төлбөртэй нэвтрүүлэхийг УИХ-ын сонгуулийн шинэ хуулиар зохицуулсан. Тиймээс телевизүүдийн төлбөртэй болон төлбөртэй шинж агуулсан нэвтрүүлгийг тооцоходоо аргазүйн хувьд бага зэрэг ялгаатай байв. СЕХ-ноос баталсан 2012 оны УИХ-ын сонгуулийн сурталчилгааг МҮОНТ-ээр нэвтрүүлэх хуваарийг хавсралтаас үзнэ үү.

Дараах тохиолдолд төлбөртэй буюу төлбөртэй шинж агуулсан нэвтрүүлэг гэж үзсэн юм.

- Төлбөртэй, захиалгатай гэж тэмдэглэсэн;
- Намын нэр, лого, таних тэмдэгтэй;
- Нам, нэр дэвшигчийн реклам, шторк, ролик;

- Нам, намын мөрийн хөтөлбөрийн дагнасан сурталчилгаа;
- Сүлжээний нэвтрүүлэгт намын төлөөлөл, нэр дэвшигч дагнан оролцсон;
- Сүлжээний нэвтрүүлэг биш боловч намын төлөөлөл, нэр дэвшигч оролцсон;
- Нэр дэвшигчийн хөрөг нэвтрүүлэг;
- Хамтран бэлтгэсэн нэвтрүүлэгт намын төлөөлөл, нэр дэвшигч оролцсон;
- Намын төлөөлөл, нэр дэвшигч, арилжааны, нийгмийн сурталчилгаанд оролцсон.

Телевизийн төлбөртэй буюу төлбөртэй шинж агуулсан нэвтрүүлгийн нийт цагийг сонгуулийн сурталчилгааны нийт 21 өдөрт хувааж хоногт зарцуулсан дундаж цагийг гаргасан юм.

4. Далд сурталчилгаанд мониторинг хийсэн аргачлал

Далд сурталчилгааг Зар сурталчилгааны тухай хуулийн 6.1, 7.5, СЕХ, ХХЗХ-ны 2012 оны 56/38 тоот хамтарсан тогтоолоор баталсан “Олон нийтийн радио телевизээс бусад радио, телевизээр сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх журам”-ын 2.16, 3.1 хэсэгт заасны дагуу тодорхойлсон болно. Эрх зүйн орчин хэсгээс үзнэ үү.

Далд сурталчилгааг дотор нь гурав ангилж үзсэн.

“А” хэлбэр:

Үүнд УИХ, Засгийн Газар, түүний харьяа агентлаг, төр захиргааны байгууллага, сайд, дарга, албан тушаалтнуудын үйл ажиллагааны тухай, тэдгээрийн дэргэдэх хэвлэл мэдээллийн алба, телевизийн студиуд сонгуульд нэр дэвшиэн салбарын сайд, дарга нарыг дагалдан явж, тэдэнтэй холбоотой мэдээ сурвалжлага бэлтгэн хэвлэл мэдээллээр цацсан, ойд зориулсан мэндчилгээ, талархлын шинжтэй нэвтрүүлгүүдийг хамруулсан.

Дээрх нэвтрүүлэгт орж байгаа нэр дэвшигчид зөвхөн хийж, гүйцэтгэж байгаа ажилтайгаа холбоотой зүйл ярьж байгаа тохиолдолд А1, харин ажлаа ямар нэгэн байдлаар сонгуультай холбож байвал А2 гэсэн кодоор тэмдэглэсэн.

“Б” хэлбэр:

Үүнд улстөрийн нам, нэр дэвшигчидтэй холбоотой үйл явдал, асуудлыг зориудаар сурвалжилж мэдээлсэн тохиолдлыг бүртгэсэн. Тухайлбал:

- Ямар нэгэн үйл явдал, асуудал хөндсөн мэдээллийг нэг эсвэл нэг намын хэд хэдэн нэр дэвшигчээр тайлбарлуулах, тэдний санал бодлыг тусгайлан авч оруулах
- Бодит шаардлагагүй байхад улстөрийн нам, эвсэл, нэр дэвшигчийн таних тэмдэг, зураг, дурс, нэр, тэдний дуу хөгжим зэргийг анхаарал татахуйцаар нийтлэх, үзүүлэх, сонсгох гэх мэт

“В” хэлбэр:

Тухайн хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлчид улстөрийн нам, эвсэл, нэр дэвшигчийн талаар дагнан сурталчилсан нэвтрүүлэг. Үүнд:

- Хэвлэл мэдээлэл, сэтгүүлч өөрөө улстөрийн нам, нэр дэвшигчийн төлөө саналаа өгөх, өгөхгүй байхыг ил ба далд арга хэлбэрээр уриалах.
- Улстөрийн нам, эвсэл, нэр дэвшигчтэй ярилцлага хийхдээ тэдний яриаг таслах, таслахгүй байх, эсвэл асуулт тавих, тавихгүй байх аргаар нэг талын байр суурийг илэрхийлэх.
- Улстөрийн нам, эвсэл, нэр дэвшигчдийн талаар янз бүрийн санал бодлыг түүж оруулах, эсвэл оруулахгүй байх аргаар дан нэг талын байр суурийг илэрхийлэх.
- Улстөрийн төлбөртэй сурталчилгаа гэдгийг тодорхой ойлгуулахгүй нууж хаах, далдлах замаар сэтгүүл зүйн нэвтрүүлэг гэж ойлгуулах.

4.4 МОНИТОРИНГИЙН ҮР ДҮН

СОНГУУЛИЙН МЭДЭЭЛЭЛ


2012 оны УИХ-ын сонгуулийн сурталчилгааны 21 өдөр МҮОНТ, UBS, ТВ5, ТВ9, 25-р суваг телевизийн 112 357 минутын эфирийн цагт ажиглалт хийв. Үүнээс 17476 минут буюу эфирийн цагийн 15,5 хувийг сонгуулийн мэдээлэл эзэлжээ.

Хүснэгт 1. Телевизүүдийн сонгуулийн мэдээлэлд зориулсан хугацаа (минутаар)

	1-р үе шат	2-р үе шат	3-р үе шат	Нийт
МҮОНТ	484	872	758	2114
UBS	519	1104	1742	3365
MN25	779	1077	1490	3346
ТВ5	515	1110	1091	2716
ТВ9	974	2012	2950	5936
Нийт	3270	6175	8031	17476

МҮОНТ-ийн нийт 22429 минутын нэвтрүүлэгт ажиглалт хийснээс 9,4 хувь буюу 2114 минутыг сонгуулийн мэдээлэлд зарцуулсан байна. Арилжааны телевизүүдээс ТВ5 телевиз хамгийн бага буюу 2716 минут зарцуулсан нь нийт эфирийн цагийн 11,3 хувийг эзэлж байна. Харин ТВ9 телевиз хамгийн олон цаг буюу нийт 22540 минутын эфирийн 26,3 хувь болох 5,936 минутыг сонгуульд зарцуулсан байна.

График 1. Сонгуулийн мэдээлэлд зарцуулсан цагийн өсөлт



Мониторингийн хугацаанд МҮОНТ-ийн сонгуулийн мэдээллийн цаг 2-р үе шатанд эхнийхээс 1,6 хувь өсч, 3-р үе шатанд 2-р үе шатнаас 1,2 хувиар буурчээ. Харин бусад телевизийн сонгуулийн мэдээллийн цаг мониторингийн үе шат бүрт нэмэгдэж байсан ч ТВ9 телевиз хамгийн их буюу 3-р үе шатанд эхний үе шаттай харьцуулахад 3 дахин өссөн байлаа.

СОНГУУЛИЙН СУРТАЛЧИЛГАА

Тэнцүү цаг хуваарилалт

УИХ-ын Сонгуулийн тухай хуулийн 35.9-д "Сонгуулийн Ерөнхий Хороо нь олон нийтийн радио, телевизээр төлбөргүй нэвтрүүлэх сурталчилгааны нэвтрүүлгийн хуваарь, цагийг батлахдаа нам, эвсэл бүрт, түүнчлэн нэг тойрогт өрсөлдөж байгаа бие даан нэр дэвшигч бүрт тэнцүү хугацаа ногдохоор тооцож, холбогдох шийдвэр гаргаж мөрдүүлнэ" гэж заасан. Гэтэл тэнцүү цаг ногдуулах тухай хуулийн дээрх заалт хэрэгжээгүйг мониторингийн дунгээс харж болно.

СЕХ "2012 оны УИХ-ын сонгуулийн сурталчилгааг МҮОНТ-ээр нэвтрүүлэх хуваарь" баталсан. Энэ хуваарийн дагуу МҮОНТ сонгуулийн сурталчилгааны 21 өдөр нийт 23 цагийн сонгуулийн сурталчилгаа явуулахаар төлөвлөжээ. Нийт цагаа 21 өдөрт хувааж нам тус бүрт 3 удаагийн давтамжтай 20 минутын

нэвтрүүлэг хийхээр 13 цаг хуваарилсан байна. Үлдсэн 10 цагаас 1 цаг 30 минутыг бие даан нэр дэвшигчдэд, 8 цаг 30 минутыг дахин 13 нам, эвсэлд тэнцүү хуваарилсан нь нэг намд дунджаар 40 орчим минут оногджээ.

Мониторингийн явцад дээрх хуваарийн хэрэгжилтэд тулгалт хийхэд МҮОНТ баталсан хуваариар ажиллаж байсан ч бусад цагт нийт 2161 минутын төлбөргүй сурталчилгаа явуулсан байв.

Хүснэгт 2. Телевизүүдийн нам, эвсэл, бие даан нэр дэвшигчдэд хуваарилсан цаг (хувиар)

	MYONT	MN25	TB9	UBS	TB5	Нийт хувь
МАН	23	45	22	51	58	39,8
АН	18	36	31	34	22	28,2
МНН	7	-	1	-	-	1,6
ИЗНН	6	13	2	3	14	7,6
ЭОНН	5	-	1	-	-	1,2
ХХН	5	-	-	-	-	1,0
ИХН	5	1	-	1	-	1,4
ЭЧХН	5	-	-	-	-	1,0
ЭОН	5	-	2	2	-	1,8
ШЁЭ	4	2	38	3	2	9,8
ГХЭ	4	1	1	5	-	2,2
МСДН	4	-	-	-	-	0,8
МУНН	3	-	-	-	-	0,6
БД	6	2	2	1	4	3,0

2012 оны УИХ-ын сонгуулийн сурталчилгааны үеэр телевизүүдийн нам, эвсэл, бие даан нэр дэвшигчдэд цаг хуваарилсан байдлаас хараад МАН, АН-ын талаарх мэдээлэл давамгайлсан байна.

Мониторингийн хугацаанд таван телевизийн сонгуулийн нийт 17476 минутын мэдээллийн 39,8 хувийг МАН, 28,2 хувийг АН-ын талаарх мэдээлэл эзэлсэн бөгөөд бусад нам, эвсэл, бие даагчдад 0,6-9,3 хувьтай тэнцэх цаг ногджээ. ТВ9 телевиз

сонгуулийн нийт мэдээллийнхээ 38 хувийг ШЕЭ-д зориулжээ.

МУОНТ УИХ-д суудалгүй намуудаас хамгийн их буюу 7 хувийг МНН-д, хамгийн бага буюу 3 хувийг МУНН-д зориулжээ.

Арилжааны телевизүүдээр МАН, АН, ШЕЭ, ИЗНН, БД-ын сонгуулийн сурталчилгаа давамгайлсан бол ХХН, ЭЧХН, МСДН, МУНН-ын цаг 1 хувьд ч хүрээгүй байна.

- Тойрогт нэр дэвшигчдийн сурталчилгаа

УИХ-ын Сонгуулийн хуульд “олон нийтийн радио, телевизээр ...нам, эвсэл бүрт, түүнчлэн нэг тойрогт өрсөлдөж байгаа бие даан нэр дэвшигч бүрт тэнцүү хугацаа ногдохоор (35.9), “бусад радио, телевизээр ...сурталчилгааны төлбөртэй нэвтрүүлгийн нийт хугацаа нь хоногт хоёр цагаас илүүгүй байна (35.11) гэж заасан.

Хуулийн дээрх заалтын дагуу арилжааны телевизүүд сонгуулийн сурталчилгааны 21 хоногт нийт 42 цаг буюу 2520 минутын сурталчилгаа явуулхаар зөвшөөрсөн байна. Энэ цагийг зөвхөн тойрогт нэр дэвшигч 354 хүнд тэнцүү хуваавал нэг хүнд дунджаар 7 минут 6 секунд ногдоно. Хэрвээ нэр дэвшигч ногдох бүх цагаа ашиглан хамгийн хүртээмжтэй, орон даяар цацагддаг, үзэгчдийн тоо, рейтинг өндөр, зах зээлд удаан хугацаагаар оршин тогтнож, үйл ажиллагаа явуулж буй гэсэн шалгуураар арилжааны дөрвөн телевизээр сурталчилгаа явуулбал 28 минут 24 секунд ногдож байна. Гэтэл тойрогт нэр дэвшсэн 354 хүний 78,5 хувь л дээрх телевизүүдээр сурталчилгаагаа нэвтрүүлжээ.

Мониторингийн явцад таван телевизээр хамгийн олон цаг сурталчилгаа явуулсан 37 нэр дэвшигчийн 43,24 хувь нь МАН, 18,92 хувь нь АН, 13,51 хувь нь Шударга ёс эвсэл, 8,11 хувь нь ИЗНН, 5,41 хувь нь бие даагчид байв. Харин ЭОН, ЭЧХН, МНН, МУНН-аас нэр дэвшигчид тус бүр 2,7 хувь ногджээ.

Эдгээр 37 нэр дэвшигчийн 62 хувь буюу 23 нь хөдөөгийн тойрогт нэр дэвшигч, хоёр нь бие даагч, 4 буюу 10,8 хувь нь эмэгтэйчүүд байсан бол 13 нь буюу 35,14 хувь нь ялалт байгуулснаас нэг эмэгтэй нэр дэвшигч байна.

Хүснэгт 3. Хамгийн олон цагийн сурталчилгаа явуулсан 10 нэр дэвшигч

	Нэр дэвшигчид	Харьяалал	Нийт цаг
1	Л. Энх-Амгалан	МАН	05:58:31
2	З. Алтай	ИЗНН	04:52:10
3	Ё. Отгонбаяр	МАН	04:27:33
4	Н. Төмөрхүү	МАН	03:34:57
5	Л. Эрдэнэчимэг	АН	03:28:35
6	Б. Тулга	ШЕЭ	02:55:55
7	Ж. Эрдэнэбат	МАН	02:53:38
8	Ч. Ганхуяг	МАН	02:44:10
9	Га. Баярсайхан	АН	02:38:52
10	М. Билэгт	МАН	02:34:29

УИХ-ын Сонгуулийн тухай хуульд нэр дэвшигчдийн 20 хувь нь эмэгтэй нэр дэвшигч байна гэж заасан. 2012 оны УИХ-ын сонгуульд нэр дэвшсэн 544 хүний 32 хувь буюу 174 нь эмэгтэйчүүд байв.

Мониторингид хамрагдсан таван телевизээр сонгуулийн сурталчилгаагаа нэвтрүүлсэн 278 нэр дэвшигчийн 49 буюу 18 хувь нь эмэгтэйчүүд байв. Өөрөөр хэлбэл, сонгуульд нэр дэвшсэн эрэгтэйчүүдийн 61 хувь, эмэгтэйчүүдийн 28 хувь нь сурталчилгаагаа явуулжээ. Эмэгтэйчүүдийн тоо эрчүүдийнхээс 4,6 дахин бага байхад сурталчилгааны цаг 6,2 дахин бага байна. Сонгуулийн сурталчилгааны 21 хоногт нэг эмэгтэй нэр дэвшигч дунджаар 30 минутын, нэг эрэгтэй нэр дэвшигч дунджаар 41 минутын сурталчилгаа явуулсан байна.

Хүснэгт 4. Эмэгтэй, эрэгтэй нэр дэвшигчдийн сурталчилгааны цаг (хувиар)

	Эмэгтэй		Эрэгтэй	
	Минут	Хувь	Минут	Хувь
МООНТ	116	15	656	85
MN25	164	7,3	2072	92,7
TB5	198	12,6	1370	87,4
TB9	600	14,5	3523	85,5
UBS	401	19,2	1681	80,8

Мониторингид хамрагдсан телевизүүдээс UBS телевиз хамгийн өндөр буюу нийт сонгуулийн мэдээллийн 19,2 хувийг, хамгийн бага цаг буюу 7,3 хувийг 25-р суваг телевиз эмэгтэй нэр дэвшигчдэд зориулсан байна. Харин МООНТ-ийн сонгуулийн мэдээллийн 15 хувийг эмэгтэй нэр дэвшигчдийн сурталчилгаа эзэлжээ.

- Оргил цагийг нам, эвсэл, нэр дэвшигчдэд хуваарилсан байдал

СЕХ, ХХЗХ-ны хамтран баталсан “Олон нийтийн радио, телевизээс бусад телевиз, радиогоор сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх журам”-ын “...сурталчилгааны 7 хоног бүрт цагийг жигд, тэнцвэртэй хуваарилах бөгөөд энэ нь сонгогчдын хамгийн их үзэж, сонсдог оргил цагуудад (19:00-23:00) мөн адил хамаарна” (2.9) гэсэн заалтыг үндэслэн оргил цагийг нам, эвсэл, бие даан нэр дэвшигчдэд хэрхэн хуваарилсан байдалд ажиглалт хийсэн юм.

Хүснэгт 5. Оргил цагийг нам, эвсэл, нэр дэвшигчдэд хуваарилсан байдал (хувиар)

	МООНТ	MN25	TB9	UBS	TB5
МАН	19	49	23	46	59
АН	12	38	30	37	26
МНН	9	-	1	-	-
ИЗНН	8	9	3	5	9
ЭОНН	6	-	1	-	-
ХХН	6	-	-	-	-
ИХН	5	-	1	1	-
ЭЧХН	5	-	-	-	-
ЭОН	6	-	2	3	-
ШЭЭ	4	2	35	2	1
ГХЭ	4	-	1	5	-
МСДН	5	-	-	-	-
МУНН	4	-	-	-	-
БД	7	2	3	1	5

МООНТ оргил цагаар нам, эвсэл, нэр дэвшигчдийн сонгуулийн сурталчилгааг харьцангуй тэнцвэртэй нэвтрүүлсэн ч МАН, АН-д нийт оргил цагийн 31 хувь буюу 1/3-ийг зориулсан байна.

MN25, UBS, TB5 телевиз оргил цагийн нэвтрүүлгийнхээ 83-87 хувийг МАН, АН-д зориулсан бол TB9 телевиз оргил цагийнхаа 35 хувийг дангаар ШЭЭ-д зориулсан нь хамгийн өндөр байна. Харин АН, МАН-д ойролцоо буюу 23-30 хувийг зориулжээ.


МЭДЭЭЛЛИЙН ӨНГӨ АЯС

Мэдээллийн чанар тухайн ХМХ нам, эвсэл, нэр дэвшигчдэд аль хэр шударга хандсаныг илэрхийлэх үзүүлэлт болдог тул сонгуулийн мэдээллийн өнгө аясыг эерэг, төвийг сахисан буюу нейтрал, сөрөг хэмээн ангилж үзэв. Мэдээллийн чанар нь сонгогчдын сэтгэл санаа, сонголтод ихээхэн нөлөөтэй байдал.

Төвийг сахисан мэдээлэл тухайн ХМХ нам, эвсэл, нэр дэвшигчдэд аль хэр шударга хандсаныг илэрхийлэх үзүүлэлт болдог. Эерэг хэт магтсан мэдээлэл үзэгчдэд сайхан сэтгэгдэл төрүүлж, тухайн нам, нэр дэвшигчийг биширч, мөрийн хөтөлбөрийн биелэх эсэхэд шүүмжлэлтэй хандах чадварыг сулруулдаг бол сөрөг, хэт муулсан мэдээлэл үзэгчдэд таагүй сэтгэгдэл төрүүлж, тухайн нам, нэр дэвшигчийг буруушаах, эсэргүүцэх, хичнээн сайн боловсруулсан байсан ч мөрийн хөтөлбөрийг нь үгүйсгэхэд хүргэдэг.

2012 оны УИХ-ын сонгуулийн үеэр таван телевизээр нэвтрүүлсэн нам, эвсэл, нэр дэвшигчдийн талаар эерэг буюу магтаж сайшаасан мэдээллийн эзлэх хувь хэт өндөр гарсан байна. Таван телевизийн бүгд 17476 минутын сонгуулийн мэдээллийн 81 хувь буюу 14155 минут нь эерэг, 14,7 хувь буюу 2576 минут нь төвийг сахисан, 4,3 хувь буюу 745 минут нь сөрөг өнгө аястай мэдээлэл байжээ.

График 2. Мэдээллийн өнгө аяс
(телевиз тус бүрээр)



МООНТ-ийн сонгуулийн нийт мэдээллийн ердөө 9 хувь нь төвийг сахисан мэдээлэл байгаа нь анхаарал татаж байна. Харин TB5 телевизийн сонгуулийн мэдээллийн 36 хувь нь төвийг сахисан мэдээлэл байгаа нь бусад телевизтэй харьцуулахад өндөр үзүүлэлт юм. Сонгуулийн сурталчилгааны мэдээллийн өнгө аясыг 1-5 баллаар дүгнэсэн бөгөөд нэг буюу нэр дэвшигчийг хэт магтсан, тав буюу хэт муулж доромжилсон гэж үнэлэх мэдээлэл мониторингийн явцад 1 хувь хүрэхгүй байлаа.

Эерэг мэдээлэлд сайшааж, боломжийн хэмээн үзсэн, сөрөг мэдээлэлд муучилж дарсан, сөрөг сэтгэгдэл төрүүлсэн байж болох мэдээлүүд оруулсан юм. Мэдээллийн өнгө аясыг нам, эвсэл, нэр дэвшигчдийн зөвхөн төлбөртэй нэвтрүүлгийг дамжуулсан цагтай холбон авч үзэх нь учир дутагдалтай юм. Учир нь нэр дэвшигч субъект өөрт ногдсон төлбөртэй цаг дээрээ өөрийнхөө давуу талыг сурталчлах магадлал өндөр байдал. Тиймээс мэдээллийн өнгө аясыг гаргахдаа нийт сонгуулийн мэдээлэлд болон далд сурталчилгааны явцад гэж ялгавартай гаргав.

• Эерэг мэдээлэл

Таван телевизийн бүгд 17476 минутын сонгуулийн мэдээллийн 81 хувь буюу 14155 минутыг эерэг өнгө аястай мэдээлэл эзэлж байна. Мониторингт хамрагдсан таван телевизээс зөвхөн МООНТ нам, эвсэл, бие даан нэр дэвшигчдийг цагийн хувьд харилцан адилгүй ч эерэг байдлаар сурталчилжээ. Бусад телевиз тодорхой нам, эвсэл, бие даан нэр дэвшигчдийн талаар эерэг мэдээлэл давамгайлсан байлаа.

Хүснэгт 6. Эерэг өнгө аястай мэдээлэлд нам, эвсэл, бие даан нэр дэвшигчдийн эзлэх хувь

	MYOHT	UBS	MN25	TB5	TB9
МАН	21	52	45	67	20
АН	17	34	36	21	32
МНН	7	-	-	-	-
ИЗНН	6	4	14	8	2
ИХН	6	1	1	-	-
ЭОН	5	2	-	-	3
ЭОНН	5	-	-	-	1
ХХН	5	-	-	-	-
ЭЧХН	5	-	-	-	-
МСДН	5	-	-	-	-
ГХЭ	4	4	1	-	-
ШЁЭ	4	2	1	-	39
МУНН	3	-	-	-	-
БД	7	1	2	4	3
Нийт	100	100	100	100	100

Хүснэгт 7. Сөрөг өнгө аястай мэдээлэлд нам эвсэл, бие даан нэр дэвшигчдийн эзлэх хувь

	MYOHTB	UBS	MN25	TB5	TB9
МАН	30	27	68	29	60
АН	62	72	30	54	40
ИЗНН	-	-	1	-	-
ЭОН	1x	-	-	-	-
ШЁЭ	7	1	1	13	-
БД	-	-	-	4	-
Нийт	100	100	100	100	100

Сөрөг мэдээллийн хамгийн их хувь буюу 77 хувь нь TB9 телевизээр цацагдсан бол MYOHT сөрөг мэдээллийн 4,4 хувийг эзлэв.

АН-ын талаар хамгийн олон цагийн сөрөг өнгө аястай мэдээлэл явсан бол МАН удаалжээ. TB9-өөс бусад телевиз ШЁЭ-ийг сөрөг байдлаар мэдээлжээ. ИЗНН, ЭОН-ууд тус бүр нэг телевизийн сөрөг сурталчилгааны 1 хувийг эзэлж байна. Бусад нам, эвслийн талаар сөрөг сурталчилгаа илрээгүй байна. Харин зөвхөн TB5 телевиз нийт сөрөг мэдээллийн 4 хувьд бие даагчдын талаар сөргөөр мэдээлжээ.

· Сөрөг мэдээлэл

МАН-ыг TB5, UBS, MN25 телевиз хамгийн их эерэгээр сурталчилжээ. Тухайлбал, UBS телевизийн сурталчилгааны 52 хувь, TB5-ын 67 хувь нь МАН-ын талаар эерэгээр мэдээлж байсан бол TB9 телевиз сонгуулийн нийт мэдээллийнхээ 39 хувьд ШЁЭ-ийн талаар эерэгээр мэдээлжээ.

2012 оны УИХ-ын сонгуулийн сурталчилгаанд сөрөг өнгө аястай мэдээлэл бага байлаа. Таван телевизээр бүгд 745 минутын сөрөг өнгө аястай мэдээлэл нэвтрүүлсэн нь нийт 17476 минутын сонгуулийн мэдээллийн 4,3 хувьтай тэнцэж байна. Үүнийг 2008 оны УИХ-ын сонгуулийн мониторингтой харьцуулахад 1,8 хувиар буурчээ.

Төвийг сахисан мэдээлэл 2012 оны УИХ-ын сонгуулиар мониторингт хамрагдсан таван телевиз төвийг сахисан байдлаар ажиллаж чадаагүй нь мониторингийн дүнгээс харагдаж байна. Таван телевизийн бүгд 17476 минутын сонгуулийн мэдээллийн 14,7 хувь буюу 2576 минут нь төвийг сахисан мэдээлэл байна. Түүнчлэн төвийг сахисан мэдээлэл нь нэр дэвшигч субъектуудад ч харилцан адилгүй ногдсон юм. Мониторингт хамрагдсан бүх телевиз МАН, АН, ИЗНН, ШЁЭ-ийн талаар төвийг сахисан байдлаар мэдээлсэн байна. Таван телевизээр нэвтрүүлсэн төвийг сахисан нийт мэдээллийн 31,8 хувийг МАН эзлэн тэргүүлж, 26 хувиар АН удаалав.

Хүснэгт 8. Төвийг сахисан мэдээлэлд нам эвсэл, бие даан нэр дэвшигчдийн эзлэх хувь


	MYOHT	UBS	MN25	TB5	TB9
МАН	43	22	43	43	8
АН	25	10	47	22	26
МНН	1	-	-	-	4
ИЗНН	4	2	7	25	5
ИХН	2	-	-	-	-
ЭОН	-	-	-	-	1
ЭОНН	6	-	-	-	-
ХХН	-	-	-	-	-
ЭЧХН	1	-	-	1	-
МСДН	-	-	-	-	-
ГХЭ	6	43	-	-	4
ШЁЭ	8	23	3	5	51
МУНН	-	-	-	-	-
БД	4	-	-	4	1

TB9 телевизийн төвийг сахисан мэдээллийн 51 хувь нь дангаараа ШЁЭ-д ногджээ. Гэтэл ХХН, МСДН, МУНН-ын төвийг сахисан мэдээлэлд эзэлсэн хугацаа 1 хувьд ч хүрээгүй юм. Харин бие даагчдыг UBS, 25-р суваг телевиз төвийг сахисан байдлаар мэдээлээгүй болох нь хүснэгтээс харагдаж байна.

ШУУД БА ШУУД БУС ЭХ СУРВАЛЖ


Телевизээр нам, эвсэл, нэр дэвшигчдийн сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэхдээ эх сурвалж ашигласан байдлыг шууд ба шууд бус гэж ангилсан. Телевизийн нэвтрүүлэгт аливаа нэр дэвшигч өөрөө оролцон өөрийн дуу хоолойгоор мэдээлэл өгч байгаа тохиолдолд шууд эх сурвалж, сэтгүүлч, өрсөлдөгч нэр дэвшигч, өөр хэн нэгэн хүн тухайн нэр дэвшигчийн талаар мэдээлэл өгч байвал шууд бус эх сурвалж гэж үзэв.

График 3. Мэдээллийн эх сурвалж ашигласан байдал (телевиз тус бүрээр)



MYOHT-ээр нэвтрүүлсэн сонгуулийн мэдээллийн 67 хувь нь шууд эх сурвалжаас олон нийтэд хүрчээ. Арилжааны телевизүүдээс 25-р суваг телевиз хамгийн их буюу 64,7 хувь нь шууд эх сурвалжаас мэдээллээ хүргэсэн бол TB5 телевиз хамгийн их буюу 63 хувь нь шууд бус эх сурвалжийн мэдээ байна.

График 4. Шууд эх сурвалжаас хүрсэн мэдээлэл (хүйсээр)



Шууд эх сурвалжийн мэдээллийг хүйсээр ялгаж үзэхэд эрэгтэйчүүдийн хамгийн бага буюу 76,3 хувь, харин эмэгтэйчүүд хамгийн их буюу 23,7 хувь нь шууд эх сурвалжийн мэдээлэл байна. Энэ дүнгээс харахад эмэгтэй нэр дэвшигчдэд телевизийн нэвтрүүлэгт шууд оролцож боломж хязгаарлагдмал байсан гэж дүгнэж болно.

ТӨЛБӨРТЭЙ СУРТАЛЧИЛГАА

УИХ-ын Сонгуулийн шинэ хуульд “Олон нийтийн радио, телевизээс бусад радио, телевизээр сурталчилгааны нэвтрүүлгийг төлбөртэй нэвтрүүлж болох бөгөөд сурталчилгааны төлбөртэй нэвтрүүлгийн нийт хугацаа нь хоногт хоёр цагаас илүүгүй байна (35.11) гэж зохицуулалт орсон.


Төлбөртэй нэвтрүүлэгт тухайн телевиз төлбөртэй, захиалгатай гэж тодотгосон байхаас гадна төлбөртэй захиалгатай шинж агуулсан нэвтрүүлгүүдийг оруулж тооцов. Гэтэл телевизүүд сурталчилгааны хоёр цагийн хязгаарлалтыг бүгд хэтрүүлсэн байна.

Хүснэгт 9. Төлбөртэй нэвтрүүлэг цацсан байдал

	Хуулиар хуулж зөвшөөрөгдсөн нөхцөлбөр	Цацагдсан төлбөртэй	Далд сурталчилгаа	Хэтэрсэн байж боловх
MN25	2520	2090	1265	+835
TB9	2520	4522	1314	+3316
UBS	2520	3017	326	+823
TB5	2520	2048	527	+55

25-р суваг, TB5 телевизийн төлбөртэй нэвтрүүлэг хуульд заасан хугацаанаас хэтрээгүй мэт харагдаж байгаа боловч далд сурталчилгааны хугацааг нэмж тооцвол даруй 55-835 минут хэтэрсэн байна. Харин TB9, UBS телевизийн төлбөртэй нэвтрүүлгийн цаг 497-2002 минутаар хэтэрсэн бөгөөд үүн дээр далд сурталчилгаа явуулсан цагийг нэмж тооцвол 823-3316 минут хэтэрчээ. Энэ нь хуулиар зөвшөөрөгдсөн хугацаанаас 1,3-2,3 дахин хэтэрсэн үзүүлэлт юм.

График 5. Төлбөртэй нэвтрүүлгийн цацагдсан байдлыг мониторингийн үе шатуудаар харуулбал:



Сонгуулийн санал авах өдөр ойртох тусам төлбөртэй сурталчилгаа нэмэгдсээр сурталчилгааны сүүлийн шатанд 1-р үеэс даруй 2-3 дахин өсчээ.

ДАЛД СУРТАЛЧИЛГАА

Сонгуулийн үеэр УИХ, ЗГ, түүний харьяа агентлаг, төрийн захирагааны байгууллагын үйл ажиллагаа идэвхжиж, үүнийгээ сонгуулийн сурталчилгаанд ашиглах нь илүүтэй ажиглагддаг. Өөрөөр хэлбэл, нэр бүхий албан тушаалтнуудад өөрийгөө сурталчлах боломж нь бусад нэр дэвшигчидтэй харьцуулахад илүү байдал. Өргөн нэвтрүүлгийн хэрэгслүүд тэдний үйл ажиллагааг төвийг сахисан байдаар бус, магтан сайшаах, эсвэл эсэргүүцэн муулах зэргээр нөлөө оруулдаг. Мөн зарим телевиз сонгуульд оролцож буй улстөрийн нам, эвсэл, нэр дэвшигчийг янз бүрийн үйл явдал, асуудалд үндэслэлтэй ба үндэслэлгүйгээр зориудаар хамаатуулсан нэвтрүүлэг бэлтгэдэг. Түүнчлэн тухайн хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлчид улстөрийн нам, эвсэл, нэр дэвшигчдийн талаар дагнан сурталчилсан улстөрийн захиалгатай, төлбөртэй нэвтрүүлгийг сэтгүүл зүйн бүтээгдэхүүн хэлбэрээр бэлтгэх зэргээр сэтгүүл зүйн хэмжээг зөрчих явдал тохиолддог.

Монгол Улсад Зар сурталчилгааны хуулиар далд сурталчилгаа явуулахыг хориглодог. Мөн СЕХ, ХХЗХ-ны хамтарсан журмаар зохицуулсан боловч далд сурталчилгаа гэж юу болох, түүнийг таних шинж чанарыг хэт ерөнхий тодорхойлсон юм. Иймд мониторингийн баг 2004, 2008 оны УИХ-ын сонгуулийн үеэр олон улсын шинжээчдийн багтай хамтран боловсруулсан арга зүйг дахин ашигласан билээ. Энэ тухай “Мониторингийн арга зүй” бүлгээс тодруулна уу.

Хүснэгт 10. Сонгуулийн мэдээлэлд далд сурталчилгааны эзлэх хувийг 2008 оны сонгуультай харьцуулахад

	2008 он	2012 он
MYОНТ	7,5	31
MN25	38,5	37
TB9	20,8	22
UBS	32,1	10
TB5	17,6	19

MYОНТ сонгуулийн сурталчилгааны үеэр эфирийн цагийн 31 хувийг далд сурталчилгаанд зарцуулсныг 2008 оны сонгуулийн мониторингийн дүнтэй харьцуулахад 23,5 хувиар өссөн байна. Энэ нь MYОНТ-ийн хувьд байх ёсгүй үзэгдэл юм. Харин UBS 22,1 хувиар буурч, TB5, TB9, 25-р суваг телевизүүд нь 2008 оны дүнтэй ойролцоо байдлаар далд сурталчилгаа явуулсан байна.

MYОНТ далд сурталчилгааны нийт цагийн 80,5 хувийг МАН, АН-ыг зэрэгээр сурталчлахад зарцуулсан бөгөөд бусад 9 нам, 2 эвсэл, 26 бие даан нэр дэвшигчдэд нийтдээ 19,5 хувийг зарцуулсан байна.

Далд сурталчилгаагаар нэг намыг сурталчлахад хамгийн их цаг зарцуулсан телевиз бол TB5 бөгөөд нийт цагийн 66,6 хувийг МАН-д зориулжээ. Харин UBS


телевиз нийт цагийн 97,7 хувийг МАН, АН-д зориулсан байна.

Далд сурталчилгааны эерэг мэдээллийн дийлэнх хувь нь МАН-д оногджээ. Тус нам MYОНТ, TB5, UBS 25-р суваг телевиз дээр илт давуу хугацаа эзэлсэн байна. МАН-ын араас эерэг мэдээллийн хугацаа эзэлсэн байдлаараа АН удаалав. Харин ШЁЭ TB9 телевизийн далд сурталчилгааны эерэг мэдээлэл давамгайлжээ.

MYОНТ, TB9, TB5, 25-р суваг телевизүүд сөрөг өнгө аястай далд сурталчилгаа нэвтрүүлжээ. Харин UBS телевизийн далд сурталчилгаанд сөрөг өнгө аястай мэдээлэл илрээгүй болно. Далд сурталчилгааны сөрөг өнгө аястай мэдээлэл МАН, АН, ИЗНН, ШЁЭ, бие даагч гэсэн таван субъектэд хамааралтай байв.

Далд сурталчилгааны төвийг сахисан мэдээллийн хамгийн их хувийг МАН эзэлсэн бол АН, ИЗНН, ШЁЭ удаалсан байна. UBS телевиз МАН-ыг төвийг сахисан байдлаар хамгийн их сурталчилсан нь нийт далд сурталчилгааны төвийг сахисан мэдээллийн 90,14 хувийг эзэлж байна.

График 6. Далд сурталчилгааны байдлыг мониторингийн үе шатуудаар харуулбал:



Телевизүүдийн далд сурталчилгаа сонгуулийн өдөр ойртох тусам өссөн дүн нийтлэг ажиглагдсан.

Хүснэгт 11. Далд сурталчилгааг хэлбэрээр авч үзвэл (хувиар)

	A1	A2	B	B
MYOHT	9	70	21	-
MN25	2	34	58	6
TB9	-	43	56	1
UBS	-	28	71	1
TB5	-	51	38	11

Далд сурталчилгааны хэлбэрийн талаар мониторингийн аргачлал хэсгээс үзнэ үү.

Сонгуулийн мониторингийн дүнгээс харахад төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг зориуд сонгуультай холбож мэдээллэх, зориудаар сурвалжлах, бодит шаардлагагүй байхад нам, эвсэл, нэр дэвшигчдийг илэрхий, анхаарал татахуйцаар мэдээлсэн явдал далд сурталчилгааны дийлэнх хувийг эзэлсэн байна. Нэг нам эвслийг дагнан сурталчлах, зориуд нэг талын байр суурийг баримтлах зэрэг байдал харьцангуй бага гарчээ.

СЭТГҮҮЛ ЗҮЙН ХАРААТ БУС СЭТГҮҮЛ ЗҮЙН НЭВТРҮҮЛГИЙН ЦАГ

- Цаг үеийн мэдээний хөтөлбөр 2012 оны УИХ-ын сонгуулийн үеэр телевизүүд мэдээний хөтөлбөрөө мэргэжлийн түвшинд бэлтгэж байгаа эсэх болон СЕХ, ХХЗХ-ноос хамтран баталсан “Олон нийтийн радио телевизээс бусад телевиз радиогоор сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх журам”-ын “Сонгуулийн сурталчилгааг улс орны болон дэлхий дахинь амьдралын цаг үеийн шинжтэй үйл явдлын тухай тогтмол мэдээ, мэдээллийн нэвтрүүлэг, боловсролын болон хүүхдэд зориулсан нэвтрүүлгийн дундуур нэвтрүүлэхийг хориглоно./3.2/” гэсэн заалтад үндэслэн мэдээний хөтөлбөрт тоон болон чанарын шинжилгээ хийв.

Хүснэгт 12. Мэдээний хөтөлбөрт сонгуультай холбоотой мэдээллийн эзлэх хувь

Сонгуультай холбоотой мэдээлэл (мин/ Сонгуулийн мэдээлэлд эзлэх хувь	Эрэг	Төвийг сахисан	Серэг
MYOHT	583	28	82
MN25	434	13	92
TB9	1035	17	38
UBS	75	2	25
TB5	406	15	27
			62
			11

МУОНТ мэдээний хөтөлбөрөөрөө 583 минутын сонгуультай холбоотой мэдээлэл нэвтрүүлсний 82 хувь нь эерэг, 17 хувь нь сөрөг мэдээлэл байлаа. Харин ТВ9 телевиз 1035 минутын сонгуулийн мэдээлэл цацсан нь хамгийн өндөр байв. UBS телевизийн цаг үеийн мэдээний хөтөлбөрөөр хамгийн бага буюу 75 минутын сонгуулийн мэдээлэл явуулжээ. Үүний 75 хувь нь төвийг сахисан шинжийг агуулсан нь бусад телевизээс хамгийн өндөр үзүүлэлт юм.

Хүснэгт 13. Мэдээний хөтөлбөрт нам, эвсэл бие даагчдын эзлэх хувь

	MYOHT	MN25	TB9	UBS	TB5
МАН	41	42	25	89	30
АН	35	18	18	8	17
МНН	1	1	2	-	-
ИЗНН	4	29	1	2	33
ЭОНН	1	-	-	-	-
ИХН	2	-	-	-	-
ЭЧХН	2	-	-	-	3
ЭОН	1	-	3	1	-
ШЁЭ	4	7	48	-	13
ГХЭ	2	-	1	-	-
БД	7	3	2	-	4

МҮОНТ мэдээний хөтөлбөрийнхөө хамгийн их цагийг МАН-д, түүнээс 6 хувиар бага цагийг АН-д зориулжээ. Харин ТВ9 телевиз мэдээний хөтөлбөрийнхөө 48 хувийг ШЁЭ-д зориулсан нь бусад телевизээс онцлог байв. Арилжааны бусад гурван телевизийн мэдээний хөтөлбөрөөр МАН-ы мэдээлэл давамгайлж АН, ИЗНН, ШЁЭ удаалжээ. ХХН, МСДН, МУНН мэдээний хөтөлбөрт огт цаг эзлээгүй байна.

- Сонгогчдын боловсролд зориулсан нэвтрүүлэг

УИХ-ын Сонгуулийн тухай хуулиар ХМХ-д сонгогчдын боловсролд зориулсан материал нийтлэх, нэвтрүүлэх үүрэг ногдуулаагүй. Харин олон улсын жишгээр олон нийтийн радио телевизээс гадна арилжааны телевизүүд ч ийм үүрэгтэй байдаг. ХМХ-ийн амин чухал үүрэг нь сонгогчдын эрх ашигт үйлчлэх явдал билээ. Иймд мониторингийн баг өргөн нэвтрүүлгийн хэрэгслүүд сонгуулийн сурталчилгааны үед сонгогчдын боловсролд хэрхэн анхаарсан талаар дүн шинжилгээ хийсэн юм. Сонгогчдын боловсролд хамааруулан авч үзсэн тухай жагсаалтыг арга зүй хэсгээс үзнэ үү.

2012 оны УИХ-ын сонгуулиар арилжааны телевизүүд сонгогчдын боловсролд төдийлөн анхаарсангүй. МҮОНТ нь сонгогчдын боловсролд нийт сонгуулийн мэдээллийн 32,4 хувь буюу 701 минутыг зориулсан байна. Бусад арилжааны телевизийн сонгогчдын боловсролд зориулсан нэвтрүүлэг нийт сонгуулийн мэдээллийн 0,6 -4,5 хувийг эзэлжээ. Телевиз тус бүрээр авч үзвэл 25-р суваг телевиз 0,6 хувь, UBS 1,1 хувь, ТВ9 1,6 хувь, ТВ5 4,5 хувь байсан болно.

СОНГУУЛИЙН СУРТАЛЧИЛГАА ЗОГССОН БОЛОН САНАЛ ХУРААХ ӨДӨР

УИХ-ын Сонгуулийн тухай хуулийн “Сонгуулийн сурталчилгааг санал авах өдрөөс 24 цагийн өмнө буюу санал авах өдрийн өмнөх өдрийн 00:00 цагаас өмнө зогсоно. (35.3)” гэсэн заалтыг үндэслэн 6 дугаар сарын 27-ны өдөр таван телевизийн нийт 5257 минутын бичлэгт мониторинг хийв.

Энэ хугацаанд хуулийн дээрх заалтыг зөрчсөн үйлдэл телевизүүдэд илрээгүй. Харин ТВ9 телевизээр 16 минут, МҮОНТ-ээр 6 минут, 25-р суваг телевизээр 33 минутын сонгогчдын боловсролд зориулсан нэвтрүүлэг цацсан байна.

4.5 ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

ДҮГНЭЛТ

2012 оны УИХ-ын сонгуулийн сурталчилгаа хууль эрх зүйн шинэ орчинд явагдсанаараа онцлог болсон юм. “Глоб Интернэшнл” төрийн бус байгууллага энэ удаа үндэсний хэмжээнд өргөн нэвтрүүлэг эрхэлдэг телевизийн таван сувгийн нийт 112357 минутын эфирийн цагт ажиглалт хийв. Үүнээс 17476 минут буюу эфирийн цагийн 15,5 хувийг сонгуулийн мэдээлэлд зарцуулсанбайна. Мониторингт хамрагдсан телевизийн сувгууд УИХ-ын сонгуулийн тухай хуульд заасны дагуу улстөрийн нам, нэр дэвшигчдийн сонгуулийн сурталчилгаа явуулснаас гадна мэдээний хөтөлбөр, мэтгэлцээн зэрэг сонгуулийн сэтгүүл зүйн төрөл хэлбэрээр сонгогчдод сонгуультай холбоотой мэдээлэл түгээжээ.

Мониторингийн ерөнхий дүнгээс харахад, телевизүүд 2012 оны УИХ-ын сонгуулийн кампанит ажлын үеэр тэнцвэртэй, шударга ажиллаж чадаагүй нь харамсалтай. Далд сурталчилгаа хийсэн, мэдээний хөтөлбөр нь нам, эвсэл, нэр дэвшигчдийн сурталчилгаа болон хувирсан, хуульд заасан сурталчилгааны цагийн хязгаарыг хэтрүүлсэн зэрэг өмнөх сонгуулиудын сурталчилгааны явцад гарч байсан зөрчлүүд мөн давтагдсан байна.

Мониторингийн үр дүнд тулгуурлан дараах зүйлүүдийг онцолж байна.

Сурталчилгаа тэнцвэртэй байсангүй

Хэвлэл мэдээллийн хэрэгсэл нам, эвсэл, нэр дэвшигчдэд сурталчилгааны адил тэнцүү цаг хуваарилахын зэрэгцээ төвийг сахисан байр суурьтай мэдээлэл түгээхийг мэргэжлийн сэтгүүл зүйд тэнцвэртэй сурталчилгаа гэж ойлгодог. Хэт зерэг, сөрөг сурталчилгаа сонгогчдыг төөрөгдүүлж, шударга сонгууль хийхэд нөлөөлдөг гэж үздэг билээ. Мониторингт хамрагдсан таван телевизийн сонгуулийн мэдээлэл тэнцвэртэй байж чадсангүй. Тухайлбал:

Хуулийн дагуу нам, эвсэл, нэр дэвшигчдэд сурталчилгааны адил тэнцүү цаг хуваарилах ёстой ч биелэгдсэнгүй. Нам, эвслийн сурталчилгааг авч үзвэл, таван телевизийн сонгуулийн нийт мэдээллийн 39,8 хувийг МАН дангаараа эзэлж, АН 28,2 хувиар удаалжээ. Ерөнхийдөө телевизүүдээр МАН, АН, ШЁЭ-ийн сонгуулийн мэдээлэл бусад нам, эвслээс илүү давамгайлсан нь мониторингийн дүнгээс харагдаж байна. МАН, АН-ын сонгуулийн мэдээлэлд МУОНТ нийт цагийнхаа 41 хувь, ТВ5 телевиз 80 хувь, 25-р суваг 81 хувь, UBS телевиз 85 хувийг зориулсан бол ТВ9 телевиз ШЁЭ-д 38 хувийг зориулсан байна. Тойрогт нэр дэвшигчдийн сурталчилгааг авч үзвэл, 354 нэр дэвшигчийн 78,5 хувь нь дээрх телевизүүдээр сурталчилгаа явуулжээ. Хамгийн их сурталчилгаа явуулсан 37 нэр дэвшигчийн 43,24 хувь нь МАН, 18,92 хувь нь АН, 13,51 хувь нь ШЁЭ, 8,11 хувь ИЗНН-аас нэр дэвшигчид байсан бол 5,41 хувь нь бие даагчид байв. Харин ЭОН, ЭЧХН, БНН, МУНН-аас нэр дэвшигчид тус бүр 2,7 хувь оногджээ. Сонгуулийн сурталчилгааны нийт цагийн ердөө 5,4 хувь нь бие даан нэр дэвшигчдэд ногдажээ.

Сурталчилгааны өнгө аясын хувьд зэрэг буюу хэт магтаал давамгайлсан байна.

2012 оны УИХ-ын сонгуулиар мониторингт хамрагдсан таван телевиз төвийг сахисан байдлаар ажиллаж чадсангүй. Телевизүүдийн нийт сурталчилгааны 82 хувийг эерэг, 4,2 хувийг сөрөг мэдээлэл эзэлсэн нь энэ удаагийн сонгуулийн сурталчилгаанд магтаал давамгайлсныг харуулж байна. Нийт мэдээллийн 13.8 хувь нь төвийг сахисан өнгө аястай байсан бөгөөд үүний 31,8 хувийг МАН, 26 хувийг АН эзэлжээ. ТВ9-д төвийг сахисан мэдээллийнх нь 51 хувь дангаараа ШЁЭ-д оногджээ. 2008 оны сонгуулийн сурталчилгаатай харьцуулахад төвийг сахисан мэдээллийн хэмжээ 33.2 хувиар буурчээ.

Арилжааны телевизцүд хуулиар ногдуулсан сурталчилгааны хязгаарлалтыг хэтрүүлжээ

УИХ-ын Сонгуулийн тухай хуулиар сонгуулийн төлбөртэй сурталчилгааг хоногт хоёр цагаас хэтрүүлэхгүй байхаар хязгаарласныг арилжааны телевизүүд зөрчсөн байна. Тухайлбал, ТВ9 телевиз өдөрт дунджаар 2 цаг 37 минут 54 секундээр хэтрүүлсэн нь хамгийн өндөр байсан бол, ТВ5 телевиз өдөрт дунджаар 2 минут 38 секундээр хэтрүүлсэн нь хамгийн бага үзүүлэлт байв. Сонгуулийн сурталчилгааны цаг санал өгөх өдөр ойртох тусам өсч, мониторингийн сүүлийн шатанд эхнийхээс 2,4 дахин өссөн байлаа.

СЕХ, ХХЗХ-ноос хамтран баталсан “Олон нийтийн радио телевизээс бусад телевиз радиогоор сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх журам”-ын “Сонгуулийн сурталчилгааг улс орны болон дэлхий дахины амьдралын цаг үеийн шинжтэй үйл явдлын тухай тогтмол мэдээ, мэдээллийн нэвтрүүлэг, боловсролын болон хүүхдэд зориулсан нэвтрүүлгийн дундуур нэвтрүүлэхийг хориглоно (3.2)” гэсэн заалт хэрэгжсэнгүй. ТВ9 телевиз мэдээнийхээ хөтөлбөрөөр 1035 минутын сонгуулийн мэдээлэл цацсан нь хамгийн

өндөр, UBS телевиз хамгийн бага буюу 75 минутын сонгуулийн мэдээлэл явуулжээ.

Далд сурталчилгаа нэмэгдсэн байна

Сонгуулийн үеэр телевизийн мэдээний хөтөлбөрүүдэд далд сурталчилгаа зонхильтон байна. МУОНТ мэдээний хөтөлбөрийнхөө хамгийн их цагийг МАН-д, түүнээс 6 хувиар бага цагийг АН-д зориулжээ. Харин ТВ9-ийн мэдээний хөтөлбөрт 48 хувийг ШЁЭ эзэлжээ. Арилжааны бусад телевизэд ч мөн л эрх баригч нам, тухайлбал МАН-ын мэдээлэл давамгайлж АН, ИЗНН, ШЁЭ-ийн мэдээлэл удаалав.

Сонгогчдын боловсролд ач холбогдол өгсөнгүй

Арилжааны телевизүүдэд сонгогчдын боловсролд зориулсан нэвтрүүлэг нийт сонгуулийн мэдээллийн ердөө 0,6-4,5 хувийг эзэлжээ. МУОНТ-ийн сонгуулийн мэдээллийн 32,4 хувь нь сонгогчдын боловсролд зориулж, нам, эвслийн төлөөллийг оролцуулсан цуврал мэтгэлцээн, “Чиний сонголт, чиний ирээдүй” тусгай нэвтрүүлэг бэлтгэсэн байна.

МУОНТ сонгуулийн цээр шударга, тэнцвэртэй байж чадсангүй

“Олон нийтийн радио телевизийн тухай” хууль батлагдсанаас хойш МУОНТ хоёр дахь удаагаа УИХ-ын сонгуулийн сурталчилгаанд оролцлоо.

МУОНТ Сонгуулийн Ерөнхий хорооноос баталсан “2012 оны УИХ-ын сонгуулийн сурталчилгааг МУОНТ-ээр нэвтрүүлэх хуваарь”-ийн дагуу ажиллаж, нам, эвслүүдэд төлбөргүй сурталчилгаа хийх боломж олгосон юм.

Мөн сонгуулийн мэдээллийнхээ гуравны нэгийг сонгогчдын боловсролд зориулсан нь (11:41:14 цаг) өмнөх сонгуультай харьцуулахад 24.6 хувиар өссөн нь сайшаалтай. Гэсэн хэдий ч сурталчилгааны

тэнцвэрт байдлыг хангаж, мэргэжлийн түвшинд ажиллаж чадаагүй нь харамсалтай.

МУОНТ, Сонгуулийн Ерөнхий хорооны баталсан “2012 оны УИХ-ын сонгуулийн сурталчилгааг МУОНТ-ээр нэвтрүүлэх хуваарь”-ийг сайн баримталж ажиллаж байсан ч бусад цагт нийт 2161 минутын төлбөргүй сурталчилгаа явуулсан байв.

Сонгуулийн мэдээллийн 23 хувийг МАН, 18 хувийг АН, 7 хувийг МНН-д зарцуулсан байна. Харин нийт цагийн 6 хувь нь ИЗНН-д, ЭОНН, ХХН, ИХН, ЭЧХН, ЭОН-д адил 5 хувь, Шударга ёс эвсэл, Гурав дахь хүчин эвсэл, МСДН-д адил 4 хувь, хамгийн бага буюу 3 хувь нь МУНН-д ногдсон байна. Бие даагчдад 6 хувьтай тэнцэх цаг ногджээ.

Сурталчилгааны өнгө аясыг авч үзвэл, дийлэнх нь буюу 89 хувь нь эерэг, 2 хувь нь серөг өнгө аястай байлаа. Төвийг сахисан мэдээлэл нь 2008 оны сонгуулийн сурталчилгааны үеэр нийт мэдээллийн 67 хувийг эзэлж байсан бол энэ удаа 9 хувь болж буурсан байна.

МУОНТ-ээр 10:51:01 цагийн далд сурталчилгааны шинж агуулсан мэдээлэл нэвтрүүлсэн нь сонгуулийн нийт мэдээлэлд 31 хувийг эзэлж байна. Үүнээс 47 хувь нь МАН-д, 32 хувь нь АН-д ногджээ. Энэ нь 2008 онтой харьцуулахад 24.5 хувиар нэмэгджээ.

Үүнээсгадна мэдээний хөтөлбөр, сонгогчдын боловсролд зориулсан нэвтрүүлэгт сонгуулийн сурталчилгааны туршид 36 цаг зарцуулсан байна. Хуваарыт бус бусад цаг, мөн оргил цаг, мэдээний хөтөлбөрөөр цацсан сонгуулийн мэдээллийн 23 хувь нь МАН, 18 хувь нь АН-д ногджээ.

МУОНТ-ийн оргил цагийн “Цагийн хурд” мэдээний хөтөлбөр нь байнга хамгийн олон үзэгчтэйд тооцогддог. Энэ удаагийн мониторингоос харахад, МУОНТ-ийн мэдээний хөтөлбөрт 09:42:34 цагийн

сонгуультай холбоотой мэдээлэл илэрсэн байна. Энэ нь сонгуулийн нийт мэдээллийн 28 хувийг эзэлж байгаа юм.

Мэдээний хөтөлбөрт нам, эвсэл, бие даагчдын эзэлсэн хувь хэмжээг харьцуулан үзүүлвэл, МАН 41 хувь, АН 35 хувийг эзэлжээ. Бие даагчдын тухай мэдээлэл нийт цагийн 7 хувьтай тэнцэж байна. Мэдээний хөтөлбөрт мэдээллийн 82 хувь нь эерэг, 17 хувь нь төвийг сахисан, 1 хувь нь серөг өнгө аястай байлаа. Өөрөөр хэлбэл, мэдээний хөтөлбөр ерөнхийдөө нам, эвсэл, нэр дэвшигчдийн сурталчилгаа болон хувирсан байв. Сонгуулийн сурталчилгаа зогссон өмнөх өдөр буюу 2012 оны 6 дугаар сарын 26-ны өдрийн “Цагийн хурд”-ээр МАН-ын Ж.Сүхбаатарын сурталчилгааны роликийг нэвтрүүлсэн нь мэргэжлийн ноцтой зөрчил байв.

Эмэгтэй нэр дэвшигчдийн сурталчилгаа эрэгтэйчүүдийнхээс бага байв

2012 оны УИХ-ын сонгуульд нийт 544 (намын жагсаалтыг хамруулан) хүн нэр дэвшигчдээс 32 хувь буюу 174 нь эмэгтэйчүүд байв. Сонгуульд нэр дэвшигч эрэгтэйчүүдийн 61 хувь, эмэгтэйчүүдийн 28 хувь нь таван телевизээр сурталчилгаагаа нэвтрүүлснийг харахад эмэгтэйчүүдэд сурталчилгаа хийх боломж тааруу байсан гэж дүгнэж болохоор байна.

Сонгуулийн сурталчилгаа албан ёсоор зогссон санал авах өдрөөс 24 цагийн өмнө буюу 6 дугаар сарын 27-ны өдөр ямар нэгэн хууль зөрчсөн сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлээгүй болно.

УИХ-ын Сонгуулийн тухай шинэ хуульд хэвлэл мэдээллээр эвсэл, нэр дэвшигчийн сурталчилгаа явуулах зохицуулалтыг цаашид улам боловсронгуй болгох шаардлагатай байна.

Тухайлбал, Өмнөх хуульд байсан “тэнцвэртэй сурталчилгаа”-ны тухай

заалтыг адил тэнцүү цаг хуваарилах тухай заалтаар орлуулсан нь Сонгуулийн шинэ хуулийн дутагдал байв. Нам, эвсэл, нэр дэвшигчийн сурталчилгааны цагийн хязгаарыг тогтоосон нь сайн боловч энэ нь далд сурталчилгааг өөгшүүлэх боломж олгосноороо дутагдалтай болжээ. Далд сурталчилгааг СЕХ, ХХЗХ-ны хамтарсан журам, мөн Зар сурталчилгааны тухай хуулиар хориглосон боловч тодорхойлолт нь бүрхэг, хэлбэр нь тодорхой бус тул дагаж мөрдөхөд учир дутагдалтай байна.

Өргөн нэвтрүүлгийн хэрэгсэл буюу радио, телевиз нь ард түмний өмч болох долгион ашигладаг, мөн мониторингт хамрагдсан телевизүүдийн цацалтын зардлыг нийтийн төсвөөс даадаг зэрэг нь олон нийтийн эрх ашигт үйлчлэх үүрэг ногдуулах шаардлагатайн нотолгоо юм. Гэсэн хэдий ч сонгогчдын боловсролд зориулсан мэдээлэл түгээх үүргийг хуулиар хүлээлгээгүй нь арилжааны сувгуудад сонгуулийг гагцхүү орлого олох хэрэглүүр гэж харахад хүргэж байна.

Нэг тойрогт нэр дэвшигч бүрт сурталчилгааны адил тэнцүү цаг олгох тухай заалт нь тунхаглалын шинж чанартай учир хэрэгжихэд учир дутагдалтай байна. Тухайлбал, амьдрал дээр түрүүлж бүртгүүлсэн нэр дэвшигч нь сурталчилгаагаа түрүүлж эхлэх илүү боломжтой, төлбөртэй сурталчилгаа хийх боломж нэр дэвшигч бүрт өөр, нөгөөтэйгүүр хөдөөд нэр дэвшигчдэд үндэсний хэмжээний өргөн нэвтрүүлгийн хэрэгслээр суртачилгаа хийх зайлшгүй шаардлага байхгүй байна.

ЗӨВЛӨМЖ

Хууль тогтоогч, боловсруулагчдад:

УИХ-ын сонгуулийн үеэр хэвлэл мэдээллийн чөлөөтэй, шударга сурталчилгааг хөхиулэн дэмжих зорилгоор хэвлэл мэдээлэлтэй холбоотой зохицуулалтыг илүү боловсронгуй болгох

шаардлагатай байна. Үүний тулд хуульч, иргэний нийгэм, хэвлэл мэдээллийн төлөөллийг оролцуулан сонгуулийн хуулийн хэвлэл мэдээлэлтэй холбоотой заалтад харьцуулсан судалгаа хийх нь зүйтэй.

- Сонгуулийн хуулийн хэвлэл мэдээлэлтэй холбоотой зүйл заалтыг боловсронгуй болгох талаар:
 - УИХ-ын сонгуулийн тухай хуульд “тэнцвэртэй сурталчилгаа” явуулах тухай заалт оруулах. Сонгуулийн сурталчилгааны хугацааг нэр дэвшигчдэд адил тэнцүү боломж олгох зарчимд нийцүүлэх;
 - Олон нийтийн телевизийн нам, эвсэл, нэр дэвшигчдэд төлбөргүй сурталчилгааны цаг хуваарилах зарчмыг илүү боловсронгуй болгох;
 - Бие даагчдын сурталчилгааны тухай тусгай зохицуулалт бий болгох;
 - Далд сурталчилгааны нарийвчилсан тодорхойлолт, зохицуулалт бий болгох;
 - Нам, нэр дэвшигчдийн дунд халз мэтгэлцээн зохион явуулах зүйл заалт оруулах;
 - Арилжааны телевизүүдэд сонгуулийн кампанит ажлын үеэр олон нийтийн эрх ашигт илүү үйлчлэх зарчмыг баталгаажуулах, тухайлбал, сонгогчдын боловсролд зориулсан мэдээлэл түгээх үүрэг ногдуулах;
 - Радио, телевизийн сурталчилгаа тэнцвэртэй эсэхийг хянах механизмыг журмаар бус хуулиар зохицуулах, аливаа зөрчлийг олон нийтэд ил тод, нээлттэй мэдээлэх.
- Шинээр батлах хууль тогтоомж:

Сонгуулийн үеэр хэвлэлийн эрх чөлөө, сэтгүүлчийн эрх, хэвлэл мэдээллийн нийгмийн өмнө хүлээх үүрэг, нэр төр, алдар

хүнд, ХМХ-ийн үйл ажиллагаа, өмчлөл, төвлөрөл, зар сурталчилгаа гэх мэт олон асуудал хөндөгддөг. Иймээс Сонгуулийн тухай хуулийг боловсронгуй болгохын тул хэвлэл мэдээллийн эрх зүйн асуудлыг цогцоор нь авч үзэх шаардлагатай юм. Тухайлбал:

- Өргөн нэвтрүүлгийн буюу Радио телевизийн тухай хуулийг батлах нь өмчлөл, санхүүжилт, өргөн нэвтрүүлэг түгээх хэлбэр нь өөр өөр олон тооны радио, телевизийн ард түмний өмч болох долгионыг илүү үр ашигтай ашиглах боломжийг нэмэгдүүлэх, олон нийтэд үзүүлэх үйлчилгээг сайжруулах, нэвтрүүлгийн агуулгыг сайжруулах, зах зээлд шударга өрсөлдөх боломж олгох, тусгай зөвшөөрөл олгох үйл явцыг ил тод, шударга болгох зэрэг олон тооны ач холбогдолтой.
- Сонгуулийн үеэр янз бүрийн өмч, эзэнтэй ХМХ ухуулга сурталчилгаа, суртал нэвтрүүлгийн өөр өөр арга хэлбэрээр өөр өөр, заримдаа эсрэг тэсрэг үзэл бодлыг илэрхийлж байдаг. Ийм тохиолдолд сонгогчид төөрөгдөлд ордог. Иймд сонгогчдын эргэлзээг тайлах үүднээс ХМХ-ийн өмчлөл нийтэд ил тод байх нь зүйтэй. Иймээс холбогдох хуульд өмчлөл ил тод байх үүргийг баталгаажуулах, одоо үйлчилж буй ХХЗХ-ны журмыг эргэн нягталж хуульчлах нь чухал байна.
- Эрүүгийн хууль дахь гүтгэлэг, доромжлолтой холбоотой заалтыг хүчингүй болгох шаардлагатай. Ингэхгүйгээр сонгуулийн үеэр ХМХ, сэтгүүлчдэд тавих цензур арилах боломжгүй юм.

Хэвлэл мэдээллийн хэрэгсэл, сэтгүүлчдийн байгууллагад:

- Сонгуулийн үеэр хэвлэл мэдээллийн баримтлах зарчим, сэтгүүл зүйн хэм хэмжээг боловсруулан дагаж мөрдөх;
- Редакцийн хараат бус байдлыг баталгаажуулсан баримт бичиг боловсруулж гаргах, түүнийг дагаж мөрдөх, зөрчсөн тохиолдолд олон нийтэд ил тод болгон хэлэлцүүлж байх арга механизмыг бүрдүүлэх;
- Цаг үеийн мэдээний хөтөлбөрийг зөвхөн сонгогчдын эрх ашгийн төлөө бэлтгэн нэвтрүүлж, нам, эвсэл нэр дэвшигчдийн далд сурталчилгаа явуулдаг туршлагыг халах;
- Сонгууль сурвалжлах, сурталчиллах тухай сэтгүүлчдэд зориулсан сургалт явуулах;
- 2012 оны УИХ-ын сонгуулийн сурталчилгаанд хэвлэл мэдээллийн хэрэгслүүдийн оролцоо, гүйцэтгэсэн үүрэг, гарсан хүндрэл, бэрхшээлийн талаар өргөн хүрээтэй яриа, хэлэлцүүлэг зохион байгуулах.

СОНГУУЛИЙН САНАЛ АВАХ, САНАЛ ТООЛОХ УЙЛ АЖИЛЛАГААНЫ АЖИГЛАЛТЫН ТАЙЛАН



2012 оны УИХ-ын сонгуулийн уйл явц:
2012 оны 6 дугаар сарын 28.
Эх сурвалж www.gogo.mn сайт.



5.1 ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

ЗОРИЛГО

Ажиглалтын зорилго нь 2012 оны УИХ, НИТХ-ын сонгуулийн санал хураах, тоолох, дүн гаргах үйл явц нь хууль болон тогтоосон журмын дагуу явагдаж буй эсэхийг зохих аргачлалын дагуу хянаж, хяналт тавих, уг үйл ажиллагааны ил тод байдлыг ханган, улмаар болзошгүй зөрчлөөс сэргийлэхэд чиглэсэн болно.

ЗОРИЛТ

- Сонгуулийн санал авах, санал тоолох, дүн гаргах үйл ажиллагаанд хөндлөнгийн ажиглалт хийж хяналт тавих замаар уг үйл ажиллагаа хуульд заасан журам, нөхцөлийн дагуу явагдаж буй эсэх, нээлттэй, ил тод байх хуулийн шаардлагыг хангаж буй эсэхийг тогтоох, зөрчлийг баримтжуулах;
- Сонгуулийн үйл явцад хяналт тавих иргэний нийгмийн байгууллагуудын чадавхыг бэхжүүлэх, туршлага бий болгох;
- Ажиглалтын дүн дээр үндэслэн сонгуулийн хууль тогтоомжийг боловсронгуй болгоход нөлөөлөх явдал юм.

Дээрх зорилтод хүрэхэд чиглэсэн дараах үйл ажиллагааг төслийн хүрээнд зохион байгуулж гүйцэтгэв:

- Сүлжээний болон Азийн сонгуульд хяналт тавьдаг иргэний нийгмийн байгууллагуудын сүлжээний аргачлал, туршлагад үндэслэн ажиглалтын аргачлал боловсруулах;

- Ажиглагчдыг иргэний нийгмийн болон залуусын байгууллагуудаас тодорхой шалгууртайгаар сонгон авч, холбогдох хууль, журам болон ажиллах ёс зүйн хэм хэмжээг таниулах сургалт зохион байгуулах;
- Ажиглагчдыг СЕХ-ноос баталсан зохих журмын дагуу бүртгүүлэх ажлыг нэгдсэн удирдлагатайгаар зохион байгуулах;
- Сонгуулийн санал хураах, санал тоолох, дүн гаргах үйл ажиллагааг ажиглах, санал тоолох үйл явцтай холбоотой мэдээлэл цуглуулах;
- Санал тоолох үйл ажиллагааг ажиглаж ажигласан дүнгээ олон нийтэд хүргэж тайлгнах;
- Ажиглалтын үр дүн, санал зөвлөмж бүхий тайлан боловсруулан гаргаж холбогдох байгууллагуудад хүргүүлэх.

ТӨСЛИЙН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Төслийн удирдагчаар “Өөрчлөлтийн Төлөөх Залуу Эмэгтэйчүүд” ТББ-ын Ерөнхий зохицуулагч Б. Золзаяа, зохицуулагчаар “Эрхийнхээ төлөө гарцаа өргөцгөө” аяны оролцогч Ц. Мандхайхатан, “Өөрчлөлтийн Төлөөх Залуу Эмэгтэйчүүд” ТББ-ын гишүүн Ц. Амударъяа нар ажилласан.

Энэхүү ажиглалтын төсөлд:

- Өөрчлөлтийн Төлөөх Залуу Эмэгтэйчүүд ТББ
- Нээлттэй Нийгэм Форум
- Сонгогчдын Боловсрол Төв
- Хүний Эрх Хөгжил Төв
- Глоб Интернэшил ТББ
- Филантропи Хөгжлийн Төлөө Төв
- МИДАС ТББ
- Хүүхэд Хүүхдийн Төлөө ТББ
- Охид залуу эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах Гүнж Төв зэрэг есөн байгууллагаас томилсон болон сайн дурын нийт 180 ажиглагч, тэднийг удирдан зохион байгуулсан 20 хүний бүрэлдэхүүнтэй баг, нийт 200 хүн оролцон ажилласан болно.

СЕХ-ны 2012 оны 4 дүгээр сарын 6-ны өдрийн 25 тоот тогтоолын хавсралтаар батлагдсан Монгол Улсын Их Хурлын сонгуулийг ажиглах, сурвалжлах тухай журмын 5.9-д “Дотоодын байгууллага нь өөрийн томилсонажилтнууддаа сонгуулийн тухай хууль тогтоомжийн хүрээнд сонгуулийн явцыг ажиглах аргачлалын талаар сургалт зохион байгуулах үүрэгтэй” гэж заасны дагуу ажиглагчдыг 2 шаттай сургалтад хамрууллаа.

Эхний шатанд ажиглалтыг зохион байгуулж удирдах багт зориулан сонгуулийн хуулийн агуулга, хэрэгжилтийн явцад тулгардаг бэрхшээл болон автоматжуулсан сонгуулийн зарчим, үйл явц, эрсдэл, давуу болон сөрөт талууд, сонгуулийн өдрийн ажиглалтын шалгах хуудсыг хэрхэн боловсруулах, ажиглалтын тайлан боловсруулж бичих аргачлал, сонгуулийн ажиглагчийн эрх, үүрэг, хариуцлага, дагаж мөрдөх ёс зүйн зарчмын талаар ойлголт өгөх зорилготой 2 өдрийн сургалтыг зохион байгуулсан. Энэ сургалтыг “Шударга Сонгуулийн Төлөө Иргэний Нийгмийн Хяналт” сүлжээний туршлагатай ажиглагчид, Азийн Чөлөөт Шударга Сонгуулийн Бүсийн Сүлжээ мөн Филиппиний Чөлөөт Сонгуулийн Иргэдийн Үндэсний Хөдөлгөөний төлөөлөлтэй хамтран удирдан зохион байгуулав.

Ийнхүү суурь мэдлэг, мэдээлэлтэй болж, олон улсын туршлагаас суралцсаны дунд ажиглалтын үйл ажиллагааг зохион байгуулагчид хоёр дахь шатны сургалт буюу ажиглагчдад сонгуулийн эрх зүйн орчны талаар тодорхой ойлголт өгөх, аргачлал эзэмшүүлэх дөрвөн удаагийн сургалтыг зохион байгуулж нийт ажиглагчдыг хамруулж бэлтгэсэн.

Түүнчлэн сонгуулийг ажиглахдаа аль нэг нам, эвсэл, нэр дэвшигчийг төлөөлөхгүй, төвийг сахиж, сонгуулийн хууль тогтоомжийн хүрээнд ажиллах Иргэний нийгмийн ажиглагчийн ёс зүйн гэрээг ажиглагч тус бүртэй байгуулан хяналт тавьж ажилласан.

5.2 АЖИГЛАЛТЫН АРГАЧЛАЛ

Сонгуулийн үйл явцын ажиглалт нь сонгуулийн санал хураах өдрийн 06:00 цагаас санал авах хэсгийн хороод санал авахад бэлтгэснээс эхлэн санал авах, санал тоолох үйл ажиллагаа болон санал хураалтын дүнг хэсгийн хороод хуралдан батлах үеийг хамарсан болно. Иргэний нийгмийн ажиглагчид нь төслийн багаас урьдчилан боловсруулсан сонгуулийн санал авах, тоолох үйл ажиллагааны үнэлгээний хуудас, санал тоолох үед гарсан өргөдөл, гомдол, хүсэлтийг бүртгэх хүснэгтийг зааврын дагуу бөглөж, цугласан мэдээллээ фото зураг авах, видео бичлэг хийх, баримт бичгийг хуулбарлан авах, урьдчилан бэлтгэсэн ажиглалтын болон үнэлгээний маягт бөглөх аргаар баримтжуулав.

Төрлийн хувьд суурин ажиглалт хийсэн бөгөөд сонгуулийн баримт бичгийг тээвэрлэн дээд шатны сонгуулийн хороонд хүргэх ажлыг хамраагүй болно.

Ийнхүү сонгуулийн үйл явцыг бүхэлд нь ажиглаж, дүн шинжилгээ хийн, санал дүгнэлтийг боловсруулахад дараах аргуудыг ашиглав.

- Ажиглалт
- Санал асуулга
- Ярилцлага
- Кейс судлах
- Баримт бичигт дүн шинжилгээ хийх.

Ажиглалт

Ажиглалтын аргачлалыг Филиппиний Чөлөөт Сонгуулийн Төлөө Иргэдийн Үндэсний Хөдөлгөөн (NAMFREL/ НАМФРЕЛ), Азийн Чөлөөт Сонгуулийн Төлөө Бүсийн Сүлжээний (ANFREL/ АНФРЕЛ) болон Европын байгууллагуудын аргазүй, туршлагад үндэслэн боловсруулсан. Дотоодын холбогдох хууль тогтоомж, журмыг тушиглэн ажиглалт хийх шалгах хуудсыг дараах 4 бүлэг асуудлаар тус бүр нарийвчлан боловсруулсны дотор: “А – Санал авах ажиллагааны нээлт,” “Б – Санал авах ажиллагаа,” “В – Санал тоолох, санал хураалтын дүн гаргах” болон “Иргэний нийгмийн ажиглагчийн зөрчил, гомдлыг бүртгэх хуудас” тус тус багтсан. Эдгээр шалгах хуудас нэг талаас сонгуулийн санал хураалтын үйл явцыг ажиглах хөтөч, нөгөө талаас баримтжуулах арга хэрэгсэл болсон юм.

Асуулга

Ажиглалтад хамрагдсан хэсгийн хороод хяналт тавьсан улстөрийн нам, эвслийн ажиглагчид сонгуулийн санал авах ажиллагаа, санал тоолох төхөөрөмжийн бэлэн байдал, ашиглалт, санал тоолох ажиллагааны явцыг хэрхэн үнэлж буйг асуулгын аргаар судалсан. Ингэхдээ дараах шалгуурыг ашигласан болно:

- 1. Mash сайн:** Ямар нэгэн зөрчил гараагүй;
- 2. Сайн:** Сонгуулийн үйл явц, санал тооллогын үйл явцад сөрөг нөлөө үзүүлээгүй, тохиолдлын чанартай жижиг зөрчлүүд гарсан;
- 3. Дунд:** Сонгуулийн дунд ноцтой нөлөө үзүүлээгүй зөрчил гарсан;
- 4. Муу:** Сонгуулийн үйл явц, санал тооллогын дунд сөргөөр нөлөөлсөн зөрчил гарсан;
- 5. Mash муу:** Сонгуулийн үйл явц, санал тооллогын дунг зөвшөөрөх боломжгүй болгосон зөрчил гарсан.

Ярилцлага

Хэсгийн хороод дээр манай ажиглагчид 6-16 цагийн хооронд, 16 цагаас сонгуулийн дүн гаргах хүртэл хугацаанд ээлжлэн хяналт тавьсан бөгөөд сонгуулийн үйл явцын талаарх мэдээллийг шуурхай хүлээн авч, баримтжуулах зорилгоор 6-16 цагийн хооронд ажилласан нэгдүгээр ээлжийн ажиглагчидтай утсаар болон биечлэн ярилцаж дараах асуудлуудаар мэдээлэл авсан. Үүнд: “Санал хураах үйл явц цагтаа эхэлсэн үү. Зохих дарааллын дагуу явагдсан уу”, “Сонгогчийн нэрийн жагсаалттай холбоотой зөрчил гарч байна уу”, “Санал тоолох төхөөрөмжид саатал, гэмтэл гарч байна уу”, “Санал авах ажиллагааны явцад сонгогч болон ажиглагч нараас гомдол гарч байна уу”, “Ажиглалт хийхдээ ямар нэг хүндрэл бэрхшээл учирч байна уу. Тийм бол ямар”.

Мөн сонгуулийн өдрийн дараа тухайн хэсгийн хороонд ноцтой зөрчил гарсан болон тодруулах шаардлага гарсан ажиглагчидтай биечлэн уулзаж холбогдох мэдээллийг цаг алдалгүй баримтжуулсан болно.

Кейс судлах

Дотоодын байгууллагын ажиглагчид нь хэсгийн хороод дээр ажиглалт хийх үед тохиолдсон онцлог кейсүүдийг тэмдэглэл хөтлөх, зураг авах, бичлэг хийх зэргээр баримтжуулсан бөгөөд тэдгээр тохиолдлоос заримыг сонгон авч мониторингийн тайланд тусгалаа.

Баримт бичигт дун шинжилгээ хийх

Сонгуулийн хороодоос дотоодын байгууллагын ажиглалт болон санал авах, санал тоолох үйл явцтай холбогдуулан гаргасан шийдвэр эрх зүйн баримт бичгүүд, хэсгийн хороодын тогтоол, санал тоолох төхөөрөмжөөс хэвлэгдсэн “эхлэлийн лог” хуудас, дүнгийн тайлан болон улстөрийн нам, эвсэл, нэр дэвшигчдийн бөглөсөн сонгуулийн ерөнхий үнэлгээ зэрэг баримт бичгийг нэгтгэн судалсан.

5.3 ЭРХ ЗҮЙН ОРЧИН

2012 оны УИХ-ын сонгууль нь Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай, Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хуулиуд болон СЕХ-оос баталсан Сонгогч саналын хуудсанд саналаа тэмдэглэх, саналын хуудсаа санал тоолох төхөөрөмж (саналын хайрцаг)-д хийх, Сонгуулийн хороодын хуралдааны тэмдэглэл хөтлөх, Улсын Их Хурлын сонгуулийн саналын хуудсыг хэвлүүлэх, хадгалах, хүргүүлэх, хамгаалах журмууд болон Монгол Улсын Их Хурлын Сонгуулийг ажиглах, сурвалжлах тухай журам, Сонгогчдын санал авах, санал тоолох, дүн гаргах ажлыг сонгуулийн хороодод зохион байгуулах тухай заавар, Санал хуудасны тухай, Хяналтын тооллого явуулах тухай зэрэг хууль тогтоомжийн хүрээнд явагдсан.

ДОТООДЫН БАЙГУУЛЛАГЫН АЖИГЛАГЧ СОНГУУЛИЙН ҮЙЛ ЯВЦЫГ АЖИГЛАХ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглалын 21-р зүйлд “Ард түмний хүсэл зориг бол застгийн эрх мэдлийн үндэс байх ёстой. Энэ хүсэл зориг нь сонгуулийн бүх нийтийн тэгш эрхийн үндсэн дээр саналыг нууцаар хураах буюу саналаа чөлөөтэй гаргах явдлыг хангахуйц өөр адил чанартай хэлбэрийг ашиглах замаар явуулж байвал зохих тогтмол, хуурамч бус сонгуулиар

илрэлээ олно,” Монгол Улсын Үндсэн Хуулийн 3.1-т “Монгол Улсад застгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ” гэж заасан нь иргэд шударга, чөлөөт сонгуультай байх эрхийг хамгаалсан эрх зүйн суурь зарчим, үндэслэл юм.

2011 онд баталсан УИХ-ын Сонгуулийн тухай хуулийн 9.1-т:

- Хууль дээдлэх;
- Ил тод байдлыг хангах;
- Шударга ёсыг хангах;
- Маргааныг шуурхай, үндэслэлтэй, шударга шийдвэрлэх;
- Сонгогчдын эрх, сонгуулийн хууль тогтоомж зөрчсон байгууллага, албан тушаалтанд хуулийн хариуцлага зайлшгүй хүлээлгэх нь “Сонгуулийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд баримтлах зарчим” гэж тодорхойлсон.

Сонгуулийн үйл явцад иргэд хяналт тавих боломжтой байх нь сонгуулийн үр дүнд хууль бусаар нөлөөлөх гэсэн болзошгүй зөрчил будлианаас сэргийлж, сонгуульд итгэх олон нийтийн итгэлийг нэмэгдүүлэхэд онцгой чухал нөлөөтэй. Ийм ч учраас сонгуулийн үйл явцын ил тод байдал нь ардчилсан сонгуулийн гол зарчмын нэг юм.

“Санал хураалт болон санал тоолох үйл явц”-ыг хөндлөнгөөс ажиглах боломжийг дотоодын байгууллага буюу иргэний нийгмийн байгууллагуудад нээж өгсөн эрх зүйн зохицуулалт нь Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 9.5-р зүйл юм.

УИХ-ын сонгуулийн тухай
хуулиас...

9 дүгээр зүйл

9.5. Төрийн хэргийг удирдахад иргэдийг оролцуулах дүрмийн үүрэг, зорилт бүхий төрийн бус байгууллага нь Сонгуулийн Ерөнхий Хорооноос тогтоосон журмын дагуу сонгуулийн хороод, сонгуульд оролцогч бусад байгууллага, албан тушаалтан сонгуулийн хууль тогтоомжийг хэрхэн биелүүлж байгаад хяналт шинжилгээ (мониторинг) хийх, сонгогчийн боловсрол, мэдлэгийг дээшлүүлэх, түүнд эрхээхэрэгжүүлэхэд нь аргачилсан туслалцаа үзүүлэх зэргээр сонгуулийг хуулийн дагуу, шударгаар явуулахад туслалцаа үзүүлэх эрхтэй.

УИХ-ын сонгуулийн тухай
хуулиас...

44 дүгээр зүйл

44.8. Сонгуулийг ажиглахтай холбогдсон журмыг Сонгуулийн Ерөнхий Хороо батална.
44.9. Дотоод, гадаадын байгууллага болон хэвлэл мэдээллийн байгууллага сонгуулийн явцыг ажиглах, сурвалжлахтай холбогдсон харилцааг энэ хуулийн 44.8-д заасан журмаар зохицуулна.

Ийнхүү тус хуулийн 44.8-р зүйлийг үндэслэн Сонгуулийн Ерөнхий Хорооноос “Монгол Улсын Их Хурлын Сонгуулийг ажиглах, сурвалжлах тухай журмыг иргэний нийгмийн байгууллагуудаас авсан саналд үндэслэн баталсан.

Монгол Улсын Их Хурлын Сонгуулийг ажиглах, сурвалжлах тухай журмаас...

1 дүгээр зүйл

1.2.3 “Дотоодын байгууллага” гэж иргэний сонгох эрхийг дэмжиж, хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулах дүрмийн үүрэг, зорилт бүхий энэ журмын 5.3-д заасан шаардлагыг хангасан төрийн бус байгууллагыг;

1.7. Дотоодын байгууллагыг бүрэн эрх нь Сонгуулийн Ерөнхий Хороонд бүртгүүлснээр эхэлж сонгуулийн албан ёсны дүн гарсан өдрөөр, нам, эвсэл, бие даан нэр дэвшигчээс томилсон ажиглагчийн бүрэн эрх хэсгийн хороонд бүртгүүлж үнэмлэх авснаар эхэлж, тухайн хэсгийн хорооноос санал хураалтын дүнг гаргаж зарласнаар тус тус дуусгавар болно.

Сонгуулийн “ил тод байдлыг хангах” зарчимд тулгуурлан, “дотоодын байгууллага”-аас сонгуулийн үйл явцыг бүхэлд нь ажиглах эрх зүйн орчныг бий болгосон байна. Түүнчлэн, дээрх журмаар сонгуулийн үйл явцыг ажиглах “дотоодын байгууллага” болон ажиглагчид тавигдах шаардлагыг дараах байдлаар тодорхойлсон.

Монгол Улсын Их Хурлын Сонгуулийг ажиглах, сурвалжлах тухай журмаас...

Дотоодын байгууллага:

- Улстөрийн намын харьяаллын бус, улстөрийн намаас санхүүждэггүй
- Удирдах албан тушаалтан нь нэр дэвшээгүй байх, хэрэв нэр дэвшсэн бол үүрэгт ажлаасаа чөлөөлгэсэн байх
- Улстөрийн нам, нэр дэвшигчээс хараат бус, шударга, чөлөөтэй, хуульд захирагдах, төвийг сахиж ажиллах ёс зүйн дүрэмтэй байх
- Сонгуульд хараат бус, бие даасан хөндлөнгийн ажиглалт хийж байсан тодорхой туршлагатай, эсхүл ийм төрлийн туршлага бүхий байгууллагаас зохион байгуулсан сургалтад хамрагдсан байх.

Ажиглагч:

- Улстөрийн намын гишүүн бус байх
- Ажиглалт хийх тойротг өрсөлдөж буй нэр дэвшигчтэй болон тухайн тойргийн хорооны гишүүнтэй төрөл садан биш байх.

ДОТООДЫН БАЙГУУЛЛАГЫН АЖИГЛАГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

Ажиглалт хийх эрх зүйн зохицуулалтаас үзэхэд ажиглагчийн эрх, үүргийг “нам, эвсэл, бие даагч,” “дотоодын байгууллага,” “гадаадын байгууллага” болон “хэвлэл мэдээллийн байгууллага”-ын ажиглагч гэж үндсэн 4 хэсэгт хуваан, эрх үүргийг ялгаатай байдлаар тодорхойлсон.

Дотоодын байгууллагын ажилтан/ ажиглагчийн эрх:

- сонгуулийн хэсгүүдэд хуваарийн дагуу очиж, санал хураалтын явцыг ажиглах;

- сонгуулийн бэлтгэл ажлын болон сонгуулийн санал хураалтын явцтай танилцах;
- санал авах байрны зохион байгуулалттай танилцах;
- хэсгийн хороонд нээлттэй тавьсан сонгогчдын нэрийн жагсаалттай танилцах;
- сонгогчийн саналыг зөөврийн битүүмжилсэн хайрцгаар авах үйл явцын талаар мэдээлэл авах, санал авах ажиллагааг ажиглах;
- санал авах, санал тоолох, дүн гаргах, мэдээлэх, мэдээллийг дамжуулах зэрэг ажиллагаатай танилцах;
- санал авах ажиллагаа дууссаны дараа сонгуулийн явцыг ажигласан тухай тайлан, санал дүгнэлтээ Сонгуулийн Ерөнхий Хороонд хүргүүлэх, хэвлэн нийтлэх.

Харин “дотоодын байгууллага”-ын ажиглагчийн үүрэг нь улстөрийн нам, эвсэл, бие даан нэр дэвшигчээс томилсон ажиглагчийнхтай ижил буюу “Монгол Улсын Үндсэн хууль болон сонгуулийн тухайхууль тогтоомжийг хүндэтгэн сахих”, “сонгуулийн хороодын үйл ажиллагаанд хутгалдан оролцохгүй, зөвхөн хөндлөнгөөс ажиглах”, “саналаа нууцаар гаргаж буй сонгогчийн эрхийг хүндэтгэх, тэдэнд саад учруулахгүй байх”, “санал тоолох, дүн гаргах ажиллагаанд саад учруулахгүй байх”, “санал авах байрны дэг журмыг сахих, сонгуулийн хорооны гишүүд, сонгогчидтой зөв боловсон, хүндэтгэлтэй харьцах” юм.

СОНГУУЛИЙН САНАЛ АВАХ АЖИЛЛАГААНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

УИХ-ын сонгуулийн тухай
хуулиас...

43 дугаар зүйл

- 43.1. Санал авах өдрийн 07.00 цагт хэсгийн хорооны бүрэлдэхүүн сонгогчдын төлөөллийг байлцуулан санал тоолох төхөөрөмж, санал авах бүх хайрцгийг нээж харуулан, шалган битүүмжилж, лацаадсаны дараа хэсгийн хорооны дарга дараах мэдээлэл хийнэ:
- 43.1.1. сонгогчын нэрийн жагсаалтад бичигдсэн сонгогчдын тоо;
 - 43.1.2. хүлээн авсан, алдагдаж үргэгдсэн, устсан, үлдсэн саналын хуудасны тоо;
 - 43.1.3. саналын хуудасны индекс дугаар;
- 43.2. Энэ хуулийн 43.1-д заасан ажиллагаа, мэдээллийг нэг бүрчлэн тусгасан тэмдэглэл хөтөлж хэсгийн хорооны дарга, нарийн бичгийн дарга болон бүх гишүүн гарын үсэг зурна.
- 43.3. Сонгуулийн ажиглагч энэ хуулийн 43.2-т заасан тэмдэглэлтэй танилцсан тухайгаа гарын үсэг зурж тэмдэглүүлж болно.

Сонгогч саналаа хэрхэн өгөхийг мөн УИХ-ын сонгуулийн тухай хуулийн 45-р зүйлд заасан ба СЕХ-ны 2012 оны 5 дугаар сарын 22-ны өдрийн 68 дугаар тогтоолоор батлагдсан “Сонгогч саналын хуудсанд саналаа тэмдэглэх, саналын хуудсаа санал тоолох төхөөрөмж (саналын хайрцаг)-д хийх журнаар нарийвчлан зохицуулсан.

Сонгогч үндсэн 3 алхмын дагуу саналаа өгнө.

1-р алхам. Сонгогчдын нэрийн жагсаалтыг нягтлан шалгах ажиллагаа:

Хурууны хээ болон иргэний үнэмлэхийг тулган шалгасны үндсэн дээр бүртгэлийн хуудсыг өгнө. Сонгогчийн бүртгэлийн хуудас болон иргэний үнэмлэхийг тулган шалгаад саналын хуудсыг олгоно. Ийнхүү сонгогч саналын хуудас хүлээн авсан болохоо баталгаажуулж гарын үсэг зурна.

2-р алхам. Санал тэмдэглэх:

Сонгогч санал бэлтгэх бүхээг дэх зааварчилгаатай танилцана. Мөн саналын хуудас дахь товч заавартай танилцаж болох бөгөөд саналын хуудаст мандатын тоотой тэнцүү нэр дэвшигч болон зөвхөн нэг нам, эвслийн төлөө саналаа ДҮҮРГЭН БУДАЖ саналаа тэмдэглэнэ.

Мандатын тооноос илүү, эсвэл дутуу нэр дэвшигчийн төлөө өгсөн санал, нэгээс илүү нам, эвслийн төлөө өгсөн санал болон дүүргэн будахаас өөр тэмдэглэл хүчингүй байхаар зохицуулсан.

3-р алхам. Саналын хуудсыг санал тоолох төхөөрөмжид хийх:

Төхөөрөмжийн дэлгэцэнд “САНАЛЫН ХУУДАС ҮНШИХАД БЭЛЭН” гэсэн мэдээлэл гарч ирсний дараа аль ч талаар нь харуулан саналын хуудсыг хийнэ. Саналын хуудас хийсний дараа “САНАЛЫН ХУУДАС АМЖИЛТТАЙ ҮНШИГДЛАА” гэсэн мэдээлэл гарч ирснээр санал тоологдоно.

“Сонгогч саналын хуудсанд саналаа тэмдэглэх, саналын хуудсаа санал тоолох төхөөрөмж (саналын хайрцаг)-д хийх журнаас...

Сонгогчдод дараах зүйлийг хориглоно:

- Хууль, энэ журамд зааснаас өөр тэмдэглэл хийх,
- Тухайн санал авах байранд санал өгөх эрхгүй байж санал өгөх, эсхүл хуурч болон өөр хүний бичиг баримт ашиглах, санал өгөх, өгөхийг оролдох, хуурч мэхлэх,
- Санал авах байранд гаднаас өөр саналын хуудас авч орох, авч гарах,
- Саналын хуудсанд тэмдэглэсэн саналаа баталгаажуулан зураг авах, дүрс бичлэг хийх,
- Саналын хуудсанд тэмдэглэсэн саналаа бусдад харуулах,
- Аль нэг нам, эвсэл, нэр дэвшигчийн төлөө санал өгөх, эсхүл өгөхгүй байхаар амлалт авах, мөнгө, эд зүйл шаардах, авах,
- Саналын хуудсаа нугалах, гэмтээх.

СОНГУУЛИЙН САНАЛ ТООЛОХ, ДҮН ГАРГАХ АЖИЛЛАГААНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

Хуулийн 46 дугаар зүйл болон СЕХ-оос баталсан “Сонгогчдын санал авах, санал тоолох, дүн гаргах ажлыг сонгуулийн хороодод зохион байгуулах тухай заавар”-аар зохицуулсан.

УИХ-ын сонгуулийн тухай хуулиас...

46 дугаар зүйл

Хэсэгт санал тоолох ажиллагааг 20.00 цагт эхэлж, ажиглагч, хэвлэл мэдээллийн байгууллагын төлөөлөгчийг байлцуулан ил тод, нээлттэй явуулна.

Ийнхүү санал тоолох, дүн гаргах ажиллагаанд ажиглагчид, хэвлэл мэдээллийн байгууллагын төлөөлөгчдийг оролцуулж болох, харагдахаар зайд, байрлалд уг ажиллагааг явуулах эрх зүйн үндэслэлийг тодорхойлсон.

Нэг. Санал тоолох ажиллагааг явуулах

Хэсгийн хороо өмнөх өдөр ажил үүргийн хуваарь батлах бөгөөд санал тоолох, дүн гаргах үеийн бүхий л үйл ажиллагааг хэсгийн хорооны дарга тухай бүрт нь зарлан, хөтөлж явуулна. Ингэхдээ санал авах байранд байгаа бүх л хүмүүст сонсогдохоор чанга дуугаар зарлан явуулна. Сонгогчийн санал авах ажиллагааг нээх, хаах, санал тоолох, дүн гаргах ажлын явцын талаарх мэдээллийг хэсгийн хорооны санал тоолох, дүн гаргах үйл явцын хуралдааны тэмдэглэлд заавал тусгана.

Хоёр. Санал тоолох бэлтгэл

1. Саналын хуудсыг битүүмжлэх хэрэгсэл, тусгай уут, шаардлагатай үзэг, эсгий бал, цавуу, хайч, скоч зэрэг бичиг хэргийн зүйлс болон санал хураалтын дүнгийн тухай хэсгийн хорооны хуралдааны тэмдэглэлийн маягт, санал хураалтын дүнгийн тухай сонгуулийн хэсгийн хорооны тогтоолын маягтыг тус бүр 5 хувь бэлтгэнэ.

2. Хэсэгт хуваарилагдан ирсэн санал тэмдэглэх зориулалтын бүх үзгийг боож битүүмжлэн тэмдэглэлд тусгана.

3. Сонгогчдын нэрийн жагсаалтад бичигдсэн сонгогчдын тоо, зөөврийн битүүмжилсэн хайрцаар саналаа өгсөн сонгогчийн тоог сонгогчдын нэрийн жагсаалтыг үндэслэн тус бүрт нь гарган зарлаж тэмдэглэлд тусгана. Сонгогчдын нэрийн жагсаалтын хуудас бүрийн доод талд тухайн хуудсанд бичигдсэн сонгогчдын тоо, санал өгсөн сонгогчдын тоог бичиж, хэсгийн хорооны тэмдэг дарна. Сонгогчдын нэрийн жагсаалтын сүүлийн хуудаст санал өгсөн нийт сонгогчдын тоог бичиж, хэсгийн хорооны дарга, нарийн бичгийн дарга гарын үсэг зурж, тэмдэг дарна.

4. Санал өгсөн нийт сонгогчийн тоо санал авахад олгосон саналын хуудасны тоотой тохирч байгаа эсэхийг тулган шалгаж, эцсийн тооцоо гаргаж энэ тухай тэмдэглэлд тусгах. Санал авахад зарцуулагдалгүй үлдсэн болон буруу тэмдэглэл хийснээс хураагдсан саналын хуудсыг тус тусд нь тоолж, баруун дээд өнцгийг нь хайчлан, энэ тухай тэмдэглэлд тусган боож битүүмжилнэ. Битүүмжилсэн баглаа боодол дээр баримтын нэр, тоо ширхгийг тодорхой бичсэн байна.

5. Дээр дурдсан ажиллагааг гүйцэтгэсний дараа зөөврийн битүүмжилсэн саналын хайрцаар өгсөн саналын хуудсыг санал тоолох төхөөрөмж (саналын хайрцааг)-д хийж үншүүлна. Эдгээр бүх ажлыг хийж гүйцэтгэсний дараа хэсэгт явагдсан санал хураалтын дүнгийн тайланг хэвлэж гаргана. Санал тоолох ажиллагаанд байлцсан нам, эвсэл, бие даан нэр дэвшигчийн ажиглагч, төрийн бус байгууллагын ажилтнуудад тайланг хэвлэн өгч болно.

6. Нэгээс дээш тооны санал тоолох төхөөрөмжтэй хэсэгт төхөөрөмж тус бүрээс хэвлэгдэн гарсан санал хураалтын дүнгийн тайлангийн үзүүлэлтийг нэгтгэж хэсгийн хэмжээнд санал хураалтын дүнг гаргана. Хэсгийн хэмжээнд санал хураалтын дүнг нэгтгэн гаргасны дараа саналын хуудасны зарцуулалтын тайланг холбогдох маягтын дагуу гаргаж, мэдээллийг тэмдэглэлд тусгана.

Гурав. Санал тоолох ажлыг дуусгах, дүн гаргах

1. Хэсгийн хороо хуралдаанаараа санал тоолох төхөөрөмжөөс хэвлэн гаргасан санал хураалтын дүнгийн тайланг үншиж сонсгосны дараа санал тоолох төхөөрөмжөөс саналын хуудсуудыг гаргана.

-
2. Санал тоолох төхөөрөмжид үншигдсан бүх саналын хуудсыг хүчинтэй саналын хуудас гэж тооцож боож битүүмжилнэ.
 3. Дараа нь хэсгийн хорооны санал тоолсон дүнгийн тогтоол, тэмдэглэлийг үйлдэж, зарлана. Үүний дараа хэсгийн хороо санал хураалтын дүнгийн тухай тогтоолыг үйлдэн хуралдаанаараа хэлэлцэн баталж, үншиж сонсгох бөгөөд санал хураалтын дүнг дээд шатны хороондоо мэдээлнэ.
 4. Хэсгийн хороо санал тоолох төхөөрөмжийн санал тоолсон дүнг харилцаа холбооны тусгай суваг ашиглан төв серверт дамжуулна. Хэрэв үүрэн холбооны сүлжээгүй бол сүлжээ бүхий газарт санал тоолох төхөөрөмжийг зөввэрлэн аваачиж санал тооллогын дүнг дамжуулна.
 5. Хэсгийн хороо санал хураалтын дүнг гаргасан даруйдаа санал хураалтын дүнгийн тухай тогтоол, санал хураалтын дүнг хэлэлцсэн хуралдааны тэмдэглэл, санал хураалтын дүнгийн тайлан, саналын хуудасны зарцуулалтын тайлан, санал хураалтын ажиллагаатай холбоотой бусад баримт бичиг, тусгай уутанд хийж битүүмжилсэн саналын хуудас зэргийг салбар хороонд, салбар хороогүй бол нэн даруй тойргийн хороонд хүргэх ажлыг хийнэ.
-

Дөрөв. Санал тоолох үйл ажиллагааны үед хороиглох зүйл

- Хууль журамд зааснаас бусад тохиолдолд санал тоолох төхөөрөмжийн лацыг хөндөх;
 - Санал авах байранд хэсгийн хорооны гишүүд ажиглагчид, төрийн бус байгууллагын ажилтнууд, сурвалжлагч, хамгаалалтын ажилтнуудаас бусад этгээд байх;
 - Санал тоолох төхөөрөмжийн нууц үг, тусгай түлхүүрийг хариуцаж байгаа хүмүүс эдгээрийг бусдад дамжуулах, задруулах, зориулалтын бусаар ашиглах;
 - Санал тоолох цаг болоогүй байхад санал тоолох төхөөрөмжөөр саналыг тоолуулах;
 - Санал тоолох төхөөрөмжийг санаатай болон санамсаргүйгээр гацаах, гэмтээх;
 - Санал тоолох ажиллагааны үед санал тоолж буй байранд байгаа хүмүүс гар утас болон хөдөлгөөнт холбооны хэрэгсэл ашиглах;
 - Санал тоолох, дүн гаргах ажиллагаанд хэсгийн хорооны гишүүдээс бусад этгээд хутгалдан оролцох, дарамт шахалт үзүүлэх, хууль бус шаардлага тавих;
 - Санал хураалтын дүн гаргаж, мэдээлэхээс өмнө санал авах байранд байгаа хүмүүс зөвшөөрөлгүйгээр гарах, санал авах байранд гаднаас хүн оруулах.
-

5.4 АЖИГЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

ДОТООДЫН БАЙГУУЛЛАГЫН АЖИГЛАГЧААР БҮРТГҮҮЛЭХ ҮЙЛ ЯВЦ

Сонгуулийн санал авах, санал тоолох, санал хураалтын дүн гаргах ажиллагааг дотоодын байгууллага буюу “Шударга Сонгуулийн Төлөө Иргэний Нийгмийн Хяналт” сүлжээний гишүүн ТББ-уудаас Нийслэлд байрлалтай УИХ-ын нийт 6 тойргийн 100 хэсгийн хороонд 200 ажиглагчийг ажиллуулахаар төлөвлөсөн байсан ба зохих журмын дагуу бүртгүүлж дууссаны дараа Нийслэлд байрлалтай 6 тойргийн нийт 359 хэсгийн хорооны 31 хувь буюу 112 хэсгийн хороонд 180 ажиглагчийг ажиллуулахад хүрсэн.

СЕХ-ноос баталсан Монгол Улсын Их Хурлын сонгуулийг ажиглах, сурвалжлах тухай журамд зааснаар ажиглалт хийхэд “дотоодын байгууллагыг бүртгүүлэх,” “ажиглагчийг бүртгүүлэх” гэсэн үндсэн хэсгээс бүрдэхээр заасан байна.

Дотоодын байгууллагыг бүртгүүлэх

Дээрх журмын 2.1-т зааснаар санал хураах өдрөөс 30-аас доошгүй хоногийн өмнө СЕХ-нд “Бичгээр гаргасан хүсэлт, тойрог тус бүрт ажиллах ажилтны тоо, улсын бүртгэлийн гэрчилгээний нотариатаар гэрчлүүлсэн хуулбар, байгууллагын дүрмийн хуулбар, санхүүгийн эх үүсвэрийн талаарх мэдээлэл, байгууллагын удирдах ажилтны нэрс, албан тушаал болон байгууллагын үйл ажиллагааны тухай танилцуулга, ялангуяа сонгуулийн чиглэлээр ажилласан туршлагыг дэлгэрэнгүй дурдсан” баримт

бичгүүдийг хүргүүлж байгууллагыг бүртгүүлэхэд хүндрэл гараагүй болно.

Ажиглагчийг бүртгүүлэх

Хэдийгээр СЕХ-нд байгууллагуудыг бүртгүүлэх үйл явц бэрхшээл багатай байсан боловч тус журмын 5.4-т “Дотоодын байгууллага нь сонгуулийн нэг тойрогт 5 хүртэл тооны ажилтныг томилон.. тойргийн хороонд бүртгүүлнэ” гэж заасан нь иргэний нийгмийн зүгээс тодорхой аргачлалын дагуу түүвэрлэн авсан хэсгүүд дээр ажиглалт хийх боломжийг хаасан ба сонгуулийн хуулийн холбогдох заалтын зорилгыг зөрчсөн гэж дүгнэж байна.

Цаашид сонгуулийн үйл ажиллагаанд ажиглалт, хяналт хийх ТББ-уудын хүрээг нэмэгдүүлэхэд энэ заалт хязгаарлалт болж буйг анхааран сонгуулийн үйл ажиллагааг иргэд, ТББ-уудад илүү нээлттэй болгоход зохих шалгуур хангасан ТББ-ын ажиглагчийн тоо нэг хэсгийн хороон дээр 2-оос дээшгүйгээр хязгаарлах нь олон улсын сайн туршлагад илүүтэй нийцнэ.

Дотоодын байгууллагаар бүртгүүлсний дараа тус журмын 2.1-т заасны дагуу “Сонгуулийн хороод энэ журмын 3.2, 4.4, 5.5-д заасан баримт бичгийг хүлээн авч, ажиглагч, дотоодын байгууллагын ажилтныг бүртгэн үнэмлэх олгоно” гэж заасны дагуу бид 200 ажиглагчийг бүртгүүлэхээр “Тухайн байгууллагыг бүртгэсэн тухай СЕХ-ны шийдвэрийн хуулбар, биеийн байцаалтын хуулбар (иргэний үнэмлэх, албан газрын үнэмлэх), ажиглагчийн анкет”-ыг бүрдүүлэн тойргийн хороодод сонгууль болож өдрөөс 7-8 хоногийн өмнө хүргүүлсэн болно.

Хүргүүлсэн материалыг шалгасны үндсэн дээр нийслэлийн 6 тойргийн хорооноос 21, 25, 26 гэсэн гурван тойргийн хороо ажиглагчийг бүртгэж, үнэмлэх олгосон бол бусад гурван тойргийн хороо нь хэсгийн хороод руу шийдвэрлүүлэхээр шилжүүлсэн нь дээрх журмын 2.1-ийг зөрчсөн үйлдэл болсон ба ажиглагчийг бүртгүүлэх үйл ажиллагаанд хүндрэл учруулсан байна. Учир нь тойргийн хороодоос материалыг хугацаа тулгаж өгсний улмаас зарим хэсгийн хороо намын ажиглагч нартай адилтган авч үзэж З хоногийн өмнө материал өгсөнгүй гэсэн үндэслэлээр үнэмлэхийг олгохгүй гэж татгалзах, эсвэл албан бичиг шаардах, ажиглагчийн үнэмлэх дууссан гэх зэрэг шалтгаанаар ажиглагчдыг бүртгэхээс татгалзаж байв. Холбогдох журмын 5.7-д “Тойргийн хороо энэ журмын 5.7-д дурдсан шалгуураас бусад үндэслэлээр дотоодын байгууллагын ажилтныг бүртгэхээс татгалзахыг хориглоно” гэж заасан тухай хэсгийн хороодод хандан тайлбарлахад манай журам өөр гэж цөөнгүй хэсгийн хороод тайлбар тавьж байсан нь хэстийн хороод СЕХ-ноос баталсан энэ журмын талаар ойлголт муутайн дээр сонгуулийн хуульд заасны дагуу шатлан захирагдах зарчмаар ажиллаж дээд шатны хороодын шийдвэрийг дагах ёстой талаар ойлголт муутай байгаа нь харагдаж байлаа.

5.5 АЖИГЛАЛТЫН ДҮН

А – САНАЛ АВАХ АЖИЛЛАГААНЫ НЭЭЛТ

Ажиглалтад хамрагдсан хэсгийн хороодын санал авах байрны дотно болон гадна орчин хуульд заасан нөхцөл, шаардлагыг хангасан эсэх болон санал тоолох төхөөрөмжийн иж бүрдлийн бэлэн байдал, санал авах ажиллагааны нээлт хуульд заасан журмын дагуу явагдаж буй эсэхийг хянасан ажиглалтын дунд үндэслэн дараах дүгнэлтүүдийг хийж байна. Үүнд:

- **Орчин**

Хэсгийн хороодын дийлэнх нь санал авах байрны тохижилт, дотоод зохион байгуулалт, аюулгүй байдал болон санал авах байранд бэлтгэсэн байх шаардлагатай зүйлсийг зохих журам, зааврын дагуу сайтар анхаарч бэлтгэсэн байсан хэдий ч дийлэнх санал авах байранд нийтлэг ажиглагдсан дутагдал нь хөгжлийн бэрхшээлтэй иргэн саналаа хүндрэлгүй өгөх нөхцөл, боломжийг хангаагүй явдал байв. Нийт хэсгийн хороодын 73.3 хувьд хөгжлийн бэрхшээлтэй сонгогчийн саадгүй зорчих нөхцлийг хангасан налуу зам байгаагүй, 65.8 хувь нь тусгайлан санал бэлтгэх бүхээг байрлуулаагүй байсан төдийгүй зарим санал авах байр нь тухайн барилгынхаа 2, 3, 4 давхруудад байрлаж байсан нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд сонгох эрхээ эдлэхэд хүндрэл учруулсан байна.

Хэсгийн хороодын нэлээдгүй хувь нь санал авах ажиллагааны явцад сонгогчийн

саналын нууцлал алдагдаж болохуйц нөхцөл байдалд байсан байна. Эдгээр хэсгийн хороодын санал авах байрны зайд талбай хэт бага байсны улмаас санал бөглөх бүхээгийг ойрхон байрлуулсан нь сонгогчид хоорондоо ярилцах, бие биеийнхээ саналын хуудсыг харах, саналын хуудсанд тэмдэглэх үед нөлөөлж болохуйц байдалтай байжээ.

Мөн 18.8 хувь нь ажиглагчдын суух суудлыг сонгогч хурууны хээгээ таниулахаас эхлээд санал тоолох төхөөрөмжид саналаа уншуулах хүртэл үйл явцыг бүхэлд нь ажиглах боломжгүй, хэт хол зассан байна. Түүнчлэн зарим хэсгийн хороо улстөрийн нам, эвсэл, нэр дэвшигчдийн ажиглагчдад суух суудал бэлтгэсэн байсан хэдий ч тухайн хэсгийн хороонд бүртгүүлж ажиглагчийн үнэмлэхээ авсан дотоодын байгууллагын ажиглагчид суух ширээ, сандал бэлтгээгүй байснаас ажиглалтын хугацааны турш зогсоогоор ажиллав.

Нийт ажиглагчдын 21.6 хувь нь санал авах байрны ойрын 100 метрийн зайнд сонгуулийн сурталчилгааны хуудас болон самбар байсан тухай тэмдэглэсэн байна. Харин санал авах байрны дотор нам, эвсэл, нэр дэвшигчийн сурталчилгаа байсан тохиолдол гараагүй.

Санал авах ажиллагаа эхлэх үед санал авах байранд бэлтгэсэн байх шаардлагатай зүйлсийг бүрэн бэлтгэсэн хэсгийн хороо нийт хэсгийн хороодын 87.4 хувийг эзэлж байгаа бол үлдсэн хэсгийн хороодод хэвлэгч төхөөрөмж (кассын), утас, видео камер зэргийг бэлтгээгүй байсан байна. Видео камерыг бэлтгэсэн байсан хэдий ч тухайн камерыг санал авах ажиллагааг эхлүүлэх үеэс ажиллуулалгүй сонгуулийн өдрийн үдээс хойш асааж ажиллуулсан тохиолдол нэг хэсгийн хороонд бүртгэгдлээ.

- **Санал тоолох төхөөрөмжийн бэлэн байдал**

2012 оны УИХ-ын болон НИТХ-ын сонгуулиар сонгуулийн санал авах, санал

тоолох, дүн гаргах ажиллагааг анх удаа сонгуулийн автоматжуулсан системээр явуулсан. Автомат төхөөрөмжийн бэлэн байдал хэрхэн хангагдсан байсныг хянахад ажиглалтад хамрагдсан нийт хэсгийн хороо санал тоолох төхөөрөмжийн бэлэн байдлыг сайтар хангасан, санал тоолох төхөөрөмжийг урьдчилан бэлтгэж байрлуулсан, төхөөрөмжид санал авах ажиллагаанд хүндрэл учруулахуйц илэрхий алдаа дутагдал гаргаагүй байна. Харин Сонгино-Хайрхан дүүргийн 73-р хэсгийн хороон дээр сонгуулийн өдрийн өмнөх туршилтын үеэр нэг санал тоолох төхөөрөмжийн лац хөндөгдсөн байсан байна.

• Санал авах ажиллагааг эхлүүлэх

Ажиглалтад хамрагдсан хэсгийн хороодын 70 хувь нь санал авах ажиллагааг хуульд заасан хугацаа болох өглөөний 07:00 цагт эхлүүлсэн ба цагтаа нээгээгүй хэсгийн хороод нь өглөөний 07:00 цагаас өмнө эсвэл хоцорч нээсэн байна. Хэд хэдэн хэсгийн хороо санал авах ажиллагааг хоцорч нээсэн шалтгаан нь санал тоолох төхөөрөмжийг буруу угсарсан болон кодыг буруу хийсэн явдал байв. Түүнчлэн Баянгол дүүргийн 46, 15 дугаар хэсэг, Банзүрх дүүргийн 35 дугаар хэсэгт ажиглагчид өглөөний 06:10-06:40 цагийн хооронд очиход төхөөрөмжийг хэдийнээ угсарчихсан, санал авах байрыг нээсэн байсан ба хуульд заасан хугацаанаас өмнө санал авах ажиллагааг эхлүүлсэн байв.

Санал авах ажиллагааны нээлтийн үед хэсгийн хорооны дарга, нарийн бичгийн дарга, гишүүдийн ирц бүрэн байсан бөгөөд бүх хэсгийн хороо сонгогчийн төлөөллийг байлцуулсан байна.

Ажиглалт хийгдсэн нэгээс бусад бүх хэсгийн хороод санал тоолох төхөөрөмж тус бүрээс “Эхлэлийн лог” хуудсыг хэвлүүлсэн байна. “Эхлэлийн лог” хуудас хэвлээгүй Сонгино-Хайрхан дүүргийн хэсгийн хорооноос шалтгааныг

тодруулахад “өмнөх өдөр нь туршилтын саналыг төхөөрөмжинд уншуулсан бөгөөд “эхлэлийн лог” хэвлүүлсэн тул дахин хэвлэх шаардлагагүй” гэсэн тайлбар өгчээ. Хэсгийн хороодын санал тоолох төхөөрөмжөөс хэвлэгдсэн “эхлэлийн лог” хуудсанд ямар нэг алдаа байгаагүй буюу хуудасны хэвлэлт уншигдахуйц тод, төхөөрөмжөөс хэвлэгдсэн хуудас бүр ижил байв.

“Эхлэлийн лог” хуудсыг улстөрийн нам, эвсэл, нэр дэвшигчийн томилсон ажиглагчдад хэвлэж өгсөн боловч дотоодын байгууллагын ажиглагчдад хэвлэж өгөөгүй тохиолдол олон гарсан. Түүнчлэн дийлэнх хэсгийн хороод дунгийн тайлан хэвлэх цаас хүрэлцэхгүй, нэг хэвлэсэн хуудсыг дамжуулж үз хэмээн улстөрийн томоохон намуудаас томилсон ажиглагч нарт л хэвлэж өгсөн байв. Хуудсыг хувилж (канондож) авах хүсэлт гаргасан ажиглагчдад тодорхой үндэслэл дурдалгүй татгалзсан хариу өгчээ. Баянзүрх дүүргийн нэг хэсгийн хороонд “эхлэлийн лог” хуудсыг ажиглагчдад өгөхгүй, албан бичгээр хүсэлт гаргах хэрэгтэй” хэмээн аль ч ажиглагчид өгөөгүй байна.

Хэсгийн хороодын 30 хувьд нь тухайн хэсгийн хороонд ирсэн саналын хуудасны индекс дугаарыг нийтэд зарласан байна. Ажиглагчдын тэмдэглэлээс үзвэл дийлэнх хэсгийн хорооны гишүүд болон улстөрийн нам, эвсэл, нэр дэвшигчдийн томилсон ажиглагчдад саналын хуудасны индекс дугаарын тухай ойлголт дутмаг бөгөөд саналын хуудасны индекс дугаарыг тухайн тойргийн саналын хуудасны индекстэй тохирч байгаа эсэхийг нягтлах боломжоор хангаагүй байна.

Санал авах ажиллагааны нээлтийн тэмдэглэлтэй холбоотой асуултад хариулсан тоон үзүүлэлт болон ажиглагчдын тэмдэглэлээс үзвэл хэсгийн хороод санал авах ажиллагааны нээлтийн үед холбогдох мэдээллийг ажиглагчид

болон иргэдийн төлөөлөлд зарласан боловч тухайн мэдээллийг нэг бурчлэн тусгасан тэмдэглэл хөтлөх, түүнд хэсгийн хорооны дарга, нарийн бичгийн дарга болон бүх гишүүд гарын үсэг зурах ажиллагаагааг ажиглагчдын өмнө хийгээгүй төдийгүй тэмдэглэлд ажиглагчдаар гарын үсэг зуруулсан байдал 36.6 хувьтай байна. Энэ нь тэмдэглэлд буй мэдээлэл нь нийтэд зарласан мэдээлэлтэй тохирч байгаа эсэхийг нягтлах боломжийг хязгаарласан байна.

Б - САНАЛ АВАХ АЖИЛЛАГАА

· Санал авах ажиллагаа

Ажиглалт хийгдсэн хэсгийн хороодын санал авах ажиллагаа ерөнхийдөө хуульд заасан журмын дагуу хэвийн явагдсан байна. Саналаа өгөхөөр ирсэн сонгогчдын хурууны хээ, бичиг баримтыг зохих журмын дагуу нягталж саналын хуудсыг олгож байсан байна. Гэвч Хан-Уул дүүргийн нэг хэсгийн хороонд тухайн хэсгийн хорооны гишүүн иргэний үнэмлэхгүй, хаягаасаа өөр хэсгийн хороонд ажиллаж байгаа тул санал өгөх шилжүүлэг хийсэн тодорхойлолт бүхий цаасыг үндэслэн өөрийн ажиллаж буй хэсгийн хороондоо санал өгсөн болон Сонгино-Хайрхан дүүргийн хоёр хэсгийн хороонд санал өгөхөөр ирсэн сонгогчийг сонгогчийн цахим мэдээлэлтэй хурууны хээ, регистрийн дугаарын алинаар нь ч шүүж тулгалгүй саналын хуудас олгосон тохиолдууд бүртгэгдсэн байна.

Санал авах ажиллагааны үед авах байранд аль нэгэн нам эвсэл, нэр дэвшигчийн сурталчилгаа хийгдсэн эсэх гэсэн асуултад нийт ажиглагчдын 18.8 хувь нь “тийм” гэсэн хариултыг өгсөн байна. Тухайн ажиглагчдын тэмдэглэлд саналаа өгөхөөр ирсэн сонгогч аль нэг нам, эвсэл, нэр дэвшигчийг дэмжсэн тэмдэг зүүсэн байх, тийм агуулга бүхий бичиг барьж орж ирэх, санал бөглөх бүхээгийн ард сонгуулийн

сурталчилгааны хуудас үлдээх, саналаа өгөөд гараадаа бусад сонгогчдод хандан аль нэг нам, эвсэлд саналаа өгөхийг уриалсан үг хэлэх болон хэсгийн хорооны гишүүн, хамтаалалтын цагдаа сонгогчийг аль нэг нам, эвсэлд саналаа өгөхийг ятгасан тухай бүртгэгджээ.

Ажиглалт хийгдсэн хэсгийн хороодын 14.1 хувьд нь сонгогч саналаа санал бөглөх бүхээгт нууцаар гаргаагүй тохиолдол бүртгэгдсэн. Ажиглагчдын тэмдэглэлд сонгогчид саналын хуудсыг хэрхэн бөглөх талаар мэдээлэл муутай байсны улмаас бүхээгт очоод бусад бүхээг рүү шагайх, саналын хуудсаа бусдад харуулах, бусдад зааж өгөх, хэсгийн хорооны гишүүд болон ажиглагчдаас туслалцаа хүсэх зэргээр саналаа нууцаар гаргаагүй нөхцөл байдал зонхицж байна. Мөн гэр бүлээрээ ирсэн сонгогчид санал бэлтгэх бүхээгийн ард ярилцах, хамтдаа сууж саналын хуудсаа бөглөх тохиолдол гарсан байна. Түүнчлэн нэг хэсгийн хороонд саналын хуудас авсан сонгогчдод бүхээг хүрэлцэхгүй байсан тул зарим сонгогч цонхны тавцан дээр эсвэл хана налж саналын хуудсаа бөглөх, зайд талбай хангалтгүйн улмаас хөгжлийн бэрхшээлтэй сонгогч бүхээгт очих боломжгүй болж санал авах байрны үүдний хэсэгт саналын хуудсыг бөглөхөд хурсэн тохиолдол тус тус бүртгэгдсэн нь сонгогч саналаа санал бөглөх бүхээгт нууцаар гаргах хуулийн заалтыг зөрчсөн явдал болсон байна.

Хуульд заасны дагуу саналаа биечлэн өгөх боломжгүй иргэн итгэмжлэгдсэн хүний туслалцаа авах явдал нийт хэсгийн хороодын 77 хувьд нь ажиглагдсан. Итгэмжлэгдсэн хүнээр ихэвчлэн гэр булийн хүмүүс нь байсан боловч ганцаараа ирсэн өндөр настан, бичиг үсэг тайлгадаагүй, харааны бэрхшээлтэй хүмүүс саналаа өгөхөд бэрхшээл учирсан тул хэсгийн хорооны гишүүн, мэдээллийн технологийн даамал зэрэг итгэмжлэгдсэн биш этгээд

туслалцаа үзүүлсэн тохиолдлууд гарсан байна. Үүнээс гадна нэг хэсгийн хороонд ганцаараа ирсэн өндөр настанд ажиглагчдын өмнө саналын хуудсан дахь нэрийг уншиж сонсгон саналыг нь өгүүлсэн нь хууль зөрчсөн үйлдэл байлаа.

Ажиглагчдын 57.3 хувь нь сонгогч саналын хуудсыг санал тоолох төхөөрөмжид уншуулахад хүндрэл гарсан гэж хариулсан ба нийтлэг хүндрэл нь сонгогч саналын хуудсыг санал тоолох төхөөрөмжид хэрхэн уншуулах талаар хангалттай мэдээлэлгүйн улмаас буруу хийж байсан бөгөөд зарим тохиолдолд үүнээс шалтгаалан санал тоолох төхөөрөмж гацсан байна. Мөн санал тоолох төхөөрөмж саналын хуудсыг уншихгүй байх болон уншихгүй байсан саналын хуудсыг нөгөө талаар нь эсвэл өөр санал тоолох төхөөрөмжид хийхэд унших тохиолдлууд гарч байсан байна. Сонгогч саналын хуудасны бар кодыг гэмтээсэн, саналын хуудсыг нугалсан, илүү дутуу бөглөсөн зэргээс шалтгаалан саналын хуудсыг уншихгүй байх тохиолдол мөн бүртгэгдсэн байна.

Ажиглалт хийсэн хэсгийн хороодын 51.7 хувьд нь сонгогч саналын хуудсыг санал тоолох төхөөрөмжид уншуулах үед саналын нууцлал алдагдаж болзошгүй нөхцөл үүссэн гэж хариулжээ. Ингэж хариулсан нийтлэг шалтгаан нь сонгогч саналын хуудсыг санал тоолох төхөөрөмжид хийх үед сонгогчид бэрхшээл учирсан тохиолдолд мэдээллийн технологийн даамал болон хэсгийн хорооны гишүүд туслалцаа үзүүлэх, эсвэл шаардлага гараагүй байхад саналын хуудсыг харж болохуйц зайнд ойртоноор саналын хуудасны тэмдэглэгээг бүрэн харж байсан байна. Зарим тохиолдолд саналын хуудас уншуулах гэж ирсэн сонгогчийг НИТХ-ын хэсгийг бөглөөгүй байна гэж дахин бөглөхийг мэдээллийн технологийн даамал зааварлаж байсан нь сонгогчийн саналын нууцлал алдагдаж байсны илрэл байв.

Түүнээс гадна Улаанбаатар хотын сонгогчдын санал өгөх саналын хуудас нь хоёр талдаа тэмдэглэгээтэй байсан тул санал бөглөх бүхээгээс санал тоолох төхөөрөмж очих хүртэл замд бусад сонгогч, ажиглагчид, хэсгийн хорооны гишүүд саналын хуудасны тэмдэглэгээг харж болохуйц байгаа тухай ажиглагчид дурдсан байна.

• Санал авах ажиллагааны зорчил

Нийт хэсгийн хороодын 62.3 хувьд нэрийн жагсаалтад бүртгэгдээгүй сонгогч гарч байсан байна. Тэдгээр тохиолдлуудад нэг гэр бүлийн гишүүдийн нэг нь бүртгэгдсэн ч нөгөө нь бүртгэгдээгүй байх, тухайн хаяган дээрээ цахим үнэмлэх авсан боловч бүртгэгдээгүй байх, хурууны хээ нь танигдсан боловч цаасаар хэвлэгдсэн сонгогчийн нэрийн жагсаалтад нэр нь байхгүй байх, мөн burtgel.mn хаягаар нэрээ шалгахад нэр нь орсон байсан боловч хэсгийн хороон дахь нэrsийн жагсаалтад бүртгэгдээгүй зэрэг нөхцөл байдал үүссэний улмаас сонгогчид саналаа өгч чадаагүй байна.

Мөн Сонгино-Хайрхандүүргийн нэгхэсгийн хороонд шинээр ашиглалтад орсон байранд амьдардаг бүх иргэд нэрийн жагсаалтад бүртгэгдээгүй байжээ. Тус байрны иргэд гомдол гаргахад хэсгийн хорооны дарга “өмнө нь цахим хэлбэрээр эсвэл биеэр ирж бүртгэлээ нягталсангүй” гэж иргэдийг загнасан бөгөөд үүссэн нөхцөл байдлыг иргэний бүртгэлийн ажилтнуудын алдаа хэмээн тайлбарласнаар тухайн байрны иргэд саналаа өгч чадаагүй байна.

Хэсгийн хороодын 46.2 хувьд нь сонгогч иргэний бүртгэлээс олгосон лавлагаа, жолооны үнэмлэх, гадаад паспортоор санал өгөх гэсэн, эсвэл бичиг баримтын мэдээлэл нь зөрүүтэй байх, орон нутгаас нийслэлд нүүж ирсэн боловч хаягийн шилжилт хийлгээгүй байх тохиолдлууд бүртгэгджээ.

Санал авах ажиллагааны уед сонгогч хэсгийн хорооны гишүүдэд гомдол гаргасан тохиолдол нийт хэсгийн хороодын 38.2 хувьд нь ажиглагдсан байна. Иргэд хамгийн ихээр гомдол гаргаж байсан үндэслэл нь тухайн хаяган дээрээ оршин суудаг байхад сонгогчийн нэрийн жагсаалтад бүртгэгдээгүй байсантай холбоотой байна. Мөн өөрийнх нь хаяг дээр амьдардаггүй хүн бүртгэлтэй байгааг хасуулах гэсэн гомдол, хүсэлт гаргасан, түүнчлэн саналаа өгөх гэж ирсэн сонгогчдын урт дараалал үүсч байсан байна. Түүнчлэн санал авах байр хэт хол байсан мөн өмнөх сонгуулиудад санал өгч байсан санал авах байр нь өөрчлөгдсөн тул хэсгийн хороогоо андуурч ирэх тохиолдол их байгаад бухимдсан сонгогчид байсан байна.

Саналаа биечлэн өгөх боломжгүй иргэн итгэмжлэгдсэн хүний туслалцаа авахаас бусад тохиолдолд саналын хуудсыг сонгогчийн өмнөөс бөглөсөн тохиолдол нийт хэсгийн хороодын 41.8 хувьд ажиглагдсан бөгөөд сонгогч саналын хуудсанд хэрхэн тэмдэглэл хийх мэдээллэлгүй, эсвэл хөгжлийн бэрхшээлтэй, нүдний хараа муу, гар нь чичирдэг гэх мэт шалтгаанаар хэсгийн хорооны дарга, нарийн бичгийн дарга, гишүүд, мэдээллийн технологийн даамал болон бусад сонгогчоор саналын хуудсаа бөглүүлсэн байв.

Нийт хэсгийн хороодын 46.2 хувьд нь сонгогч ямар нэг байдлаар зөрчил гаргасан тохиолдол бүртгэгдсэн. Сонгогчдын түгээмэл гаргасан зөрчил нь саналын хуудсанд тэмдэглэсэн саналаа баталгаажуулан зураг авах, саналын хуудсанд хийсэн тэмдэглэгээгээ бусад харуулах, санал бөглөх бүхээгний ард утсаар ярих, бусад сонгогчийн санал бэлтгэх бүхээг рүү шагайх, ярилцах зэрэг зөрчил байв. Түүнчлэн санал авах байранд сонгуулийн сурталчилгаа хийх, согтууруулах ундаа хэрэглэсэн уедээ танхайрсан зөрчил гаргажээ. Эдгээрээс

гадна гадаад улсад байхдаа саналаа өгсөн хүн дахин санал өгөхийг орлдох, саналаа өгсөн сонгогч дахин санал өгөхөөр орж ирэх, хүүхдийнхээ бичиг баримтаар санал өгөхийг орлдох, нэг сонгогч хоёр саналын хуудас авч түүнийгээ хамтад нь төхөөрөмжид уншуулахаар орлдох, нэг сонгогч гурван хүний саналын хуудсыг төхөөрөмжид уншуулахыг завдах тохиолдол тус тус нэг бүртгэгдсэн байна.

Нам, эвсэл, нэр дэвшигчийн ажиглагчдаас хэсгийн хороонд санал, гомдол гаргасан тохиолдол хэсгийн хороодын 47.1 хувьд нь гарсан. Тэдгээрийн санал, гомдол гаргасан үндэслэлийг дурдвал хэсгийн хорооны зохион байгуулалт муу, ажиглагчдын суудал ажиглалт хийх боломжгүй байрлалд байх, хэсгийн хорооны дарга намуудын ажиглагч нарт ялгавартай хандах, санал тоолох төхөөрөмж гацах, саналын хуудсыг зажлах, мэдээллийн технологийн даамал сонгогчийн саналын хуудсыг харах, хүрэх, нэрийн жагсаалт дахь сонгогчийн тоо СЕХ-ны вэбсайт дахь тооноос зөрүүтэй байх, санал авах байранд нам, эвсэл, нэр дэвшигчийн ухуулагч байна гэсэн гомдлууд байсан бөгөөд зохих арга хэмжээ авахыг хүссэн байна.

• Санал тоолох төхөөрөмжийн saatал, гэмтэл

Ажиглалтад хамрагдсан хэсгийн хороодын 19.5 хувьд нь санал авах ажиллагааны уед санал тоолох төхөөрөмж, түүний иж бурдэлд ямар нэгэн байдлаар saatал, гэмтэл учирсан. Ихэнх тохиолдолд сонгогчдын санал тоолох төхөөрөмжид саналын хуудсыг хэрхэн уншуулах тухай ойлголт дутмаг байсан бөгөөд саналын хуудсыг хөндлөнгөөр нь хийх, нэг саналын хуудсыг уншиж дуусаагүй байхад дараагийн хуудсыг уншуулахыг орлдох зэргээр саналын хуудсaa төхөөрөмжид буруу хийж төхөөрөмжийт гацааж байсан тухай ажиглагчид мэдээлсэн байна. Түүнчлэн төхөөрөмжийн саналын хуудас татдаг

хэсэг буюу толгой бохирдож төхөөрөмж ажиллагаагүй болох, иргэний бүртгэлийн сүлжээ тасалдаж гарын хурууны хээ таних төхөөрөмж ажиллагаагүй болох тохиолдол ажиглагдсан. Налайх дүүргийн нэг хэсгийн хороонд тойргийн мэдээллийн технологийн газраас ажилтан ирж төхөөрөмжийн санал татдаг хэсэг бохирдооос сэргийлж цэвэрлэсний дараа тухайн төхөөрөмж гацсан тохиолдол бүртгэгджээ.

Нийт хэсгийн хороодын 8 хувьд нь санал авах байрны тог тохиолдлын чанартай 2-50 минутын хугацаагаар тасарсан ба энэ үед зөөврийн компьютер, санал тоолох төхөөрөмж зэрэг нь өөрийн нөөц баттерейгаар ажиллаж байсан тул санал авах ажиллагаа тасалдалгүй хэвийн явагджээ.

Ажиглалтад хамрагдсан 112 хэсгийн хорооноос хоёр хэсгийн хороонд санал авах ажиллагаа техникийн saatlaas болж завсарласан байна. Хуулиар санал авах ажиллагааг завсарлуулж болохгүй ба техникийн saat ал гарсан тохиолдолд нөөц төлөвлөгөөнд шилжих ёстой байсан ч Баянзүрх дүүргийн нэг хэсгийн хорооны толгой компьютер гацсан болон Сонгинохайрхан дүүргийн нэг хэсгийн хороонд улсын бүртгэлийн сүлжээ тасалдсанаас техникийн saatlyg засварлах хүртэл санал авах ажиллагааг 10-30 минутын хугацаагаар завсарлуулсан байна.

Баянзүрх дүүргийн хоёр хэсгийн хороонд санал авах ажиллагаа тодорхой хугацаагаар гар ажиллагаанд шилжсэн. Нэг хэсгийн хорооны санал тоолох төхөөрөмж саналын хуудсыг уншихгүй байсан тул өглөөний 09:49-10:42 цагийн хооронд гар ажиллагаанд шилжсэн. Шалтгаан нь санал тоолох төхөөрөмжийг саналын хайрцагтай буруу угсарсан байв. Нөгөө хэсгийн хороонд төхөөрөмжийн кодыг буруу хийснээс өглөөний 07:00-07:20 цагийн хооронд санал авах ажиллагааг гар ажиллагаанд шилжүүлсэн байна.

Мэдээллийн технологийн даамал санал тоолох төхөөрөмж, түүний иж бурдэлд наад захын засвар үйлчилгээ хийх мэдлэг, чадваргүй байсан нь хэсгийн хорооны үйл ажиллагаа тасралтгүй хэвийн явуулахад хүндрэл учруулсан тухай зарим ажиглагчид тэмдэглэсэн байна.

• Санал авах ажиллагааны хаалт

Сонгуулийн өдрийн 20:00 цагт иргэний бүртгэлийн сүлжээ автоматаар зогч хурууны хээ таних төхөөрөмж ажиллах боломжгүй болсноор сонгуулийн хэсгийн хороодын санал авах ажиллагаа хуульд заасан хугацаанд нэг зэрэг дууссан байна.

Хэсгийн хороодын 72.9 хувь нь санал авах ажиллагаа хуульд заасан хугацаа болох 20:00 цагт бүрэн хаасан гэж бүртгэгдсэн. Харин 23.1 хувьд нь 20:00 цагаас өмнө хурууны хээгээ таниулж, “бүртгэлийн хуудас” авсан боловч саналын хуудсаа санал тоолох төхөөрөмжид уншуулж амжаагүй сонгогчдын саналын хуудсыг санал тоолох төхөөрөмжид уншуулж дууссаны дараа санал авах байрыг хаасан ба хамгийн сүүлийн сонгогч 20:15 цагт төхөөрөмжид саналын хуудсаа уншуулсан байна.

Ажиглагчдын мэдээлснээр нийт хэсгийн хороодын 80.1 хувийн санал авах ажиллагаа хаах үед сонгуулийн санал авах байрны гадна болон дотор саналаа өгч амжилгүй үлдсэн сонгогч байгаагүй байна. Харин 17.8 хувьд нь 1-10 сонгогч саналаа өгч чадаагүй үлджээ.

B - САНАЛ ТООЛОХ, САНАЛ ХУРААЛТЫН ДҮН ГАРГАХ

• Санал тоолох ажиллагааны бэлтгэл

Ажиглалт хийгдсэн 112 хэсгийн хороодын 85.4 хувь нь СЕХ-ноос гаргасан зааврын дагуу санал тоолох ажиллагаанд шаардлагатай зүйлсийг хангалттай сайн бэлтгэсэн байсан боловч 5 хэсгийн хороонд саналын хуудсыг битүүмжлэх хэрэгсэл, цавуу, хайч, скоч, бичиг хэргийн зүйлсийг

урьдчилан бэлтгээгүй, нэг хэсгийн хороонд санал хураалтын дүнгийн тухай тэмдэглэл, тогтоолын маягтыг бэлтгээгүй дутагдал ажиглагдсан.

Хэсгийн хороодын 8.9 хувьд нь санал тоолох ажиллагаа эхлэх үед хэсгийн хорооны гишүүд хэрхэн ажиллах талаар ойлголтгүй байсан бөгөөд хэсгийн хорооны дарга нэг бүрчлэн зааварчилан, холбогдох хууль журамтай тухайн үед уншиж танилцсаны үндсэн дээр санал тоолох ажиллагааг эхлүүлэх тохиолдол гарсан байна.

Хэсгийн хороодын 5.3 хувийн санал тоолох байрны ажиглагчдын суудлыг санал тоолох, дүн гаргах ажиллагаагаа бүрэн ажиглаж болохуйц байрлалд байрлуулаагүй ба санал авах ажиллагааны үед сууж байснаас нь өөрчлөгдөөгүй, санал тоолох ажиллагаа явагдаж буй хэсгээс хэт хол зйтай байсан байна.

• Санал тоолох ажиллагаа

Ажиглалт хийгдсэн хэсгийн хороодод санал тоолох ажиллагаанд ноцтой нөлөөлөхүйц зөрчил, дутагдал ажиглагдаагүй бөгөөд ерөнхийдөө хуульд заасан журмын дагуу хэвийн явагдсан боловч зарим хэсгийн хороонд санал тоолох ажиллагааны үед хэрхэн ажиллах талаар хангалттай төлөвлөөгүй байснаас цаг алдах, санал тоолох ажиллагаа сунжрах, зарим ажиллагааг орхигдуулахад хүрсэн байна.

Санал өгсөн нийт сонгогчийн тоо санал авахад зарцуулсан саналын хуудастай тохироогүй байх тохиолдол нийт хэсгийн хороодын 18.6 хувьд нь 1-3 саналын хуудасны зөрүү гарсан бөгөөд тэдгээр нь зохих журмын дагуу зөрүүг гаргахаар дахин нягтлах ажиллагаа явуулсан байна. Ийнхүү нягталсаны дараа СБД-ийн 22-р хэсгийн хороонд 1 саналын хуудас, 11-р хэсгийн хороонд 2 саналын хуудас, Багануур дүүргийн 38 дугаар хэсгийн хороонд 2 саналын хуудас тус тус дутсан байна.

СХД-ийн 40-р хэсгийн хороонд санал авахад зарцуулаагүй үлдсэн саналын хуудасны тоог зарлаагүй байна.

СБД-ийн 11-р хэсгийн хороонд нийт уншигдсан саналын хуудаснаас саналын хайрцаг нээхэд нугалагдаж гарч ирсэн 2 саналын хуудсыг хасч ашиглагдаагүй саналын хуудас гэж тооцон хүчингүй болгосон байна.

СХД-ийн 5-р хэсгийн хороонд санал авахад зарцуулаагүй үлдсэн 1123 саналын хуудсыг хүчингүй болголгүй (хайчлалгүй) саарал уутанд хийж битүүмжилсэн тохиолдол гарсан байна. Ажиглагч саналын хуудсыг хүчингүй болгох шаардлага тавихад “манай журам ийм” гэсэн тайлбар өгчээ.

Санал тоолох төхөөрөмжийн тайланг ажиглагчдад хэвлэж өгөөгүй 7 тохиолдол бүртгэгдсэн. ЧД-ийн 25-р хэсгийн хорооны хэсгийн хороондын дарга “тайланг хэвлэж өгөх журам байхгүй” гэсэн шалтгаанаар дунгийн тайланг ажиглагчдад хэвлэж өгөөгүй ба бүх ажиглагчийн дунд нэг CD өгч түүнийгээ нэгнээсээ хувилж авахыг зөвлөсөн байна. Мөн БЗД-ийн нэг хэсгийн хороонд “тойргийн хорооны дарга дунгийн тайланг хэвлэж өгч болохгүй гэж дээрээс мэдэгдсэн” гэсэн тайлбар хэлсэн байна. Хан-Уул дүүргийн 33-р хэсгийн хорооны дарга “дүнгийн тайланг зөвхөн нам, эвсэл, нэр дэвшигчийн ажиглагчдад хэвлэж өгнө” гэж хэлээд дотоодын ажиглагчдад өгөөгүй. Өөр нэг хэсгийн хороонд “бидэнд албан бичиг өгөөгүй учраас тайланг хэвлэж өгөхгүй” гэсэн байна.

Ажиглагчид шалгах хуудасны санал тоолох хэсгийн асуултад хариулаагүй байх тохиолдол харьцангуй их байгаа нь санал тоолох ажиллагааны үед бичгийн хэлбэрээр үйлдэх, хэсгийн хорооны тэмдэг дарж баталгаажуулах, гарын үсэг зурах, сонгогч буруу тэмдэглэл хийснээс хураагдсан саналын хуудсыг хүчингүй болгох зэрэг ажиллагааг ажиглагчдын өмнө хийгээгүй, эсвэл ажиглагчдад

зарлах ёстай мэдээллийг орхигдуулах, ажиглагчийг мэдээлэлтэй танилцах боломжоор хангаагүй байх болон санал тоолох ажиллагааг явуулахдаа хууль тогтоомжид заасан дарааллыг баримтлалгүйгээр ажиллах тохиолдлууд байсантай холбоотой байна.

• Санал хураалтын дүн гаргах

Ажиглалт хийгдсэн хэсгийн хороодоос санал хураалтын дүнгийн тайланг санал тоолох төхөөрөмжөөс хэвлэж гаргасан боловч тухайн тайланг хуралдаанд уншиж сонсгоогүй хэсгийн хороо 17.8 хувь нь байна. БГД-ийн нэг хэсгийн хороонд хяналтын тооллого хийсэнтэй холбоотойгоор дүнгийн тайланг уншиж сонсгоогүй ба дүнгийн тайланд гарын үсэг зураагүй байна.

Хэсгийн хороодын 19.5 хувьд нь санал хураалтын дүнгийн тухай тогтоолыг хэсгийн хороо хуралдаанаар хэлэлцэж батлаагүй байна. Зарим хэсгийн хороо “цаг амжихгүй байна” гэж тайлбарласан бол үлдсэн хэсгийн хороод энэ ажиллагааг огт хийлгүй орхигдуулсан байна. Дээрх шалтгаанаар санал хураалтын дүнгийн тухай тогтоолыг үйлдээгүй болон үйлдсэн боловч түүнийг уншиж сонсгоогүй хэсгийн хороо нийт хэсгийн хороодын 20.4 хувийг эзэлсэн нь санал хураалтын дүн гаргах ажиллагааны чухал хэсгийг орхигдуулсан явдал болжээ. Гэхдээ зарим хэсгийн хороо уншиж сонсгоогүй боловч ажиглагчдыг түүнийг уншиж, гарын үсэг зурах боломжоор хангасан байна. СХД-ийн 15-р хэсгийн хороонд “тойргийн хорооноос хяналтын тооллого явуулах хүмүүс ирнэ” гэсэн үндэслэлээр өглөөний 6 цаг хүртэл сонгуулийн дүнг тойргийн хороо руу хүргүүлээгүй бөгөөд ажиглагчдад дүнгийн тайлан, тогтоолыг танилцуулаагүй байна

Ажиглалт хийгдсэн хэсгийн хороодоос УИХ-ын сонгуулийн 25 дугаар тойргийн 9, 23 дугаар хэсгийн хороонд “хяналтын тооллого” албан ёсоор хийсэн байна. Мэн ажиглагчдын мэдээлнээр тойргийн

хорооноос хяналтын тооллого хийнэ гэж мэдэгдсэн тул тойргийн хорооноос хүн ирж тооллого хийхийг хүлээж байсан өөр 3 хэсгийн хороо байна.

25 дугаар тойргийн 23 дугаар хэсгийн хороонд хяналтын тооллого 2012 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн 00:30 цагт эхэлж, 13 цагийн орчимд дууссан ба тухайн хэсгийн хорооны хоёр дахь санал тоолох төхөөрөмжид нэг саналын зөрүү гарснаас өөр зөрүү гараагүй байна. Хяналтын тооллого хийгдсэн хоёр дахь хэсгийн хороо болох 9-р хэсгийн хорооны эхний санал тоолох төхөөрөмжийн санал хураалтын дүнгийн тайлан нь хяналтын тооллогын дунгээс нэг саналаар зөрсөн ба дотоодын ажиглагч хоёрдахь төхөөрөмжийн тооллогод оролцож чадаагүй байна.

Дотоодын ажиглагчдын шалгах хуудасны санал хураалтын дүн гаргах гэсэн хэсэгт хариулсан хариулт болон хөтөлсөн тэмдэглэлээс үзвэл дийлэнх хэсгийн хороонд санал хураалтын дүн гаргах ажиллагаа ажиглагчдад нээлттэй, ил тод байдлаар явагдсан байна. Гэсэн хэдий ч зарим хэсгийн хороо ажиглагчдад зохих мэдээллийг өгөөгүй, ажиглалт хийх боломжоор бүрэн дүүрэн хангаагүй нь санал хураалтын дүн гаргах ажиллагаа хуульд заасан журмын дагуу явагдаж байгаа эсэх талаар ажиглалтын хуудсанд тэмдэглэхэд хүндрэл учруулсан байна.

Монгол Улсад анх удаа сонгуулийн санал тоолох төхөөрөмжийг ашигласнаар санал тоолох, санал хураалтын дүн гаргах ажиллагаа түргэн шуурхай явагдах нөхцлийг бүрдүүлж хэсгийн хороонд ажиллаж буй хүмүүсийн механик ажиллагааг багасгасан сайн нөлөө үзүүлсэн нь ажиглалдсан. Гэхдээ зарим хэсгийн хороодод санал тоолох төхөөрөмжийн дүнг харилцаа холбооны тусгай суваг ашиглан төв серверт дамжуулах үед ачаалал ихэссэний улмаас төхөөрөмж гараж хүлээлт үүсчээ.

• Санал тоолох ажиллагааны зөрчил

Ажиглалт хийсэн хэсгийн хороодод санал тоолох ажиллагааны үед харьцангуй цөөн зөрчил гарсан бөгөөд санал тоолох ажиллагааг будлиantuулах, санал хураалтын дүнд нөлөөлөхүйц хэмжээний зөрчил ажиглагдаагүй байна. Гэсэн хэдий ч зарим хэсгийн хороодод санал тоолох ажиллагааны зохион байгуулалт муу, зохих дарааллын дагуу явагдаагүй зөрчлүүд илэрсэн байна. Энэ шалтгаанаар 22 дугаар тойргийн 81 дугаар хэсгийн хороонд саналын хуудсыг тоолох ажилд ажиглагчдыг гар бие оролцуулсан¹⁵ зөрчил гарчээ. Мөн БГД-ийн нэг хэсгийн хороонд санал авах ажиллагааг хаасан даруйд журамд заасан ажиллагааг алгасан шууд санал тоолох төхөөрөмжөөс санал хураалтын дүнгийн тайланг хэвлүүлсэн зөрчил илэрсэн байна.

Санал тоолох ажиллагааны үед зохих зөвшөөрөлгүйгээр хэсгийн хорооны гишүүд, ажиглагчид орж, гарч байсан тохиолдол 6.2 хувьтай байна. Гэхдээ санал тоолох байранд гаднаас зөвшөөрөлгүй этгээд орж ирсэн тохиолдол гараагүй тухай ажиглагчид тэмдэглэсэн байна.

Хэсгийн хороодын 53.4 хувьд нь санал тоолох ажиллагааны үеэр хэсгийн хорооны гишүүд болон ажиглагчид гар утас ашиглан хэсгийн хорооны санал тоолох ажиллагааны талаарх мэдээллийг дамжуулж байсан нь хууль зөрчсөн үйлдэл болжээ.

22 дугаар тойргийн нэг хэсгийн хороонд нэг намын 3 ажиглагч санал хураалтын дүнг хүлээн зөвшөөрөхгүй заавал саналыг дахин гараар тоолуулна гэсэн гомдол гаргасан. Түүний хариуд СЕХ-ноос дахин

гараар тоолох шаардлагагүй гэж мэдэгдсэн боловч хэсгийн хорооны гадаа тус намын 20 орчим хүмүүс хаалга хааж зогсон санал тоолох байрнаас хүн гаргахгүй шөнийн 03:00 цаг хуртэл саатуулж байсныг цагдаагийн ажилтнууд ирж хэсгийн хорооны гишүүд болон ажиглагчдыг гаргасан байна.

• Санал тоолох төхөөрөмжийн saatал, гэмтэл

Санал тоолох ажиллагааны үед санал тоолох төхөөрөмж гацсан тохиолдол 4.4 хувьтай байна. Тэдгээр нь санал тоолох төхөөрөмжид модем танигдахгүй байх болон төхөөрөмжийн мэдээллийг төв серверт дамжуулах үед сүлжээний ачаалал ихэссэнээс гацах тохиолдлууд гарч байжээ.

• Ажиглалт хийх үед тулгарсан хүндрэл, бэрхшээл

“Шударга Сонгуулийн Төлөө Иргэний Нийгмийн Хяналт” сүлжээнээс хэрэгжүүлсэн ажиглалт нь нийт 112 хэсгийн хороог хамарсан бөгөөд ажиглагчид сонгуулийн өдрийн өглөө 07.00 цаг болохоос өмнө тус тусын хэсгийн хороодод очиж ажиглалтаа эхэлсэн болно. Өглөө хэсгийн хороон дээрээ очих үед Баянзүрх дүүргийн нэг хэсгийн хороонд манай нэг ажиглагчийг албан бус, энгийн хувцаслалттай байна (жинсэн өмд, пүүз) гэсэн үндэслэлээр хэсгийн хороонд нэвтрүүлээгүй ба тус ажиглагч гэр лүүгээ буцан очиж хувцсаа сольсноор ажиглалтаа хийх боломжтой болсон. Хэсгийн хорооны зүгээс тавьсан шаардлага нь хууль болон журамд заагдаагүй, ажиглалтын үйл ажиллагаанд саад учруулсан үндэслэлгүй шаардлага байв. Мөн Баянгол дүүргийн 2 хэсгийн хорооны санал авах байр товлосон байрлалаа сонгуулийн өмнөх өдөр өөрчилсөн тохиолдол гарсан. Энэ тухай ажиглагчдад мэдээлээгүйгээс ажиглагчид санал авах байрыг хайж цаг алдан санал авах ажиллагааны нээлтээс хоцорсон байна.

¹⁵ хуульд зааснаар ажиглагч нарыг санал тоолох үйл ажиллагаанд оролцуулах ёсгүй, ажиглах л ёстой болохоос хуудсыг тоолуулж цэгцлэх зэрэг ажилд оролцуулсан нь зөрчил болсон байгаа юм

Санал авах ажиллагааны нээлтийн үед ажиглагч нь санал тоолох төхөөрөмжийн гэрчилгээ, түүний лац болон саналын хайрцагны лацыг шалгаж, тэмдэглэж авах нь тухайн төхөөрөмжийн гэрчилгээ болон төхөөрөмж дээрх серийн дугаар тохирч байгаа эсэхийг нягтлах, санал авах ажиллагаа дууссаны дараа тухайн лац бүрэн бүтэн, өөрчлөгдөөгүй байгаа эсэхийг хянах чухал ач холбогдолтой юм. Гэтэл олон хэсгийн хороод дээр ажиглагчийг төхөөрөмжид ойртуулаагүй, лацны дугаарыгуншижсонгоогүй, төхөөрөмжийн гэрчилгээтэй танилцах боломж олгоогүй зэргээс шалтгаалан холбогдох мэдээллийг тэмдэглэж авч чадаагүй байна.

Санал авах, санал тоолох ажиллагааны үед хийгдэвэл зохих зарим тэмдэглэл, маягтыг хэсгийн хорооны гишүүд зохих журмын дагуу хөтөлж байгаа эсэх нь ажиглагчдад ил тод бус, танилцах боломжгүй байв. Тухайлбал, дийлэнх хэсгийн хороо ажиглагчдын гаргасан санал, гомдол бүрийг хүлээн авч тухай бүр шийдвэрлэж байсан боловч санал, гомдлын агуулга болон шийдвэрлэсэн байдлыг тусгасан тэмдэглэл үйлдэж байгаа байдал ажиглагдаагүй, ажиглагчдыг тэмдэглэлтэй танилцах боломжоор хангаагүй, мөн санал тоолох ажиллагааны үед ажиллах ажил үүргийн хуваарийг баталсан эсэх нь тодорхойгүй зэрэг бичгээр үйлдэгдсэн баримт бичгүүдтэй танилцах, баримтжуулалт хийхэд бэрхшээл тулгарч байсан байна.

2012 оны УИХ-ын болон НИТХ-ын сонгуулийн өдрийн санал авах, санал тоолох, дүн гаргах ажиллагаанд анх удаа дотоодын байгууллагын ажиглагчид ажиглалт хийсэн тул хэсгийн хорооны гишүүд, бусад ажиглагчид иргэний нийгмийн байгууллагын ажиглагчдын статус, зорилгын талаар ойлголт муутай байсан бөгөөд улстөрийн намын ажиглагчидтай андуурах, ажиглалт хийх нөхцөл боломжоор хангахдаа ялгавартай хандах, тавьсан хүсэлтийг нь үл тоомсорлох байдал ажиглагдсан байна. Мөн хэсгийн хороодын багтаамжаас шалтгаалан иргэний нийгмийн ажиглагчид нь хэсгийн хорооны байранд ганцаараа ажиллаж байсан бөгөөд нэг хэсгийн хороонд манай ажиглагчийн ажиллах цагийн хуваарийг тогтоож санал авах байрнаас санал авах ажиллагааны З цагийн хугацаанд гаргасан байна.

5.6 ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

ДҮГНЭЛТ

“Шударга Сонгуулийн Төлөө Иргэний Нийгмийн Хяналт” сүлжээний ажиглагчдын 112 хэсгийн хороонд ажиглалт явуулсан мэдээллийг үндэслэн тус хэсгийн хороодын хүрээнд 2012 оны УИХ-ын болон НИТХ-ын сонгуулийн санал авах, санал тоолох, санал хураалтын дунг гаргах ажиллагаа хуулийн дагуу явагдсан ба сонгуулийн дунд нөлөөлөхүйц ноцтой зөрчил гараагүй гэж дүгнэж байна. Ажиглалт хийсэн хэсгийн хороод дээр зохион байгуулалтын болон тохиолдлын чанартай зөрчлүүд гарсан ч энэ нь санал тооллогын дунд сөрөг нөлөө үзүүлээгүй байна.

Сонгуулийн санал хураах, тоолох, дунг гаргах үйл явцад гарсан зарим зөрчил, алдааг дурдвал:

Сонгуулийн хууль тогтоомжийн талаар:

Сонгуульд ажиглалт хийх дотоодын байгууллага болон түүний ажиглагчдыг бүртгэх журмыг тойргийн хороо, хэсгийн хороод нэг мөр ойлгож хэрэглээгүй байна. Мөн хуульд заасан журмын дагуу санал авах ажиллагааг явуулах үед сонгогчийн саналын нууцлал алдагдаж болохуйц нөхцөл байдал үүсч байсан нь сонгуулийн үндсэн зарчмын нэг болох сонгогч саналаа нууцаар гаргах зарчмыг алдагдуулсан байна. Хяналтын тооллого явуулах хэсгийн хороог сонгох журам нь тодорхойгүйн улмаас уг тооллогыг явуулна гэж өмнө нь зарласан хэсгийн хороодод тодорхойгүй байдал үүссэн байна.

Сонгуулийн хороодын үйл ажиллагааны талаар:

Хөгжлийн бэрхшээлтэй иргэд саналаа өгөх нөхцөл байдал хантагдаагүй, санал

авах ажиллагааны явцад сонгогчийн саналын хуудсан дахь саналын нууцлал алдагдахуйц нөхцөл байдал үүссэн, зарим мэдээллийг ажиглагчдад зарлаагүй бөгөөд танилцах боломжоор хангаагүй, журамд заасан ажиллагааг ажиглагчдын ажиглалтаас гадуур хийх, дотоодын байгууллагын ажиглагчдад ялгавартай хандаж ажиглалт хийх нөхцөл боломжоор бүрэн хангахгүй байх, санал тоолох ажиллагаа явуулах дараалал, хийгдэвэл зохих ажиллагааны талаар хэсгийн хорооны дарга, гишүүд зохих мэдлэггүй байх, түүний улмаас зарим ажиллагааг орхигдуулах, ажиглагчдыг мэдээлэлтэй танилцах боломжоор хангахгүй байх, санал тоолох ажиллагааны үед утсаар ярих зэрэг зөрчлүүд илэрсэн байна.

Сонгогчдын боловсролын талаар:

Ажиглагчдын мэдээллээс үзвэл сонгогчид саналын хуудсанд хэрхэн тэмдэглэгээ хийх, саналын хуудсаа төхөөрөмжид хэрхэн уншуулах талаар хангалттай мэдээлэлгүй байсан байна. Мөн өөрийнхөө нэрийг нэрийн жагсаалтад байгаа эсэхийг нягтлаагүй, хуульд заасан бичиг баримттайгаар санал авах байранд ирээгүй зэрэг нь сонгогч өөртөө хүндрэл учруулахад хүрч байсан. Түүнчлэн саналын хуудасныхаа тэмдэглэгээг бусдад харуулах, саналын хуудасны зураг авах, бусад иргэний саналын хуудсыг төхөөрөмжид уншуулах зэрэг хуульд заасан зөрчлүүдийг гаргасан байна.

Сонгуулийн автоматжуулсан системийн талаар:

Сонгуулийн автоматжуулсан системийн ажиллагааны харьцангуй сайнбайсан бөгөөд зарим тохиолдолд иргэний бүртгэлийн сүлжээ тасалдах, санал тоолох төхөөрөмж гацах, саналын хуудсыг уншихгүй байх, төхөөрөмжийн толгой бохирдох, толгой компьютер гацах, дунг серверт дамжуулах үед сүлжээний ачаалал ихэссэний улмаас гацах, мэдээллийн технологийн даамлын чадвар дутмаг зэрэг дутагдлууд илэрч байв.

ЗӨВЛӨМЖ

Ажиглалтын үр дүнгээс үүдэн Сонгуулийн тухай хууль тогтоомж болон сонгуулийн үйл явцыг сайжруулах зорилгоор дараах зөвлөмжийг гаргаж байна.

- Сонгуулийн үйлажиллагаандажиглалт, хяналт хийх ТББ-уудын оролцоог нэмэгдүүлэхэд анхаарч нэг тойргийн хороонд ажиллах ажиглагчийн тоог хязгаарлахгүй байхаар тогтоох;
- Хэсгийн хороодын гишүүдийг хууль тогтоомжийн талаар нэгдсэн ойлголттой болгох сургалтын чанарыг сайжруулах, мэдээллээр бүрэн хангах дээр анхааран ажиллах. СЕХ-ноос цаашид батлан гаргасан дүрэм журмуудаа хэсгийн хороодод тайлбарлан таниулахад сайтар анхаарах шаардлагатай бөгөөд ялангуяа хэрэгжилтийг нь хэсгийн хороодод жигдүүлэх;
- Санал тоолох ажиллагааны материаллаг бэлтгэл болон хэсгийн хорооны гишүүдийн мэдлэгийг дээшлүүлэх. Саналтооложажиллагааны дүng танилцуулсан бичиг баримттай ажиглагчид танилцах, мэдээлэл авах боломжоор хангах;
- Сонгогчдын боловсролыг дээшлүүлэх (тухайлбал, саналын хуудсанд хэрхэн тэмдэглэгээ хийх, санал тоолох төхөөрөмжид хэрхэн саналын хуудсаа уншуулах) болон сонгогчдод шаардлагатай мэдээллийг нээлттэй, цаг алдалгүй хүргэх дээр анхаарч ажиллах;
- Сонгогч өөрийн итгэмжлэгдсэн хүний туслалцаа авах эрхзүйн зохицуулалтыг боловсронгуй болгох;
- Хэсгийн хороонд сонгуулийн санал авах, санал тоолох, санал хураалтын дүн гаргах бүхий л ажиллагааны үед холбогдох ажиллагаа болон бичиг баримтыг ажиглагчдын нүдэн дээр хийх, холбогдох баримтыг ажиглагчдад танилцуулж түүнд гарын үсэг зуруулах боломж, оролцоогоор хангах;
- Саналавах байрыг бэлтгэхдээ хөгжлийн бэрхшээлтэй иргэн саналаа хүндрэлгүй өгөх нөхцөл бололцоог хангасан налуу шат, санал бэлтгэх бүхээг, томруулдаг шил зэргийг нийт хэсгийн хороод бүрэн бэлтгэсэн байхад анхаарах. Мөн санал авах байрыг тухайн барилгын 2, 3, 4 давхарт байгуулахаас зайлсхийх, харааны бэрхшээлтэй сонгогчдод зориулсан баррел үсэгтэй саналын хуудас бэлтгэх;
- Хэсгийн хорооны дарга, гишүүд, мэдээллийн технологийн даамал сонгогчид ямар нэгэн байдлаар нөлөөлөх, саналын хуудастай танилцах, сонгогчийн өмнөөс саналын хуудсанд тэмдэглэгээ хийх явдлыг таслан зогсоох;
- Сонгогчдод санал авах ажиллагааны үед хориглосон зөрчлийн талаарх мэдээлэл өгөх, зөрчсөн тохиолдолд таслан зогсоох арга хэмжээ авах;
- Дотоодын байгууллагын ажиглагчдын статусыг хууль, журмаар тодорхой болгох, тэдгээрийн зорилгын талаар хэсгийн хорооны гишүүддэд танилцуулах, ажиглалт хийх боломжоор бодитоор хангах;
- Иргэний бүртгэлийн сүлжээ, санал тоолох төхөөрөмжийн иж бүрдлийн хэвийн ажиллагааг хангах, дүng төв серверт дамжуулах үед сүлжээний ачааллыг тохируулах арга хэмжээ авдаг байх;
- Мэдээллийн технологийн даамлын чиг үүргийг өргөжүүлж, холбогдох сургалтыг явуулсны үндсэн дээр санал тоолох төхөөрөмжөөс бусад тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагааг хариуцдаг болгох;
- Хяналтын тооллого явуулах журмыг боловсронгуй болгох (тодорхой байхын зэрэгцээ цаг алдахгүй талаар анхаарах).

ХАВСРАЛТ



2012 оны УИХ-ын сонгуулийн ажиглалтын
тайлан, баримт материал, 2012 оны 6 дугаар сар.
Гэрэл зургийг Б. Золзаяа, “Өөрчлөлтийн төлөөх
залуу эмэгтэйчүүд” ТББ

1. САНАЛЫН ХУУДАС ХЭВЛЭХ, ХАДГАЛАХ, ХАМГААЛАХ, ХҮРГҮҮЛЭХ, АРХИВТ ШИЛЖҮҮЛЭХ ҮЙЛ ЯВЦЫН ХЯНАЛТ

- 1.1 СЕХ-ны 71-р тогтоол
- 1.2 СЕХ-ноос ирүүлсэн 279 тоот албан захидал
- 1.3 24-р тойргийн саналын хуудасны зарцуулалт
- 1.4 24-р тойргийн хэсгийн хороодоос саналын хуудас хүлээн авч архивт өгсөн баримт
- 1.5 19-р тойргийн салбар болон хэсгийн хороодод саналын хуудас хуваарилсан судалгаа
- 1.6 19-р тойргийн саналын хуудасны зарцуулалт

2. СОНГОГЧДЫН НЭРИЙН ЖАГСААЛТЫН МОНИТОРИНГ

- 2.1 УИХ-ын сонгуулийн-р тойргийн-р хэсгийн хорооны сонгогчийн шилжилт хөдөлгөөний ажиглалтын маягт
- 2.2 УИХ-ын сонгуулийн-р тойргийн-р хэсгийн хорооны сонгогчдын хувийн мэдээлэлд өөрчлөлт оруулсан мэдээллийн маягт
- 2.3 УИХ-ын сонгуулийн-р тойргийн-р хэсгийн хорооны сонгогчдын нэрийн жагсаалтад шинээр сонгогч бүртгэсэн маягт
- 2.4 УИХ-ын сонгуулийн-р тойргийн-р хэсгийн хорооны сонгогчдын нэрийн жагсаалтаас хасалт, тусгай тэмдэглэгээ хийгдэж байгаа сонгогчдын бүртгэлийн маягт
- 2.5 УИХ-ын сонгуулийн-р тойргийн-р хэсгийн хорооны сонгогчдын нэрийн жагсаалтад шинээр бүртгэгдсэн сонгогчын хаягийн тулгалтын маягт

3. 2012 ОНЫ УИХ-ЫН СОНГУУЛИЙН ҮЕЭР ХИЙСЭН ТЕЛЕВИЗИЙН МОНИТОРИНГ

- 3.1 Мониторингийн дүн телевиз тус бүрээр
- 3.2 УИХ-ын 2012 оны сонгуулийн сурталчилгааг МУОНТ-ээр нэвтрүүлэх хуваарь
- 3.3 Олон нийтийн радио телевизээс бусад радио, телевизээр сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх журам
- 3.4 Мэдээлэл цуглуулах хүснэгтүүд

4. СОНГУУЛИЙН САНАЛ АВАХ, САНАЛ ТООЛОХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ АЖИГЛАЛТ

- 4.1 Иргэний нийгмийн ажиглагчийн баримтлах ёс зүйн дүрэм
- 4.2 Иргэний нийгмийн ажиглагчийн шалгах хуудас бөглөх заавар, зөвлөмж
- 4.3 Иргэний нийгмийн ажиглагчийн шалгах хуудас: А – Санал авах ажиллагааны нээлт
- 4.4 Иргэний нийгмийн ажиглагчийн шалгах хуудас: Б – Санал авах ажиллагаа
- 4.5 УИХ, НИТХ-ын Сонгуулийн үйл явцын ерөнхий үнэлгээний маягт
- 4.6 УИХ, НИТХ-ын Сонгуулийн үйл явцын ерөнхий үнэлгээ
- 4.7 Иргэний нийгмийн ажиглагчдын шалгах хуудас: Нэгтгэсэн дүн
- 4.8 Иргэний нийгмийн ажиглалтын үйл ажиллагааны аман мэдээллийн тэмдэглэлийн хуудас
- 4.9 Иргэний нийгмийн ажиглагчийн зөрчил, гомдлыг бүртгэх хуудас: Санал авах ажиллагааны Б шалгах хуудас
- 4.10 Иргэний нийгмийн ажиглагчийн шалгах хуудас: В – Санал тоолох, санал хураалтын дүн гаргах



МОНГОЛ УЛС
СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООНЫ
ТОГТООЛ

2012 оны 5 сарын 22 өдөр

Дугаар 71

Улаанбаатар хот

Сонгуулийн үйл ажиллагаанд хяналт шинжилгээ хийх
төрийн бус байгууллагуудыг бүртгэж, зөвшөөрөл олгох
тухай


Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.5 дахь хэсэг, Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.7 дахь заалт, 12 дугаар зүйлийн 12.3 дахь хэсэг, Сонгуулийн ерөнхий хорооны 2012 оны 30 дугаар тогтоолоор баталсан "Төрийн бус байгууллага сонгуулийн үйл ажиллагаанд хяналт шинжилгээ /мониторинг/ хийх, сонгочдод аргачилсан туслалцаа үзүүлэх тухай журам"-ын 2.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хорооноос ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Их Хурлын 2012 оны сонгуулийн үйл ажиллагаанд хяналт шинжилгээ /мониторинг/ хийх дор дурдсан төрийн бус байгууллагуудыг бүртгэж, зөвшөөрөл олгосугай. Үүнд:

- Шударга сонгуулийн төлөө Иргэний нийгмийн хяналт сүлжээ /Нээлттэй нийгэм фонум, Сонгочдын боловсрол төв, Хүний эрх хөгжил төв, Глоб Интернэшнл ТББ, Филантропи хөгжлийн төлөө төв, МИДАС ТББ, Өөрчлөлтийн төлөө залуу эмэгтэйчүүд ТББ
- "Иргэний эрхийн гүүр төв" ТББ
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн Бизнес инкубатор төв
- Нийгэм судалгааны Шинэ сэтгэлгээний төв ТББ
- Нийгмийн бодлого, хөгжлийн судалгааны хүрээлэн
- Инфратест сургалт судалгааны төв
- Монголын тэргэнцэртэй иргэдийн үндэсний холбоо
- Дорнод аймгийн "Дорнод нутгийн иргэдийн хөгжлийн төв" ТББ

2. Сонгуулийн үйл ажиллагаанд хяналт шинжилгээ хийх төрийн бус байгууллагуудыг үйл ажиллагаагаа явулахад нь холбогдох хууль, журамд заасны дагуу дэмжлэг үзүүлж ажиллахыг сонгуулийн хороодод үүрэг болгосугай.

3. Сонгуулийн хууль тогтоомжийг үйл ажиллагаандаа чанд мөрдөн ажиллахыг дээрх төрийн бус байгууллагуудын удирдлагуудад үүрэг болсугай.



000149

1.2 СЕХ-ноос ирүүлсэн 279 тоот албан захидал



СОНГОГЧДЫН БОЛОВСРОЛ ТӨВИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
С.ОЮУНТУЯА ТАНАА

МОНГОЛ УЛС СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРОО

15141 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Ж.Самбуурийн гудамж 11, Засгийн газрын XI байр,
Утас: 26-09-75. Факс: (976-11) 32-69-75,
E-mail: gecm@gec.gov.mn, http://www.gec.gov.mn

2012.05.26 № 279
таний 2012.05.10-ны № 18-т

Хариу өгөх тухай

Танай 2012 оны 5 дугаар сарын 10-ны өдрийн 18 тоот албан бичгээр ирүүлсэн хүсэлттэй танилцлаа.


Сонгуулийн ерөнхий хорооны 2012 оны 5 дугаар сарын 22-ны өдрийн хуралдаанаар Монгол Улсын Их Хурлын сонгуулийн үйл ажиллагаанд хяналт, шинжилгээ хийх төрийн бус байгууллагуудыг бүртгэж, зөвшөөрөл олгох асуудлыг хэлэлцэж "Шударга сонгуулийн төлөө Иргэний нийгмийн хяналт сүлжээ"-г сонгуулийн үйл ажиллагаанд хяналт, шинжилгээ хийх ТББ-аар бүртгэсэн болно.

Сонгуулийн үйл ажиллагаанд хяналт, шинжилгээ хийхтэй холбогдсон асуудлаар төлөөлөх эрх бүхий этгээдээр дамжуулан асуудлаа биечлэн ирж тавих нь зүйтэй бөгөөд танай ирүүлсэн дараах хүсэлтийг хүлээн авах боломжтой байна. Үүнд:

1. Улсын Их Хурлын сонгуулийн саналын хуудас хэвлэх, хадгалах, хүргүүлэх, хамгаалах, хүргүүлэх үйл явц, холбогдох журамтай танилцах,
2. Тус Хорооны хуралдаанд холбогдох асуулаар хөндлөнгийн ажиглагчаар оролцох зэрэг болно.

Улсын Их Хурлын сонгуулийн саналын хуудасны цаас худалдан авах, саналын худсыг хэвлэх аж ахуйн нэгжийг сонгон шалгаруулах, гэрээ байгуулах зэрэг үйл явц нь тус Хорооны дотоод ажил хэрэгт хамаатай, төрийн аудитын хяналтад байдаг асуудал байна.

Жич: Танай 2012 оны 5 дугаар сарын 23-ны өдрийн "Захидлын хариу шаардах тухай" 24 тоот албан бичигт дурьдсан танай 2012 оны 5 дугаар сарын 01-ний өдрийн 15 тоот албан захидал тус Хороо дараахад дээрээдэй болно.



000516

1.3 24-р тойргийн саналын хуудасны зарцуулалт

**Улсын Их Хурлын сонгуулийн саналын хуудсыг хэвлүүлэх, хадгалах,
хүрүүлэх, хамгаалах журмын 2 дугаар хавсралт**
**УЛСЫН ИХ ХУРЛЫН СОНГУУЛИЙН САНАЛЫН ХУУДАСНЫ
ЗАРЦУУЛАЛТЫН ТАЙЛАН**

Улсын Их Хурлын сонгуулийн 24 дугаар тойргийн хороо
сарын 30-ны өдөр

№	Салбар, эзслэйн хордоны дугаар	Нарийн жасалтад бичигдсэн сонголчын тоо	Саналын хуудасны тоо			Үүнээс			Зорцуулагаагүй уласан саналын хуудасны тоо
			Хувьарлагдсан	Хүлээн авсан	Зерүү	Санал хураалтад зарцуулсан саналын хуудасны тоо	Сонгон буруу тэмдэглэл хийнээс хүчингүй болгосон	Зөвөрний битгүүн-жилсэн хайрцгаар санал авахад	
1	1-р хэсэг	2461	2582	0	1601	9	21	1571	981
2	2-р хэсэг	2380	2477	0	1652	5	25	1622	825
3	3-р хэсэг	1833	1919	0	1213	6	14	1193	706
4	4-р хэсэг	1862	1951	0	1258	6	9	1243	693
5	5-р хэсэг	1806	1827	0	1248	8	12	1228	579
6	6-р хэсэг	1511	1635	0	1010	8	16	986	625
7	7-р хэсэг	1763	1847	0	1168	4	8	1156	679
8	8-р хэсэг	1633	1716	0	1065	6	11	1048	651
9	9-р хэсэг	2216	2305	0	1490	11	13	1466	815
10	10-р хэсэг	2385	2496	0	1595	13	9	1573	901
11	11-р хэсэг	2893	3027	0	1820	25	14	1781	1207
12	12-р хэсэг	2953	3093	0	1745	17	13	1715	1348
13	13-р хэсэг	2944	3090	0	1767	14	18	1735	1323
14	14-р хэсэг	1486	1561	0	996	14	10	972	565
15	15-р хэсэг	2008	2106	0	1325	4	4	1317	781
16	16-р хэсэг	2560	2679	0	1597	14	12	1571	1082
17	17-р хэсэг	2835	2977	0	1787	18	6	1763	1190
18	18-р хэсэг	2761	2905	0	1803	8	19	1776	1102
19	19-р хэсэг	2827	2977	0	1802	18	12	1772	1175
20	20-р хэсэг	2242	2354	0	1514	3	9	1502	840

1.3-ын үргэлжлэл

ЛЫГЧ	21 -р хэсэг	2175	2279	2279	0	1412	10	14	1402	867
+ ДҮГЭР 20	22 -р хэсэг	2304	2420	2420	0	1434	35	5	1394	986
ТОЙРГИИН 28	23 -р хэсэг	2201	2312	2312	0	1365	22	3	1340	947
ХОРЛОО 25	24 -р хэсэг	2797	2933	2933	0	1825	14	7	1811	1108
МОНГОЛЫН 25	25 -р хэсэг	2270	2310	2310	0	1527	17	75	1435	783
26	26 -р хэсэг	2906	3041	3041	0	1846	11	12	1823	1195
27	27 -р хэсэг	2922	3063	3063	0	1885	19	5	1863	1178
28	28 -р хэсэг	2920	3059	3059	0	1902	19	17	1866	1157
29	29 -р хэсэг	2445	2569	2569	0	1501	9	14	1492	1088
30	30 -р хэсэг	2931	3056	3056	0	1977	19	15	1943	1079
31	31 -р хэсэг	2892	3022	3022	0	1944	14	19	1930	1078
32	32 -р хэсэг	2842	2962	2962	0	1691	12	22	1657	1271
33	33 -р хэсэг	2969	3097	3097	0	1911	31	13	1867	1186
34	34 -р хэсэг	2596	2722	2722	0	1682	47	11	1682	1040
35	35 -р хэсэг	2157	2249	2249	0	1451	24	11	1416	798
36	36 -р хэсэг	1971	2069	2069	0	1192	8	12	1172	877
37	37 -р хэсэг	2368	2466	2466	0	1478	24	13	1478	988
38	38 -р хэсэг	2542	2651	2651	0	1565	27	12	1526	1086
39	39 -р хэсэг	2552	2680	2680	0	1558	21	12	1525	1122
40	40 -р хэсэг	1967	2061	2061	0	1259	15	11	1233	802
41	41 -р хэсэг	2242	2348	2348	0	1439	15	9	1415	909
42	42 -р хэсэг	2132	2230	2230	0	1356	10	14	1332	874
43	43 -р хэсэг	2426	2536	2536	0	1587	13	24	1550	949
44	44 -р хэсэг	2226	2330	2330	0	1379	22	6	1351	951
ТОЙРГИИН ДУН	105112	109989	109989	9	0	67622	669	611	66493	42367



Тойргийн хорооны дарга
Нарийн бичгийн дарга
Галсанпүнцаг
Д.Артаг

Тэмдэг

1.4 24-р тойргийн хэсгийн хороодоос саналын хуудас хүлээн авч архивт өгсөн баримт

УИХ-ын Сонгуулийн 24-р тойргийн хэсгийн хороодоос
саналын хуудас хүлээн авсан баримт №1

2012-06-28

Хэсгийн хороо №	Колны дугаар	Хүлээгдэн өгсөн хүний нэр												
		I YYT	II YYT	III YYT	IV YYT	V YYT	VI YYT	VII YYT	VIII YYT	IX YYT	X YYT	XI YYT	ХҮЛЭЭГДЭЛ ТОО	
1-р хэсэг	7726	400	7729	392	7727	400	7728	400	7723	9	7724	481	7725	500
2-р хэсэг	7716	400	7717	425	7718	-	7719	1647	7721	5	-	-	-	7
3-р хэсэг	7715	350	7713	350	7730	350	7714	157	7712	6	706	-	-	5/2
4-р хэсэг	7708	350	7709	350	7710	350	7707	202	7711	699	-	-	-	5
5-р хэсэг	7703	621	7704	619	7702	587	-	-	-	-	-	-	-	3
6-р хэсэг	7697	325	7698	392	7699	310	7700	300	7701	308	-	-	-	5
7-р хэсэг	7669	400	7666	209	7671	347	7670	400	7696	208	7822	300	-	6
8-р хэсэг	7655	350	7662	359	7659	350	7665	6	7661	651	-	-	-	5
9-р хэсэг	7652	11	4914	400	7653	415	7644	400	7649	279	7642	400	7643	400
10-р хэсэг	4913	350	4911	350	4912	350	4910	350	4907	350	4909	350	4908	396
11-р хэсэг	4898	922	4899	873	хайр	1207	4900	25	-	-	-	-	-	7
12-р хэсэг	4889	4895	4894	4891	4897	-	4890	-	4893	-	4896	4892	4894	9
13-р хэсэг	4883	873	4882	880	4887	14	4881	600	4880	723	-	-	-	5/4
14-р хэсэг	4875	332	4876	332	4877	318	4878	289	4879	289	-	-	-	5
Нийт:	14		14		13	12	12	5	4	1	1	1	91	2

76

Хүлээн авсан: УИХ-ын сонгуулийн 24-р тойргийн хорооны гишүүн
Ц.Доржжавжавын, Л.Оюунцэцэг

М.Энхийн
М.Энхийн

Ажлын
адил : А.Доржжавжавын
Ц.Энхсайхан

УИХ-ын Сонгуулийн 24-р тойргийн хэсгийн хороодоос

саналын хуудас хүлээн авсан баримт №2

2012-06-28

Хэсгийн № хороодоо	I YYT	Кодны дугаар										Хүлээнэлгээнд өгсөн хүний нэр	
		II YYT	III YYT	IV YYT	V YYT	VI YYT	VII YYT	VIII YYT	IX YYT	X YYT	YTHPI TOO		
15-р хэсг	4872	350	4871	350	4869	271	4870	350	4874	400	4873	385	-
16-р хэсг	4866	400	4865	200	4864	200	4868	200	4866	200	4867	10	1082
17-р хэсг	7771	892	7770	877	7776	18	7775	590	7777	600	--	-	-
18-р хэсг	7762	595	7763	400	7764	400	7769	8	7767	502	7768	600	-
19-р хэсг	7761	838	7755	446	7759	500	7757	400	7756	375	7760	18	-
20-р хэсг	7753	9	7752	400	7749	393	7747	393	7748	366	7751	350	440
21-р хэсг	7744	350	7741	463	7742	410	7746	295	7743	357	7745	400	-
22-р хэсг	7739	500	7736	238	7740	240	7735	200	7734	308	7737	434	500
23-р хэсг	7731	450	7733	450	4964	200	4962	400	4963	369	7732	443	-
24-р хэсг	4961	800	4955	969	4954	839	4959	322	-	-	-	-	-
25-р хэсг	4953	400	4952	400	4951	400	4950	310	-	-	-	-	-
26-р хэсг	4943	300	4945	300	4944	300	4947	300	4942	346	4946	300	4941
27-р хэсг	4932	344	4933	350	4934	150	4937	467	4931	334	4938	467	4939
28-р хэсг	7832	350	2203	350	2202	350	7829	350	7831	350	7828	133	557

Хүлээн авсан: УИХ-ын сонгуулийн 24-р тойргийн хороодоо гишүүн Д. Оюунцэцэл П. Оюунцэцэл

М. Энхчимэг

М. Энхчимэг Д. Оюунцэцэл

УИХ-ын Сонгуулийн 24-р тойрийн хэсгийн хороодоос
саналын хуудас хүлээн авсан баримт №3

2012-06-28

Хэсгийн хороо №	I YYT	Кодны дугаар										Хүлээлгэн өгсөн хүний нэр	
		II YYT	III YYT	IV YYT	V YYT	VI YYT	VII YYT	CHAHABHIH XYJAC TOO	CHAHABHIH XYJAC TOO	CHAHABHIH XYJAC TOO	CHAHABHIH XYJAC TOO		
29-р хэсэг	7820	761	7825	731	7821	700	7826	364	7824	4	7823	9	-
30-р хэсэг	7816	960	7814	998	7818	1079	7817	19	-	-	-	-	6
31-р хэсэг	7596	14	7592	500	7597	803	7591	443	7594	500	7593	487	7595
32-р хэсэг	7585	900	7586	779	7589	400	7583	400	7813	ялас	7582	483	-
33-р хэсэг	4930	400	4927	386	4928	400	4929	131	4923	350	4922	350	4924
34-р хэсэг	4920	729	4919	229	4921	700	4916	493	4915	500	4919	75	ягас
35-р хэсэг	7812	723	7807	704	7810	798	7809	24	-	-	-	-	-
36-р хэсэг	7806	322	7802	308	7801	283	7805	270	хэд	877	-	-	-
37-р хэсэг	7796	350	7803	350	7804	350	7794	500	7797	350	7799	488	7795
38-р хэсэг	7790	27	7793	668	7789	536	7788	550	7791	870	-	-	-
39-р хэсэг	7786	400	7641	400	7781	400	7785	400	7782	408	7783	329	7784
40-р хэсэг	7640	444	7634	402	7636	15	7638	400	7635	400	7637	400	-
41-р хэсэг	7623	300	7621	374	7624	300	7622	324	7618	350	7619	350	7620
42-р хэсэг	7616	337	7613	336	7615	337	7617	336	7611	442	7612	442	-
43-р хэсэг	7605	13	7607	85	7608	350	7606	350	7609	350	7610	350	7614
44-р хэсэг	7600	301	7599	0	7601	356	7598	300	7602	751	7604	400	7603
Нийт №3													222
Нийт дун:													-
													109
													1

Хүлээн авсан: УИХ-ын сонгуулийн 24-р тойрийн хорооны гишүүн
Г. Оюунтуяа. Оюунтуяа

М. Аль

М. Энхчимэг

Д. Батбаяр
Д. Батбаяр
Д. Батбаяр

Д. Булган
Д. Булган
Д. Булган

Д. Ганбагат

Д. Жартгал

Д. Цогцадрах

Д. Нараншээг

О. Мандах

О. Оджаргал

Ж. Баатарсүрэн

Х. Багболд

Б. Оргилболд

Б. Агиймаа

М. Дондоддорж

Н. Болхуй

З. Лхагвадорж

2012. 07. 05

1.5 19-р тойргийн салбар болон хэсгийн хороодод саналын хуудас хуваарилсан судалгаа

УИХ-ЫН СОНГУУЛИЙН 19 ДҮГЭР ТОЙРГИЙН САЛБАР БОЛОН ХЭСГИЙН ХОРООДОД САНАЛЫН
ХУУДАС ХУВААРИЛСАН СУДАЛГАА 2012.06.21

№	Салбар, хэсгийн нэр, дугаар	Нэрийн жагсаалтанд бичигдсэн сонгогчдын тоо	Хуваарилсан саналын хуудас	Хүлээлгэн өгсөн	Хүлээн авсан
1	1 дүгээр хэсэг	1394	1400	Ч.Чин	
2	2 дугаар хэсэг	1337	1400	Ч.Чин	
3	3 дугаар хэсэг	1098	1100	Ч.Чин	
4	4 дүгээр хэсэг	2010	2000	Ч.Чин	Б.Сүхбаатар
5	5 дугаар хэсэг	2048	2100		Б.Сүхбаатар
6	6 дугаар хэсэг	1679	1700		Б.Сүхбаатар
7	7 дугаар хэсэг	1935	2000		Б.Сүхбаатар
8	8 дугаар хэсэг	2336	2400		Б.Сүхбаатар
9	9 дүгээр хэсэг	2125	2200		Б.Сүхбаатар
10	10 дугаар хэсэг	1722	1800		Б.Сүхбаатар
11	11 дүгээр хэсэг	1656	1700		Б.Сүхбаатар
12	12 дугаар хэсэг	1586	1600	Ч.Чин	Ч.Чин
13	13 дугаар хэсэг	1986	2000	Ч.Чин	Ч.Чин
14	14 дүгээр хэсэг	2009	2000	Ч.Чин	Ч.Чин
15	15 дугаар хэсэг	2067	2100	Ч.Чин	Ч.Чин
16	16 дугаар хэсэг	2146	2200	Ч.Чин	Ч.Чин
17	17 дугаар хэсэг	1618	1700	Ч.Чин	Ч.Чин
18	18 дугаар хэсэг	1572	1600	Ч.Чин	Ч.Чин
19	19 дүгээр хэсэг	1473	1500	Ч.Чин	Ч.Чин
20	20 дугаар хэсэг	1630	1700	Ч.Чин	Ч.Чин
21	21 дүгээр хэсэг	2180	2250	Ч.Чин	Ч.Чин
22	22 дугаар хэсэг	2056	2100	Ч.Чин	Ч.Чин
23	23 дугаар хэсэг	2262	2300	Ч.Чин	Ч.Чин
24	24 дүгээр хэсэг	2174	2200	Ч.Чин	Ч.Чин
25	25 дугаар хэсэг	2362	2400	Ч.Чин	Ч.Чин
26	26 дугаар хэсэг	2345	2400	Ч.Чин	Ч.Чин
27	27 дугаар хэсэг	1446	1500	Ч.Чин	Ч.Чин
28	28 дугаар хэсэг	1590	1600	Ч.Чин	Ч.Чин
29	Дархан сумын салбар хороо	51842	52950		
30	29 дүгээр хэсэг	1867	1900	Ч.Чин	Ч.Чин
31	30 дугаар хэсэг	1741	1800	Ч.Чин	Ч.Чин
32	31 дүгээр хэсэг	1839	1900	Ч.Чин	Ч.Чин
33	Шарын гол сумын салбар хороо	5447	5600		
34	32 дугаар хэсэг	1722	1800	Ч.Чин	Ч.Чин
35	33 дугаар хэсэг	882	950	Ч.Чин	Ч.Чин
36	34 дүгээр хэсэг	1124	1200	Ч.Чин	Ч.Чин
37	Хонгор сумын салбар хороо	3728	3950		
38	35 дугаар хэсэг	1747	1800	Ч.Чин	Ч.Чин
39	36 дугаар хэсэг	408	500	Ч.Чин	Ч.Чин
40	Орхон сумын салбар хороо	2155	2300	Ч.Чин	Ч.Чин
41	Тойргийн хороо		899 - 100 = 799		
	Нийт дүн	63172	65699		

Жи: Тайршиг хороолуулж узсон (жошуу-ж)
899 шерхийнс 4 дугаар хэсэг 100н тохиц
авсан. Тайршиг хороолуулж 799ш узлондот цацдал
чаджсан. Шаардсаны гарвал тохиц хувьшилаа

1.6 19-р тойргийн саналын хуудасны зарцуулалт

Улсын Их Хурлын сонгуулчийн 19 дугаар тойргийн хорбоо
Дархан-үүл зиймаг

УЛСЫН ИХ ХУРЛЫН СОНГУУЛИЙН САНАЛЫН ХУУДАСНЫ ЗАРЦУУЛАЛТЫН ТАИЛАН

Улсын Их Хурлын сонгуулчийн 19 дугаар тойргийн хорбоо
Дархан-үүл зиймаг

2012.06.28

№	Сандар, хасгын хорооны дугаар	Нарийн жагсаалтад бичигдээн соногчдын тоо	Саналын хуудасны тоо		Санал хэрэгтэй зарцуулсан саналын хуудасны тоо <i>и/ч шинж чадуулж</i>	Сонгын буруу тэнцэлэлтэй хийсээс хичнээсний болгосон хайрчигар санал авахад	Үнээс Зөвхөрийн буруу тэнцэлэлтэй хийсээс хичнээсний болгосон хайрчигар санал авахад	Санал авах ёдөр санал тоолок төхөөрөмжөөр санал авахад	Зарцуулдагчийн саналын хуудасны тоо
			Хувьзсан авсан	Хувьзсан авдсан					
1	1	1306	1400	1400	889	4	1	884	511
2	2	1305	1400	1400	919	7	6	906	481
3	3	1080	1100	1100	707	3	12	692	393
4	4	1980	2100	2100	1332	5	10	1317	768
5	5	2054	2100	2100	1386	2	13	1373	712
6	6	1669	1700	1700	1073	11	17	1045	627
7	7	1959	2000	2000	1412	1	6	1405	588
8	8	2352	2400	2400	1616	5	11	1600	784
9	9	2112	2200	2200	1373	6	3	1364	827
10	10	1670	1800	1800	1156	10	3	1143	644
11	11	1646	1700	1700	1109	4	17	1088	591
12	12	1565	1600	1600	1012	4	4	1004	588
13	13	1971	2000	2000	1290	3	2	1285	710
14	14	1986	2000	2000	1302	4	14	1284	698
15	15	2047	2100	2100	1354	2	20	1332	746
16	16	2126	2200	2200	1457	4	11	1442	743
17	17	1614	1700	1700	1130	1	5	1124	570
18	18	1568	1600	1600	1082	2	12	1068	518
19	19	1460	1500	1500	945	1	2	942	555
20	20	1628	1700	1700	1104	2	5	1097	596
21	21	2168	2250	2250	1412	6	4	1402	838
22	22	2044	2100	2100	1320	5	3	1312	780
23	23	2307	2300	2300	1553	3	12	1538	747
24	24	2127	2200	2200	1408	3	2	1403	792
25	25	2348	2400	2400	1444	1	3	1440	956
26	26	2322	2400	2400	1500	5	5	1490	900
27	27	1429	1500	1500	938	3	3	932	562
28	28	1562	1600	1600	1055	6	8	1041	545
29	29	51445	53050	53050	0	34280	113	214	33953
30	30	1853	1900	1900	1194	7	11	1176	706
31	31	1736	1800	1800	1142	8	21	1113	658
32	32	1825	1900	1900	1260	8	17	1235	640
33	33	5414	5600	5600	3596	23	49	3524	2004
34	34	1712	1800	1800	1189	4	16	1169	611
35	35	894	950	950	515	5	2	508	435
36	36	1124	1200	1200	824	3	10	811	376
37	37	3750	3850	3850	2528	12	28	2488	1422
38	38	1728	1800	1800	1211	9	11	1191	589
39	39	413	500	500	303	1	5	297	197
40	40	2141	2300	2300	1514	10	16	1488	786
41	41	799	799	799	41918	158	307	799	23781
42	42	65698	65698	65698	0	41453	41453	41453	41453
43	43	62730	62730	62730	0	62730	62730	62730	62730
44	44	62730	62730	62730	0	62730	62730	62730	62730
45	45	62730	62730	62730	0	62730	62730	62730	62730
46	46	62730	62730	62730	0	62730	62730	62730	62730
47	47	62730	62730	62730	0	62730	62730	62730	62730
48	48	62730	62730	62730	0	62730	62730	62730	62730
49	49	62730	62730	62730	0	62730	62730	62730	62730
50	50	62730	62730	62730	0	62730	62730	62730	62730
51	51	62730	62730	62730	0	62730	62730	62730	62730
52	52	62730	62730	62730	0	62730	62730	62730	62730
53	53	62730	62730	62730	0	62730	62730	62730	62730
54	54	62730	62730	62730	0	62730	62730	62730	62730
55	55	62730	62730	62730	0	62730	62730	62730	62730
56	56	62730	62730	62730	0	62730	62730	62730	62730
57	57	62730	62730	62730	0	62730	62730	62730	62730
58	58	62730	62730	62730	0	62730	62730	62730	62730
59	59	62730	62730	62730	0	62730	62730	62730	62730
60	60	62730	62730	62730	0	62730	62730	62730	62730
61	61	62730	62730	62730	0	62730	62730	62730	62730
62	62	62730	62730	62730	0	62730	62730	62730	62730
63	63	62730	62730	62730	0	62730	62730	62730	62730
64	64	62730	62730	62730	0	62730	62730	62730	62730
65	65	62730	62730	62730	0	62730	62730	62730	62730
66	66	62730	62730	62730	0	62730	62730	62730	62730
67	67	62730	62730	62730	0	62730	62730	62730	62730
68	68	62730	62730	62730	0	62730	62730	62730	62730
69	69	62730	62730	62730	0	62730	62730	62730	62730
70	70	62730	62730	62730	0	62730	62730	62730	62730
71	71	62730	62730	62730	0	62730	62730	62730	62730
72	72	62730	62730	62730	0	62730	62730	62730	62730
73	73	62730	62730	62730	0	62730	62730	62730	62730
74	74	62730	62730	62730	0	62730	62730	62730	62730
75	75	62730	62730	62730	0	62730	62730	62730	62730
76	76	62730	62730	62730	0	62730	62730	62730	62730
77	77	62730	62730	62730	0	62730	62730	62730	62730
78	78	62730	62730	62730	0	62730	62730	62730	62730
79	79	62730	62730	62730	0	62730	62730	62730	62730
80	80	62730	62730	62730	0	62730	62730	62730	62730
81	81	62730	62730	62730	0	62730	62730	62730	62730
82	82	62730	62730	62730	0	62730	62730	62730	62730
83	83	62730	62730	62730	0	62730	62730	62730	62730
84	84	62730	62730	62730	0	62730	62730	62730	62730
85	85	62730	62730	62730	0	62730	62730	62730	62730
86	86	62730	62730	62730	0	62730	62730	62730	62730
87	87	62730	62730	62730	0	62730	62730	62730	62730
88	88	62730	62730	62730	0	62730	62730	62730	62730
89	89	62730	62730	62730	0	62730	62730	62730	62730
90	90	62730	62730	62730	0	62730	62730	62730	62730
91	91	62730	62730	62730	0	62730	62730	62730	62730
92	92	62730	62730	62730	0	62730	62730	62730	62730
93	93	62730	62730	62730	0	62730	62730	62730	62730
94	94	62730	62730	62730	0	62730	62730	62730	62730
95	95	62730	62730	62730	0	62730	62730	62730	62730
96	96	62730	62730	62730	0	62730	62730	62730	62730
97	97	62730	62730	62730	0	62730	62730	62730	62730
98	98	62730	62730	62730	0	62730	62730	62730	62730
99	99	62730	62730	62730	0	62730	62730	62730	62730
100	100	62730	62730	62730	0	62730	62730	62730	62730
101	101	62730	62730	62730	0	62730	62730	62730	62730
102	102	62730	62730	62730	0	62730	62730	62730	62730
103	103	62730	62730	62730	0	62730	62730	62730	62730
104	104	62730	62730	62730	0	62730	62730	62730	62730
105	105	62730	62730	62730	0	62730	62730	62730	62730
106	106	62730	62730	62730	0	62730	62730	62730	62730
107	107	62730	62730	62730	0	62730	62730	62730	62730
108	108	62730	62730	62730	0	62730	62730	62730	62730
109	109	62730	62730	62730	0	62730	62730	62730	62730
110	110	62730	62730	62730	0	62730	62730	62730	62730
111	111	62730	62730	6					

2.1 УИХ-ын сонгуулийн-р тойргийн-р хэсгийн хорооны сонгогчийн шилжилт хөдөлгөөний ажиглалтын маягт

ШУДАГА СОНГУУЛИЙН ТӨЛӨӨ
ИРГЭНИЙ НИЙГМИЙН ХЯНАЛТ СУЛЖЭЭ

ХЭРЭГЛЭГДЭХҮН 1 Багийн дугаар.....

УИХ-ЫН СОНГУУЛИЙН-р тойргийн-р хэсгийн хорооны сонгогчын шилжилт хөдөлгөөний ажиглалтын маягт

Сонгогчдын нэрийн жагсаалтын мониторинг

Судлаачийн дугаар.....

УИХ-ЫН СОНГУУЛИЙН-р тойргийн-р хэсгийн хорооны сонгогчын шилжилт хөдөлгөөний ажиглалтын маягт

№	Овог, нэр	Регистрийн дугаар	Он сар өдөр	Шилжихэс өмнөх хаяг	Шилжилт хийсэн газрын хаяг	Нэрийн жагсаалтын бүртгэлийн дугаар	Шилжин ирсэн сонгогчын мэдэгдэх хуудасны №	Сонгогчын шилжсэн тухай мэдэгдэх хуудасны №	Холбоо барих утас
1									
2									
3									
4									
5									
6									
7									
8									
9									
10									
11									
12									
13									
14									
15									

Судлаачийн тэмдэглэл.....

Сулжээний гишүүн “Филантропи хөгжлийн төлөө төв” ТББ

Төслийн удирдагч Ч.Мөнхцэцэг, утас: 99086707

2.2 УИХ-ын сонгуулийн-р тойргийн-р хэсгийн хорооны сонгогчдын хувийн мэдээлэлд өөрчлөлт оруулсан мэдээллийн маягт

ШУДАРГА СОНГУУЛИЙН ТӨЛӨӨ
ИРЭЭНИЙ НҮҮГМНИЙ ХЯНАТ СУЛЖЭЭ

ХЭРЭГЛЭГДЭХҮН 2

Багийн дугаар.....

Судлаачийн дугаар.....

УИХ-ЫН СОНГУУЛИЙН-Р ТОЙРИЙН-Р ХЭСГИЙН ХОРООНЫ СОНГОГЧДЫН ХУВИЙН МЭДЭЭЛЭЛД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛСАН МЭДЭЭЛЛИЙН МАЯГТ

№	Овог, нэр	Регистрийн дугаар	Он сар өдөр	Өөрчлөлт оруулах шаардлагатай мэдээллийн агуулга	Өөрчлөлт оруулсан мэдээллийн үндэслэл	Сонгогчын хувийн мэдээлэлд оруулсан өөрчлөлтийн агуулга	Холбоо барих утас
1							
2							
3							
4							
5							
6							
7							
8							
9							
10							
11							
12							
13							
14							
15							

Сулжээний гишүүн “Филантропи хөгжлийн төлөө төв” ТББ

Төслийн удирдагч Ч.Мөнхцэг, утас: 99086707

2.3 УИХ-ын сонгуулийн-р тойргийн-р хэсгийн хорооны сонгогчдын нэрийн жагсаалтад шинээр сонгогч бүртгэсэн маягт

ШУДАРГА СОНГУУЛИЙН ТӨЛӨӨ
НИЙГМНИЙ ХЯНАТ СУЛЖЭЭ

ХЭРЭГЛЭГДЭХҮН 3

Багийн дугаар.....

УИХ-ЫН СОНГУУЛИЙН-р ТОЙРИЙН-р ХЭСГИЙН ХОРООНЫ СОНГОЧДЫН НЭРИЙН ЖАГСААЛАТДАШИНЭЭР СОНГОГЧ БҮРТГЭСЭН МАЯГТ

Сонгогчдын нэрийн жагсаалтын мониторинг

Судлаачаййн дугаар.....

№	Овог, нэр	Регистрийн дугаар	Он сар өдөр	Гэрийн хаяг	Буртгэдээгүй байсан шалтгаан	Буртгэл хийсэн үндэслэл	Холбоо барих утас
1							
2							
3							
4							
5							
6							
7							
8							
9							
10							
11							
12							
13							
14							
15							

Сулжээний гишүүн “Филантропи хөгжлийн төлөө төв” ТББ

Төслийн удирдагч Ч.Мөнхцэцэг, утас: 99086707

2.4 УИХ-ын сонгуулийн-р тойргийн-р хэсгийн хорооны сонгогчдын нэрийн жагсаалтаас хасалт, тусгай тэмдэглэгээ хийгдэж байгаа сонгогчдын бүртгэлийн маягт

**ШУДАРГА СОНГУУЛИЙН ТӨЛӨВ
Нийтийн нийтийн хяналт суржээ**

ХЭРЭГЛЭГДЭХҮН 4

Багийн дугаар.....
Судлаачийн дугаар.....
УИХ-ЫН СОНГУУЛИЙН-Р ТОЙРИГИЙН-Р ХЭСГИЙН ХОРООНЫ СОНГОГЧДЫН НЭРИЙН ЖАГСААЛТААС ХАСАЛТ, ТУСГАЙ ТЭМДЭГЛЭГЭЭ ХИЙГДЭЖ БАЙГАА СОНГОГЧДЫН БҮРТГЭЛИЙН МАЯГТ

Сонгогчдын нэрийн жагсаалтын мониторинг

УИХ-ЫН СОНГУУЛИЙН-Р ТОЙРИГИЙН-Р ХЭСГИЙН ХОРООНЫ СОНГОГЧДЫН НЭРИЙН ЖАГСААЛТААС ХАСАЛТ, ТУСГАЙ ТЭМДЭГЛЭГЭЭ ХИЙГДЭЖ БАЙГАА СОНГОГЧДЫН БҮРТГЭЛИЙН МАЯГТ

№	Овог, нэр	Регистрийн дугаар	Он сар өдөр	Гэрийн хаяг	Бүртгэлээс хассан шалтгаан	Хасалт хийсэн үндэслэл	Холбоо барих утас
1							
2							
3							
4							
5							
6							
7							
8							
9							
10							
11							
12							
13							
14							
15							

Суржээний гишүүн “Филантропи хөгжлийн төлөө төв” ТББ

Төслийн удирдагч Ч.Мөнхцэцэг, утас: 99086707

ШУДАГА СОНГУУЛИЙН ТӨЛӨӨ ИРГЭНИЙ НИЙГМИЙН ХЯНАЛТ СУЛЖЭЭ

ХЭРЭГЛЭГДЭХҮН 5

Багийн дугаар.....

УИХ-ЫН СОНГУУЛИЙН-р ТОЙРИЙН-р ХЭСГИЙН ХОРООНЫ СОНГОГЧДЫН НЭРИЙН ЖАГСААЛАТДАД ШИНЭР БҮРТГЭГДСЭН СОНГОГЧЫН ХЯГИЙН ТУЛГАЛТЫН МАЯГТ

№	Үндсэн шалгах мэдээлэл		Нэр бүхий хүнд хамаарах тодруулах мэдээлэл				
	Овог нэр	Төрсөн он сар өдөр	Хаяг	Тухайн хүн мөн эсэх	Тухайн хаяг дээр байна амьдардаг эсэх	Иргэнний чамлах дээр нь энэ хаяг байдаг эсэх	Сонгуулийн үеэр энэ хаяг дээр байх эсэх
1				1. Мөн	1. Тийм	1. Тийм	1. Тийм
				2. Биш	2. Үгүй	2. Үгүй	2. Үгүй
2				1. Мөн	1. Тийм	1. Тийм	1. Тийм
				2. Биш	2. Үгүй	2. Үгүй	2. Үгүй
3				1. Мөн	1. Тийм	1. Тийм	1. Тийм
				2. Биш	2. Үгүй	2. Үгүй	2. Үгүй
4				1. Мөн	1. Тийм	1. Тийм	1. Тийм
				2. Биш	2. Үгүй	2. Үгүй	2. Үгүй
5				1. Мөн	1. Тийм	1. Тийм	1. Тийм
				2. Биш	2. Үгүй	2. Үгүй	2. Үгүй
6				1. Мөн	1. Тийм	1. Тийм	1. Тийм
				2. Биш	2. Үгүй	2. Үгүй	2. Үгүй

Сонгогчдын нэрийн жагсаалтын мониторинг
Судлаачийн дугаар.....

Нэр бүхий хүнд хамаарах тодруулах мэдээлэл

Эрэж холбоо барих
угас, регистрийн
дугаарыг бичих

2.5 УИХ-ЫН СОНГУУЛИЙН-р ТОЙРИЙН-р ХЭСГИЙН ХОРООНЫ СОНГОГЧДЫН НЭРИЙН ЖАГСААЛАТДАД ШИНЭР БҮРТГЭГДСЭН СОНГОГЧЫН ХЯГИЙН
БҮРТГЭГДСЭН СОНГОГЧЫН ХЯГИЙН ТУЛГАЛТЫН МАЯГТ

Сулжээний гишүүн "Филантропи хөгжлийн төлөө төв" ТББ

Төслийн удирдагч Ч.Мөнхцэцэг, утас: 99086707

3.1 Мониторингийн дүн телевиз тус бүрээр

МҮОНТ

СЕХ, УИХ-ын 2012 оны сонгуулийн үеэр МҮОНТ-ээр сонгуулийн төлбөргүй сурталчилгаа нэвтрүүлэх хуваарийг баталсан. Энэ хуваарийн дагуу МҮОНТ зургаадугаар сарын 6-наас 26-ныг дуустал хугацаанд 13 нам, эвсэл, бие даагчдад нийт 23 цаг зарцуулахаар төлөвлөжээ. Нийт цагийг 21 өдөрт хувааж нам тус бүр 20 минутын гурван нэвтрүүлэгт оролцоо хуваарилсан нь бүгд 13 цаг байна. Үлдсэн 10 цагаас бие даагчдад 1 цаг 30 минут хуваарилж, 8 цаг 30 минутыг дахин 13 нам, эвсэлд тэнцүү хуваарилсан нь нэг намд дунджаар 40 орчим минут оногджээ.


Мониторингийн хугацаанд МҮОНТ-ийн эфирийн 22429 минутын бичлэгт мониторинг хийснээс 2114 минут нь сонгуультай холбоотой мэдээлэл байсан нь нийт цагийн 9,4 хувийг эзэлж байна

Тэнцүү цаг хуваарилалт

Сонгуулийн мэдээллийн 23 хувийг МАН, 18 хувийг АН, 7 хувийг МНН-д зарцуулсан байна. Харин нийт цагийн 6 хувь нь ИЗНН-д, ЭОНН, ХХН, ИХН, ЭЧХН, ЭОН-д адил 5 хувь, Шударга ёс эвсэл, Гурав дахь хүчин эвсэл, МСДН-д адил 4 хувь, хамгийн бага буюу 3 хувь нь МУНН-д оногдсон байна. Бие даагчдад 6 хувьтай тэнцэх цаг оногджээ.

Сонгуулийн сурталчилгаатай холбоотой нэвтрүүлгийн 62 хувь нь оргил цагт цацагдажээ. Үүнээс МАН 19 хувь, АН 15 хувь, МНН 9 хувь, ИЗНН 8 хувийг тус тус эзэлсэн бол ЭОНН, ХХН, ЭОН-д адилхан 6 хувь, ИХН, МСДН, ЭЧХН-уудад адил тэнцүү 5 хувь, Шударга ёс эвсэл, Гурав дахь хүчин эвсэл, МУНН-уудад адилхан 4 хувь тус бүр ногджээ.

Харин бие даагчдад оргил цагийн 7 хувьтай тэнцэх цаг оногдсон байна.




Мэдээллийн өнгө аяс

МҮОНТ-ийн мэдээлэл чанарын хувьд 89 хувь нь эерэг хандлагатай, 9 хувь нь төвийг сахисан, 2 хувь нь сөрөг аястай мэдээлэл байна.


Эерэг өнгө аястай мэдээллийн 21 хувь нь МАН-д, 17 хувь нь АН-д, 7 хувь нь МНН-д оногджээ. ИЗНН, ЭЧХН, ИХН-уудад адил тэнцүү 6 хувь ЭОН, ЭОНН, ХХН, МСДН-уудад адилхан 5 хувь, Гурав дахь хүчин эвсэл, Шударга ёс эвсэлд адилхан 4 хувь тус бүр ногдсон бол, МУНН-д эерэг аястай мэдээллийн 3 хувь оногдов. Харин бие даан нэр дэвшигчид эерэг мэдээллийн 7 хувийг эзэлсэн байна.

Тус телевиз МАН-ыг хамгийн их төвийг сахисан байдлаар мэдээлжээ. Энэ нь нийт төвийг сахисан мэдээллийн 37 хувийг эзэлсэн бол АН-ын төвийг сахисан мэдээлэл 24 хувийг эзэлжээ. Шударга ёс эвсэл, ХХН-д адилхан 7 хувь, Гурав дахь хүчин эвсэлд 6 хувь, ЭОНН, ИЗНН-ууд ижилхэн 4 хувь, МУНН, ИХН-уудад тэнцүү 2 хувь, ЭОН, ЭЧХН, МНН-уудад адил 1 хувь тус тус оногджээ. Төвийг сахисан мэдээллийн 4 хувийг бие даагчид эзэлсэн байна.


МОНТ - Мэдээллийн чанар



МОНТ - Эерэг



МҮОНТ - Төвийг сахисан



Сөрөг өнгө аястай мэдээлэл харьцангуй бага илэрсэн нь 33 минут байв. Үүний 62 хувь нь АН-д, 30 хувь нь МАН-д, 7 хувь нь Шударга ёс эвслийн тухай мэдээлэл байв. Харин ЭОН-ын талаар цацсан сөрөг агууламжтай мэдээлэл нь 1 хувьтай тэнцжээ. Энд дурдагдаагүй бусад нам, эвсэл болон бие даагчдын талаар сөрөг өнгө аястай мэдээлэл цацаагүй байна.


Сонгуулийн мэдээллийн 67 хувийг шууд, 33 хувийг шууд бус эх сурвалжаас бэлтгэсэн байв.

Далд сурталчилгаа

МҮОНТ сонгуулийн сурталчилгааны үеэр эфирийн 31 хувь буюу 651 минутыг далд сурталчилгаанд зарцуулсан нь 2008 оны сонгуулийн мониторингийн дүнтэй харьцуулахад 24.5 хувиар өсжээ.

МҮОНТ далд сурталчилгааны нийт цагийн 80,5 хувийг МАН, АН-ыг эерэгээр сурталчлахад зарцуулсан бөгөөд бусад 9 нам, 2 эвсэл, 26 бие даан нэр дэвшигчдэд нийтдээ 19,5 хувийг зарцуулсан байна. Далд сурталчилгааны шинж агуулсан мэдээллийн 6 хувь нь бие даагчдын тухай мэдээлэл байсан нь судалгаагаар илэрчээ.

МҮОНТ - Сөрөг



МҮОНТ - Далд сурталчилгаа



Далд сурталчилгааг агуулгаар нь ангилахад дийлэнх буюу 70 хувь нь А2 хэлбэрийн (эрхэлж буй ажлаа ямар нэгэн байдлаар сонгуультай холбосон), 21 хувь нь Б хэлбэрийн (улс төрийн нам, нэр дэвшигчидтэй холбоотой үйл явдал, асуудлыг зориудаар сурвалжилж мэдээлсэн), 9 хувь нь А1 хэлбэрийн (нэр дэвшигчид зөвхөн хийж, гүйцэтгэж байгаа ажилтайгаа холбоотой) мэдээлэл байв. Харин В хэлбэрийн мэдээлэл (улс төрийн нам, эвсэл, нэр дэвшигчийн талаар дагнан сурталчилсан) 5 секунд эзэлсэн нь 0 хувьтай гарчээ.

Мэдээний хөтөлбөр

МҮОНТ-ийн мэдээний хөтөлбөрөөр 583 минутын сонгуультай холбоотой мэдээлэл нэвтрүүлсэн нь нийт мэдээллийн 28 хувийг эзэлж байна. Үүний 82 хувь нь эерэг, 17 хувь нь төвийг сахисан, 1 хувь нь сөрөг өнгө аястай мэдээлэл байгаа нь МҮОНТ-ийн мэдээлэлд төвийг сахисан байдал алдагдсан нь харагдаж байна.

МҮОНТ - Мэдээний хөтөлбөр



Мэдээний хөтөлбөрт нам, эвсэл, бие даагчдын эзэлсэн хувь хэмжээг харьцуулахад МАН 41 хувь, АН 35 хувийг эзэлжээ. Шударга ёс эвсэл, ИЗНН-д адил тэнцүү 4 хувь, Гурав дахь хүчин эвсэл, ЭЧХН, ИХН-д тэнцүү 2 хувь, МНН, ЭОНН-д адил 1 хувь тус

тус оногдов. Харин бие даагчдын тухай мэдээлсэн байдал нь нийт мэдээний хөтөлбөрөөр илэрсэн цагийн 7 хувьтай тэнцэж байна. МУНН, ХХН, МСДН-ын талаар тус бүр 2 минут гаруй мэдээлсэн нь 1 хувь д ч хүрээгүй байна.

Нэр дэвшигчийн сурталчилгаа

Нэр дэвшигчид	Харьялал	Хугацаа (минут/)
1 Б.Жаргалсайхан	БНН	27
2 Н.Жамсран	ЭЧХН	23
3 Б.Эрдэнэбат	ЭОН	22
4 Д.Зоригт	МАН	20
5 Ш.Адьшaa	Бие даагч	19
6 С.Ганбаатар	Бие даагч	18
7 М.Энхболд	МАН	17
8 Б.Амарсанаа	МАН	17
9 Б.Чулуунбат	МУНН	17
10 Я.Батсуурь	АН	14

МҮОНТ-ээр хамгийн олон цагийн сурталчилгаа нэвтрүүлсэн эхний 10 нэр дэвшигчийн талаар дийлэнхдээ эерэг буюу магтаж сайшаасан өнгө аястай мэдээлэл давамгайлжээ. Үүнээс Б.Жаргалсайхан (БНН), бие даан нэр дэвшигч Ш.Адьшaa, Я.Батсуурь (АН) нарын мэдээллийн 91-95 хувь нь эерэг өнгө аястай байв.

Сонгогчдын боловсролд зориулсан цаг

МҮОНТ-ийн сонгуультай холбоотой мэдээллийн 701 минут буюу 32,4 хувь нь сонгогчдын боловсролд зориулсан агуулгатай мэдээлэл байжээ.

БУСАД ТЕЛЕВИЗ

Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хууль (шинэчилсэн найруулга 35.11 зүйл

Олон нийтийн радио, телевизээс бусад радио, телевизээр сурталчилгааны нэвтрүүлгийг төлбөртэй нэвтрүүлж болох бөгөөд сурталчилгааны төлбөртэй нэвтрүүлгийн нийт хугацаа нь хоногт хоёр цагаас илүүгүй байна.


25-р суваг телевиз

Сурталчилчилгааны хугацаанд 25-р суваг телевизийн 20520 минутын эфирт мониторинг хийснээс 3346 минут буюу 16 хувь нь сонгуультай холбоотой мэдээлэл байлаа.

Тэнцүү цаг хуваарилалт

Тус телевиз сонгуулийн сурталчилгаанд зориулсан нэвтрүүлгийнхээ 45 хувийг МАН-д, 36 хувийг АН-д, 13 хувийг ИЗНН-д 2 хувийг ЭЧХН, ЭОН-д зарцуулжээ. Гурав дахь хүчин эвсэл, МУНН-д тус бүр ижил 1 хувь оногдсон байна. Бусад нам, эвслийн талаар дурьдах төдий мэдээлжээ. Харин тус телевиз бие даагчдад 2 хувьтай тэнцэх цаг оноосон байна.

25 суваг телевиз - Цаг хуваарилсан байдал



Сонгуультай холбоотой мэдээллийн 82 хувийг оргил цагаар цацжээ. Үүний 49 хувь нь МАН-д, 38 хувь нь АН-д, 9 хувь нь ИЗНН-д, 2 хувь нь Шударга ёс эвсэлд оногджээ. Тус телевизийн оргил цагийн нэвтрүүлгийн 2 хувьтай тэнцэх цагийг бие даагчид эзэлжээ.


Мэдээллийн өнгө аяс

Мэдээллийн чанарын хувьд дийлэнх буюу 93 хувь нь эерэг, 5 хувь нь төвийг сахисан, 2 хувийг сөрөг мэдээлэл эзэлж байна.

Эерэг өнгө аястай мэдээллийн 45 хувь нь МАН-д, 36 хувь нь АН-д, 14 хувь нь ИЗНН-д оногдсон бол Шударга ёс эвсэлд 2 хувь, Гурав дахь хүчин эвсэл, ИХН-ууд адилхан 1 хувийг эзэлжээ. Бусад нам эвслийг эерэг өнгө аясаар мэдээлсэн нь 2 минутаас бага байгаа нь нийт эерэг өнгө аястай мэдээллийн 1 хувьд хүрээгүй байна. Мөн бие даагчдад ноогдуулсан цаг 2 хувь байна.

25-р суваг телевиз төвийг сахисан мэдээллийн 47 хувийг АН эзэлж, мөн ойролцоо буюу 43 хувийг МАН-ын мэдээлэл эзэлжээ. ИЗНН 7 хувийг эзэлсэн бол Шударга ёс эвсэлд үлдсэн 3 хувь нь оногдсон байна. Бусад нам, эвсэл, бие даагчдын талаар 1-13 секунд дурьдан өнгөрсөн нь 1 хувьд ч хүрээгүй байна.

25 суваг телевиз - Мэдээллийн чанар



25 суваг телевиз - Эерэг



Сөрөг сурталчилгаанд нийт цагийн 2 хувь буюу 33 минут зарцуулсаны 68 хувь нь МАН-д, үлдсэн 30 хувь нь АН-д оногдсон байна. Харин Шударга ёс эвсэл, ИЗНН-ын тухай сөрөг мэдээлэл тус бүр 1 хувийт эзэлжээ. Бусад нам, эвсэл болон бие даагчдын талаар сөрөг хандлагатай мэдээлэл цацаагүй байна.

Нийт мэдээллийн 76 хувь нь шууд эх сурвалжаас, 24 хувь нь шууд бус эх сурвалжаас авсан мэдээлэл байна.

25 суваг телевиз - Төвийг сахисан




Төлбөртэй сурталчилгаа

25-р суваг телевизээр цацагдсан сонгуультай холбоотой нийт мэдээллийн 62 хувь буюу 2090 минут нь төлбөртэй, захиалгатай гэж тэмдэглэсэн, мөн төлбөртэй шинж агуулсан мэдээлэл байв. Үүнийг мониторинг хийсэн 21 өдөрт хуваахад хуульд заасан хоёр цагийг хэтрүүлээгүй мэт боловч далд сурталчилгааны 1265 минутыг нэмэхэд 835 минутаар буюу өдөрт 40 минутаар хэтрүүлжээ.

Далд сурталчилгаа


Тус телевизээр нэвтрүүлсэн 1265 минутын далд сурталчилгааны 42 хувийг МАН эзэлсэн бол АН 28 хувь, ИЗНН 24 хувь, Шударга ёс эвсэл, ИХН адилхан 2 хувь, Гурав дахь хүчин эвсэл 1 хувийг тус тус эзэлжээ. Харин бусад нам, эвслийн талаар цацагдсан мэдээлэл нь 1 хувьд ч хүрээгүй байна. Бие даагчдын талаар далд хэлбэрийн сурталчилгаа цацсан нь 1 хувьтай тэнцжээ.



Тус телевизийн далд сурталчилгааг агуулгаар нь ангилахад 58 хувь нь улс төрийн нам, нэр дэвшигчидтэй холбоотой үйл явдал, асуудлыг зориуд сурвалжилж мэдээлсэн буюу Б хэлбэрт, 34 хувь нь эрхэлж буй ажлаа ямар нэгэн байдлаар сонгуультай холбосон буюу А2 хэлбэрт, бхувь нь нам, эвсэл, нэр дэвшигчдийн талаар дагнан сурталчилсан В хэлбэрийн далд сурталчилгаа байв. Харин А1 хэлбэрийн далд сурталчилгаа 2 хувьд хүрчээ.

Мэдээний хөтөлбөр

25 суваг телевизийн мэдээний хөтөлбөрөөр сонгуультай холбоотой 434 минутын мэдээлэл нэвтрүүлжээ. Энэ нь нийт сонгуультай холбоотой мэдээллийн 13 хувьтай тэнцэж байна. Өнгө аясын хувьд 92 хувь нь эерэг, 4 хувь нь төвийг сахисан, 4 хувь нь сөрөг өнгө мэдээлэл байв.



Нийт мэдээллийн 42 хувийг МАН, 29 хувийг ИЗНН, 18 хувийг АН, 7 хувийг Шударга ёс эвсэл, 1 хувийг МНН тус бүр эзэлжээ. Бие даагчдад мэдээний хөтөлбөрөөр 3 хувьтай тэнцэх цаг оногдажээ. Харин бусад нам, эвслийн талаар нэр дурьдах төдий мэдээлжээ.

Нэр дэвшигчийн сурталчилгаа

Нэр дэвшигчид	Харьяалал	Хугацаа (минут/
1 З.Алтай	ИЗНН	292
2 Л.Энх-Амгалан	МАН	180
3 Ч.Ганхуяг	МАН	104
4 Л.Эрдэнэчимэг	АН	101
5 Ё.Отгонбаяр	МАН	100
6 Б.Лхагважав	МАН	93
7 С.Бямбацогт	МАН	79
8 С.Чинзориг	МАН	67
9 Н.Төмөрхүү	МАН	65
10 Л.Гантөмөр	АН	58

25-р суваг телевизээр сонгуулийн сурталчилгаанд хамгийн их цаг зориулсан 10 нэр дэвшигчийг З.Алтай (ИЗНН) тэргүүлж байна. Энэ нь тус телевизийн сонгуультай холбоотой мэдээллийн цагийн 8,6 хувийг эзэлжээ. Дээрх нэр дэвшигчийн талаар зөвхөн эерэгээр буюу магтаж, сайшаасан мэдээлэл илт давамгайлсан байна.

Сонгогчдын боловсролд зориулсан цаг

Сонгуулийн сурталчилгаатай холбоотой нийт 3346 минутын мэдээллийн 21 минут нь сонгогчдын боловсролд зориулсан агуулгатай мэдээлэл байв. Энэ нь нийт мэдээллийн 1 хувьтай тэнцэж байгаа нь тус телевиз нэр дэвшигч субъектуудыг сурталчлахад дийлэнх цагаа зориулсныг харуулж байна.


ТВ9 ТЕЛЕВИЗ

Сурталчилгааны хугацаанд ТВ9 телевизийн 22540 минутын эфирт мониторинг хийснээс 5936 минут буюу 26 хувь нь сонгуулийн сурталчилгаатай холбоотой мэдээлэл байлаа.

Тэнцүү цаг хуваарилалт

Тус телевиз сонгуулийн сурталчилгаанд зориулсан нэвтрүүлгийнхээ 38 хувийг Шударга ёс эвсэлд, 31 хувийг АН-д, 22 хувийг МАН-д зарцуулсан бол ЭОН, ИЗНН-д, адилхан 2 хувийг, МНН, ЭОНН, Гурав дахь хүчин эвсэлд адил 1 хувьтай тэнцэх цаг зарцуулжээ. Харин бие даагчид оногдсон цаг нь 2 хувьтай тэнцэж байна.

ТВ9 - Цаг хуваарилсан байдал



Сонгуулийн сурталчилгаатай холбоотой нэвтрүүлгийн 47 хувийг оргил цагаар нэвтрүүлжээ. Үүний 35 хувийг Шударга ёс эвсэл, 30 хувийг АН, 23 хувийт МАН, 3 хувийт ИЗНН, 2 хувийт ЭОН-ын мэдээлэл эзэлж, ИХН, ЭОНН, Гурав дахь хүчин эвсэл, МНН-уудад тус бүр ижилхэн 1 хувь оногджээ. Оргил цагт бие даагчдын эзлэх хувь 3 хувьтай тэнцжээ. Үлдсэн бусад намуудын талаар мэдээлсэн байдал нь тун бага хугацааг эзэлж байгаа тул 1 хувьд ч хүрсэнгүй.


Мэдээллийн өнгө аяс

Мэдээллийн чанарын хувьд 67 хувь нь эерэг, 23 хувь нь төвийг сахисан өнгө аястай мэдээлэл байв. Сөрөг мэдээлэл 10 хувийг эзэлж байгаа нь бусад телевизтэй харьцуулахад өндөр үзүүлэлт юм.


Эерэг өнгө аястай мэдээллийн 39 хувь нь Шударга ёс эвсэл-д, 32 хувь нь АН-д 20 хувь нь МАН-д зарцуулсан нь дийлэнх хувийг эзэлжээ. Харин ЭОН-д 3 хувь, ИЗНН-д 2 хувь, ЭОНН-д 1 хувьтай тэнцэх цаг ногдсон байна. Бие даагчид эерэг мэдээллийн 3 хувийг эзэлсэн байна. Бусад нам эвслийн талаар цацагдсан эерэг мэдээлэл нь 1 хувьд ч хүрээгүй байна.

ТВ9 телевизийн төвийг сахисан мэдээллийн хамгийн их цагийг Шударга ёс эвсэл 51 хувиар эзэлжээ. Түүний дараа АН 26 хувьтай байна. МАН-ын төвийг сахисан мэдээлэл 7 хувийг, ИЗНН 5 хувийг, Гурав дахь хүчин эвсэл 4 хувь, МНН 3 хувийг, ЭОН 1 хувийг тус эзэлжээ. Бие даагчдад төвийг сахисан мэдээллийн 1 хувьтай тэнцэх цаг оногдсон байна.

ТВ9 - Мэдээллийн чанар




ТВ9 - Эерэг



Нийт 574 минутын сөрөг сурталчилгааны 60 хувь нь МАН-ын, 40 хувь нь АН-ын тухай мэдээлэл байв. ИЗНН-ын талаар 36 секунд, Шударга ёс эвсэл-ийн талаар 54 секундын сөрөг өнгө аястай мэдээлэл илэрсэн нь 1 хувьд хүрээгүй байна. Бусад нам, эвсэл болон бие даагчдын талаар сөрөг хандлагатай мэдээлэл илрээгүй байна.

Нийт мэдээллийн 72 хувь нь шууд бус, 28 хувь нь шууд эх сурвалжийн мэдээлэл байна.

ТВ9 - Төвийг сахисан



Төлбөртэй сурталчилгаа


ТВ9 телевизээр цацагдсан сонгуулттай холбоотой нийт мэдээллийн 76 хувь буюу 4522 минут нь төлбөртэй, захиалгатай гэж тэмдэглэсэн нэвтрүүлэг байв.

Төлбөртэй нэвтрүүлгийн цагийг мониторингийн 21 өдөрт хуваан тооцоход хуульд заасан хоёр цагийг дунджаар өдөрт 95 минутаар хэтрүүлжээ. Харин далд болон төлбөртэй сурталчилгааны цагийг нийлүүлэн тооцоход өдөрт 2 цаг 37 минутаар хэтрүүлсэн байна.

Далд сурталчилгаа

ТВ9 телевизээр нийт мэдээллийн 22 хувь буюу 1314 минутын далд сурталчилгаа цацсанаас 46 хувь нь дангаараа Шударга ёс эвслийн тухай мэдээлэл байв. Харин МАН 25 хувийг, АН 20 хувийг, ЭОН 3 хувийг, МНН 2 хувийг эзэлсэн бол Гурав дахь хүчин эвсэлд 1 хувь оногдсон байна. Бие даагчид далд сурталчилгааны 2 хувийг эзэлж байна.

ТВ9 - Далд сурталчилгаа




Далд сурталчилгааг агуулгаар ангилахад 56 хувь нь Б буюу улс төрийн нам, нэр дэвшигчидтэй холбоотой үйл явдал, асуудлыг зориудаар сурвалжилж мэдээлсэн, 43 хувь нь А2 буюу эрхэлж буй ажлаа ямар нэгэн байдлаар сонгуультай холбосон, В буюу улс төрийн нам, эвсэл, нэр дэвшигчийн талаар дагнан сурталчилсан далд сурталчилгаа 1 хувийг эзэлжээ. Харин А1 хэлбэрийн далд сурталчилгаа илрээгүй байна.

Мэдээний хөтөлбөр

ТВ9 телевизийн цаг үеийн мэдээний хөтөлбөрөөр 1035 минутын сонгуультай холбоотой мэдээлэл нэвтрүүлсэн нь нийт цагийн 17 хувийг эзэлжээ. Үүний 48 хувь нь Шударга ёс эвсэлд оногдож байна. Түүний дараа МАН 25 хувийг, АН 18 хувийг, ЭОН 3 хувийг, МНН 2 хувийг эзэлсэн бол Гурав дахь хүчин эвсэл, ИЗНН-ууд ижилхэн 1 хувьтай тэнцэх цаг оногдсон байна. Тус телевизийн мэдээний хөтөлбөрөөр Бие даагчдын талаар мэдээлсэн байдал нь 2 хувьд хүрч байна.

ТВ9 - Мэдээний хөтөлбөр



Мэдээний хөтөлбөрөөр нэвтрүүлсэн мэдээллийн 38 хувь нь эерэг, 43 хувь нь төвийг сахисан, 19 хувь нь сөрөг хандлагатайгаар мэдээлсэн байна.

Нэр дэвшигчийн сурталчилгаа

Нэр дэвшигчид	Харьяалал	Хугацаа (минут)
1 Б.Тулга	ШЁЭ	176
2 Га.Баярсайхан	АН	159
3 М.Энхсайхан	ШЁЭ	123
4 О.Чулуунбат	ШЁЭ	114
5 Л.Эрдэнэчимэг	АН	107
6 Х.Амарсайхан	ШЁЭ	102
7 Д.Батцогт	ШЁЭ	97
8 Л.Энх-Амгалан	МАН	96
9 Н.Батбаяр	АН	95
10 М.Билэгт	МАН	91

Судалгааны хугацаанд нэр дэвшигчдийг мэдээлсэн байдлаар эхний 10-т орсон нэр дэвшигчдээс Га.Баярсайхан (АН)-ы талаар мэдээллийн 98 хувь, М.Билэгт (МАН)-ийн 95 хувь, М.Энхсайхан (ШЁЭ)-ы 89 хувь, Л.Энх-Амгалан (МАН)-гийн 94 хувь нь эерэгээр, Д.Батцогт (ШЁЭ) 83 хувь төвийг сахисан байдлаар мэдээлжээ.

Сонгогчдын боловсролд зориулсан цаг

Сонгуулийн сурталчилгаатай холбоотойгоор 5936 цагийн нэвтрүүлэг цацсанаас 96 минутыг сонгогчдын боловсролд зориулсан нь нийт мэдээллийн 2 хувийг эзэлж байна.


UBS ТЕЛЕВИЗ

UBS телевизийн 23000 минутын бичлэгт мониторинг хийснээс 3365 цаг буюу 15 хувь нь сонгуулийн сурталчилгаатай холбоотой мэдээлэл байлаа.

Тэнцүү цаг хуваарилалт

Тус телевиз энэ хугацаанд сонгуулийн сурталчилгаанд зориулсан нэвтрүүлгийнхээ 51 хувийг МАН-д, 34 хувийг АН-д зориулсан бол Гурав дахь хүчин эвсэл 5 хувийг эзэлсэн нь бусдаасаа илүү байв. Шударга ёс эвсэл 3 хувь, ИЗНН-д адилхан 4 хувь оногдсон бол ЭОН-ын тухай мэдээлэл 2 хувьд хүрчээ. ИХН-д оногдсон цаг нь 1 хувьтай тэнцсэн бол ЭОНН-ын талаар мэдээлсэн нь 6 минут байсан нь 1 хувьд ч хүрээгүй байна. Улдсэн бусад намын талаар огт мэдээлээгүй байна. Харин бие даагчдад оногдсон цаг нь 1 хувийг эзэлжээ.

UBS - Цаг хуваарилсан байдал




Сонгуулийн сурталчилгаатай холбоотой мэдээллийн 74 хувийг оргил цагаар нэвтрүүлжээ. Үүний 46 хувийг МАН, 37 хувийг АН-д зориулсан бол Гурав дахь хүчин эвсэл, ИЗНН-д адил тэнцүү 5 хувь оногдсон бол ЭОН 3 хувь, Шударга ёс эвсэл 2 хувь, ИХН 1 хувийг эзэлсэн бол ЭОНН 1 хувьд ч хүрээгүй юм. Бусад нам эвслийн талаар оргил цагаар огт мэдээлэгүй байна. Харин бие даагчдад 1 хувьтай тэнцэх цаг ноогджээ.

Мэдээллийн өнгө аяс

Мэдээллийн чанарын хувьд сонгуулийн сурталчилгааны дийлэнх буюу 96 хувь нь эерэг, 1 хувь нь сөрөг өнгө аястай мэдээлэл байв. Төвийг сахисан мэдээлэл нийтдээ 3 хувийг эзлэв. Учир нь тус телевизийн сонгуулийн сурталчилгаатай холбоотой мэдээллийн дийлэнхийг намын захиалгат нэвтрүүлэг болон реклам эзэлж байна.

Эерэг өнгө аястай мэдээллийн 52 хувь нь МАН-д, 34 хувь нь АН-д оногдсон бол Гурав дахь хүчин эвсэл, ИЗНН-д адил 4 хувь, ЭОН 2 хувь, Шударга ёс эвсэлд адилхан 3 хувь ногдож үлдсэн 1 хувь нь ИХН-ын тухай мэдээлэл байв. ЭОНН-ын талаар эерэг байдлаар мэдээлсэн нь 1 хувьд ч хүрээгүй байна. Бие даагчдын талаар зөвхөн эерэг өнгө аясаар мэдээлсэн нь 1 хувьд хүрчээ.



Төвийг сахисан мэдээллийн 43 хувь нь Гурав дахь хүчин эвсэлийн тухай мэдээлэл байв. Харин Шударга ёс эвсэлд 23 хувь, МАН-д 22 хувь, АН-д 10 хувь, ИЗНН-д 2 хувьтай тэнцэх цаг тус тус оногдсон байна.

UBS телевиз 40 минутын сөрөг өнгө аястай мэдээлэл нэвтрүүлсэний 72 хувь нь АН, 27 хувь нь МАН, 1 хувь нь Шударга ёс эвслийн мэдээлэл байв.

Нийт мэдээллийн 61 хувь нь шууд эх сурвалжаас авсан, 39 хувь нь шууд бус эх сурвалжийн мэдээлэл байна.

Төлбөртэй сурталчилгаа

UBS телевизийн сонгуулийн сурталчилгаатай холбоотой нийт мэдээллийн 89 хувь буюу 3017 минут сурталчилгаа төлбөртэй, захиалгатай гэдэг нь илт тодорхой байв. Үүнийг сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх 21 өдөрт хуваахад өдөрт 2 цаг 23 минут 40 секунд ноогдож байна. Харин далд сурталчилгаа, төлбөртэй сурталчилгааны цагийг нийлүүлэн тооцоход хуулиар зөвшөөрөгдсөн цагийг өдөрт 39 минутаар хэтрүүлжээ.

Далд сурталчилгаа

UBS телевизээр нийт 326 минутын далд сурталчилгаа нэвтрүүлсэн сонгуультай холбоотой мэдээллийн 10 хувийг эзэлж байгаа нь бусад телевизтэй харьцуулахад хамгийн бага үзүүлэлт юм.

Далд сурталчилгааны 57 хувь нь МАН-ын, 41 хувь нь АН-ын тухай мэдээлэл байв. ЭОН, Гурав дахь хүчин эвсэлд адилхан 1 хувь оногдсон бол бусад нам, эвсэл, бие даагчдын талаар далд сурталчилгаа нэвтрүүлээгүй байна.


Тус телевизийн далд сурталчилгааг агуулгаар нь ангилбал 71 хувь нь Б хэлбэрийн буюу улс төрийн нам, нэр дэвшигчидтэй холбоотой үйл явдал, асуудлыг зориудаар сурвалжилж мэдээлсэн, 28 хувь нь А2 буюу эрхэлж буй ажлаа ямар нэгэн байдлаар сонгуультай холбосон, 1 хувь нь В буюу улс төрийн нам, эвсэл, нэр дэвшигчийн талаар дагнан сурталчилсан хэлбэрт хамарагдаж байна. Харин А1 хэлбэрийн далд сурталчилгаа 1 минут 11 секунд илэрсэн нь дангаараа МАН-ын тухай мэдээлэл байв.

Мэдээний хөтөлбөр

UBS телевизийн цаг үеийн мэдээний хөтөлбөрөөр сонгуультай холбоотой 75 минутын мэдээлэл нэвтрүүлжээ. Энэ нь нийт мэдээллийн 2 хувийг эзэлж байгаа бөгөөд бусад телевизтэй харьцуулахад хамгийн бага үзүүлэлт юм.

Мэдээний хөтөлбөрийн нэвтрүүлсэн сонгуулийн мэдээллийн 89 хувийг МАН, 8 хувийг АН, 2 хувийг ИЗНН, 1 хувийг МУНН-ын талаар мэдээлжээ. Бие даагчид болон бусад нам, эвслийн талаар мэдээний хөтөлбөрөөр огт мэдээлээгүй байна. Мэдээллийн 75 хувь нь төвийг сахисан, 25 хувь нь эерэг өнгө аястай байв.

UBS - Мэдээний хөтөлбөр



Нэр дэвшигчийн сурталчилгаа

Мониторингийн хугацаанд UBS телевизээр хамгийн олон цагийн сурталчилгаа нэвтрүүлсэн 10 нэр дэвшигчдийг 100 хувь эерэгээр буюу сайшаан магтжээ.

Нэр дэвшигчид	Харьялал	Хугацаа (минут/
1 Ж.Эрдэнэбат	МАН	174
2 Ё.Огтонбаяр	МАН	87
3 М.Энхболд	МАН	81
4 Л.Энх-Амгалан	МАН	81
5 М.Зоригт	АН	73
6 Н.Төмөрхүү	МАН	73
7 М.Билэгт	МАН	63
8 Ч.Ганхуяг	МАН	60
9 Д.Зоригт	МАН	55
10 Л.Амгалан	МАН	54

Сонгогчдын боловсролд зориулсан цаг


Сонгуультай холбоотой 3383 минутын мэдээллийн 40 минут нь сонгогчдын боловсролд зориулсан агуулгатай мэдээлэл байна. Энэ нь нийт мэдээллийн 1 хувийг эзэлж байна.

ТВ5 ТЕЛЕВИЗ

Сурталчилгааны хугацаанд ТВ5 телевизийн 23863 минутын бичлэгт мониторинг хийснээс 2716 минут буюу 11 хувь нь сонгуультай холбоотой мэдээлэл байлаа.

Тэнцүү цаг хуваарилалт

ТВ5 телевиз сонгуулийн сурталчилгааны үед улс төрийн нам, эвсэл, нэр дэвшигчдэд тэнцвэртэй бус цаг хуваарилсан байна. Тус телевиз сонгуулийн сурталчилгаанд зориулсан нэвтрүүлгийнхээ талаас илүү буюу 58 хувийг МАН-д, 22 хувийг АН-д, 14 хувийг ИЗНН-д, 2 хувийг Шударга ёс эвсэлд зориулжээ. Харин бие даагчдад 4 хувьтай тэнцэх цаг оногджээ. Харин ЭЧХН, МУНН, ЭОН, ХХН, МСДН-ын талаар хүргэсэн мэдээлэл нь нийлээд 1 хувьд хүрэхгүй байна. Үлдсэн бусад нам эвслийн талаар огт мэдээлэл хүргээгүй байна.



Сонгуулийн сурталчилгаатай холбоотой нэвтрүүлгийн 67 хувийг оргил цагаар нэвтрүүлжээ. Үүний 59 хувийг МАН, 26 хувийг АН, 9 хувийг ИЗНН, 1 хувийг Шударга ёс эвсэл тус тус эзэлжээ. Харин бие даагчдын талаар оргил цагт мэдээлсэн нь 5 хувьтай тэнцэв.


Мэдээллийн өнгө аяс

Мэдээллийн чанарын хувьд 66 хувь нь эерэг өнгө аястай, 32 хувь нь төвийг сахисан өнгө аястай, 2 хувь нь сөрөг мэдээлэл байв.

Эерэг өнгө аястай мэдээллийн талаас илүү буюу 66 хувь нь МАН-д, 21 хувь нь АН-д, 8 хувь нь ИЗНН-д тус тус оногджээ. Бусад нам, эвслийн талаар эерэг аястай мэдээлэл цацаагүй байна. Харин бие даагчид эерэг мэдээллийн 4 хувийг эзэлсэн байна.


ТВ5 телевиз МАН-ыг хамгийн их төвийг сахисан байдлаар мэдээлжээ. Энэ нь 43 хувийг эзэлж байна. Харин ИЗНН-д 26 хувь, АН-д 22 хувь, Шударга ёс эвсэлд 5 хувь тус тус ногджээ. Бусад нам, эвсэл, бие даагчдын талаар төвийг сахисан байдлаар мэдээлсэн нь дурдах төдий байж энэ нь нийт нейтрал өнгө аястай мэдээллийн 1 хувьд ч хүрээгүй байна. Бие даагчдын талаарх мэдээлэл 4 хувь эзэлж байна.

TB5 - Эерэг



TB5 телевизийн сөрөг аястай мэдээллийн 54 хувь нь дангаараа АН-ын тухай мэдээлэл байв. Харин сөрөг мэдээллийн 29 хувийг МАН, 13 хувийг Шударга ёс звэсл тус тус эзэлжээ. Бусад нам болон эвслийн талаар сөрөг мэдээлэл нэвтрүүлээгүй бол бие даагчдын талаарх сөрөг мэдээлэл 4 хувьтай тэнцэв.

TB5 - Төвийг сахисан



Нийт мэдээллийн дийлэнх буюу 62 хувь нь шууд эх сурвалжаас, 38 хувь нь шууд бус эх сурвалжаас авсан мэдээлэл байна.


Төлбөртэй мэдээлэл

TB5 телевизийн сонгуулттай холбоотой нийт мэдээллийн 2048 минут буюу 76 хувь нь төлбөртэй, захиалгатай гэдэг нь илт танигдаж байв.

Төлбөртэй нэвтрүүлгийн цагийг судалгаанд хамрагдсан 21 өдөрт хуваахад өдөрт 1 цаг 38 секунд оногдож байна. Гэтэл далд болон төлбөртэй сурталчилгааны цагийг нийлүүлэн тооцоход өдөрт 2 минут 38 секундээр төлбөртэй сурталчилгааны цагийг хэтрүүлсэн нь бусад телевизитэй харьцуулахад хамгийн бага байв.


Далд сурталчилгаа

Далд сурталчилгааны шинжтэй 527 минутын мэдээлэл нэвтрүүлсэн нь сонгуультай холбоотой мэдээллийн 19 хувийг эзэлж байна. Далд сурталчилгааны 47 хувь нь МАН-д, 25 хувь нь ИЗНН-д, 13 хувь нь АН-д, Шударга ёс эвсэлд 9 хувь, ЭЧХН-д 2 хувь тус бүр оногджээ. Бусад нам, эвслийн талаар далд сурталчилгаа 1 хувиас ч бага байна. Харин бие даагчдад олгогдсон цаг 2 хувьд хүрчээ.



Тус телевизийн далд сурталчилгаа явуулсан цагийг агуулгаар нь ангилбал 51 хувь нь А2 буюу эрхэлж буй ажлаа ямар нэгэн байдлаар сонгуультай холбосон, 38 хувь нь Б хэлбэрийн буюу улс төрийн нам, нэр дэвшигчидтэй холбоотой үйл явдал, асуудлыг зориудаар сурвалжилж мэдээлсэн, 11 хувь нь В буюу улс төрийн нам, эвсэл, нэр дэвшигчийн талаар дагнан сурталчилсан хэлбэрт хамарагдаж байна.

Мэдээний хөтөлбөр



TB5 телевизийн мэдээний хөтөлбөрөөр 407 минутын сонгуультай холбоотой мэдээлэл явуулсан нь 15 хувийг эзэлж байна. Үүнд ИЗНН 33 хувийг, МАН 30 хувийг, АН 17 хувийг, Шударга ёс эвсэл 13 хувийг, ЭЧХН 3 хувийг тус тус эзэлжээ. Бие даагчдын талаар мэдээлсэн нь 3 хувийг эзэлсэн байна.

Мэдээллийн өнгө аясын хувьд 62 хувь нь төвийг сахисан, 27 хувь нь эерэг, 11 хувь нь сөрөг мэдээлэл байв.

Нэр дэвшигчийн сурталчилгаа

TB5 телевиз дараах 10 нэр дэвшигчийн талаар хамгийн олон цагийн сурталчилгаа нэвтрүүлжээ.

Нэр дэвшигчид	Харьяалал	Хугацаа (минут/
1 Ё.Отгонбаяр	МАН	81
2 Н.Төмөрхүү	МАН	77
3 С.Ганбаатар	Бие даагч	73
4 С.Бямбацогт	МАН	71
5 Ц.Дашдорж	МАН	71
6 Г.Занданшатар	МАН	60
7 Ж.Мөнхбат	МАН	60
8 Б.Наранхүү	АН	60
9 Т.Наранцэцэг	ИЗНН	55
10 Х.Бат-Ялалт	ИЗНН	53

Мэдээллийн өнгө аясын хувьд МАН-аас нэр дэвшигч С. Бямбацогт, Н. Төмөрхүү, Г. Занданшатар Ц. Дашиборж нарын мэдээллийн 96-98 хувь, АН-аас нэр дэвшигч Б. Наранхүүгийн талаар нийт мэдээллийн 97 хувь эерэг буюу магтан сайшаасан өнгө аястай мэдээлэл байв.

Сонгогчдын боловсролд зориулсан цаг

Сонгуулийн сурталчилгаатай холбоотой 2699 минутын нэвтрүүлгийн 5 хувь буюу 123 минут нь хараат бус, сонгогчдын боловсролд зориулсан агуулгатай мэдээлэл байв.

3.2 УИХ-ЫН 2012 ОНЫ СОНГУУЛИЙН СУРТАЛЧИЛГААГ МҮОНТ-ЭЭР НЭВТРҮҮЛЭХ ХУВААРЬ

БАТЛАВ. СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООНЫ ДАРГА Н.ЛУВСАНЖАВ

УИХ-ЫН 2012 ОНЫ СОНГУУЛИЙН СУРТАЛЧИЛГААГ МҮОНТ-ЭЭР НЭВТРҮҮЛЭХ ХУВААРЬ

Д/д	Нам, Эвсэл, дэвшигчдийн нэр	Сар, өдөр, гараг	Цаг	Төлбөр	Хугацаа (мин/
1.	Субъект №1 Эх орон нам	06-р сарын 06 Лхагва	18.40	Төлбөргүй	20 мин
2.	Субъект №8 "Хөгжлийн хөтөлбөр" нам	06-р сарын 06 Лхагва	21.05	Төлбөргүй	20 мин
3.	Субъект №2 АН	06-р сарын 07 Пүрэв	18.40	Төлбөргүй	20 мин
4.	Субъект №9 ИЗНН	06-р сарын 07 Пүрэв	21.05	Төлбөргүй	20 мин
5.	Субъект №3 Эрх чөлөөг хэрэгжүүлэгч нам	06-р сарын 08 Баасан	18.40	Төлбөргүй	20 мин
6.	Субъект №10 МСДН	06-р сарын 08 Баасан	21.05	Төлбөргүй	20 мин
7.	Субъект №4 "Гурав дахь хүч" эвсэл	06-р сарын 09 Бямба	18.40	Төлбөргүй	20 мин
8.	Субъект №11 МАН	06-р сарын 09 Бямба	21.05	Төлбөргүй	20 мин
9.	Субъект №5 Шударга ёс эвсэл	06-р сарын 10 Ням	18.40	Төлбөргүй	20 мин
10.	Субъект №6 Иргэний хөдөлгөөний нам	06-р сарын 11 Даваа	18.40	Төлбөргүй	20 мин
11.	Субъект №13 Эх орончдын нэгдсэн нам	06-р сарын 11 Даваа	21.05	Төлбөргүй	20 мин
12.	Субъект №7 МУНН	06-р сарын 12 Мягмар	18.40	Төлбөргүй	20 мин
13.	Субъект №14 Монголын ногоон нам	06-р сарын 12 Мягмар	21.05	Төлбөргүй	20 мин
14.	Субъект №8 "Хөгжлийн хөтөлбөр" нам	06-р сарын 13 Лхагва	18.40	Төлбөргүй	20 мин
15.	Субъект №1 Эх орон нам	06-р сарын 13 Лхагва	21.05	Төлбөргүй	20 мин
16.	Субъект №9 ИЗНН	06-р сарын 14 Пүрэв	18.40	Төлбөргүй	20 мин
17.	Субъект №2 АН	06-р сарын 14 Пүрэв	21.05	Төлбөргүй	20 мин
18.	Субъект №10 МСДН	06-р сарын 15 Баасан	18.40	Төлбөргүй	20 мин
19.	Субъект №3 Эрх чөлөөг хэрэгжүүлэгч нам	06-р сарын 15 Баасан	21.05	Төлбөргүй	20 мин
20.	Субъект №11 МАН	06-р сарын 16-ны Бямба	18.40	Төлбөргүй	20 мин
21.	Субъект №4 "Гурав дахь хүч" эвсэл	06-р сарын 16 Бямба	21.05	Төлбөргүй	20 мин
22.	Субъект №5 Шударга ёс эвсэл	06-р сарын 17 Ням	21.05	Төлбөргүй	20 мин
23.	Субъект №13 Эх орончдын нэгдсэн нам	06-р сарын 18 Даваа	18.40	Төлбөргүй	20 мин
24.	Субъект №6 Иргэний хөдөлгөөний нам	06-р сарын 18 Даваа	21.05	Төлбөргүй	20 мин
25.	Субъект №14 Монголын ногоон нам	06-р сарын 19 Мягмар	18.40	Төлбөргүй	20 мин
26.	Субъект №7 МУНН	06-р сарын 19 Мягмар	21.05	Төлбөргүй	20 мин
27.	Субъект №1 Эх орон нам	06-р сарын 20 Лхагва	18.40	Төлбөргүй	20 мин
28.	Субъект №8 "Хөгжлийн хөтөлбөр" нам	06-р сарын 20 Лхагва	21.05	Төлбөргүй	20 мин
29.	Субъект №2 АН	06-р сарын 21 Пүрэв	18.40	Төлбөргүй	20 мин
30.	Субъект №9 ИЗНН	06-р сарын 21 Пүрэв	21.05	Төлбөргүй	20 мин

31.	Субъект №3 Эрх чөлөөг хэрэгжүүлэгч нам	06-р сарын 22 Баасан	18.40	Төлбөргүй	20 мин
32.	Субъект №10 МСДН	06-р сарын 22 Баасан	21.05	Төлбөргүй	20 мин
33.	Субъект №4 "Гурав дахь хүч" эвсэл	06-р сарын 23 Бямба	18.40	Төлбөргүй	20 мин
34.	Субъект №11 МАН	06-р сарын 23 Бямба	21.05	Төлбөргүй	20 мин
35.	Субъект №5 Шударга ёс эвсэл	06-р сарын 24 Ням	18.40	Төлбөргүй	20 мин
36.	Субъект №6 Иргэний хөдөлгөөний нам	06-р сарын 25 Даваа	18.40	Төлбөргүй	20 мин
37.	Субъект №13 Эх орончдын нэгдсэн нам	06-р сарын 25 Даваа	21.05	Төлбөргүй	20 мин
38.	Субъект №7 МУНН	06-р сарын 26-ны Мягмар	18.40	Төлбөргүй	20 мин
39.	Субъект №14 Монголын ногоон нам	06-р сарын 26-ны Мягмар	21.05	Төлбөргүй	20 мин
1.	"Сонгууль-2012" шууд нэвтрүүлэг Сэдэв: Байгаль экологи-хөгжил	06-р сарын 07 Пүрэв	21.25	Төлбөргүй	90 мин
2.	"Сонгууль-2012" шууд нэвтрүүлэг Сэдэв: Эдийн засгийн өсөлт- хөгжил	06-р сарын 14 Пүрэв	21.35	Төлбөргүй	90 мин
3.	"Сонгууль-2012" шууд нэвтрүүлэг Сэдэв: Гэр бүл, хүүхэд-хөгжил	06-р сарын 15 Баасан	21.35	Төлбөргүй	90 мин
4.	"Сонгууль-2012" шууд нэвтрүүлэг УИХ-ын сонгуульд бие даан нэр дэвшигчид оролцно.	06-р сарын 20 Лхагва	21.35	Төлбөргүй	90 мин
5.	"Сонгууль-2012" шууд нэвтрүүлэг Сэдэв: Сайн засаглал-хөгжил	06-р сарын 21 Пүрэв	21.35	Төлбөргүй	90 мин
6.	"Сонгууль-2012" шууд нэвтрүүлэг Нам,эвсэлийн дарга нар оролцно.	06-р сарын 26-ны Мягмар	21.35	Төлбөргүй	150 мин

**3.3 Олон нийтийн радио телевизээс бусад радио, телевизээр сонгуулийн
сурталчилгаа нэвтрүүлэх журам**

**МОНГОЛ УЛСЫН СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРОО, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ХАМТАРСАН ТОГТООЛ**

2012 оны 5 дугаар сарын
15-ны өдөр

Дугаар 56/38

Улаанбаатар
хот

**Олон нийтийн радио, телевизээс бусад радио, телевизээр
сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх журам батлах тухай**

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.13, Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.7, 12 дугаар зүйлийн 12.3, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.13-д заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хороо, Харилцаа холбооны зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

Нэг. Олон нийтийн радио, телевизээс бусад радио, телевизээр сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх журмыг нэгдүгээр хавсралтаар, 2012 оны Монгол Улсын Их Хурлын сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх телевиз, радиогийн өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгчдийн нэrsийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

Хоёр. Олон нийтийн радио, телевизээс бусад радио, телевизээр сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Сонгуулийн ерөнхий хороо /Н.Лувсанжав/, Харилцаа холбооны зохицуулах хороо (Б.Болдбаатар), тойргийн хорооны дарга, нарийн бичгийн дарга нарт тус тус даалгасугай.

**СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООНЫ
ДАРГА**

Н.ЛУВСАНЖАВ

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Ч.СОДНОМЦЭРЭН

**ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ДАРГА**

Б. БОЛДБААТАР

ГИШҮҮН

Ч.СОДНОМЦЭРЭН

Ж. УРАНЧИМЭГ

М. МЭНД-ОЧИР

Н. БААТАРХУЯГ

Н. ЭРДЭНЭХҮҮ

Б. МӨНХБАТ

Сонгуулийн ерөнхий хороо,
Харилцаа холбооны зохицуулах хорооны
2012 оны 5 дугаар сарын 15-ны өдрийн
56/38 дугаар хамтарсан тогтоолын
нэгдүгээр хавсралт

ОЛОН НИЙТИЙН РАДИО, ТЕЛЕВИЗЭЭС БУСАД ТЕЛЕВИЗ, РАДИОГООР СОНГУУЛИЙН СУРТАЛЧИЛГАА НЭВТРҮҮЛЭХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Энэхүү журмын зорилго нь Олон нийтийн радио, телевизээс бусад телевиз, радиогоор, (цаашид телевиз, радио гэх) сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.
2. Олон нийтийн радио, телевизээс бусад телевиз, радиогоор сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэхэд Сонгуулийн ерөнхий хороо, Харилцаа холбооны зохицуулах хороо хамтарч хяналт тавина.
3. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.11 дэх хэсэгт заасан радио телевизэд Харилцаа холбооны зохицуулах хорооноос олгосон телевиз, радиогийн өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй телевиз, радио хамаарна.
4. Телевиз, радио нь нам, эвсэл нэр дэвшигчийн сонгуулийн сурталчилгааг (цаашид сонгуулийн сурталчилгаа гэх) нэвтрүүлэхдээ Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомж болон энэхүү журмыг дагаж мөрднө.
5. Телевиз, радио нь сонгуулийн сурталчилгааг нэвтрүүлэхдээ Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.14 дэх хэсэгт заасны дагуу сонгуулийн сурталчилгааны тэнцвэрт байдлыг хангаж, олон нийтэд үнэн зөв, бодит мэдээллийг хүргэж, редакцийн хараат бус байдлыг ханган, сэтгүүл зүйн мэргэжлийн зарчим, ёс зүйн хэм хэмжээг баримтлан ажиллана.

Хоёр. Сонгуулийн сурталчилгааг телевиз, радиогоор нэвтрүүлэх

- 2.1. Телевиз, радио нь сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх бол сонгуулийн сурталчилгааны нэвтрүүлгийг нам, эвсэл, нэр дэвшигч, захиалагчтай байгуулсан гэрээний үндсэн дээр төлбөртэй нэвтрүүлнэ.
- 2.2. Телевиз, радио нь нэгээс илүү сувагтай бол сурталчилгааны нэвтрүүлгийг зөвхөн агаарын долгион ашигладаг үндсэн сувгаар нэвтрүүлнэ.
- 2.3. Сонгуулийн сурталчилгааны нэвтрүүлгийг зөвхөн агаарын долгион ашигладаг телевиз, радиогоор нэвтрүүлнэ.
- 2.4. Харилцаа холбооны зохицуулах хороо нь энэ журмын 1.3-д заасан телевиз, радиогийн нэrsийг энэ журмын 2 дугаар хавсралтын дагуу гаргаж, сонгуулийн сурталчилгаа эхлэхээс 7 хоногийн өмнө нийтэд мэдээлнэ.
- 2.5. Сурталчилгааны төлбөртэй нэвтрүүлгийн нийт хугацаа нь хоногт хоёр цагаас илүүгүй байна.

- 2.6. Телевиз, радио нь нам, эвсэл, нэр дэвшигчийн сонгуулийн сурталчилгааны нэвтрүүлгийн хуваарийг энэ журмын 1 дугээр хавсралт дахь загварын дагуу гаргасан байна.
- 2.7. Телевиз, радио нь сонгуулийн сурталчилгааны нэвтрүүлгийн хуваарь, цагийг гаргахдаа Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.9, 35.10 дахь заалтад заасан зарчмыг баримтлан нам, эвсэл бүрд, түүнчлэн нэг тойрогт өрсөлдөж байгаа бие даан нэр дэвшигч бүрд тэнцүү хугацаа ногдохоор тооцох бөгөөд баталсан хуваарь, цагийг бусад нам, эвсэл, нэр дэвшигчид шилжүүлэхийг хориглоно.
- 2.8. Телевиз, радио нь энэ журмын 2.6-д заасан хуваарийг гаргаж, Харилцаа холбооны зохицуулах хороонд нам, эвсэл, нэр дэвшигч, захиалагчтай байгуулсан гэрээний эх хувийн хамт Сонгуулын ерөнхий хороо, тойргийн хороо нэр дэвшигчийг бүртгэх хугацаа дууссан өдрөөс эхлэн ирүүлж бүртгүүлнэ.
- 2.9. Энэхүү журмын 2.6-д заасан хуваарийн дагуу нам, эвсэл, нэр дэвшигчийн сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэхдээ телевиз, радиогоор сонгуулийн сурталчилгаа албан ёсоор эхэлсэн хугацаанаас тооцох сурталчилгааны 7 хоног бүрт цагийг жигд, тэнцвэртэй хуваарилах бөгөөд энэ нь сонгогчдын хамгийн их үзэж, сонсдог оргил цагуудад (19:00-23:00) мөн адил хамаарна.
- 2.10. Харилцаа холбооны зохицуулах хороо нь энэ журмын 2.3-т заасан телевиз, радиогоос ирүүлсэн нам, эвсэл, нэр дэвшигчийн сонгуулийн сурталчилгааны нэвтрүүлгийн хуваарийг Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.9-35.12, 35.14 дэх хэсэг, энэ журмын 2.9 -д нийцэж буй эсэхийг хянаж бүртгэнэ.
- 2.11. Энэ журмын 2.8-д заасны дагуу сонгуулийн сурталчилгааны нэвтрүүлгийн хуваария бүртгүүлсэн телевиз, радио сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлж эхлэх бөгөөд сонгуулийн сурталчилгааны нэвтрүүлгийн хуваарийг бүртгүүлээгүй телевиз, радиог Сонгуулийн тухай хууль болон энэ журмыг зөрчсөн гэж үзэж сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэхийг зөвшөөрөхгүй.
- 2.12. Харилцаа холбооны зохицуулах хороо телевиз, радиогоос ирүүлсэн сонгуулийн сурталчилгааны нэвтрүүлгийн хуваарь нь энэ журмын 2.10-д заасан хуулийн холбогдох зүйл, заалтад нийцээгүй тохиолдолд тухайн телевиз, радиод хуваарийг энэ журамд заасан шаардлагад нийцүүлэхийг шаардана.
- 2.13. Харилцаа холбооны зохицуулах хороо нь энэ журмын 2.10-д заасны дагуу бүртгэж авсан телевиз, радиогийн сонгуулийн сурталчилгааны нэвтрүүлгийн хуваарийг цахим хуудсандaa байршуулж, нийтэд ил тод мэдээлнэ.
- 2.14. Сонгуулийн ерөнхий хороо, тойргийн хороо нь нам, эвсэл, нэр дэвшигчийг бүртгэж үнэмлэх олгоходо энэ журмын хувийг нам, эвсэл, нэр дэвшигч телевиз, радиогоор сонгуулийн сурталчилгаа явуулах зааварчилгааны хамт өгнө.
- 2.15. Телевиз, радио нь Харилцаа холбооны зохицуулах хорооноос хянаж, бүртгэсэн сонгуулийн сурталчилгааны нэвтрүүлгийн хуваарийг мөрдөх ба энэ хуваарыт зааснаас бусад цагт сонгуулийн сурталчилгааг ил, далд хэлбэрээр нэвтрүүлэхийг хориглоно.
- 2.16. Энэ журмын 3.1-д заасныг зөрчиж сонгуулийн сурталчилгаа гэдгээ онцолж тодотгоогүй, улс төрийн нам, эвсэл, нэр дэвшигчийг сурталчилж байгаагаа ил тод тайлбарлаж ойлгуулаагүй, сонгогчдын ухамсар, сонголтод шууд бусаар нөлөөлөх

мэдээ, мэдээлэл, нэвтрүүлэг зэрэг аливаа хэлбэрийн далд сурталчилгаа явуулахыг хориглоно.

- 2.17. Сонгуулийн сурталчилгааны нэвтрүүлгийн хуваария бүртгүүлсэн телевиз, радио нь сонгуулийн сурталчилгааг нэвтрүүлж эхлэх ба Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.3 дахь хэсэгт заасан хугацаанд зогсоон.
- 2.18. Нам, эвсэл, нэр дэвшигч нь Харилцаа холбооны зохицуулах хороонд бүртгэсэн хуваарьт заасан цагт сонгуулийн сурталчилгаа явуулахгүй болсон тохиолдолд телевиз, радио нь тухайн хуваарилагдсан цагт сонгуулийн өөр сурталчилгаа нэвтрүүлэхийг хориглоно.
- 2.19. Телевиз, радио нь бүртгүүлсэн хуваарьтаа өөрчлөлт оруулах зайлшгүй шаардлага гарсан тохиолдолд, хуваарийг сурталчилгааны 7 хоногоор дахин гаргаж Харилцаа холбооны зохицуулах хороонд нэн даруй бүртгүүлнэ.
- 2.20. Телевиз, радио нь нам, эвсэл, нэр дэвшигчийн сонгуулийн сурталчилгааны тэнцвэрт байдлыг хангах, сурталчилгааны нэвтрүүлгээ явуулах тэгш боломж олгох зарчмыг баримтлан сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх үнэ тарифийг тогтоож, нийтэд ил тод мэдээлнэ.
- 2.21. Харилцаа холбооны зохицуулах хороо нь нам, эвсэл, нэр дэвшигчид сонгуулийн сурталчилгаа явуулах тэгш боломж олгох нөхцлийг хангах зорилгоор телевиз, радиогоор сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх үнэ тарифийн дээд хязгаарыг тогтооно.
- 2.22. Сонгуулийн сурталчилгаанд хуваарилсан эфирийн цагийг телевиз, радиогийн өргөн нэвтрүүлгийн зохицуулалтын ерөнхий нөхцөл шаардлагын 6.4-т заасан зар сурталчилгааны хязгаарлалтад оруулж тооцохгүй.

Гурав. Телевиз, радиогоор сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэхэд баримтлах зарчим

- 3.1. Телевиз, радио нь сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэхдээ тухайн сурталчилгааны агуулга, хэлбэр, түүнийг түгээж байгаа арга хэрэгслээс үл хамааран дуу, дурс, авиа, тайлбар зэргийг ашиглан сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлж буй гэдгээ ойлгомжтой тодорхой гаргаж, төлбөртэй, захиалгатай гэж тодотгон, тухайн сурталчилгааны нэвтрүүлгийн нийт хугацааны туршид захиалагч нам, эвсэл, нэр дэвшигч, захиалагчийн нэрийг тодорхой харагдахуйц байдлаар бичиж нэвтрүүлнэ.
- 3.2. Сонгуулийн сурталчилгааг улс орны болон дэлхий дахины амьдралын цаг үеийн шинжтэй үйл явдлын талаарх тогтмол мэдээ, мэдээллийн нэвтрүүлэг, боловсролын болон хүүхдэд зориулсан нэвтрүүлгийн дундуур нэвтрүүлэхийг хориглоно.
- 3.3. Телевиз, радио нь иргэдийг үнэн зөв, бодитой, тэнцвэртэй мэдээллээр хангах зорилгоор тухайн телевиз, радиогийн редакцийн зүгээс бэлтгэн нэвтрүүлсэн нам, эвсэл, нэр дэвшигч, тэдний төлөөллийг оролцуулсан хэлэлцүүлэг, сонгуульд өрсөлдөгчдийн хооронд явуулах мэтгэлцээн зэрэг нэвтрүүлгүүдэд нам, эвсэл, нэр дэвшигч, тэдний төлөөллийг оролцуулахдаа оролцогч бүрт адил тэгш боломж олгоно.
- 3.4. Сонгуулийн үйл явдлын тухай мэдээ, сурвалжлага, сонгогчдын боловсролд зориулсан мэдээ, мэдээлэл, энэ журмын 3.3 -д заасан нэвтрүүлэг, сонгуулийн тухай хуулийг тайлбарласан мэдээлэл, сурталчилгаа, сонгуулийн хороодын албан ёсны мэдээллийг сонгуулийн сурталчилгааны нэвтрүүлэгт хамааруулахгүй.

- 3.5. Телевиз, радио нь нам, эвсэл, нэр дэвшигчээс ирүүлсэн дараах сонгуулийн сурталчилгааг нэвтрүүлэхийг хориглоно. Үүнд:
- 3.5.1. Сонгуульд оролцооос татгалзах, сонгуулийн болон бусад хууль тогтоомж зөрчихийг уриалсан агуулга бүхий сурталчилгаа нэвтрүүлэх
 - 3.5.2. Улс төрийн чансаа тогтоох зорилго бүхий аливаа хэлбэрийн шалгаруулалтын үр дүнг сурталчлах
 - 3.5.3. Улс төрийн албан хаагчаас бусад төрийн албан хаагч болон насанд хүрээгүй иргэнийг татаан оролцуулсан нэвтрүүлэг нэвтрүүлэх
- 3.6. Сонгуулийн сурталчилгааны үеэр үндэсний эв нэгдлийг сахин дээдэлж, нийгмийн дэг журам, тогтвортой байдлыг хангах үүднээс Монгол Улсын холбогдох хууль, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалыг мөрдөж, холбогдох бусад хууль тогтоомж, дараах заалтуудыг зөрчсөн нэвтрүүлэг болон зар сурталчилгаа бүтээх, түгээхийг хориглоно:
- 3.6.1. Эрүүгийн хуулийн 179 дугаар зүйлд заасан нийтийн эмх замбараагүй байдалд өдөөн турхирсан;
 - 3.6.2. Эрүүгийн хуулийн 86 дугаар зүйлд заасан үндэсний эв нэгдлийг бусниулах чиглэлээр сурталчилгаа явуулсан;
 - 3.6.3. Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.4.4 дэхь заалтад заасан нийгэмд хууль ёс, дэг журам, сахилга, хариуцлага суларч эмх замбараагүй байдалд хүргэх;
 - 3.6.4. Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.6.1 дэхь заалтад нийгмийн сэтгэл зүй, тогтвортой байдал, хувь хүний ухамсар, ёс зүйд хөндлөнгөөс нөлөөлөхөөр оролдсон;

Дөрөв. Сонгуулийн сурталчилгаанд тавих хяналт

- 4.1. Сонгуулийн ерөнхий хороо, Харилцаа холбооны зохицуулах хороо нь телевиз, радиогоор сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэхэд тавих хяналтыг энэ журмын 2.17 -д заасан хугацаанд хэрэгжүүлнэ.
- 4.2. Телевиз, радиогоор сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх үйл ажиллагаанд дараах байдлаар хяналт тавина. Үүнд:
 - 4.2.1. Телевиз, радиогоор нэвтрүүлэх сурталчилгааны төлбөртэй нэвтрүүлгийн нийт хугацаа нь хоногт 2 цагаас илүүгүй эсэх;
 - 4.2.2. Сонгуулийн сурталчилгааны нэвтрүүлгийг зөвхөн агаарын долгион ашигладаг телевиз, радиогоор нэвтрүүлж байгаа эсэх;
 - 4.2.3. Телевиз, радио нь нэгээс илүү сувагтай бол сурталчилгааны нэвтрүүлгийг зөвхөн агаарын долгион ашигладаг үндсэн сувгаар нэвтрүүлж буй эсэх;
 - 4.2.4. Энэ журмын 2.8-д заасны дагуу Харилцаа холбооны зохицуулах хорооны хянаж бүртгэсэн хуваарийг мөрдөж буй эсэх;
 - 4.2.5. Сурталчилгааны нэвтрүүлгийн хянаж бүртгэсэн хуваарыт заасан цагийг бусад нам, эвсэл, нэр дэвшигчид шилжүүлсэн эсэх;
- 4.3. Орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа телевиз, радио нь сонгуулийн сурталчилгааны хугацаанд эфирийн нийт цагийн бичлэгийг сурталчилгааны 7 хоногоор хийж, тухайн 7 хоногийн эцэст тойргийн хороонд ирүүлнэ. Тойргийн хороо уг бичлэгийг битүүмжлэн Харилцаа холбооны зохицуулах хороонд ирүүлнэ.

- 4.4. Хяналт тавихад ашиглаж байгаа мэдээ, мэдээллийг энэ журамд зааснаас өөр зорилгоор ашиглахгүй.

Тав. Бусад

- 5.1. Сонгуулийн ерөнхий хороо болон Харилцаа холбооны зохицуулах хороо энэ журмын хэрэгжилтэд хяналт тавих ажлыг удирдан зохион байгуулах үүрэг бүхий байнгын ажиллагаатай ажлыг хэсэг байгуулж ажиллуулна.
- 5.2. Хяналтын дүн мэдээ, зөрчлийн талаар сонгуулийн сурталчилгааны үеэр олон нийтэд мэдээлнэ.
- 5.3. Телевиз, радио нь сонгуулийн сурталчилгаа дууссанаас хойш 10 хоногт багтаан энэ журмыг мөрдөж ажилласан тухай тайлангаа Харилцаа холбооны зохицуулах хороонд ирүүлнэ.

*Олон нийтийн радио, телевизээс
бусад телевиз, радиогоор сонгуулийн
сурталчилгаа нэвтрүүлэх журмын
нэгдүгээр хавсралт*

Батлав. Ерөнхий захирал) ТВ (Радио (

**... ТЕЛЕВИЗ, РАДИОГООР НЭВТРҮҮЛЭХ НАМ, ЭВСЭЛ, НЭР ДЭВШИГЧИЙН
ТӨЛБӨРТЭЙ СУРТАЛЧИЛГААНЫ НЭВТРҮҮЛГИЙН ХУВААРЬ**

Огноо

№	Сар өдөр	Нам, эвсэл, нэр дэвшигчийн нэр	Гариг	Үргэлжлэх хугацаа	Нэвтрүүлэг эхлэх, дүусах цаг	Тайлбар
1	2	3	4	5	6	7
1	огноо	HAM - 1		... мин	00:00-00:00	
2	огноо	HAM - 2		... мин	00:00-00:00	
3	огноо	HAM - 3		... мин	00:00-00:00	
4	огноо	HAM - 4		... мин	00:00-00:00	
5	огноо	HAM - 5		... мин	00:00-00:00	
6	огноо	HAM - 6		... мин	00:00-00:00	
7	огноо	HAM - 7		... мин	00:00-00:00	
8	огноо	HAM - 8		... мин	00:00-00:00	
9	огноо					
10	огноо					
11	огноо					
12	огноо					
13	огноо					
